



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ГАМШИГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН**

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭМХЭТГЭЛ - 2019

**Улаанбаатар хот
2020 он**

УЛААНБААТАР ХОТЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Д.Сэржмядаг¹, П.Чимэдцэрэн², Д.Нарантуяа³, Ч.Одонбаатар⁴, А.Мөнхсайхан⁵

¹ГСХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа

²ГСХ-ийн Инновацийн төвийн дарга, доктор (Ph.D), ахмад

³ГСХ-ийн Секторын эрхлэгч, докторант, дэслэгч

⁴ООГФХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)

⁵ООГФХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Оршил

Монгол орон нь эх газрын сейсмийн харьцангуй өндөр идэвхжилтэй бүсэд ордог. Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газар хөдлөлтийн судалгаанаас харахад манай улсын хот, суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн 7 ба түүнээс дээш, 12 сум, суурин газар нь газар хөдлөлтийн 9 баллаас дээш баллын бүс нутагт оршиж байна. 7 ба түүнээс дээш балл бүхий газар хөдлөлтийн бүс нутагт нийт хүн амын 86 хувь нь амьдарч байна. Манай улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь хот, суурин газарт байнга суурьшдаг ба зөвхөн нийслэлд 40-50 орчим хувь нь амьдарч байна (ОБЕГ 2017).

Одон орон, геофизикийн судалгааны төвийн судалгаагаар 2005 оноос эхлэн Улаанбаатар хот болон түүний орчмын бүс нутагт газар хөдлөлтийн идэвхжилт огцом нэмэгдсэн бөгөөд 2014 онд болсон газар хөдлөлтийн тоог 2005 оныхтой харьцуулж үзэхэд 2 дахин нэмэгдсэн байна.

Улаанбаатар хот нь бүс нутгийн үйлдвэрлэл, бизнес, шинжлэх ухаан, технологи, боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн төв бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 60% орчим хувийг бүрдүүлдэг байна (Чилхаасүрэн, Баасанхүү, 2013; Нийслэлийн хот төлөвлөлтийн алба, 2014; Азийн сан, 2016).

Хэдийгээр Монгол Улс хүн амын хамгийн сийрэг суурьшсан орны тоонд ордог боловч хот суурингийн хүн амын нягтрал нэмэгдсээр байна. Энэ нь бүс нутагт тохиолдож болох аюулд хот суурин газрын хүн амын ертөмтгий байдлыг нэмэгдүүлэх талтай. Улаанбаатар хот нь 7 магнитутын газар хөдлөлтийг үүсгэх магадлалтай 4 идэвхтэй хагарлаар хүрээлэгдсэн бөгөөд 2005 оноос хойш газар хөдлөлтийн идэвхжил ихэссээр байна (Jeggle, 2013). Монгол Улсын Шинжлэх ухааны академийн 2000 онд хийсэн судалгаагаар 7 магнитутын хүчтэй газар хөдлөлтөд Улаанбаатар хотын 60,000 орчим хүн, 300 орчим барилга байгууламж өртөж болзошгүй гэсэн тооцоо гарчээ (Jeggle, 2013). Сүүлийн 18 жилд хүн амын тоо эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор дээрх тоо өссөн бөгөөд энэ эрсдэл нь хотын дөрөвний нэг орчим хувийг хамрахаар байна (ADRC, 2013).

Монгол Улсын Засгийн газраас газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн дараах хямралыг богино хугацаанд гэтлэн давах чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, барилга, байгууламжийн газар хөдлөлтийн чичирхийллийн тэсвэрлэх байдал, чанарыг тодорхойлох, мэдээллийн сан бүрдүүлэх, хүн амд зарлан

мэдээллийг дамжуулах систем байгуулах зэрэг бүтцийн арга хэмжээг авч хэрэгжүүлсний зэрэгцээ эрх зүйн орчин бүрдүүлэх, гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох байгууллага, албан тушаалтны гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх сургалт, дадлага явуулах зэрэг бүтцийн бус тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Одоогоор манай орны хувьд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх асуудлыг тухайлан авч судалж үзсэн, цаашид энэ чиглэлээр авах арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлсон судалгааны ажил байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн идэвхжилт нийслэл хот орчмын бүс нутагт огцом нэмэгдэж байгаа, манай улсын нийт хүн амын 40 гаруй хувь нь амьдардаг зэрэг нь Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг тодорхойлох, улмаар түүнийг дээшлүүлэх асуудлыг тодорхойлох чиглэлээр судалгаа хийх үндэслэл болж байна.

Судалгааны зорилго, зорилт

Улаанбаатар хотын хэмжээнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх талаар хийгдэж буй арга хэмжээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, цаашид бэлэн байдлыг дээшлүүлэх талаар дунд болон урт хугацаанд шийдвэрлэх арга замын хувилбаруудыг санал болгоход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. Үүнд:

- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах асуудлыг авч үзэх онол, аргазүйн үндсийг тодорхойлох;
- Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээний өнөөгийн байдлыг шинжлэх;
- Орон нутгийн захиргаа, ААНБ-ийн түвшинд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж буй байдалд шинжилгээ хийх;
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын талаарх иргэдийн мэдлэг, хандлагыг тодорхойлох;
- Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох.

Судалгааны аргазүй

Судалгааны ажилд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, ажиглалт хийх зэрэг шинжлэх ухааны ерөнхий аргыг болон агуулгын шинжилгээ, нэгтгэсэн өгөгдөл шинжлэх зэрэг нийгмийн судалгааны аргыг хэрэглэсэн.

Судалгааны ажлын хязгаарлалт

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээний зорилго нь гамшгийн аюулыг урьдчилан мэдэж, түүний болзошгүй сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах, гамшгийн үед болон дараа юу хийх ёстой,

хэрхэн үүнийг хийхийг мэдэх болон эдгээр шуурхай арга хэмжээг үр дүнтэй явуулах техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байхад оршдог.

Бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, төрийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, жирийн иргэд оролцоно. Захиргааны байгууллага, онцгой байдлын, яаралтай тусламжийн байгууллага болон бусад гамшгийн үед чиг үүрэг гүйцэтгэх байгууллагуудын хүрээнд төрийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг, харин иргэд болон бизнес эрхлэгчдийн хүрээнд хүн амын бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч үздэг. Төрийн бэлэн байдлыг хангах хүрээнд 1) гамшгаас хамгаалах төлөвлөлт; 2) гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт; 3) гамшгаас хамгаалах сургалт; 4) гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл; 5) гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрхзүйн орчин гэсэн 5 арга хэмжээ хамаардаг. Харин хүн амын бэлэн байдлыг хангах хүрээнд 1) гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох; 2) зан үйлийг хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх; 3) зарлан мэдээлэх дохиогоор ажиллахад сургах гэсэн арга хэмжээнүүд хамаарна.

Энэ судалгааны ажилд гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрхзүйн орчин гэсэн төрийн бэлэн байдлыг хангах хүрээнд хамаарах хоёр арга хэмжээг авч үзээгүй болно.

Судалгааны ач холбогдол

- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах асуудлыг авч үзэх онол, аргазүйн үндэс бүрдэнэ.
- Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах боломж бүрдэнэ.
- Хотын хөгжил, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн оновчтой арга замаар газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх боломж бүрдэнэ.
- Орон нутгийн захиргаа, иргэдийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдал, эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголт нэмэгдэж, бэлэн байдал дээшилнэ.
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын талаар судалгаа хийх судлаачдын судалгааны ажлын ур чадвар нэмэгдэнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ОНОЛ, АРГАЗҮЙН АСУУДАЛ

Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийн нөхцөл байдал

Улаанбаатар хот нь газар хөдлөлтийн хувьд Монгол Улсын баруун хэсгийн газар хөдлөлтийн идэвхтэй бүс болон зүүн хэсгийн харьцангуй сул идэвхтэй бүс нутгийн заагт оршдог харьцангуй бага идэвхжилтийн бүсэд багтдаг гэсэн ойлголт саяхныг хүртэл байсан. 1994 оноос хойш Франц Улсын хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хот орчимд орчин үеийн мэдрэмж сайтай газар хөдлөлтийн станцууд суурилуулсан ба эдгээр станц нь магнитут 3.5-аас бага хэмжээтэй сул газар

хөдлөлтүүдийг ч бүртгэнэ. Улаанбаатар хотоос 100 км-т 600 орчим газар хөдлөлт бүртгэгдсэнээс ихэнх нь сул газар хөдлөлтүүд байгаа боловч эдгээр хөдлөлтүүд нь идэвхитэй бүсүүдийг тогтооход чухал ач холбогдолтой. 2000 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн төсөл болон санхүүжүүлэлтээр Японы мэргэжилтнүүд Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна.

Урьдчилсан судалгаагаар Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт үүсэх магадлал бүхий голомт идэвхжиж, 6.5-6.8 магнитутын хүчтэй байх бөгөөд энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд 9-10 баллын доргилт үүсэх үндэслэлтэй гэж эрдэмтэд дүгнэлт гаргасан байна.

Улаанбаатар хотын Сонгино-Сонсголонгийн бүс нутагт 2005 оноос газар хөдлөлтийн өндөр идэвхжилт ажиглагдаж эхэлсэн нь Улаанбаатар хотод бодит аюул учруулж болохуйц тектоник тогтоцын эвдрэлийн үзэгдэл явагдаж эхэлж байгааг харуулж байна. 1995-2009 оны хооронд Улаанбаатар хот орчмын бүсэд нийт 600 гаруй сул хүчтэй /магнитут нь 4.2 буюу түүнээс доош/ газар хөдлөлтийн төв тодорхойлогдсоны 50 орчим нь 1995-2003 онд тохиолдсон бол 2005 оны 4-р сараас эхлэн 450 орчим болж мэдэгдэхүйцээр өссөн байна.

Энэхүү идэвхитэй бүс нь Эмээлт болон Сонгино орчмын бүс нутагт 30 орчим км урт, 13 орчим км гүний хэмжээтэй томоохон талбайг хамарч байгааг урьдчилсан судалгаагаар тогтоогоод байна. Улаанбаатар хотын нийт барилгажилтын талбайн 25% нь 6 баллын, 52% нь 7 баллын, 23% нь 8 баллын бүсэд хамрагддаг. Үүнд:

6 баллын бүсэд - Баянзүрх дүүргийн XII хороолол, Баянгол дүүргийн III, IV хорооллын зарим хэсэг;

7 баллын бүсэд - Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг бүхэлдээ, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн зарим хэсэг;

8 баллын бүсэд - I, X хороолол, Дунд гол, Туул, Сэлбэ голын сав газар, Сонгинохайрхан дүүргийн Толгойтын хэсгийн газрууд орно.

Сүүлийн 14 жилийн хугацаанд нийслэлийн нутаг дэвсгэрт 10 төрлийн гамшиг осол гарсны 3.7 хувийг газар хөдлөлт эзэлж байна. Монгол оронд газар хөдлөлтийн 6 баллаас дээшхи тохиолдол сүүлийн 20 жилд 40 гаруй удаа болсон бол 8 баллаас дээш хүчтэй газар хөдлөлт /XX зуунд/ 4 удаа болсон. Тухайлбал зөвхөн 1994–2009 оны хооронд Улаанбаатар хот болон түүний орчмын бүс нутагт бүртгэгдсэн газар хөдлөлтийн тархалтын статистик мэдээнээс үзэхэд нийтдээ 2000 гаруй сулаас дунд зэргийн хүчтэй (магнитут нь 4.2 буюу түүнээс доош хүчтэй) газар хөдлөлтийн төв тодорхойлогдсон байна.

Үүнээс эхний 10 жилийн хугацаанд (1994-2004) зөвхөн 250 орчим газар хөдлөлт тохиолдсон бол харин 2005 оны 4-р сараас эхлэн мэдэгдэхүйцээр өсөж 2000 гаруй болсон нь Улаанбаатар хотод бодит аюул учруулж болох хэмжээний тектоник тогтоц идэвхжиж эхэлж буйг харуулж байна. Үүний зэрэгцээ магнитут нь 4 хүрсэн газар хөдлөлт 2008 оны 5 сарын 6-нд Хустай нуруунд, 10 сарын 5-нд Батсүмбэрийн нутагт болон 2009 оны 3 сарын 22-нд Улаанбаатар хотоос урагш Авдар уул орчимд болсон

нь хотын оршин суугчдад мэдрэгдсэн нь нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн аюул ойрхон байгааг сануулж байна. Газар хөдлөлтийн давтамж 50 жил гэж үздэг.

Судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд газар хөдлөлтийг доорх 3 төрлөөр ангилсан байна. Үүнд:

1. Улаанбаатар хотоос хол зайд хөдлөх хүчтэй газар хөдлөлт
2. Улаанбаатар хотоос дунд зэргийн зайд хөдлөх дунд зэргийн хүчтэй газар хөдлөлт

3. Улаанбаатар хотын зөвхөн өмнө хэсгийн ойр орчимд болох сул газар хөдлөлт

Эдгээрээс нийслэл хотод хамгийн их эрсдэл учруулах нь дунд зэргийн зайд хөдлөх дунд зэргийн хүчтэй газар хөдлөлт гэж судалгаагаар үзсэн байна. 1930-1960 оны дунд үе хүртэл Сүхбаатар, Ажилчин, Октябрь, Найрамдлын /хуучин нэрээр/ районуудад томоохон хэмжээний иргэний болон үйлдвэрийн чанартай барилгууд баригдаж эхэлсэн нь газар хөдлөлтийг тооцолгүй барьсан барилгууд байсан юм.

1960 оны эцсээс баригдсан барилгуудад газар хөдлөлтийг тооцож эхэлсэн боловч зарим нэг судалгаагаар газар хөдлөлтийн чичирхийллийн хүчийг дааж чадах эсэх нь тодорхойгүй байна. Улаанбаатар хотын хувьд болзошгүй газар хөдлөлтийн улмаас хотын нийт барилга байгууламжийн 70 гаруй хувь, хүн амын 5-6 хувь нь өртөх магадлалтай ажээ. Хөдөөгийн хүмүүс хот руу ихээр нүүж ирж байгаатай холбогдон Улаанбаатар хотын хүн ам хурдацтай өсөн төвлөрөл ихсэж үүнтэй зэрэгцэн барилга байгууламж хурдацтайгаар нэмэгдэж байна.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, 120 хороогоор авч үзэхэд нийт барилгын 67% орчим нь тоосгон, үлдсэн хэсэг нь угсармал панелэн болон бусад төрлийн хийцтэй барилга эзэлж байна. 2007 онд Улаанбаатар хотын хэмжээнд явуулсан орон сууцны барилгын тооллогын дүнгээс харахад нийт барилгын 4.6 хувь нь газар хөдлөлтийн нөлөөллийг тооцоогүй зураг төслөөр баригдсан байна. Тооцоо судалгаанаас үзэхэд нийслэл хотын нийт барилгын 28.3% нь “А” хэв шинжийн, 26.7% нь “Б” хэв шинжийн, 44.9% нь “В” хэв шинжийн барилга эзэлдэг бөгөөд тэдгээрт нийт хүн амын 51.6% нь амьдарч байна.

“А” хэв шинжийн буюу тооцоогүй барьсан барилга байгууламжуудыг дүүргээр нь авч үзвэл Баянгол дүүрэгт-22.1%, Чингэлтэй дүүрэгт-34.3%, Сүхбаатар дүүрэгт-14.3%, Хан-Уул дүүрэгт-9.9%, Баянзүрх дүүрэгт-5.4, Сонгинохайрхан дүүрэгт-13.8% тус тус ноогдож байна.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын нийт 2897 барилга байгууламжийн болзошгүй хүчтэй хэлбэлзлийг даах чанарын судалгааг хийж үзэхэд “сайн” [1] барилга-683, “муу” [2] барилга-2174, үүнээс сайн барилга-25%, муу барилга-75% нь эвдрэл гэмтэлд нэрвэгдсэн барилгууд байна.

- [1] Болзошгүй хүчтэй хэлбэлзлийг хамгийн сайн тэсвэрлэх загвар;

- [2] Болзошгүй хүчтэй хэлбэлзлийг хамгийн муу тэсвэрлэх загвар;

Мөн ахуй үйлчилгээний зориулалтаар орон сууцны зориулалтыг олон арваар нь өөрчлөн даацын ханыг нураан цонх, хаалга гаргах зэргээр нэмж өргөтгөл барьж байгаагаас барилга, орон сууцны ашиглалт, хамгаалалтанд сөргөөр нөлөөлж,

болзошгүй газар хөдлөлтийн үед үүсэх эрсдлийг улам нэмэгдүүлж байна. Өнөөдрийн байдлаар нийслэлд 1 давхрын орон сууцны зориулалтыг өөрчилж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах 2452 зөвшөөрөл олгосон байна. Нийслэл Улаанбаатар хотод орон сууц, олон нийтийн зориулалтын нийт 92360 барилга байгаагийн 540 барилга нь 2004-2007 онд баригдсан байна.

2008 онд 7000 орчим айлын орон сууц ашиглалтанд оржээ. Сүүлийн 5 жилд дунджаар 5000 ажлын байр бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын болон төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан байна.

Судалгаагаар БД31-103-00-ийн 12.2-ын дагуу газар хөдлөлтөд тэсвэргүй 1961 оноос өмнө баригдсан 152 барилга, 1961-1973 онд баригдсан 111 барилга, БД31-103-00-ийн 10.2-ын дагуу газар хөдлөлтөд аюултай 1961-1973 онд баригдсан 15 барилга, 1973-1987 онд баригдсан 89 барилга Улаанбаатар хотод байдаг гэсэн тооцоо гарсан байна.

Болзошгүй газар хөдлөлтийн үед анхаарууштай бас нэг чухал асуудал нь химийн бодис ашигладаг болон худалдан борлуулдаг үйлдвэр, аж ахуй нэгжүүд юм. Ихэнх байгууллагууд нийслэлд ноёлох салхины дээд талд байрладаг бөгөөд энэ нь их хэмжээний эрсдэлийг бий болгох аюултай.

Газар хөдлөлтийн гамшиг нь тухайн хот суурин газрын нийгмийн амьдралын бүх хүрээнд нөлөөлж, дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, хүн амд эрүүл мэндийн болон ахуйн бусад төрлийн яаралтай тусламж, үйлчилгээг шуурхай хүргэх, дэд бүтцийн салбарт хойшлуулшгүй сэргээн босгох олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг.

Нэрвэгдэгсдийг аврахад 24157 аврагч, 3135 машин механизм, 3461 эмнэлгийн хүч хэрэгсэл, 26.1 мянган ор шаардагдана гэсэн тооцоог 2002 оны “Нийслэлийн иргэний хамгаалалтын төлөвлөгөө”-нд тусгасан нь тухайн жилийн тайван цагт иргэний хамгаалалтын томилгоотой байгаа хүч хэрэгслээс 4-5 дахин их хүн, хүч, техник хэрэгсэл ноогдож байна.

Дээрх тоо хэмжээ болон их хэмжээгээр гэмтсэн барилгад гарч болохуйц хүн амын эндэгдэл болон барилгын стагистик мэдээлэлд тулгуурлан хүн амын нийт эрсдэлийг 3700-12000 хүн гэж тооцоолсон байна. Болзошгүй хүчтэй хэлбэлзлийн үед Улаанбаатар хотын даац муутай угсармал, төмөр бетонон барилгууд нь хэв гажилтын түвшингийн хязгаараас хэтэрснээс нийтдээ бүрэн эвдэрч нурна гэж шинжээчид үзэж байна. Энэ нь хүний амь насанд ихээхэн эрсдэлтэй юм.

Дан ганц газар хөдлөлтийн уршгаас барилга байшин нурж хохирол үзэхээс гадна хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан багахан хэмжээний чичирхийллээс ч хүн ам олноор эрсдэж болзошгүй олон нөхцөл байдлууд бий болж байна. Тухайлбал, сүүлийн үеийн барилгуудын зураг төсөлд газар хөдлөлтийг тооцож хийсэн атал барилга угсралтын явцад нь инженер техникийн хяналт тавигддаггүйгээс нурж унасан тохиолдлууд нилээдгүй гарсан байдаг.

Мөн гүүр, цахилгаан болон усан хангамж зэрэг онцгой чухал инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтөөс үүдэн учрах хохирлыг тооцоолоогүй бөгөөд гамшигийн

нөхцөлд, тухайлбал: нэг л цахилгаан станцад дунд зэргийн эвдрэл тохиолдож хаагдахад дулаан хангамжийн бүхий л шугам сүлжээний систем зогсох юм. Газар хөдлөлтийн гамшгийн үед Улаанбаатар хотын гүүрүүдийн 60% эвдэрч нурах магадлалтай тул дэлхийн 30 гаруй орны туршлагаар богино хугацаанд угсардаг зөөврийн гүүр /өргөн нь 4.5 м, нэг алслалын урт 40 м байх бөгөөд нийтдээ 150 ул м гүүр/ авах шаардлагатай. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 2010 онд гаргасан судалгаагаар нийтийн орон сууцны 17 барилгыг нурах аюултай, дахин төлөвлөлтөнд тусгаж шинэчлэн барилгажуулах 27-н нийтийн орон сууцны барилгын жагсаалтыг гаргасан байна.

Ган, зуд, хар салхи, усны үер, гал түймэр гэх мэт байгалийн бүхий л гамшигт үзэгдэлтэй харьцуулахад маш богино хугацаанд асар их хохирол учруулдаг байгалийн үзэгдэл бол хүчтэй газар хөдлөлт юм. Хүчтэй газар хөдлөлт нь жилийн аль ч улиралд өдөр шөнө ялгалгүй агшин зуур тохиолдож богино хугацаанд хүн, байгаль, барилга байгууламжид гамшиг учруулдаг аюулт үзэгдлийн нэг юм.

Хүн төрөлхтөн 20 дугаар зуунд хүчтэй газар хөдлөлтийн улмаас учирсан хохирлыг бусад гамшгийн хэмжээтэй харьцуулахад 50.9 хувьд хүрсэн байна. Өнгөрсөн зуунд дэлхий дээр болсон хамгийн их хохирол учруулсан 30 орчим газар хөдлөлтийн уршгаар ойролцоогоор 1.5 сая хүний амь нас үрэгдэж, олон тэрбумаар хэмжигдэх эдийн засгийн хохирол учирч байсан байна.

Хүчтэй газар хөдлөлтийн учруулах хохирлын хэмжээ нь байгалийн гамшигт үзэгдлийн цар хүрээ, эрчимшилтээс хамаарахаас гадна учирч болох аюулыг урьдчилан хэрхэн тогтоосон, түүнээс хамгаалах арга хэмжээг ямар арга замаар хэрхэн шийдвэрлэснээс хамаардаг болохыг дээрхи жишээ тод харуулж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр нь Төв Азийн газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд оршдог бөгөөд судлаачдын боловсруулсан “Монголын газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг”-т нийт нутаг дэвсгэрийн 75 хувь нь 7 ба түүнээс дээш /М5К-/ газар хөдлөлт болох магадлалтай болохыг тогтоожээ. Иймд Монгол орны нийт хүн амын 50 гаруй хувь нь оршин суудаг Нийслэл Улаанбаатар хот болон суурин газруудад газар хөдлөлтийн эрсдэлийг бодит байдлаар үнэлэн, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хүн амын аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой.

Болзошгүй газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтын хувьд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, норм, дүрмийн дагуу зохион байгуулж байна.

Одоо үйлчилж байгаа Барилгын чанар байдал, аюулгүй барилгын норм ба дүрмийн эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангаж, хяналтыг сайжруулах өнөөгийн нөхцөл байдалд тохирохгүй байгаа зүйлсийг шинэчлэн, уялдуулан зохицуулж улам боловсронгуй болгох шаардлага гарч байна.

Монгол оронд газар хөдлөлтийн аюул бодитой байгаа өнөөгийн нөхцөлд хүн ам олноор төвлөрсөн хот суурингийн ихэнх барилгууд нь хуучирсан, засвар үйлчилгээ хийгдээгүй, шинээр баригдаж буй зарим барилгууд нь зохих горимын дагуу баригдсан

эсэх нь тодорхойгүй зэрэг бодит шалтгааны улмаас газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг томоохон хотуудын хэмжээнд нэн ялангуяа Улаанбаатар хотод зайлшгүй хийх шаардлага тулгарч байна.

Сүүлийн 50 жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газар хөдлөлтийн судалгаанаас харахад манай улсын хот, суурин газрын 70 гаруй хувь нь газар хөдлөлтийн 7 ба түүнээс дээш балл бүхий газар хөдлөлтийн бүс нутагт манай нийт хүн амын 80 орчим хувь нь амьдарч байна.

ШУА-ийн газар хөдлөлтийн албанаас гаргасан статистик судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд манайд жил бүр дунджаар 60 орчим мянган удаа бага хэмжээний газар чичирхийлэл болдог байна.

Газар хөдлөлтийн аюул тохиолдоход хот суурин газарт олон хүний амь нас үрэгдэх, гал түймэр гарах, цахилгаан дулаан хангамж, харилцаа холбоо тасалдах, цэвэр бохир ус холилдох, их хэмжээний нурангийн улмаас төвлөрсөн зам хаагдаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учрах, удирдлага алдагдаж эмх замбраагүй байдал үүсэх зэрэг олон бэрхшээл, хавсарсан гамшиг үүсэх бөгөөд энэ байдал удаан үргэлжилбэл иргэд орон байр, хоол хүнсээр гачигдах, улмаар төрөл бүрийн халдварт өвчин тархах зэрэг нийгмийн хүрээний олон асуудлыг хамарсан хямралт байдал бий болно.

Нийслэл хотод орон сууц олон нийтийн зориулалтын 24650 барилга байгууламж байна. Гэр хорооллын хувьд аж ахуйн аргаар баригдсан байдаг тул барилгын үндсэн мэдээлэл тодорхойгүй бөгөөд уг барилгуудын хувьд гамшгийн эрсдэлийг үнэлэх боломжгүй.

Улаанбаатар хотыг газрын хөрсний хэв шинжээр нь авч үзвэл газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй газарт тооцогдоно. Энэ бичил мужлалын зураг нь БАК-ын 1980 оны 20-р тогтоолоор одоо мөрдөгдөж буй бичил мужлалын зураг юм.

Улаанбаатар хотын нийт барилгын 67% орчим нь тоосгон, үлдсэн хэсэг нь угсармал панель болон бусад төрлийн хийцтэй барилга эзэлдэг.

Нийслэл хотын барилгын шинж чанарыг тодорхойлох хялбарчилсан загвар болон хотын статистик /нийтийн орон сууц, олон нийтийн зориулалтын 24650 барилга/ мэдээлэл дээр тулгуурласан нийт эвдэрч гэмтэж болзошгүй барилгын тоог тооцов.

Нийслэлийн барилгын чанар, аюулгүй байдлын хэлтсийн барилга байгууламжийн тоо бүртгэл, 1999-2000 онд хэрэгжүүлсэн Улаанбаатар хотын болзошгүй газар хөдлөлтийн үеийн эрсдэлийн менежментийн тогтолцоо МОН99-301 төслийн судалгаанд хамрагдсан 2837 барилга байгууламжийн талаарх судалгааны үр дүнг үндэслэн одоо байгаа 24650 барилга байгууламжийн эрсдэлийн зураглалыг гаргахад:


-Улаанбаатар хотод газар хөдлөлтийн 6 баллын үед нийтийн орон сууц болон нийтийн үйлчилгээний барилга байгууламжийн 5 орчим хувь нь эвдрэл гэмтэл үүсч нэрвэгдэж сүйрэх магадлалтай;

-Газар хөдлөлтийн 7 баллын үед нийтийн орон сууц болон нийтийн үйлчилгээний барилга байгууламжийн 25-30 орчим хувь нь эвдрэл гэмтэл үүсч нэрвэгдэж сүйрэх магадлалтай;

-Газар хөдлөлтийн 8 баллын үед нийтийн орон сууц болон нийтийн үйлчилгээний барилга байгууламжийн 75-80 орчим хувь нь эвдрэл гэмтэл үүсч нэрвэгдэж сүйрэх магадлалтай;

-Газар хөдлөлтийн 9 баллын үед нийтийн орон сууц болон нийтийн үйлчилгээний барилга байгууламжийн 95 орчим хувь нь эвдрэл гэмтэл үүсч нэрвэгдэж сүйрэх магадлалтай;

-Газар хөдлөлтийн 10 ба түүнээс дээш баллын үед баригдсан барилга байгууламж, гүүр, төмөр зам болон засмал зам, газар доорхи хоолойнууд маш ихээр эвдрэн ашиглах боломжгүй болно.




Зураг 1. Улаанбаатар хот орчимд бүртгэгдсэн газар хөдлөлтийн тоон хамаарал¹

Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилт (2018 он)


2018 онд Улаанбаатар орчмын бүс нутагт нийт 854 газар хөдлөлт (өргөргийн 46.5-49, уртрагийн 104.8-109.8) бүртгэгдсэн ба идэвхтэй голомтын бүсүүд болох Эмээлт, Мөнгөнморьт, Хустайн хагарлын бүсүүдэд газар хөдлөлтийн идэвхжилт өндөр хэвээр ажиглагдсаар байна. Харин Гүнж, Авдар, Шархайн хагарлын орчимд газар хөдлөлтийн идэвхжилт энэ онд бага байна. Энэ хугацаанд болсон газар хөдлөлтүүдийг хүчний хувьд ялган үзүүлбэл: $ml < 1$ хүчтэй газар хөдлөлт 439, $1.0 \leq ml < 2.0$ хүчтэй газар хөдлөлт 352, $2.0 \leq ml < 3.0$ хүчтэй газар хөдлөлт 54, $2.0 \leq ml < 3.0$ хүчтэй газар хөдлөлт нийт 8, $ml = 4.6$ хөдлөлт 1 удаа тус тус болсон байна. Үүнд:

- 2018 оны 08 сарын 05-нд Төв аймгийн Баянцагаан сумаас хойшоо 37 км-т магнитут нь 3.4 хүчтэй,
- 2018 оны 09 сарын 24-нд Налайх дүүргээс урагшаа 18 км-т магнитут нь 3.0 хүчтэй,
- 2018 оны 10 сарын 24-нд Гацууртын уурхайгаас баруун тийш 7 км-т магнитут нь 3.0 хүчтэй хөдлөлтүүд тус тус болжээ.

¹ ООГФХ, 2018




Зураг 2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн хүч болон тоон үзүүлэлт



Зураг 3. Улаанбаатар хот орчимд болсон нийт газар хөдлөлтийн тоог өмнөх оныхтой харьцуулж үзэхэд газар хөдлөлтийн тоо буураагүй мөн идэвхжилтэй бүс нутгуудын идэвхжилт хэвээр байна.

Энэ онд Улаанбаатар хот орчимд болсон нийт газар хөдлөлтийн тоог өмнөх оныхтой харьцуулж үзэхэд газар хөдлөлтийн тоо буураагүй мөн идэвхжилтэй бүс нутгуудын идэвхжилт хэвээр байна.



Зураг 4. 2018 онд болсон хөдлөлтийг 2017 оны газар хөдлөлтийн тоотой харьцуулсан байдал

Улаанбаатар хот болоод түүний эргэн тойрны бүс нутгуудаар сул хөдлөлтүүд нэлээд бүртгэгдсэн байна. Тухайлбал: Төв аймгийн Баянчандмань, Баянцогт, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Алтанбулаг, Өндөр дов, Баянхангай, Зуун мод, Угтаал-Цайдам, Сэлэнгийн Баянгол, Бороогийн уурхай орчим, Улаанбаатарын Асралт, Налайх, Гацуурт, Биокомбинат, Хустай, Эмээлт, Гүнж зэрэг бүсүүдэд сул газар хөдлөлтүүд бүртгэгджээ. Үүнээс хамгийн их идэвхжилтэй бүсүүдэд Хустай, Эмээлт, Мөнгөнморьтын хагарал орчмын бүсүүд орж байгаа бөгөөд бүсүүдийг тус бүрээр нь ангилж үзвэл:

- Хустайн бүсэд нийт 91 газар хөдлөлт бүртгэгдсэнээс хамгийн хүчтэй нь $M=2.2$ -той (2018/04/10) газар хөдлөлт болсон байна.
- Эмээлтийн бүсэд нийт 144 сул газар хөдлөлт бүртгэгдсэнээс хамгийн хүчтэй нь $M=2.2$ -тай (2018/07/13) газар хөдлөлт болсон байна.
- Мөнгөнморьтын бүсэд нийт 77 газар хөдлөлт бүртгэгдсэнээс магнитуд нь 2 хүрсэн газар хөдлөлт 6 удаа үүнээс хамгийн хүчтэй нь $M=2.5$ -тэй (2018/01/04) газар хөдлөлт болсон байна.

Улаанбаатар хотын шинэ идэвхтэй хагарал дээрх судалгааны ажил:

Японы Нагояагийн их сургуулийн эрдэмтэд 2018 онд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт агаар сансрын зураг болон палеосейсмологийн хээрийн судалгаа хийсний дүнд хотын баруун хойд захаас зүүн урагшаа чиглэлтэй нийт 50 орчим км үргэлжилсэн идэвхитэй хагарлыг илрүүлэн тус хагарлыг Улаанбаатар хагарал гэж нэрлэж хагарлын ерөнхий шинж болон газар хөдлөлтийн давтагдлын насыг тодорхойлох судалгааг хийж байна.



Зураг 5. Шинээр илрүүлсэн Улаанбаатар хагарлын тойм зураг

2018 онд Улаанбаатар хот болон түүний орчмын нутаг дэвсгэрт ажиглагдсан газар хөдлөлтийн тоо болон тархалтаас үзэхэд идэвхжилт явагдсаар байна гэж үзэж болно. Гол идэвхжилт Эмээлт, Хустай болон Авдар уулын хагарлын дагуу явагдаж байна. Үүний зэрэгцээ Мөнгөнморьтын хагарал, Зүүнхараа орчим урьд жилүүдээс харьцангуй илүү идэвхжилт ажиглагдаж байна.

Японы эрдэмтэд Улаанбаатар хагарал нь 7.1 магнитудын хүчтэй газар хөдлөлтөөр үүссэн бөгөөд цаашид нарийвчилсан судалгаа хийх, улмаар энэхүү хагарлаас Улаанбаатар хотод учирч болзошгүй эрсдэлийг дахин үнэлэх шаардлагатай гэсэн урьдчилсан дүгнэлтийг гаргасан.

Энэхүү шинэ хагарлын дагуу хийгдсэн урьдчилсан судалгааны ажлын үр дүнд энэ нь дөрөвдөгчийн идэвхтэй хагарал болох нь батлагдсан. Улмаар уг хагарлын шинж чанар, үүссэн нөхцөл болон түүн дээр болсон боломжит хүчтэй газар хөдлөлтүүд, давтагдлыг судлах ажлыг нарийвчлан хийх шаардлагатай гэж дүгнэж байна.

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээ

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь гамшгийн өмнөх үе шатанд хамаарах ба түүний үндсэн зорилго нь гамшгийн эрсдэлийг бууруулах замаар гамшгаас үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг багасгах буюу эрсдэлийг бууруулах, гамшгийн үед шуурхай ажиллах бэлэн байдлыг хангахад оршдог.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь болзошгүй газар хөдлөлтийн аюулын тохиолдох магадлалыг эсвэл тухайн аюулын учруулах хор уршгийг бууруулах үндсэн зорилгоор хийгдэх бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээнээс бүрдэнэ.

Эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ нь инженерийн шийдлийг хэрэглэж бодит нөхцөл байдлыг өөрчлөх эсвэл шинээр барьж байгуулах замаар эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажиллагаа болно. Эрсдэлийг бууруулах бүтцийн бус арга хэмжээ нь инженерийн бүтцийг ашиглахгүйгээр байгалийн үйл явц болон хүний зан төлөвт өөрчлөлт хийх замаар эрсдэлийг бууруулах ажиллагаа юм.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ

Эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ тухайн гамшгийн эрсдэлийн магадлал ба хор уршгийг бууруулахад чиглэсэн хийц бүтээц, инженерийн арга ажиллагааны зарим хэлбэрийг эсвэл механик өөрчлөлт, сайжруулалтыг авч хэрэгжүүлэх хэрэгцээгээр тодорхойлогдоно. Бүтцийн арга хэмжээ өртөг өндөртэй бөгөөд өргөн хүрээтэй судалгаа, тооцоо, эрх зүйн зохицуулалт, дэмжлэг шаардана. Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулахад дараах бүтцийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Тэсвэртэй барилга, байгууламж
2. Барилга, байгууламжийн норм, дүрэм
3. Хийц, бүтээцийн хувиргалт
4. Нийтийн хоргодох байрыг байгуулах
5. Илрүүлэх систем
6. Оршин байх аюулгүй байдлыг хангах дэд бүтцийг нөөцлөх

Тэсвэртэй барилга, байгууламж: Аюулын сөрөг нөлөөллийг тэсэж гарах боломжтой бүтээцийг бий болгох хамгийн сайн арга зам бол үүнийг барилга угсралтын бүх үе шатанд ийм байхаар загварчлах явдал юм. Хувь хүн, албан байгууллага, төрийн байгууллагын аюулын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь тэсвэртэй барилга, байгууламж барих асуудалд анхаарал хандуулахад чухал нөлөөтэй. Аюулыг бууруулах арга хэмжээ гэдэг утгаараа аюулд тэсвэртэй барилга байгууламж барих нь хамгийн үр ашигтай арга замыг сонгох тохиолдолд амжилттай болно. Аюулд тэсвэртэй барилга, байгууламж барих нь аюулд өртөх эмзэг байдлыг бууруулах хамгийн үр дүнтэй арга зам юм.

Барилга, байгууламжийн норм, дүрэм: Хүн амыг аюулд тэсвэртэй барилга, байгууламж барих баталгааг хангах үндсэн арга зам бол засгийн газраас барилга, байгууламжийн норм, дүрмийг гаргаж мөрдүүлэх явдал юм. Улс орондоо тохиолдож болох газар хөдлөлтийн аюулын талаар хангалттай мэдлэгтэй тохиолдолд инженерүүд тухайн аюулын сөрөг нөлөөллийг тэсвэрлэж чадах загварыг тусгасан дагаж мөрдөх барилгын норм, дүрмийг боловсруулна. Барилгын норм, дүрэм газар хөдлөлтийн төрөл бүрийн сөрөг нөлөөллийг тэсвэрлэх хийц, загварыг бий болгоход чиглэгддэг.

Хийц бүтээцийн хувиргалт: Судалгаа, эрдэм шинжилгээний ажил нь газар хөдлөлтийн аюулын талаарх нэн чухал мэдээллээр хангадаг. Энэ мэдээлэл нь эрсдэлтэй бүсийг тодорхойлох, тухайн газар дээрх хийц бүтээцийг болзошгүй аюулын хүчийг тэсвэрлэх боломжгүй байгааг тодорхойлно. Ийм хийц, бүтээцэд гурван

төрлийн арга хэмжээ авна. Нэгд, юу ч хийхгүй байх, хоёрт, түүнийг нураагаад аюулын шинэ мэдээлэлд тохируулж дахин барих, гуравт хамгийн тохиромжтой арга бол тухайн нөхцөл байдлыг тэсэж гарах байдлаар хийц бүтээцийг нь өөрчлөх юм. Үүнийг хийц бүтээцийг хүчитгэх гэж нэрлэнэ.

Нийтийн хоргодох байрыг байгуулах: Газар хөдлөлтийн аюулын учруулах тодорхой хэлбэрийн сөрөг нөлөөллийг тэсэж гарч чадахаар төлөвлөсөн хорогдох байрыг бий болгосноор хүн амын амь насыг аюулд учрахаас хамгаалж чадна. Хоргодох байр бол хүн амын ихэнхийн хувьд тэдгээрийн орон гэртээ эсвэл хаа байгаа газарт нь учирч болох аюулаас хамгаална гэж үзэх магадлал бага, бодитой бус байдлаар ихэвчлэн баригдсан байдаг. Хоргодох байр амжилттай үүргээ гүйцэтгэхэд 2 зүйл нэн чухал юм. Нэгд, аюул тохиолдохоос өмнө хүмүүс хоргодох байранд хүрэх боломжтой хугацаанд хүн амд зарлан мэдээлэл хүргэх систем байх ёстой. Хоёрт, хоргодох байр руу хэрхэн очих арга замыг хүн амд зааж сургасан байх шаардлагатай.

Илрүүлэх систем: Энэхүү систем нь хүмүүсийн мэдрэх боломжгүй газар хөдлөлтийн чичирхийллийн хэмжээг мэдэрч, аюулыг хор уршиг учруулахаас урьтаж анхааруулах, гамшиг болохоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

Оршин байх аюулгүй байдлыг хангах дэд бүтцийг нөөцлөх: Хүмүүсийн амьдрах орчин нөхцөл нийгмийн дэд бүтцээс ихээхэн хамаардаг. Өнөөдөр хүмүүсийн хоол, хүнс, ундны ус, цахилгаан, холбоо, тээвэр, эмнэлгийн үйлчилгээ зэрэг наад захын хэрэгцээ бүгд ямар нэгэн дэд бүтцээс хамааралтай байна. Энэ нь газар хөдлөлт тохиолдсон үед маш хүнд нөхцөл байдлыг үүсгэж болно. Иймд цахилгаан, эрүүл мэнд, ундны ус, дулаан, зам тээвэр, хүнсний хангалтын дэд бүтцийн нөөцийг бүрдүүлэх шаардлагатай.

Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийг бууруулах бүтцийн бус арга хэмжээ

Бүтцийн бус арга хэмжээ нь инженерийн арга хэмжээ хэрэглэхгүйгээр байгалийн үйл явц ба хүний зан төлөвийг өөрчлөх замаар эрсдэлийн магадлал, үр дагаврыг бууруулахаар тодорхойлогдоно. Бүтцийн бус эрсдэлийг бууруулах арга “хүмүүс байгальтай зохицох” арга барилаар илэрхийлэгдэнэ. Эдгээр арга хэмжээ нь санхүүгийн болоод технологийн нөөц бага шаарддаг гэдэг утгаараа хэрэглэхэд илүү хялбар юм. Олон төрлийн арга хэмжээ байдаг ч эдгээр нь дараах ерөнхий ангилалд хуваагдана². Үүнд:

1. Зохицуулалтын арга хэмжээ
2. Хүн амд мэдлэг, боловсрол олгох хөтөлбөр
3. Бүтцийн бус хувиргалт
4. Зан төлөвийн өөрчлөлт

Зохицуулалтын арга хэмжээ: Зохицуулалтын арга хэмжээ гол төлөв хүмүүсийн үйлдлийг хуулиар албадан зохицуулах байдлаар эрсдэлийг хязгаарлана. Зохицуулалтууд хувь хүн ба нийгмийн амьдралын олон зүйл дээр хэрэглэгдэх бөгөөд

² Damon P.Coppalo., Intoduction to International Disaster Management, USA, 2011, p.224

нийгмийн нийтлэг сайн сайхны төлөө зайлшгүй авах шаардлагатай арга хэмжээгээр тодорхойлогдоно. Зохицуулалтын арга хэмжээг өргөн хэрэглэдэг боловч түүнийг дагаж мөрдөх асуудал нь өртөг өндөртэй, хэрэгжилтийг хангуулах ажилтан нь сургагдаагүй, ажлаа үр дүнгүй хийх, хээл хахууль зэргээс болоод их хэмжээний асуудлыг дагуулж байдаг. Зохицуулалтын арга хэмжээнд газар ашиглах менежмент, нөөцүүдийг хамгаалалтад авах, зарим үйлчилгээг хориглох, барилгын ашиглалтын зохицуулалт, зориулалтыг өөрчлөхгүй ашиглах, хортой болон аюултай материалын менежмент, аюулгүй байдлын стандарт, байгалийн нөөцийн болон хүрээлэн буй орчны хамгаалалтын болон эдийн засгийн зохицуулалт зэрэг нь хамаардаг.

Хүн амд мэдлэг, боловсрол олгох хөтөлбөр: Хүн ам нь тулгарч буй аюулын талаар мэдлэгтэй мөн аюулын эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээг зааж сургасан тохиолдолд аюулын нөлөөллөөс өөрийгөө хамгаалах бүрэн боломжтой. *Хүн амд боловсрол олгох хөтөлбөрт* аюулыг бууруулах ба бэлэн байдлыг хангах арга хэмжээнүүд аль аль нь тусгагдана. Мэдээлэлтэй хүмүүс гамшиг тохиолдохоос өмнө аюулыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж учирч болох эрсдэлийг тохиромжтой арга замаар бууруулж чадна. Хүн ам бэлэн байдлыг хангах арга хэмжээнд оролцсоноор гамшгийн дараах хор уршгийг арилгах үйл ажиллагаанд мөн сургагдаж байдаг. Зарлан мэдээлэх систем нь аюулын эрсдэл тодорхой арга хэмжээ авах шаардлагатай түвшинд хүрсэн гэдгийг хүн амд мэдээлнэ. Газар хөдлөлтийн хувьд зарлан мэдээлэх системийг бүрдүүлэх асуудал маш чухлаар тавигдана. Эрт зарлан мэдээлэх системийг сайжруулах НҮБ-ын платформ эрт зарлан мэдээлэх системийг үр дүнтэй байлгахад нөлөөлөх 4 хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлсон:

- Хүн амд нүүрлэж буй эрсдэлийг урьдчилж мэдэх
- Эдгээр эрсдэлд техникийн хяналт ба зарлан мэдээллийг бий болгох
- Эрсдэлүүдэд тохирсон ойлгомжтой хэлбэрээр зарлан мэдээллийг хүргэх
- Хүмүүст тохирсон хариу арга хэмжээ авах мэдлэг олгох, чадавх бүрдүүлэх

Зарлан мэдээлэх систем бол аюулыг тодорхойлох ба шинжлэх, илрүүлэх системийн үр дүн, сэрэмжлүүлэх мэдээллийг хүргэх байдал болон хүн амын боловсролоос хамаардаг.

Эрсдэлийн зураглал нь тодорхой нэг газарт тохиолдож болох газар хөдлөлтийн аюулыг магадлал, хор уршгийн хамт газрын зурагт дүрслэн харуулна. Эрсдэлийн зураг бол газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндэс бөгөөд эрсдэлийг бууруулах хамгийн үр дүнтэй хэрэгсэл юм. Эрсдэлийн зургийг ашиглаад засгийн газар ба бусад байгууллагууд хамгийн их хэрэгцээтэй байгаа газарт нөөцөө хувиарлах, ослын урьдчилсан төлөвлөгөө боловсруулах, өндөр эрсдэлтэй газарт шаардлагатай хүн хүчийг төлөвлөх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Бүтцийн бус хувиргалт: Үндсэн бүтцийг нь өөрчлөхгүйгээр бага хэмжээний хувиргалт хийгээд эд хөрөнгөд учирч болох эрсдэлийг бууруулах олон хэлбэрүүд байдаг. Энэ хүрээнд болзошгүй гамшгийн аюулын үед хүн ам, эд хөрөнгөнд хохирол учруулж болох тавилга, эд зүйл, цахилгаан хэрэгслийг бэхлэх арга хэмжээ хамаарна.

Зан төлөвийн өөрчлөлт: Иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлж хувь хүмүүсийн зан төлөвийг өөрчилснөөр хүн амд учирч болох эрсдэлийг бууруулах арга хэмжээ үр дүнтэй болно. Хүн амд боловсролыг үр дүнтэй олгосон тохиолдолд зан төлвийн өөрчлөлт хийгдэх боломж бүрдэнэ. Татварын хөнгөлөлт эсвэл мөнгөн тэтгэмж нь зан төлвийн өөрчлөлт амжилттай явагдахад нөлөөлнө.

Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ

Бэлэн байдлыг хангах арга хэмжээний зорилго нь гамшгийн дараа юу хийх ёстой, хэрхэн үүнийг хийхийг мэдэх болон гамшгийн дараа хийх аливаа арга хэмжээг үр дүнтэй явуулах техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байхад оршино. Энэхүү үйл явц хангалттай хэмжээнд хүрэхээс өмнө олон жилийг зарцуулах тул урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Бэлэн байдлыг хангах нь урьдчилж үр дүнтэй арга хэмжээ авснаар хор уршгийг арилгах, яаралтай тусламжийг хүргэх ажиллагааг шуурхай, оновчтой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх учраас аюулаас учрах сөрөг нөлөөллийг бууруулдаг.

Бэлэн байдлыг хангах арга хэмжээ оролцогчоосоо хамаараад 2 бүлэгт хуваагдана. Нэгдүгээр бүлэгт нь төрийн байгууллага энэ хүрээнд онцгой байдлын, яаралтай тусламжийн байгууллага болон бусад гамшгийн үед үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь хамаарна. Хоёрдугаар бүлэгт нь иргэд, олон нийт болон бизнес эрхлэгчид хамаарна.

А. Төрийн байгууллагын бэлэн байдал

Аливаа улс орны иргэд гамшиг тохиолдсон үед засгийн газар бидэнд дэмжлэг үзүүлнэ гэсэн хүлээлттэй байдаг. Үүний зэрэгцээ ихэнх засгийн газар гамшиг тохиолдвол хор уршгийг арилгах арга хэмжээг төрийн байгууллагууд хэрэгжүүлэх зохицуулалтыг хийдэг. Засгийн газрын хүн амаа хамгаалах арга хэмжээг хэрхэн авч байгааг болон хэр үр дүнтэй удирдаж байгаа нь гамшиг тохиолдсон үед бодитоор шалгагдана. Энэ шалгалтыг давж гарах эсэх нь гамшгаас хамгаалах бэлэн байдлаа хэрхэн хангаснаас хамаарна. Төрийн байгууллагын бэлэн байдлын хүрээнд хамаарах арга хэмжээ нь төлөвлөлт, дасгал сургууль, сургалт, техник хэрэгсэл болон эрх мэдэл гэсэн 5 ерөнхий хэсэгт хуваагдана.

Нэг. Төлөвлөлт: Засгийн газар, төрийн байгууллагуудын хувьд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийн ач холбогдол маш өндөр. Учир нь газар хөдлөлт нь гэнэтийн бөгөөд маш эмх замбараагүй байдлыг бий болгодог үйл явц тул энэ цаг үед хэрхэн ажиллах төлөвлөлтийг урьдчилж хийх шаардлагатай. Энэхүү төлөвлөлтөд засгийн газар, төрийн байгууллагад ямар хэрэгцээ, шаардлага үүсч болох мөн үүнийг хэрхэн шийдвэрлэх, ямар техник хэрэгсэл ашиглах, бусад ямар талууд туслах зэргийг тодорхой тусгасан байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь газар хөдлөлтийн үед хор уршгийг арилгах ажиллагаанд оролцох хүмүүс, байгууллагын хаана, хэзээ ямар үүрэг гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нь хүмүүс болон байгууллага тус бүрээр нарийвчлан тодорхойлсон баримт бичиг юм. Энд мөн иргэд ба барилга, байгууламжууд гамшгийн

үед хэрхэн хамгаалагдсан байхыг тодорхойлж өгнө. Энэ нь тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл болон нөөцийн бэлэн байдлыг харуулсан жагсаалтыг агуулна.

Энэ төлөвлөгөөг засаг захиргааны бүх түвшинд хийх шаардлагатай. Түүнээс гадна бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд ийм төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөнүүд нийт хүн амын гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааны зохицуулалтыг сайжруулах үүднээс хоорондоо уялдаатай байх шаардлагатай. Түүнээс гадна бүс нутгийн болон олон улсын төлөвлөгөө байх шаардлагатай.

Бүх түвшинд энэ төлөвлөгөөг боловсруулахдаа газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд оролцох бүх талууд оролцох ёстой, ингэснээр талууд төлөвлөгөөний талаар нэгдсэн ойлголттой болохоос гадна төлөвлөгөөнүүд хоорондоо уялдах боломж бүрдэж, хэрэгжихэд төвөгтэй байдлыг арилгадаг.

Энэ төлөвлөгөө байгууллага бүр юу хийх ёстойг тодорхойлохоос гадна ямар нөхцөл байдалд байгууллага бүр хэрхэн уялдаж ажиллахыг тодорхойлно. Тухайн орон нутгийн иргэдэд учирч болох бүх аюулын үед ажиллахаар төлөвлөгөөг боловсруулах үр дүнтэй байдаг.

Хоёр. Дасгал, сургууль: Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэг чухал зүйл нь байнгын дасгал, сургууль юм. Хор уршгийг арилгах дасгал, сургуулиар онцгой байдал үүссэн үед болон гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд оролцох Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан бүх талууд ямар нэг зүйл тохиолдохоос өмнө төлөвлөгөөний дагуу үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх ажиллагааг явуулна. Дасгал, сургууль талуудын үүргээ гүйцэтгэх бэлэн байдлыг хангах төдийгүй тайван цагт төлөвлөгөөнд байгаа тодорхойгүй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх боломжийг олгоно.

Дасгал, сургууль нь гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд оролцогч талуудыг хооронд нь уулзах боломжийг олгож бэлэн байдлыг хангахад чухал үүрэгтэй. Ингэснээр эдгээр байгууллагууд гамшгийн үед хэрхэн хамтарч ажиллах, чиг үүргээ хэрхэн уялдуулах, нөөцийг хэрхэн хувиарлах талаар мэдээлэлтэй болно.

Дасгал, сургуулийн цогц хөтөлбөр тухайн газар нутаг, хүн амын хэрэгцээнд тулгуурлаж хийгдэнэ. Ийм хөтөлбөр нь логик уялдаатай, хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн, цогц, цаашид сургамж, туршлага болохуйц байх гэсэн 4 үндсэн бүрэлдэхүүн хэсгийг агуулна. Дасгал сургуулийн цогц хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүр дараах жагсаалтад тодорхойлогдсон.

1. *Сургууль:* тодорхой хяналт, удирдлагатайгаар газраар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах бүрэлдэхүүний чиг үүргийг шалгах ба дадлага хийх арга.

2. *Ширээний дасгал ажил:* хялбаршуулсан цагийн байдал үүсгэж газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй албан тушаалтнууд дасгал ажил хийнэ. Энэ үед төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргээ талуудаас гүйцэтгэхийг шаардахаас илүүтэйгээр энэ дасгал ажил ямар асуудал, сул талууд учирч болохыг нэг бүрчлэн хэлэлцэж дүгнэлт гаргахад чиглэнэ. Энэ дасгал ажлыг зохицуулагч чиглүүлж хийнэ.

3. Мэргэжлийн дасгал ажил: Мэргэжлийн дасгал ажил нь хор уршгийг арилгах арга хэмжээ авах шаардлагатай цагийн байдлыг өгч гамшгийн менежерүүдийн ур чадварыг шалгах ба дадлагажуулах арга хэмжээ юм. Аль нэг чиг үүрэг ба үйл ажиллагааг шалгадаг сургуулиас ялгаатай нь мэргэжлийн дасгал ажлаар тухайн нөхцөл байдалд хор уршгийг арилгах хүрээнд хамтдаа хийх бүхий л арга хэмжээг хэрэгжүүлж шалгадаг.

Мэргэжлийн дасгал ажил нь ширээний дасгал ажил шиг хийх ажиллагааг хэлэлцэхгүй харин өөрсдийн чиг үүргээ илүү хүндрүүлсэн цагийн байдалд хэрхэн гүйцэтгэхийг хугацаа зааж явуулж туршдаг. Гэхдээ мэргэжлийн дасгал ажлын хүрээнд төлөвлөгөөг бүхэлд нь ажиллуулж, бүх оролцогч талууд, төлөвлөгөөний бүх бүрэлдэхүүн хэсгийн ажиллагааг шалгахыг шаардахгүй.

4. Иж бүрэн сургууль: Иж бүрэн сургууль нь бодит гамшгийн нөхцөл байдалтай ойртуулсан нөхцөлд явагдах цагийн байдалд суурилсан арга хэмжээ юм. Энэ үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан бүх талууд оролцож гамшгийн нөхцөл байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах тоног төхөөрөмжийг бүрэн ажиллуулж явагдана. Энэ сургалтаар хор уршгийг арилгах ажиллагааны чадавхыг бүрэн хэмжээгээр шалгана.

Гурав. Сургалт: Сургалт нь төрийн байгууллагын бэлэн байдлын гурав дахь бүрэлдэхүүн хэсэг юм. Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн сургагдаж бэлтгэгдээгүй байх нь өөрсдийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй төдийгүй гамшгийн үед үүргээ амжилттай гүйцэтгэх боломжгүй юм.

Сургалтыг нийтлэг хэв маягаар явуулах боломжгүй. Гамшгийн голомтод нэн тэргүүнд очиж ажилдаг цагдаа, онцгой байдал, эмнэлгийн түргэн тусламжийн ажилтнуудын хувьд бол гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд шаардагдах мэргэжлийн зааварчилгаа нь илүү техникийн байх тул хаана байгаагаас үл хамааран зарим нэг сургалтын үндсэн стандарттай байж болно.

Дөрөв. Техник хэрэгсэл: Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь гамшигт эд хөрөнгө өртөж эвдрэх хэмжээ болон хүний амь нас эрсдэх тоог бодитой бууруулахад чухал үүрэгтэй. Эдгээр нь мөн гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдын аюулгүй байдлыг хангахад ашиглагддаг. Техник хэрэгслийн төрлүүдийг 1-р хүснэгтэд үзүүллээ.

1-р хүснэгт. Аврах ажиллагааны техник хэрэгслийн төрлүүд

№	Техник хэрэгслийн төрөл	Хэлбэр
1	Гал унтраах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл (машин, трактор, завь, нисдэг тэрэг, онгоц) Багаж хэрэгсэл /гал унтраагуур, галын хошуу, дүрсжүүлэх багаж/ Бодис Хялбарчлах техник хэрэгсэл /шат, өргөгч, таслагч/
2	Аврах ажиллагааны техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	Нурсан барилга, уурхай зэрэгт тулгуур хийх болон бусад дэмжлэг үзүүлэх багаж Хүрэхэд хэцүү байрлалаас нэрвэгдэгчийг аврахад ашиглах тээврийн хэрэгсэл ба багаж хэрэгсэл Ухах, таслах, тараах болон бусад нарийн ажиллагааны багаж Дүрслэх, сонсох болон байрлал тогтоох багаж хэрэгсэл /тусгай сургагдсан амьтан энд хамаарна/ Эмнэлгийн болон онцгой байдлын үед тусгай мэргэжлийн тусламж үзүүлэх багаж /мэс заслын ор гэх мэт/
3	Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	Хэт халуун, хүйтнээс хамгаалах, Хүчилтөрөгчөөр хангах, Хими, биологи, цацрагийн аюулаас хамгаалах, Дэлбэрэлт, сумнаас хамгаалах, Нүдийг хамгаалах, Дуу чимээнээс хамгаалах, Дэлбэрэх аюултай хийнээс хамгаалах, Ухаан алдахаас хамгаалах
4	Аюултай бодис, материалаас хамгаалах хэрэгсэл	Тусгай зориулалттай гал унтраах төхөөрөмж Тусгай зориулалттай нэг бүрийн хамгаалах хэрэгсэл Тусгаарлах буюу битүүмжлэх тоног төхөөрөмж Саармагжуулах тоног төхөөрөмж Цэвэрлэх тоног төхөөрөмж Халдваргүйжүүлэх тоног төхөөрөмж
5	Гамшгийн үеийн эмнэлгийн тусламжийн хэрэгсэл	Нэрвэгдэгсдийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл Гамшгийн голомт руу эмнэлгийн ажилтныг зөөх тээврийн хэрэгсэл Хөдөлгөөнт болон хээрийн эмнэлэг болон цогцос хадгалах байр Эм, эмнэлгийн бүтээгдэхүүн нөөцлөх болон бусад шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж
6	Харилцаа холбооны болон зарлан мэдээлэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	Харилцаа холбооны: <ul style="list-style-type: none"> • Радио • Утас, үүрэн утас • Интернет • Факсийн аппарат • Видео төхөөрөмж Зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх системийн: <ul style="list-style-type: none"> • Шуурхай дуудлага хүлээн авах систем 101, 105 • Утсан холбоонд суурилсан зарлан мэдээлэх систем • Богино долгионы радио • Дуут дохио өгөх, нийтэд зарлах систем • Дохио /электрон болон энгийн, суурин болон хөдөлгөөнт/ • Интернетэд суурилсан сэрэмжлүүлэг • Гамшгийг хүн амд мэдээлэх систем
7	Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааг дэмжих бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	Гамшгийн үед хүн амыг хооллох Тээвэрлэх Хадгалах, хайх, мэдээллийг хүргэх Аюулгүй байдлыг хангах болон хамгаалах Хүрээлэн буй орчныг хянах Хоргодох

Тав. Эрх мэдэл: Төрийн байгууллагын бэлэн байдлын сүүлийн бөгөөд хамгийн чухал зүйл бол эрх мэдэл олгогдсон байх явдал юм. Газар хөдлөлтийн хор уршгийг арилгах ажиллагаанд төрийн болон хувийн хэвшлийн маш олон тооны оролцогч талууд оролцоно. Иймд эдгээр оролцогч талуудыг гамшгийн нөхцөл байдал үүссэн үед төрийн зүгээс өөрсдийн үүргээ үр дүнтэй гүйцэтгэх эрх мэдэл олгогдсон байх нь хамгийн чухал.

Гамшгийн хор уршгийг арилгах үүрэгтэй төрийн байгууллага болон түүний чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл нь орон тооны ажилтантай, тодорхой төсөвтэй байснаар баталгаажна. Гамшгийн үед нийгмийн суурь үйлчилгээ болон өргөн хэрэгцээний бараа, материалын үнэ хөлс огцом нэмэгдэх учраас урьдчилж эрх зүйн орчин бүрдүүлэхгүйгээр энэ үед үүсэх нөхцөл байдлыг удирдах боломжгүй болж эмх замбараагүй байдал үүснэ. Иймд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцааг зохицуулсан эрхзүйн орчныг бүрдүүлж, тэдгээрийн гамшгийн үед гүйцэтгэх үүрэг, эрх мэдлийг тодорхойлж өгөх шаардлагатай. Энэхүү эрх мэдлийг гамшгийн үед хэрхэн хэрэгжихийг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж өгсөн байна.

Б. Хүн амын/иргэдийн бэлэн байдал

Газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах ажиллагааг явуулах хүн хүч, нөөц хүрэлцэхгүй байх, тэдний чадавхаас хэтрэх нөхцөл байдал үүсч болно. Ийм нөхцөл байдал үүсэх үед хүн амыг өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан хор уршгийг арилгах ажиллагааг явуулах шаардлага үүсэх учраас хүн амын бэлэн байдлыг хангах асуудал их чухал юм.

Иргэдийн бэлэн байдлыг хангах гол зүйл бол иргэдийн сургалт юм. Сургалт нь аюул, эрсдэлийн талаарх хүн амын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, зан төлөвийг өөрчлөх болон зарлан мэдээлэх гэсэн 3 үндсэн зорилготой байна.

Нэг. Хүн амын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх: Аюул, эрсдэлийн талаар иргэдэд мэдлэг олгох эхний алхам бол тэдгээрийн бэлэн байдлын талаарх буруу ойлголтыг өөрчлөх явдал юм. Иймд иргэдийн аюул, эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл явц эрсдэлийн шалтгаан нь юу вэ гэдгийг иргэдэд хэлж өгөх төдийхнөөр хязгаарлагдахгүй маш өргөн хүрээг хамрана. Иргэд эрсдэл өөрсдөд нь хэрхэн нөлөөлөх, яагаад тэд эрсдэлтэй байгаа, хэзээ, хаана аюул тохиолдож болох талаар мэдлэгтэй байх ёстой юм.

Хоёр. Зан төлөвийг өөрчлөх: Иргэд аюулын талаар мэдлэгтэй болохтой зэрэгцээд тэдгээрийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулахад нь туслах мэдээллийг хүлээн авах байдал нь нэмэгддэг. Энэ арга хэмжээ зорилго, хэзээ хийхээс хамаараад 4 ялгаатай агуулгаар иргэдэд хүрнэ. Үүнд:

- Гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах зан төлөв;
- Гамшгийн өмнөх бэлэн байдлыг хангах зан төлөв;
- Гамшгийн дараа хор уршгийг арилгах зан төлөв;

- Гамшгийн дараа сэргээн босгох зан төлөв.

Гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах зан төлөв төлөвшүүлэхэд чиглэсэн иргэдийн сургалтаар болзошгүй аюул, эрсдэлийн талаар мэдлэгтэй хүмүүст тухайн эрсдэл, эмзэг байдлыг бууруулахад нь туслах тодорхой арга замуудын талаар зааж сургах хэрэгтэй. Тухайлбал, газар хөдлөлтийн эрсдэлтэй газарт тавилга, эд хогшлоо хэрхэн аюулгүй болгох аргыг зааж болно.

Гамшгийн өмнөх бэлэн байдлыг хангах зан төлөв төлөвшүүлэхэд чиглэсэн иргэдийн сургалт гамшиг болохоос өмнө тэд юу хийж чадах талаар мэдээлэл өгөхөд чиглэгдэнэ. Энэ хүрээнд тодорхой нөөцтэй болох, айл өрхийн болон олон нийтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх, уулзах аюулгүй газар товлох гэх мэт арга хэмжээ хамаарна.

Гамшгийн дараах хор уршгийг арилгах зан төлөв эзэмшүүлэх сургалтаар аюул тохиолдсон даруйд хэрхэн ажиллах, аюулгүй байдлаа хангах талаарх мэдлэг олгох хэрэгтэй. Тухайлбал, зарлан мэдээллийн дохиогоор хэрхэн ажиллах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд хэрхэн оролцох зэрэг нь хамаарах ба энэ төрлийн сургалт найз нөхөд, гэр бүл, хөршдөө болон өөртөө хэрхэн анхны тусламж хүргэх, гамшгийн үед онцгой байдлын байгууллагын чадавх, нөөц хүрэлцэхгүй үед хэрхэн бие дааж арга хэмжээ авах чадавх эзэмшүүлэхэд чиглэнэ.

Гамшгийн дараах сэргээн босгох зан төлөвийг олгох сургалт нь гамшгийн дараа иргэд хэрхэн амьжиргаагаа сэргээхийг заахад чиглэгдэнэ.

Гурав. Зарлан мэдээлэх: Гамшгаас хамгаалах иргэдийн сургалтын эцсийн зорилго бол зарлан мэдээлэх юм. Зарлан мэдээлэх нь түүнийг хүлээн авч буй иргэдэд эрсдэлийн нөхцөл байдал өөрчлөгдсөнийг ойлгуулах, тохиромжтой арга хэмжээ авах талаар албан ёсны зааварчилгаагаар хангахад хэрэглэгдэнэ.

Зарлан мэдээлэх систем ба мэдээлэл нь түүнийг хүлээн авах хүний хаана, ямар нөхцөлд байгаагаас үл хамаарч мэдээлэл хүрч байхаар зохион байгуулагдах ёстой. Зарлан мэдээлэх нь иргэдэд зөвхөн болзошгүй аюулын талаар мэдээлэл өгөөд зогсохгүй тухайн аюулаас өмнө, үед болон дараа юу хийх зааврыг өгөх хэрэгтэй.

Хүн амд зарлан мэдээлэх нь дан мэдээлэл төдийгээр хязгаарлагдахгүй. Зарлан мэдээлэх нь тухайн хүн ам, аюул, орчиндоо нийцсэн иж бүрэн системд суурилна. Зарлан мэдээлэх цогц системд дараах зүйлүүд хамаарна:

- Болзошгүй аюулыг илрүүлэх. Энэ үе шатанд урьдчилж байрлуулсан мэдрэх болон илрүүлэх системийн тусламжтайгаар газар хөдлөлтийн чичирхийллийн мэдээлэл цуглуулах ажиллагаа хамаарна.

- Аюулын тохиолдох магадлалыг үнэлэх. Эдгээр цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлаж газар хөдлөлт тохиолдох магадлал болон түүнд иргэд хэрхэн өртөж болохыг үнэлнэ.

- Тухайн аюулд өртөх магадлалтай эрсдэлтэй иргэдийг тодорхойлох. Зарлан мэдээлэх систем тухайн эрсдэлтэй хүн амд чиглэгдэж хийгдэх нь хамгийн үр дүнтэй байдаг.

- Хүн амд хүргэх. Хамгийн төвөгтэй зүйл бол хүн амд зарлан мэдээллийг хүргэх юм. Энийг шийдэх арга зам бол зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дасгал

сургуулийг иргэдэд зохион байгуулж тэдгээрийг урьдчилж мэдлэгтэй болгох явдал юм.

- Тохиромжтой арга хэмжээ авах. Зарлан мэдээлэх дохио өгснөөр иргэд тухайн аюулын онцлогт тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх чадвартай байх хэрэгтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хийсэн шинжилгээ

Энэ хэсэгт газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр Улаанбаатар хотын хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний өнөөгийн байдалд шинжилгээ хийлээ.

Газар хөдлөлт нь хот суурин газарт хамгийн их сүйтгэл учруулдаг хор уршиг ихтэй байгалийн гамшиг. Энэхүү том цар хүрээтэй гамшгийн үед нутгийн захиргааны байгууллагын үүрэг ихээхэн чухал юм. Орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах шуурхай арга хэмжээнүүдийг тусгаж, эдгээр үйл ажиллагаанд оролцогч талуудын гамшгийн үед гүйцэтгэх үүрэг, харилцан ажиллагааг нарийвчлан авч үздэг. Энэ утгаараа энэ шатны төлөвлөгөө улсын түвшний төлөвлөгөөтэй харьцуулахад ач холбогдол өндөртэй.

2.1.1. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө

Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний 2-р бүлэгт гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ гэж тодорхойлсны дагуу “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд 4 бүлэгт хамаарах 60 арга хэмжээ тусгагдсаныг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөний дагуу 2016-2020 онд хийж гүйцэтгэх юм.

Монгол Улсын Засгийн газраас газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн дараах хямралыг богино хугацаанд гэтлэн давах асуудлыг зохицуулах чиглэлээр Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах Байнгын ажиллагаатай зөвлөл”-ийг байгуулан, хэд хэдэн үе шаттай төлөвлөгөө гарган нилээд ажлыг хийгээд байна. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээг тодорхойлохдоо тус зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө”, Засгийн газрын 2014 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “**Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө**” (2014-2016) болон Засгийн Газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан Газар

хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (2016-2020)-нд тус тус шинжилгээ хийлээ.

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй арга хэмжээний өнөөгийн байдлыг өмнөх бүлэгт тодорхойлсон эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах дараах арга хэмжээнүүдээр авч үзэж шинжилсэн.


а/ Урьдчилан сэргийлэх/эрсдэлийг бууруулах

- Эрсдэлийн үнэлгээ
- Аюулыг бууруулах бүтцийн арга хэмжээ
 - Тэсвэртэй барилга, байгууламж
 - Барилга, байгууламжийн норм, дүрэм
 - Хийц, бүтээцийн хувиргалт
 - Илрүүлэх систем
- Аюулыг бууруулах бүтцийн бус арга хэмжээ
 - Зохицуулалтын арга хэмжээ
 - Хүн амд мэдлэг, боловсрол олгох хөтөлбөр
 - Бүтцийн бус хувиргалт
 - Зан төлөвийн өөрчлөлт
- Бэлэн байдал хангах
 - Төлөвлөлт,
 - Дадлага сургууль,
 - Сургалт
 - Техник хэрэгсэл
 - Эрх зүйн орчин
 - Хүн амын мэдлэг

Дээр авч үзсэн 2011-2016 онд , 2016-2018 онуудад хэрэгжсэн Засгийн газрын 2 тогтоолын хүрээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг тодорхойлбол:

- Урьдчилан сэргийлэх & Эрсдэлийг бууруулах: 34 арга хэмжээ буюу 27%
Үүнээс:
 - Эрсдэлийн үнэлгээ (2 арга хэмжээ буюу 6%)
 - Бүтцийн аюулыг бууруулах арга хэмжээ (20 арга хэмжээ 59%)
 - Бүтцийн бус аюулыг бууруулах арга хэмжээ (12 арга хэмжээ 35%)
 - Бэлэн байдлыг хангах: 92 арга хэмжээ буюу 73%
Үүнээс:
 - Засгийн газрын буюу төрийн байгууллагын бэлэн байдлыг хангах (67 арга хэмжээ 73%)
 - Олон нийт, иргэдийн бэлэн байдлыг хангах (25 арга хэмжээ 27%)
- Эдгээрийг арга хэмжээ бүрээр нь задалж авч үзэхэд дараах байдалтай байна.

Хэрэгжүүлсэн ажлын тоо



Зураг 6. 2011-2015 онд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ


Дээрх зургаас харахад газар хөдлөлтийн гамшгийн талаарх эрх зүйн орчныг сайжруулах, аюулыг бууруулах бүтцийн арга хэмжээ болон дадлага, сургууль хийх зэргийг харьцангуй олон удаа, харин газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг үнэлэх, төлөвлөх, хүн амын мэдлэгийг нэмэгдүүлэх болон зарлан мэдээллийн чиглэлээр харьцангуй цөөн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Цаашид буюу 2016-2020 онд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлд хийх ажлыг Засгийн Газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (2016-2020)-нд шинжилгээ хийж тодорхойлбол:

- Урьдчилан сэргийлэх & Эрсдэлийг бууруулах: 28 арга хэмжээ буюу 49%
 - Эрсдэлийн үнэлгээ (3 арга хэмжээ 11%)
 - Бүтцийн аюулыг бууруулах (15 арга хэмжээ буюу 53%)
 - Бүтцийн бус аюулыг бууруулах (10 арга хэмжээ буюу 36%)
- Бэлэн байдлыг хангах: 29 арга хэмжээ буюу 51%
 - Засгийн газрын буюу төрийн байгууллагын бэлэн байдлыг хангах (17 арга хэмжээ буюу 59%)
 - Олон нийт, иргэдийн бэлэн байдлыг хангах (12 арга хэмжээ буюу 41%)

Энэ хүрээнд хийгдэх арга хэмжээ бүрээр нь задалж авч үзэхэд дараах байдалтай байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо



Зураг 7. 2016-2020 онд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Ирэх 5 жилд манай улс газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд аюулыг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ, тоног төхөөрөмж, иргэдийн боловсрол, сургалт болон зарлан мэдээллийн арга хэмжээнүүдийг түлхүү хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах байнгын ажиллагаатай зөвлөл”-ийн 2018 оны төлөвлөгөө болон гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ. Төлөвлөгөөнд эрх зүйн орчинг бүрдүүлэх, сайжруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих, гамшгийн үеийн удирдлага, бэлэн байдал, аврах үйл ажиллагааг дэмжих, боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийг сургаж дадлагажуулах гэсэн 4 багц чиглэлээр нийт 69 арга хэмжээ тусгагдсан байна.

2018 онд хэрэгжсэн Засгийн газрын 2 тогтоолын хүрээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг тодорхойлбол:

Хүснэгт 2. 2018 онд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

№	Бүлэг	Арга хэмжээ			Дундаж хэрэгжилт
		Нийт	Хэвийн	Анхаарах	
1	Нэг. Эрх зүйн орчинг бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр	14	13	1	80%
2	Хоёр. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлээр	25	23	2	86%
3	Гурав. Гамшгийн үеийн удирдлага, бэлэн байдал, аврах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр	16	13	3	84%

4	Дөрөв. Боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийг сургаж дадлагажуулах чиглэлээр	14	14	-	100%
Нийт		69 / 100%	63 / 91.3%	6 / 8.7%	87%

Дээрх хүснэгтээс харахад өмнөх онуудад авсан арга хэмжээтэй харьцуулахад газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг дэмжсэн ажил үйлчилгээ, боловсон хүчин бэлтгэх мэргэшүүлэх, эрх зүйн орчны бүрдүүлэлт зэрэг нь нилээд ахисан үзүүлэлттэй гарсан байна.

Уг төлөвлөгөөнд туссан газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг өмнөх бүлэгт тодорхойлсон дараах үзүүлэлтүүдээр шинжлэхэд давхардсан тоогоор 74 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх чиглэлээр 19 буюу 25,7%
Эндээс: Аюулыг бууруулах бүтцийн арга хэмжээ 10 буюу 13,5%
Аюулыг бууруулах бүтцийн бус арга хэмжээ 9 буюу 12,2%
- Бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр 55 арга хэмжээ буюу 74,3%
Эндээс: Төлөвлөлт - 22 буюу 29,7%
Дасгал сургууль – 5 буюу 6,8%
Сургалт – 10 буюу 13,5%
Техник хэрэгсэл – 10 буюу 13,5%
Эрх зүйн орчин – 8 буюу 10.8%.

Дээрх авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон үзүүлэлтийг 8-р зургаар харуулав.

Төлөвлөж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо




Зураг 8. МУ-ын ГхГУСБАЗ-ийн 2018 онд төлөвлөж, хэрэгжүүлэх арга хэмжээ

Зургаас харахад газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээ 75 орчим хувийг эзэлж байгаагийн 40 орчим хувь нь төлөвлөлт, 27 хувь нь сургалт, дадлага сургууль, 18 хувь нь техник хэрэгсэл, үлдсэн 12,5 хувь нь эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ эзэлж байна.

Төлөвлөж хэрэгжүүлсэн эдгээр ажлын гүйцэтгэлд шинжилгээ хийсэн байдлыг дараах зургаар харууллаа.

**Төлөвлөсөн ажлын биелэлт,
/%-аар/**



Зураг 9. МУ-ын ГхГУСБАЗ-ийн 2018 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлт

Дээрх зургаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг харахад Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ сайн буюу дунджаар 87%-тай үнэлэгдсэнийг харж болохоор байна. Тухайлбал, дасгал сургууль, сургалт, техник хэрэгслийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл хангалттай сайн гэж үнэлэгджээ.

А. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл нь салбар зөвлөлтэй байхаар холбогдох журамд тусгаагүй хэдий ч нийслэл хот болон 21 аймагт газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл ажиллаж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Судалгааны ажлын хүрээнд Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлээ. Төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр нийт 35 ажил үйлчилгээ туссан байна. Төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээг дээрх үзүүлэлтүүдээр ангилж 10–р зургаар харуулав.

Төлөвлөж, хэрэгжүүлсэн арга хэмжээ




Зураг 10. Нийслэлийн ГхГУСБАЗ-ийн 2018 онд төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дээрхээс харахад нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ 26%, бэлэн байдлыг хангах, дээшлүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ 74%-ийг эзэлж байна. Энд, төлөвлөлт (нийт ажлын 29%), ард иргэдийг сургах, дадлагажуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (нийт ажлын 23%) дийлэнх хувийг эзэлж байгаа нь салбар зөвлөлийн ажил нь үйл ажиллагаанд чиглэгдэж байгаа нь харагдаж байна.

Нийслэлийн салбар зөвлөлийн хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг дараах зургаар харуулав.

Төлөвлөсөн арга хэмжээний биелэлт /хувиар/



Зураг 11. Нийслэлийн ГхГУСБАЗ-ийн 2018 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлт

Нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр 2018 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс харахад аюулыг бууруулах бүтцийн бус арга хэмжээ, дасгал, сургууль, сургалтын чиглэлээр хийсэн ажлуудын гүйцэтгэл харьцангуй сайн, аюулыг бууруулах бүтцийн арга хэмжээ,

төлөвлөлт, эрх зүйн орчны чиглэлээр авсан арга хэмжээ дундаж, техник хэрэгслийг сайжруулах чиглэлээр хийгдсэн арга хэмжээ харьцангуй сул үнэлэгдсэн байна.


Мөн судалгааны явцад төлөвлөгөөний газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг хангах арга хэмжээний биелэлтийн оновчтой байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд олон ажил төлөвлөгдөж хангалттай сайн үнэлэгдсэн хэдий ч төлөвлөсөн ажлын хүрэх үр дүн нь тодорхой бус, өөрөөр хэлбэл биелэлтийг ямар шалгуураар үнэлэх нь ойлгомжгүй байдлаас шалгаалан гүйцэтгэлийг үнэлэхэд төвөгтэй, үр дүн нь оновчгүй харагдах зэрэг дутагдалтай талууд ажиглагдлаа. Тухайлбал: Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөний 2 дугаарт “Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийн хүрээнд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд нийслэл, дүүргийн жилийн төсвийн тодорхой хувийг зарцуулж байх чиглэл барьж ажиллах” гэж төлөвлөсөн хэдий ч гүйцэтгэл нь зарим дүүргийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд зарцуулсан хөрөнгийг дурьдах төдийгөөр 100% үнэлэгдсэн байна.

Дээрх судалгааны үр дүнд тулгуурлан газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээг хангахад **Нэгд**, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийг бууруулах (энд, эрсдэлийн үнэлгээ, аюулыг бууруулах бүтцийн ба бүтцийн бус арга хэмжээг хамруулан ойлгох), бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах хяналтыг зохион байгуулах арга хэмжээнүүдэд багцалж төлөвлөх; **хоёрт**, төлөвлөгөөнд туссан ажлын биелэлтийг ямар шалгуураар үнэлэх нь тодорхой бус байгаа байдлаас шалтгаалан гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, хяналт тавихад төвөгтэй байдал үүсч байгааг анхаарах шаардлагатай.

Б. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтад “гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна” гэж заасан бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, улсын албад, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллаж байна.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны улсын төлөвлөгөө (цаашид “Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө” гэх) нэртэйгээр батлан гаргасан. Энэ төлөвлөгөө нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах, бэлэн байдлыг хангах, гамшгийн үед шуурхай үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилготой. Энэхүү төлөвлөгөөний агуулгын тоймыг 12-р зурагт үзүүллээ.



Зураг 12. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тойм

Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний 8-р бүлэгт газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, газар хөдлөлтийг анхааруулах бүдүүвч, газар хөдлөлтийн үед зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч зэргийг оруулсан. Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг тоймлон харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөний тойм

Ерөнхий удирдлага	Авах арга хэмжээний тойм	Хугацаа
ОБЕГ	Зарлан мэдээлэх Нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах Аврах ажиллагааг эхлүүлэх	10 минутын хугацаанд
Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	Шуурхай штаб байгуулах Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх	30 минутийн хугацаанд
Шуурхай штаб	Улс, аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх Түргэвчилсэн үнэлгээ гаргах Яаралтай авах арга хэмжээг хэрэгжүүлэх Хоёрдогч хөнөөл үүсэхээс сэргийлэх Нэн чухал объектыг хамгаалах	30 минутаас 1 цагийн хугацаанд
	Нэн чухал дэд бүтцийг сэргээх Хүч хэрэгсэл тодотгох, нэмэгдүүлэх Нэрвэгдэгсдийг эрэн хайх аврах, Яаралтай тусламж үзүүлэх, хангалт зохион байгуулах	1 цагаас 3 цагийн хугацаанд
	Хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх Цаашид авах арга хэмжээг төлөвлөх Хандив тусламжийн хүсэлт гаргах, хүлээн авах, зохицуулах	3- цагаас 24 цагийн хугацаанд

(Эх үүсвэр: Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны улсын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулав)

В. Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээ

Газар хөдлөлтийн дараах сэргээн босгох арга хэмжээг Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд дараах агуулгатайгаар тусгасан байна.

Хүснэгт 4. Газар хөдлөлтийн гамшгийн дараа хэрэгжүүлэх сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөний тойм

Ерөнхий удирдлага	Авах арга хэмжээний тойм	Хугацаа
Засгийн газар	Сэргээн босгох ажиллагааг удирдах, зохион байгуулах шуурхай штабыг байгуулах	3 цагийн дотор
Шуурхай штаб	Хохирол, сэргээн босгох хэрэгцээний үнэлгээ хийх Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах Хоол хүнс, орон байр, бусад нөөцөөр хангах Орчны аюулгүй байдлыг хангах Хандив тусламжийг хүлээн авах, хуваарилах	3 хоногийн дотор
Шуурхай штаб ба холбогдох яамд	Амин чухал үйлчилгээг сэргээх Барилга байгууламжийн эвдрэлийн зэргийг тогтоох Хүч хэрэгслийг дайчлах, удирдлагаар хангах	7 хоногийн дотор
Холбогдох яамд	Нэн чухал дэд бүтэц, барилга байгууламжийг хүчитгэх, сэргээн засварлах Ашиглах боломжгүй барилга, байгууламжийг буулгах	30 хоногийн дотор
	Дахин төлөвлөлтийн зураг, төсөл боловсруулах Сэргээн босголтод шаардагдах зардлыг тооцох Сэргээн босгох хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх	180 хоног ба түүнээс

(Эх үүсвэр: Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны улсын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулав)

Монгол Улсад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, газар хөдлөлтийн дараа сэргээн босгох арга хэмжээг тусгасан ерөнхийдөө газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний чиг баримжааг олгоход чиглэсэн төлөвлөгөө байна. Өөрөөр хэлбэл хийх арга хэмжээ төвтэй төлөвлөгөө гэж хэлж болно. Гэвч том цар хүрээтэй газар хөдлөлт болсон нөөц хязгаарлагдмал нөхцөлд төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамгийн чухал зүйл бол хэн эдгээр арга хэмжээг хэрхэн хийх дараалал болон хэн удирдлагаар хангах асуудал болж хувирдаг. Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөнөөс харахад газар хөдлөлтийн гамшиг тохиолдсоноос хойш 30 минутын дараа Шуурхай штаб байгуулагдах ба энэ хүртэлх хугацаанд ямар бүтэц байх, хэрхэн удирдлагаар хангах, шуурхай штабын бүрэлдэхүүн, бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн нэн тэргүүнд авах арга хэмжээ зэрэг олон зүйлүүд тодорхой бус байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшгийн үед засгийн газрын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах асуудал тодорхойлогдоогүй болох нь харагдаж байна.

Судалгааны ажлын хүрээнд Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтцийн хүрээнд шинжилгээ хийлээ.

Хүснэгт 5. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц

Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө
Нийтлэг үндэслэл
<ol style="list-style-type: none"> 1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилт 2. Нийслэл хотын товч танилцуулга, физик газар зүй, нийгэм, эдийн засгийн байдал 3. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ 4. Газар хөдлөлтийн эмзэг байдлын үнэлгээ 5. Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ
1-р бүлэг Газар хөдлөлтийн гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ
<ol style="list-style-type: none"> 1. Гамшгийн үеийн удирдах бүрэлдэхүүний хэрэгжүүлэх арга хэмжээ 2. Нийслэлийн Онцгой комиссын бүрэлдэхүүн томилсон тушаал 3. Нийслэлийн Онцгой комиссын газар хөдлөлтийн үед ажиллах ажлын хэсгийн утас, хаягийн тодотгол 4. Газар хөдлөлтийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний график төлөвлөгөө 5. Гамшгийн үеийн түр цугларах талбай 6. Гамшгийн үеийн түр хоргодох байр 7. Улаанбаатар хотод газар хөдлөлтийн үед иргэдийг түр нүүлгэн шилжүүлэх байршил 8. Гамшгийн үеийн авто замын зохицуулалт 9. Гамшгийн үед олон улсын хүмүүнлэгийн тусламж хүлээн авах авто тээвэр болон нисдэг тэрэг буух талбайн зурвас 10. Гамшгийн үед ажиллах иргэд, сайн дурынхны оролцоо
2-р бүлэг Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээ
<ol style="list-style-type: none"> 1. Газар хөдлөлтийн гамшигт тэсвэртэй хот төлөвлөлт 2. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө 3. Газар хөдлөлтийн гамшгийн үед гамшгийн нөөцийн бараа материалаар хангах бэлэн байдлын төлөвлөгөө

4. Гамшгийн үеийн нөөц /ундны ус, хүнс, эм тариа, дулаан хувцас, шатах тослох материал/
3-р бүлэг Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох үйл ажиллагаа
1. Сэргээн босгох хүч хэрэгсэл зохион байгуулалт, харилцан ажиллагаа
2. Гамшгийн матрикс
3. Нийслэлийн гамшгаас хамгаалах Улсын албадын газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх үйл ажиллагааны чиглэл, хүн, хүч хэрэгслийн судалгаа
4. Улаанбаатар хотын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж
Эх сурвалж: НОБГ, 2017

Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд дараах хэд хэдэн онцлогууд ажиглагдаж байна. Үүнд:


- Улаанбаатар хотын төлөвлөгөөний гамшгийн өмнөх арга хэмжээний хэсэгт эрсдэлийг бууруулах болон гамшгийн үеийн нөөцийн зохицуулалтын арга хэмжээг оруулсан,
- Гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд Улаанбаатар хотын төлөвлөгөө гамшгийн үеийн удирдлага, бүрэлдэхүүн болоод газар хөдлөлтийн үед авах цөөн тооны арга хэмжээг хэт ерөнхий тодорхойлсон, зохицуулалтын шинж чанаргүй, тооцоо судалгаа голлосон байдалтай байна,
- Улаанбаатар хотын төлөвлөгөөнд Гамшгийн дараах сэргээн босгох ажиллагааны зохицуулалт бараг тусгагдаагүй.

2.1.2. Нийслэлийн удирдах бүрэлдэхүүний газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний талаарх мэдлэг, хандлага


Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх нийслэлийн удирдлагууд болон төр захиргааны байгууллагын ажилтнуудын мэдлэг, хандлагыг тандах судалгааг хийсэн. Уг судалгаанд нийслэлийн Засаг даргын тамгын газрын 28 ажилтан, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 92 ажилтныг хамрууллаа.

Судалгааг газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахтай холбоотой төлөвлөгөөнд тусгагдсан байвал зохих асуудлыг оролцогчдоор үнэлүүлэх хэлбэрээр бэлтгэсэн 24 асуулт бүхий асуулгаар авсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын болон Засаг даргын тамгийн газрын ажилтнууд Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг "дунд" гэсэн үнэлгээг өгсөн.



А. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын



Б. Засаг даргын тамгийн газрын ажилтан

Зураг 13. Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдалд удирдах бүрэлдэхүүний өгсөн ерөнхий үнэлгээ

Үнэлгээний асуулгад багтсан 22 асуултуудыг дараах 3 чиглэлээр ангилж шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан талуудын үүргээ гүйцэтгэх **чадварыг** илтгэх 6 асуулт;
2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд талуудын хоорондын ажил үүргийн **зохицуулалтыг** тусгасан 8 асуулт;
3. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлын бэлэн байдлыг хангуулсан **хэрэгжилтийг** харуулах 8 асуулт.

Хүснэгт 6. Нийслэлийн удирдлагуудын Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд өгсөн үнэлгээ

	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтны хариултын хувь					Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ажилтан				
	маш муу	муу	дунд	сайн	маш сайн	маш муу	муу	дунд	сайн	маш сайн
Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан талуудын үүргээ гүйцэтгэх чадварыг илтгэх асуулт	1.8	11.6	50.3	36.0	0.4	5.0	14.2	39.7	38.3	2.8
Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд талуудын хоорондын ажил үүргийн зохицуулалтыг тусгасан асуулт	5.0	19.4	50.9	22.8	1.9	8.1	25.9	40.5	23.8	1.6
Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлын бэлэн байдлыг хангуулсан хэрэгжилтийг харуулах	3.6	15.6	48.4	30.5	1.9	11.3	19.9	35.5	31.2	2.2

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан талуудын үүргээ гүйцэтгэх **чадварыг** нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын 86.7% нь, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ажилтны 80.9% дундаас дээш гэж үнэлж харьцангуй чадвартай гэсэн үнэлэлт өгсөн.

Харин газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд талуудын хоорондын ажил үүргийн **зохицуулалтад** нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын 75.3% нь, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ажилтны 74.6% дундаас доош гэсэн үнэлгээ өгсөн нь уг төлөвлөгөөнд талуудын хоорондын харилцан ажиллагааны зохицуулалт харьцангуй сул байна гэж үзэж байгааг харуулна. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлын бэлэн байдлыг хангуулсан **хэрэгжилтэд** нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын 67.6%, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын

ажилтны 66.7% дундаас доош гэсэн үнэлгээ өгсөн байна. Эндээс харахад төлөвлөгөөнд тусгагдсан эд зүйл, барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Нийслэлийн удирдлагуудаар Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжих боломжийг үнэлүүлэхэд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын 19.3% муу, 56.6% нь дунд, 24.1% сайн гэж буюу оролцогчдын 75.9% нь хэрэгжих боломжийг дундаас доош хэмээн дүгнэсэн байна.

Орон нутгийн онцгой байдлын байгууллагын ажилтнуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах асуудлаар холбогдох талуудад мэдээ мэдээлэл өгөх, аргачлалаар хангах, заавар зөвлөмж өгөх мэдлэг чадварыг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдлаа.

2.1.3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах сургалт, дадлага, сургууль

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээний өөр нэг чухал зүйл нь байнгын сургалт, дадлага, сургууль хийх юм. Улаанбаатар хотод төрийн байгууллагын бэлэн байдлыг хангах хэмжээнд өнөөдөр дараах чиглэлээр сургалт, дадлага, сургуулийг явуулж байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.1-д "удирдах албан тушаалтны сургалт" гэж заасны дагуу

2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.2-д "онцгой байдлын байгууллагын сургалт" гэж заасны дагуу

3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.5-д "гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт" гэж заасны дагуу

4. Онцгой байдлын ерөнхий газраас жилд 1-2 аймагт иж бүрэн сургууль, 3-4 аймагт удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээс 1-2 сум, дүүрэгт иж бүрэн, 3-4 сум, дүүрэгт удирдах бүрэлдэхүүний сургууль зохион байгуулна³ гэж заасны дагуу тус тус сургалт, дадлага, сургуулийг явуулж байгаа ба эдгээрийн хүрээнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой агуулга тодорхой хэмжээнд агуулагдана гэж үзлээ. Ингээд сүүлийн 2 жилийн сургалт, дадлага, сургуулийн явагдсан байдалд харьцуулалт хийж үзлээ.

Хүснэгт 7. Улаанбаатар хотод явагдсан гамшгаас хамгаалах сургалт, дадлага, сургууль

Сургалт, дадлага, сургуулийн төрөл	2017 он		2018 он		Өөрчлөлт	
	Тоо	Хамрагдсан хүний тоо	Тоо	Хамрагдсан хүний тоо	Тоо	Хамрагдсан хүний тоо
Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль	3	-	3	13019	-	-

³ Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага зохион байгуулах заавар"-ын 2.5.2 дах заалт

Команд штабын сургууль	3	-	7	370	+1.3 дахин	-
Удирдах албан тушаалтны сургалт	96	2102	59	3744	-38%	+78%
Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт	136	4130	124	4960	-8.8%	+20%
Онцгой байдлын байгууллагын сургалт, дадлага	Улаанбаатар бүсийн “Команд штаб”-ын сургууль		1	62		
	Туршилт шинжилгээний команд штабын сургууль		1	100		

Улаанбаатар хотын хэмжээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой сургалт, дадлага, сургууль тогтмол явагдаж хэвшсэн бөгөөд ерөнхийдөө оролцогчдын тоо буюу хамрах хүрээгээ тэлж байна.

Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах онцгой байдлын байгууллагын бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор тухайлсан сургууль, дадлагыг эрчимтэй хийх болсон байна. Тухайлбал, 2018 онд Газар хөдлөлтийн гамшгийн үед гэнэтийн ослын удирдлагын системээр ажиллах боломжийг судлах, хүндрэл бэрхшээлийг тогтоох, туршиж үзэх, ажиллах зохицуулалтад дүн шинжилгээ хийх, нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжүүдийн харилцан ажиллагааг боловсронгуй болгох, үүрэг чиглэлийг тодорхойлох, бие бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлын түвшинг тогтоох, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх чадварыг үнэлэх, Гамшигтай тэмцэх удирдлагын баримт бичгийг тодотгох, дүн шинжилгээ хийх, цаашид боловсронгуй болгох санал боловсруулах, Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага хийх зорилго бүхий "Туршилт шинжилгээний команд штаб"-ын сургуулийг зохион байгуулж явуулсан бол мөн онд онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдал, албаны ур чадвар, харилцан ажиллагаа, гамшгийн нөхцөл байдлын үед авах хариу арга хэмжээ, үүрэг гүйцэтгэх чадвар, дадлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үеийн бүсийн төвийн удирдлага, зохицуулалт, хариу арга хэмжээ, харилцан ажиллагаа” сэдэвт Улаанбаатар бүсийн “Команд штаб”-ын дадлага, сургуулийг тус тус зохион байгуулжээ.

2.2. Аж ахуйн нэгж, байгууллагын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдалд хийсэн шинжилгээ

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 62.9% нь Улаанбаатар хотод байрлаж байна⁴. Эдгээр ААНБ-ууд нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.1, 34.2.1-д заасны дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тохиолдож болзошгүй аюулын бүх төрлөөр боловсруулж, хэрэгжүүлдэг.

⁴ УСХ, ААНБ-ын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ, 2017

2.2.1. Бизнесийн байгууллагын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ-аас Говь ХК-ий 2017 онд батлагдсан Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сонгон авч шинжилгээ хийлээ. Төлөвлөгөөний зорилгыг гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулж явуулах гэж маш ерөнхий бөгөөд тунхагийн чанартай тодорхойлсон байна. Энэхүү төлөвлөгөө нь нийт 110 хуудастай, түүний 40 хувийг төлөвлөгөөний үндсэн хэсэг, 60 хувь нь хавсралт хэсгээс бүрдэх бөгөөд эдгээрийн агуулгын тоймыг 8-р хүснэгтэд авч үзэв.

Хүснэгт 8. Говь ХК-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тойм

Агуулга	Авч үзсэн асуудал
Нэг. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндсэн хэсэг	
Төлөвлөгөөний нийтлэг үндэслэл	Оршил, зорилго, зорилт
Компанийн товч танилцуулга, гамшгийн сургамж дүгнэлт	Түүх, үйл ажилагааны үндсэн чиглэл, Цахилгаан эрчим хүчний хангамж Дулаан хангамж Хэрэглээний усан хангамж Хаяг, байршил, байгууллагын план зураг 2017 оны гал түймрийн нөхцлийг дурьдаж оруулсан
Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн томилгоо, хүч хэрэгсэл, нөөцийн хангамж, бэлэн байдал	Штабын бүрэлдэхүүн, Мэргэжлийн ангийн томилгоожилт, үүрэг <ul style="list-style-type: none"> • Холбоо зарлан мэдээллийн бүлэг • Цахилгаан шугам сүлжээ засах бүлэг • Гал унтраах бүлэг • Аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүлэг • Аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан бүлэг • Гамшгаас хамгаалах нөөц, хангалт хариуцсан бүлэг • Сургалт, сурталчилгаа хариуцсан бүлэг • Сэргээн босголт хариуцсан бүлэг Бэлэн байдлын зэргүүдэд орон тооны бус штаб, мэргэжлийн анги, бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг
Эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ	Улаанбаатар хотын гамшгийн эрсдэлийн үнэлгээ
Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөө	Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ Газар хөдлөлтийн гамшгийн аюул тулгарсан үед авах арга хэмжээ Газар хөдлөлтийн гамшгийн аюулын дараа нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Бусад төрлийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөө	Дор дурьдсан гамшгийн төрлүүд тохиолдох үед хийх ажил, хугацаа, хариуцах эзнийг тогтоосон <ul style="list-style-type: none"> • Хөлдөлт • Үер, усны аюул • Үйлдвэрлэлийн томоохон осол • Химийн хортой бодисын осол • Объектын гал түймэр • Дэлбэрэлт • Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал
Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед хүч	Газар хөдлөлт, гал түймэр гэсэн гамшгийн 2 төрөл дээр бэлэн байдалд шилжих хугацаа, дайчлагдах хүний тоо, техник хэрэгсэл,

хэрэгслийг дайчлан ажиллах төлөвлөгөө	багаж хэрэгслийн нэр, тоо, марк, бэлэн байдлыг хариуцах эзнийг тогтоосон
Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө	Зарлан мэдээлэл хүргэх ажилтан, мэдээлэл хүргэх хүрээ, мэдээлэл хүргэхэд ашиглах техник, хэрэгсэл, аюулгүй гарцын хуваарь, гарцыг хариуцах албан тушаалтан
Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед түр цугларах байрлал	Аюулгүй талбай, түүний хэмжээ, бүртгэл хийх ажилтан, аюулгүй талбайд байрших ажилтан, нэгж, бүртгэлийн нэгдсэн мэдээ гаргах ажилтан
Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед нүүлгэн шилжүүлэх байршуулах төлөвлөгөө	Үйлдвэрийн нэр, түр байршуулах агуулах, хариуцах эзэн
Албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцсан албаны штабын бүрэлдэхүүн	Албан тушаалтны нэр, үндсэн ажил, томилгоожсон ажил, утасны дугаар, огноо, гарын үсэг
Хоёр. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралт хэсэг	
Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн хүн, хүч хэрэгслийн тооцоо	Үйлдвэр, хэлтэс, алба, нэгжийн ажиллах зохион байгуулалт /ажлын цаг, нийт ажилчдын тоо ба хүйс/ Үйлдвэрийн машин тоног төхөөрөмжийн судалгаа Инженерийн байгууламжийн судалгаа Барилга, байгууламжийн үндсэн үзүүлэлт, ашиглалт
Гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт, холбоо зарлан мэдээлэл	Орон тооны бус штабын гишүүдийн гэрийн хаяг, утасны жагсаалт, бие холбоочин Томилгоожсон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний гэрийн хаяг, утасны жагсаалт, бие холбоочин Байгууллагын хөдөлгөөнт болон суурин радио холбооны судалгаа Зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч, байгууллагын дуут дохио дамжуулах журам
Хүч хэрэгслийн тооцоо судалгаа	Мэргэжлийн ангиудын аврах багаж хэрэгсэл, техникийн хангалтын мэдээ Салбар нэгжийн судалгаа Газар хөдлөлтийн үед нурж болзошгүй барилга, байгууламжийн судалгаа
Байгууллагын орчны аюулгүй байдал, хүн ам зүй	Ажилчдын насны ангилал Эрсдэлтэй хүчин зүйл
Байгууллагын нөөц бүрдүүлэлт	Гамшгийн эрсдэлийн нөөц хөрөнгө Хүнсний нөөц, эмнэлгийн нөөц, хөдөлмөр хамгааллын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нөөц
Бусад	Байгууллагын зураг, холбогдох тушаал, тодотгол хийсэн тэмдэглэл


Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн төлөөлөл болгож Говь ХК-ий гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээнээс дараах нийтлэг дутагдалтай зүйлүүд ажиглагдаж байна. Үүнд:

- Төлөвлөгөөний зорилго хэт ерөнхий тунхагийн шинжтэй;
- Компанийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгээгүй;
- Гамшгийн нөхцөл үүссэн үед хэрхэн ажиллах удирдлагын тогтолцоог тодорхойлоогүй.


Тус төлөвлөгөөнд газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг бие даасан бүлэг болгож авч үзсэн боловч үүндээ газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах шуурхай удирдлагын бүтэц, нэн тэргүүнд хэрэгжүүлэх ажил зэргийг тодорхойлоогүй хэт ерөнхий байдалтай байна.

2.2.2. Аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын байгууллагынхаа гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх мэдлэг, хандлага

Аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын байгууллагынхаа гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх мэдлэг, хандлагыг тандсан судалгаа (Улаанбаатар хотод байрлах 4 байгууллагын 100 ажилтан хамрагдсан)-аар тэдний энэ талын мэдлэг ажилтнуудын тухайн байгууллагад ажилласан жилээс хамаардаг бөгөөд тэдний гуравны нэг нь энэ талын мэдээлэлгүй байдаг байна (Т.Пүрэвдорж, 2018). Энэ нь байгууллага төлөвлөгөө боловсруулахдаа ажилтнуудыг оролцуулдаггүй, түүнчлэн нэгэнт боловсруулсан төлөвлөгөөгөө ажилтнуудад танилцуулахгүй байгаатай холбоотой гэж үзэж болно.



Зураг 13. Байгууллагын ажилчдыг гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад оролцуулсан байдал



Зураг 14. Байгууллага нийт ажилчиддаа гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө танилцуулсан байдал

Байгууллагын ажилтнууд төлөвлөгөөний талаар мэдлэггүй байгаагаас үүдээд тэд байгууллага дээрээ газар хөдлөлт тохиолдох үед өөрийгөө хэрхэн хамгаалах, ямар үүрэг гүйцэтгэх ёстойгоо мэдэхгүй гэж судалгаанд оролцогчдын тал хувь нь хариулсан байна (Т.Пүрэвдорж, 2018).

Энэхүү судалгаанаас харахад ихэнх аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг цөөн хэдэн хүмүүсийн хүрээнд боловсруулдаг, түүнд ач холбогдол өгөхгүй байх нийтлэг зүйл ажиглагдаж байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг удирдлага болон хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан хамтарч гэж 67 хувь, удирдлага болон ажилчдын төлөөлөл оролцож боловсруулдаг гэж 33 хувь нь хариулжээ. Түүнчлэн асуулгад оролцогчид гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад учирч буй хүндрэл бэрхшээлээр судалгаанд оролцогчид 38% нь санхүү их шаарддаг гэж, 37% заавар, стандарт байхгүй гэж, 25% мэдэхгүй гэсэн шалтгааныг тус тус нэрлэснээс аж ахуйн нэгжүүд төлөвлөгөөг ач холбогдолтой зүйл гэж үзэхгүй байгааг харуулна.

Газар хөдлөлт төдийгүй аливаа гамшгаас хамгаалах бэлэн байдалд онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардлагатай гамшгийн нөөцийг байгууллага бүр бүрдүүлэх, эсвэл бусад талуудтай гамшгийн үед энэ талаар хамтран ажиллахаар урьдчилан тохиролцож гэрээ, санамж бичиг байгуулсан байх шаардлагатай байдаг. Одоогоор судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн дөнгөж 40 орчим хувь нь энэ ажлыг хийсэн байна.

2.2.3. Аж ахуйн нэгж, байгууллагын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах сургалт, дадлага, сургууль

Улаанбаатар хотод аж ахуйн нэгж, байгууллагын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой сургалт, дадлага, сургууль нь ерөнхийдөө дараах хэдэн чиглэлээр явагдаж байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.4-д "төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалт" гэсэн заалт
2. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам" болон Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр" -ыг хэрэгжүүлэх ажил
3. Нийслэлийн Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн сургалт
4. Бусад буюу төсөл, нэгдсэн арга хэмжээ

Албан тушаалтан, ажилтанд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө нь нийт 20 цагийн багтаамжтай бөгөөд уг төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн сэдвийн агуулгыг авч үзвэл газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам 1 цаг, амилуулах суурь тусламжийн 2 цаг болон гамшгаас хамгаалах төлөвлөлт, байгууллагын гамшгаас хамгаалах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг сэдвийн хүрээнд 10 цагийн сургалтаар газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангахтай холбоотой мэдлэгийг авахаар тусгажээ⁵.

ААНБ-ийн ажилтнуудтай явуулах гамшгаас хамгаалах сургалтыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.3.7-д "хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан" гэж заасны дагуу хэрэгжиж байгаа ба Улаанбаатар хотын хэмжээнд энэ ангиллын сургалтын тоо, хамрах хүрээ эрс нэмэгджээ.

Хүснэгт 9. ААНБ-ийн ажилтнуудтай явуулсан гамшгаас хамгаалах сургалт

Үзүүлэлт		2017	2018	Өөрчлөлт	Дундаж
Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалт	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн тоо	568	904	+59%	736
	Ажилтан, албан хаагчийн тоо	20356	63582	2.1 дахин	41969
"Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг"	Байгууллагын тоо		36		
	Ажилтан, албан хаагчийн тоо		417		

Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол болон 2017 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд ААНБ-ын хүрээнд зохион байгуулж буй сургалт, сурталчилгаа, дадлагын хамрах хүрээ ч мөн өссөн байна.

⁵ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаал

Хүснэгт 10. ААНБ-ийн ажилтнуудтай явуулсан гамшгаас хамгаалах дадлага, сургууль

Арга хэмжээний төрөл	Арга хэмжээний хамрах хүрээ	2017	2018	Өөрчлөлт	Дундаж
Сургалт	Байгууллага	345	356	+3.2%	350
	Хамрагдсан хүний тоо	18332	25544	+39%	21938
Сурталчилгаа	Явуулсан давтамж	31 Led дэлгэцээр 5-8 удаагийн давтамжтайгаар 155 удаа нэвтрүүлж 26 телевиз, сайтаар 77 удаа	31 Led дэлгэцээр 5 удаагийн давтамжтайгаар 155 удаа нэвтрүүлж 26 телевиз, сайтаар 75 удаа	-	
Дадлага	Байгууллага	1290	2033	+57%	1661
	Хамрагдсан хүний тоо	468230	478648	+2.2%	473439

Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд зохион байгуулдаг иргэдэд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох сургалтад "гарын доорх материал ашиглан өөртөө болон бусдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, газар хөдлөлтийн өмнө, үед болон дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээ" гэсэн агуулгаар сургалт явуулж байна.

Хүснэгт 11. Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд сургалтад хамрагдагсдын тоо

	2017 он		2018 он		Өөрчлөлт (хамрагдсан хүн)	Дундаж (хамрагдсан хүн)
	Тоо	Хамрагдсан хүний тоо	Тоо	Хамрагдсан хүний тоо		
Төрийн байгууллага	90	4333	82	3431	-20.8%	3882
Олон улсын байгууллага	3	135	-	-		
Хувийн хэвшлийн ААНБ	40	2960	43	1482	-49.9%	2221
Нийт хамрагдсан хүний тоо						6103

Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд жилд дундажаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын 6000 гаруй ажилтан албан хаагчид газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чиглэлээр сургалтад хамрагддаг байна.

Улаанбаатар хотод аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтад жилд дундажаар 70000 ажилтан алба хаагч, харин энэ чиглэлийн дадлага, сургуульд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын нийлсэн бараг 500000 ажилтан, алба хаагчид хамрагдсан байна.

2.3. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах иргэдийн бэлэн байдалд хийсэн шинжилгээ


Иргэдийн бэлэн байдлыг хангах гол зүйл бол аюул, эрсдэлийн талаарх хүн амын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, дадлага, сургалтад хамруулах замаар аюулгүй амьдрах зан төлөвийг өөрчлөх болон зарлан мэдээллийн дохиогоор ажиллах чадвар байдаг.

2.3.1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын талаарх иргэдийн мэдлэг, хандлага

Хотын иргэдийн түвшинд газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвар, бэлэн байдлыг тодорхойлохдоо хувь хүний тухайн гамшигт хандах нийгэм, эдийн засаг, соёл, сэтгэлзүйн хүчин зүйлийг болон газар хөдлөлтийн үед аюулгүй байдлаа хангах, өөрийгөө хамгаалах арга ажиллагааг гүйцэтгэх чадавхыг авч үздэг (Д.Сэржмядаг, 2017)


Монгол улсын нийт хүн амын 40 гаруй хувь нь амьдардаг Улаанбаатар хотын иргэдийн газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдал хэрхэн хангагдаж буйг авч үзэхдээ хотын 879 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгож хамруулсан.

Судалгаанд нийт 387 (44%) эрэгтэй, 502 (56%) эмэгтэй хүмүүс оролцож, эдгээр нь боловсролын хувьд 51% нь дээд, 16% нь тусгай дунд 24% нь бүрэн дунд 8% нь бүрэн дунд болон бага боловсролтой байгаа нь уг судалгаанд хүйсийн харьцааг хангасан, зохих түвшний боловсролтой аливаа мэдлэг, мэдээллийг хүлээн авах, өөрийн үнэлэлт дүгнэлтээ өгөх бүрэн боломжтой (нийт оролцогсдын 92% нь бүрэн дундаас дээш боловсролтой) түүвэр сонгогдсон гэж үзэж болох байна.



15-р зураг. Судалгааны түүвэр, насны бүлгээр

Түүврийн насны бүлгийг авч үзвэл нийт оролцогсдын 29% нь 16-26 насныхан буюу аливааг сурч мэдэх сэдэл тэмүүлэл бүхий залуу үеийнхэн, харин 70% нь 27-48 насныхан буюу аливаа асуудалд бие даан шийдвэр гаргах, нийгмийн нөхцөл байдалд бодитой дүгнэлт хийх чадвар бүхий тулгарч буй асуудлыг шийдвэрлэх өөрсдийн чадвар, чадавхын талаар маш сайн мэдэх иргэд оролцжээ (Зураг 16).



Зураг 16. Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 31% нь төрийн байгууллагад, 21% нь хувийн байгууллагад, 11% нь төрийн бус байгууллагад, 11% нь хувиараа хөдөлмөр, бизнес эрхлэгч, 10% нь төрийн өмчит ААНБ-д, 16% нь оюутан болон ажилгүй иргэд байв (16-зураг).

Газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадавхыг иргэдийн түвшинд авч үзэхэд зайлшгүй тооцож үзэх ёстой буюу тухайн хувь хүний өөртөө болон гэр бүлдээ учирч болох газар хөдлөлтийн эрсдэлийн талаар ямар нэг зүйлийг бодох, үйлдэхэд хүргэхэд нөлөөлөх хүчин зүйл бол амьдарч буй орон сууцны нөхцөл болон санхүүгийн боломжтой байдал юм. Энэ утгаараа энэхүү судалгаанд иргэдийн орон сууцны нөхцлийг болон сарын орлогын хүрэлцээтэй байдлыг тодорхойлсон асуулга авсан.



Зураг 17. Орон сууцны нөхцөл



Зураг 18. Өрхийн сарын орлого амьдралд хүрэлцээтэй байдал

Судалгаанд хамрагдсан иргэд Та ямар сууцанд амьдардаг вэ гэсэн асуултад 49% нь төвлөрсөн халаалттай орон сууцанд, 20% нь хувийн халаалттай орон сууцанд, 23% нь ердийн байшинд, 8% нь гэрт амьдардаг гэж хариулжээ (17-р зураг). Эндээс энэхүү судалгаанд хамрагдсан иргэдийн 70 гаруй хувь нь газар хөдлөлтийн аюулд өртөх боломжтой орон сууцанд амьдарч байгаа гэж хариулсан нь тухайн

аюулын эрсдэлийг бууруулах, тохиолдсон үед хэрхэн аюулгүй байдлаа хангах талаар ямар нэг арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай иргэд түүвэрт сонгогджээ гэж үзэж болно.

Таны сарын орлого амьдралд тань хэр хүрэлцээтэй байдаг вэ гэсэн асуултанд түүврийн 67% нь хүрэлцдэггүй, 21% нь хангалттай, 12% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Түүврийн шинж байдлаас харахад насны бүтэц, боловсролын түвшин болоод хөдөлмөр эрхлэлтийн байдлаараа аливаад бодитой үнэлэлт өгөх чадвартай, харин амьдарч буй орон сууцны нөхцөл болон санхүүгийн боломжийн хувьд газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвартай болох, бэлэн байдлаа хангах талаар зайлшгүй тооцож үзэх, тодорхой арга хэмжээ авах хэрэгцээ, шаардлагатай иргэд хамрагдсан байгаа нь энэхүү түүвэр судалгааны зорилгыг хангах боломжтой гэж үзэв.

Судалгааны асуулгад иргэдийн гамшгийг даван туулах чадвар, гамшгаас хамгаалах чадавхыг субъектив байдлаар үнэлэх үүднээс газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг иргэдийн аюулгүй байдлаа хангах мэдлэг, нөөц боломж, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ зэргийг багтаасан бол газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадварыг иргэдийн хандлага, үнэлэмжийг тодорхойлоход чиглэсэн асуултуудыг тус тус багтааж авч үзсэн.

I. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдал

Иргэдийн бэлэн байдлын төвшинг хэмжихдээ аюул, эрсдэлийн талаарх хүн амын мэдлэг, хандлага, аюулгүй амьдрах дадал хэвшил, зан төлөв болон зарлан мэдээллийг хүлээн авч, түүгээр ажиллах чадвар гэсэн хүчин зүйлүүдээр хэмжинэ.


Судалгаанд оролцсон иргэдийн 49,5% нь газар хөдлөлт тохиолдсон үед өөрийгөө хамгаалах талаар ямар нэг арга хэмжээ авах чадвартай гэж үзсэн бол 29,6 хувь нь юу хийхээ мэдэхгүй байна, 20% нь ямар нэг арга хэмжээ авч чадах эсэхээ мэдэхгүй байна гэсэн хариултыг сонгосон байна (12-р хүснэгтийн А хэсэг, 19-р зураг).

Харин газар хөдлөлтийн дараа хэрэглэх хүнс, цэвэр ус, лаа, шүдэнз, дулаан хувцас зэрэг зүйлийн нөөцтэй эсэхийг тодруулсан асуултанд мөн л судалгаанд оролцогчдын тал нь буюу 45% нь 1-3 хоногийн хоол, хүнсний нөөцтэй гэж, үлдсэн 55% нь ямар нэг нөөц байхгүй, байгаа эсэхээ мэдэхгүй байна гэж хариулжээ (12-р хүснэгтийн Б хэсэг, 20 -р зураг).


Иргэд амьдрах газар, орон байраа сонгохдоо газар хөдлөлтийн эрсдэлийг тооцох нь зүйтэй гэдэгт хандах хандлагыг асуулгаар тодруулахад 80 орчим хувь нь энэ асуудалтай санал нийлж байгаагаа илэрхийлсэн бол 20 орчим хувь нь эргэлзэж байгаа дүр зураг гарсан байна (12-р хүснэгтийн В хэсэг, 21-р зураг).

Хүснэгт 12. Газар хөдлөлтийн гамшигаас хамгаалах бэлэн байдлыг тодорхойлох асуултанд хариулсан байдал


А. Гэнэт газар хөдлөлт тохиолдвол нэн тэргүүнд ямар арга хэмжээ авахаа мэднэ гэдэгтээ та хэр зэрэг итгэлтэй байна вэ?					
	Бүрэн итгэлтэй байна	Итгэлтэй байна	Мэдэхгүй	Бага зэрэг итгэлтэй байна	Ямар ч итгэлгүй байна
Тоо	136	304	186	199	64
Хувь	15,3%	34,2%	20,9%	22,4%	7,2%
Б. Танай гэр бүл газар хөдлөлтийн дараа хэрэглэх хүнс, цэвэр ус, лаа, шүдэнз, дулаан хувцас зэрэг зүйлийн нөөцтэй юу?					
	2-3 хоногийн хугацаанд хэрэглэх ус, хүнсний нөөцтэй	1 хоногийн хугацаанд хэрэглэх ус, хүнсний нөөцтэй	Мэдэхгүй	Ямар ч нөөц бэлтгээгүй	Ийм нөөцийг бэлтгэх шаардлагагүй гэж бодож байна
Тоо	162	237	98	375	20
Хувь	18%	27%	11%	42%	2,2%
В. Та орон сууц худалдаж авах, байшин барилга барихдаа газар хөдлөлтийн эрсдэлийг тооцох хэрэгтэй гэдэгтэй хэр санал нийлж байна вэ?					
	Бүрэн санал нийлж байна	Зарим талаар санал нийлж байна	Мэдэхгүй	Зарим талаар санал нийлэхгүй байна	Огт санал нийлэхгүй байна.
Тоо	476	232	132	40	12
Хувь	54%	26,1%	14,8%	4,5%	1,4%



Зураг 19. Газар хөдлөлт тохиолдвол нэн тэргүүнд ямар арга хэмжээ авахаа мэднэ гэсэн итгэл, үнэмшилдээ өгсөн иргэдийн үнэлгээ



Зураг 20. Гэр бүлийн хэмжээнд газар хөдлөлтийн дараа хэрэглэх хүнс, цэвэр ус, лаа, шүдэнз, дулаан хувцас зэргийн нөөц байгаа эсэхээ иргэдийн тодорхойлсон байдал



Зураг 21. Орон сууц худалдаж авах, байшин барилга барихдаа газар хөдлөлтийн эрсдэлийг тооцох хэрэгтэй гэдэгтэй иргэд санал нийлж буй байдал

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах иргэдийн бэлэн байдлын түвшинг тодорхойлох хүрээнд авч үзсэн дараагийн асуудал бол газар хөдлөлтийн чичирхийллийн үед өөрсдийн амь насаа хамгаалах аргын талаарх мэдлэг юм. Үүнийг газар хөдлөлтийн үед авах 3 зөв, 3 буруу арга хэмжээнээс зөвийг сонгох хэлбэрээр тодорхойлсон (13-р хүснэгт).

Хүснэгт 13. Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээнээс 3 зөвийг сонгох асуултад хариулсан байдал

Хариултын сонголт	Тоо	Хувь	
• Газар хөдлөлтийн үед “суу, нуугд, хүлээ” үйлдлийг хийж өөрийгөө халхлан хүлээнэ.	зөв хариултын дундаж 56,2%	474	53,3%
• Газар хөдлөлтийн үед бат бөх ширээн доор, цонхноос зайдуу хана дагууд болон тавилгуудын хажууд байх нь аюулгүй		605	68,1%
• Газар хөдлөлтийн үед аль болох ийш тийш хөдлөхгүй аюулгүй газар зогсож байх хэрэгтэй		420	47,2%
• Газар хөдлөлтийн үед хаалгатай ойр байх хэрэгтэй.	буруу хариултын дундаж 32,5%	232	26,1%
• Газар хөдлөх үед барилга дотор байгаа бол нэн даруй гадагш гүйж гарна		384	43,2%
• Газар хөдлөлт болох үед орондоо байх тохиолдолд орны хажуугийн шалан дээр хэвтэнэ		252	28,3%

Хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн тэн хагас (56,2%) нь буюу 2 хүн тутмын 1 нь газар хөдлөлтийн чичирхийллийн үед амь насаа хамгаалах талаар зөв арга хэмжээг авах чадвартай байгаа бол 3 хүн тутмын 1 нь энэ үед өөрийгөө хамгаалах оновчтой арга хэмжээг авах чадваргүй байгаа дүр зураг гарч байна.



Зураг 22. Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээнээс 3 зөвийг сонгох асуултад хариулсан байдал

Энэ асуултын хүрээнд 3 зөв арга хэмжээг бүгдийг нь зөв сонгосон иргэд нийт түүврийн 13,3%-ийг (нийт 879 иргэний 117 нь 3 зөв хариултыг бүгдийг нь сонгосон) эзэлж байна. Эдгээр зөв сонголтыг хийсэн буюу газар хөдлөлтийн үед аюулгүй байдлаа хангах талаар зохих мэдлэгтэй түүвэрт шинжилгээ хийж үр дүнг 23-26-р зурагт харуулав.




Зураг 23. 3 зөв хариулт сонгосон түүврийн насны бүтэц, хувиар



Зураг 24. 3 зөв хариулт сонгосон түүврийн боловсролын түвшин, хувиар



Зураг 25. 3 зөв хариулт сонгосон түүврийн ажил эрхлэлтийн байдал, хувиар



Зураг 26. 3 зөв хариулт сонгосон түүврийн сууцны нөхцөл, хувиар


Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээнээс 3 зөв хариултыг бүгдийг зөв сонгосон нийт иргэдийн 85% нь 16-аас 37 насныхан байхын зэрэгцээ тэдний 60 гаруй хувь нь дээд боловсролтой байна. Түүнээс гадна төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагад ажилдаг иргэд зөв хариултыг харьцангуй их сонгосон байгаа зэргээс харахад их, дээд сургууль төгссөн, идэвхтэй хөдөлмөр эрхэлж байгаа залуу үеийнхэн газар хөдлөлтийн үед ямар арга хэмжээ авах талаар харьцангуй мэдлэгтэй байна гэж үзэж болно.

Иргэд газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангахтай холбоотойгоор ямар нэг арга хэмжээ авч байгаа эсэхийг тодорхойлсон асуултанд дараах байдлаар хариулсан байна (14-р хүснэгт, 27-р зураг).

Хүснэгт 14. Газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангахтай холбоотой

Хариултын сонголт	Тоо	Хувь
• Хэрхэн амь насаа хамгаалах, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх аргад суралцдаг	208	23,4
• Гэр бүлийн гишүүд, ажлын хамт олон, найз нөхөдтэйгээ газар хөдлөлтийн аюул, эрсдэл, хэрхэн аюулгүй байдлаа хангах талаар ярилцдаг	239	26,9
• Орон байрныхаа газар хөдлөлтийн чичирхийлэл тэсвэршилтийн аюулгүй байдалд анхаарч, ямар нэг арга хэмжээ авдаг	107	12
• Өөрийн харъяалагдах сум/дүүргийн гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор хэрхэн ажиллахыг мэдэх	131	14,7
• Ямар нэг зүйл хийгээгүй байна.	249	28

Нийт түүврийн 28% нь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах чиглэлээр ямар нэг зүйл хийгээгүй байна гэж хариулсан бол харьцангуй бага хувь буюу 12% нь орон байрныхаа газар хөдлөлтийн чичирхийлэл тэсвэршилтийн аюулгүй байдлыг хангахад анхаарал хандуулдаг гэж хариулжээ. Мөн газар хөдлөлтийн аюул, эрсдэлийн талаар болон хэрхэн аюулгүй байдлаа хангах тухай асуудалд санаа тавьж байгаа иргэд харьцангуй өндөр хувьтай (26,9%) байна.



Зураг 27. Газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангахтай холбоотой иргэдийн авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Энэхүү асуулгын судалгаанаас одоогоор иргэдийн тал хувь нь газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангах чиглэлд ямар нэг зүйлийг хийж байгаа нь харагдаж байгаа бол үлдсэн хэсэг нь хэрхэн бэлэн байдлаа хангах талаар санаа тавьж ярилцдаг эсвэл юу ч хийж эхлээгүй байгааг харж болохоор байна.

II. Газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвар


Иргэдийн субъектив даван туулах чадвар нь тухайн хувь хүний эрсдэлд хариу үзүүлэх нийгмийн янз бүрийн систем, өрхийн чадвар, чадавхдаа өгөх өөрийн үнэлгээгээр илэрхийлэгдэнэ. Энэ хүрээнд газар хөдлөлтийн эрсдэлийн талаарх иргэдийн итгэл үнэмшил, хандлага, бодит байдал болон өөрсдийн чадвар, боломжидоо өгсөн үнэлэлтийг авч үзсэн.

Газар хөдлөлтийн эрсдэлд хандах иргэдийн итгэл, үнэмшлийг тандах зорилгоор асуусан “Таны амьдарч байгаа газарт хүчтэй газар хөдлөлт тохиолдох магадлал хэр зэрэг гэж бодож байна вэ” гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 54% нь тохиолдох магадлалтай гэж үзэж байхад 30 орчим хувь нь тохиолдох эсэхийг мэдэхгүй байна, тохиолдохгүй байх гэж 15% нь найдаж байгаа бол 2% нь огт тохиолдохгүй гэж хариулсан байна (15-р хүснэгтийн А хэсэг, Зураг 28).

Харин иргэн, айл өрх бүр газар хөдлөлтийн эрсдэлийг хэрхэн хүлээж авч түүнээс хамгаалах талаар ямар нэг зүйлийг хийх хэрэгтэй гэж үзэж байгаа эсэхийг тодруулсан асуултад судалгаанд оролцогчдын олонх нь буюу 81% нь ямар нэг зүйлийг хийх хэрэгтэй гэж үзсэн бол, 17% нь ямар нэг зүйл хийх шаардлагатай эсэхээ мэдэхгүй байна гэж хариулжээ (15-р хүснэгтийн Б хэсэг, 29 -р зураг).

Хүснэгт 15. Газар хөдлөлтийн эрсдэлийн талаарх иргэдийн итгэл үнэмшил, хандлагыг тодорхойлох асуултад хариулсан байдал

А. Таны амьдарч байгаа газарт хүчтэй газар хөдлөлт тохиолдох магадлал хэр зэрэг гэж бодож байна вэ?					
	Магадлал их	Тохиолдох магадлалтай	Мэдэхгүй	Тохиолдохгүй байх гэж найдаж байна	Хэзээ ч тохиолдохгүй
Тоо	85	397	262	131	15
Хувь	9%	45%	29%	15%	2%
Б. Иргэн, айл өрх бүр газар хөдлөлтийн аюулаас хамгаалах талаар ямар нэг зүйл хийх хэрэгтэй гэж та боддог уу?					
	Маш их зүйлийг хийх хэрэгтэй	Өөрөөс шалтгаалах бүх зүйлийг хийх хэрэгтэй	Мэдэхгүй	Хийх шаардлагатай эсэхээ мэдэхгүй байна	Ямар нэг зүйл хийх шаардлагагүй гэж бодож байна
Тоо	220	497	91	65	14
Хувь	25%	56%	10%	7%	2%



Зураг 28. Хүчтэй газар хөдлөлт тохиолдох магадлал

Энэхүү судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх нь газар хөдлөлт бидний амьдарч буй газарт тохиолдох магадлалтай гэж үзсэн байхад мөн нилээдгүй хувь нь тохиолдох эсэхийг мэдэхгүй, тохиолдохгүй байх гэж найддаг гэж үзсэн нь газар хөдлөлтийн эрсдэлд хандах иргэдийн хандлага харилцан адилгүй төвшинд байгааг илтгэнэ.



Зураг 29. Иргэн, айл өрх бүр газар хөдлөлтийн аюулаас хамгаалах талаар ямар нэг зүйл хийх хэрэгтэй эсэхийг тодорхойлсон байдал

Хэдийгээр иргэд газар хөдлөлтийн эрсдэлд харилцан адилгүй ач холбогдол өгч хандаж байгаа хэдий ч газар хөдлөлтийн эрсдэлээ бууруулах талаар иргэн хүний хувьд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Түүнээс гадна иргэд газар хөдлөлтийн эрсдэлтэй холбоотой тодорхой ажил хийх шаардлагатай гэдэгтэй нэгэнт санал нийлж, зарим нэг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлснийг иргэд одоо амьдарч буй орон сууц, байшингаа нилээдгүй хувийг (30%) нь даатгалд хамруулснаас харж болно (30-р зураг).




Зураг 30. Иргэдийн орон байраа даатгалд хамруулахад хандах байдал

Газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвартаа иргэд хэрхэн үнэлэлт өгч байгааг амь насаа хамгаалах арга хэмжээ авах чадвар болон гамшгийн дараа сэргэх санхүүгийн чадавхыг тодорхойлсон асуулгаар тодруулсан. Газар хөдлөлт тохиолдвол гэр бүлийн гишүүдийнхээ аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авах чадавхыг 40 гаруй хувь нь чадавхтай гэж, 60 гаруй хувь нь чадавхгүй байна гэж үнэлжээ (16-р хүснэгтийн А хэсэг, 31-р зураг). Судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь гамшгийн дараа эргэж сэргэхэд шаардлагатай санхүүгийн боломжиндоо эргэлзэж байгаа дүр зураг гарсан бол дөнгөж 30 гаруй хувь нь газар хөдлөлтийн дараах хохирлыг өөрсдөө арилгаж чадах санхүүгийн боломжтой гэж үзсэн байна (16-р хүснэгтийн Б хэсэг, 32-р зураг).


Хүснэгт 16. Газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвартаа иргэдийн өгсөн үнэлэлт

А. Хэрвээ хүчтэй газар хөдлөлт тохиолдвол манай гэр бүлийн гишүүд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авч чадна.					
	Маш сайн чадна	Чадна	Мэдэхгүй	Ямар арга хэмжээ авахаа мэдэхгүй	Юу ч хийж чадахгүй
Тоо	19	376	284	174	36
Хувь /%/	2	42	32	20	4
Б. Манай гэр бүл газар хөдлөлтийн дараа орон байр, амьжиргаандаа учирсан хохирлыг богино хугацаанд арилгах санхүүгийн чадавхтай.					
	Бүрэн санал нийлж байна	Зарим талаар санал нийлж байна	Мэдэхгүй	Зарим талаар санал нийлэхгүй байна	Огт санал нийлэхгүй байна
Тоо	46	258	243	159	181
Хувь /%/	5,2	29	27,3	17,9	20,4



Зураг 31. Газар хөдлөлтийн гамшгийн үед гэр бүлийн гишүүдийнхээ аюулгүй байдлаа хангах арга хэмжээ авах чадвархад өгсөн иргэдийн үнэлгээ

Судалгаанд оролцсон иргэдийн өөрсдийн үнэлгээгээр газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний талаарх мэдлэг чадвар хангалтгүй, газар хөдлөлтөөс учрах хохирлыг барагдуулах санхүүгийн чадавх ч муу байна гэж үзжээ.



Зураг 32. Газар хөдлөлтийн дараа орон байр, амьжиргаандаа учирсан хохирлыг богино хугацаанд арилгах гэр бүлийн санхүүгийн чадавхаа иргэд тодорхойлсон байдал

Газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвараа иргэд хангалтгүй байна гэж үнэлж, энэ чиглэлд зохих арга хэмжээг авах шаардлагатай гэдэг итгэл үнэмшилтэй байгаа нь энэхүү асуулгын судалгаанаас харагдаж байна.

Иргэдийн зүгээс газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн байгууллага, цаашлаад улс орны тухайн гамшгийг даван туулах чадавх, гамшгаас хамгаалах бэлэн байдалд ямар үнэлэлт, дүгнэлттэй байгааг “Та монгол улсын газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвар, гамшгаас хамгаалах бэлэн байдалд ямар үнэлгээ өгөх вэ?” гэсэн асуулгаар тандахад 6% нь сайн, 38% нь дунд, 24% нь мэдэхгүй, 27% нь муу, 5% нь маш муу гэсэн хариултыг өгсөн байна (33-р зураг).



Зураг 33. Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвар, гамшгаас хамгаалах бэлэн байдалд өгсөн иргэдийн үнэлгээ

Дээрх зургаас харахад иргэд улс орныхоо газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвар, бэлэн байдлыг хангалттай сайн биш гэсэн үнэлгээ өгсөн хувь харьцангуй их байна.

Судалгаанаас харахад иргэдийн ихэнх нь газар хөдлөлт бидний амьдарч буй газарт тохиолдох магадлалтай гэж, мөн нилээдгүй хувь нь тохиолдох эсэхийг мэдэхгүй, тохиолдохгүй байх гэж найддаг гэж үзсэн нь газар хөдлөлтийн эрсдэлд хандах иргэдийн хандлага харилцан адилгүй төвшинд байна. Түүнээс гадна газар хөдлөлтийн гамшгийг даван туулах чадвараа иргэд хангалтгүй байна гэж үнэлж, энэ чиглэлд зохих арга хэмжээг авах шаардлагатай гэдэг итгэл үнэмшилтэй бий болсон байна.

2.3.2. Иргэдэд зориулсан газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар зүйлд Гамшгаас хамгаалах сургалтыг 6 ангилж, 13.2.6 дахь заалтад **“иргэний сургалт”** гэж тусгасан бөгөөд 13.3.4-т **“иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга зохион байгуулна”** гэж заасан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалаар **“Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр”**-ийг батласан. Энэ тушаалын хавсралтанд гамшгаас хамгаалах иргэдийн сургалтын хөтөлбөрийг баталсан байна.

Манай улсын хувьд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт, дадлага нь бусад гамшгийн аюулын төрлүүдтэй харьцуулахад харьцангуй түгээмэл явагддаг төрөлд хамаарна. Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн чичирхийллийн давтамж нэмэгдэж байгаатай холбоотойгоор сургалт, дадлагын ач холбогдол улам бүр нэмэгдэж байна.

Одоогоор иргэдэд зориулсан газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах талаарх мэдлэг олгох ном, гарын авлагын агуулга дараах байдалтай байна.

Хүснэгт 17. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах талаар иргэдэд чиглэсэн сургалтын гарын авлагуудын агуулга

Ном, гарын авлагын нэр	Агуулга
Аврагч мазаалайн зөвлөмж өрхийн гарын авлага	Газар хөдлөлтийн тухай ойлголт Газар хөдлөлтийн өмнө: -Гэрийн бэлэн байдал -Хүнсний бэлтгэл -Эм эмнэлгийн материал -Хэрэгцээт багаж материал -Тавилга, эд хогшлоо зөв байршуулах -Хамтын бэлтгэл Газар хөдлөлтийн үед: - Авах арга хэмжээ -Газар хөдлөлтийн үед дагах зөвлөмж Газар хөдөлсний дараа авах арга хэмжээ Өрхийн бэлэн байдлын төлөвлөгөө Хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлсийн жагсаалт
“Аюулгүй зөвлөмж өрх”	-Улаанбаатар хотын барилгын хийц Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ: -Хүнсний бэлтгэл -Эм эмнэлгийн хэрэгсэл -Бусад хэрэгцээт зүйл -Тавилга эд хогшлоо зөв байрлуулах -Хамтын бэлтгэл Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ Газар хөдөлсний дараа авах арга хэмжээ Өрхийн бэлэн байдлын төлөвлөгөө Хүн нэг бүрийн үүргэвчид байвал зохих зүйлсийн жагсаалт
Гамшгаас үндэс зориулсан бичиг/ хамгаалах /иргэдэд сурах	Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах нь -Газар хөдлөлтийн талаарх ерөнхий ойлголт -Газар хөдлөлтийн хүч, шинж тэмдгүүд -Газар хөдлөлтийн өмнө авах арга хэмжээ -Газар хөдлөлтийн үед авах 10 арга хэмжээ -Газар хөдлөлтийн үед байгаа байршлаасаа шалтгаалан өгөх зөвлөмж -Газар хөдөлсний дараа авах арга хэмжээ -Газар хөдлөлтийн аюулгүй байдлыг шалгаж хянах хуудас
Бэлэн бай сургалтын багц	Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах - Газар хөдлөлтийн тухай ерөнхий ойлголт - Монгол орны газар хөдлөлтийн ерөнхий зүй тогтлыг ойлгох - Япон улсын газар хөдлөлтийн сургамжаас суралцах - Газар хөдлөлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хэрхэн хангах арга зам - Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ, иргэдийн мэдэж байх ёстой зүйл

Хөтөлбөрөөс харахад *иргэний сургалтын агуулга нь* газар хөдлөлтийн үед үүсч болох аюулаас өөрийгөө хамгаалах, бусаддаа тусламж, дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлаа өөрсдөө хангах дадлыг хэвшүүлэх, өрхийн түвшинд газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангах мэдлэг, чадвар, хандлагыг олгоход чиглэжээ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/130 дугаар тушаалын хавсралтад “баг, хорооны Засаг дарга өөрийн эрхийн хүрээнд хорооны нийгмийн ажилтанд иргэдийн сургалтыг хариуцуулна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага арга зүйн зөвлөмжөөр хангаж, олон улсын байгууллагын төсөл,

хөтөлбөрийн хүрээнд баг, хорооны нийгмийн ажилтнуудыг иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургагч багшаар бэлтгэнэ. Үүнд: Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг мөн татан оролцуулна” гэж зааж өгсөн байна.

Иргэдийн сургалтыг баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан явуулах эрхзүйн зохицуулалттай байгаа бөгөөд мөн үүнтэй зэрэгцээд төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон дээрх байгууллагаас бэлтгэсэн мэдээллийг дамжуулах хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн үндсэн 4 сувгаар иргэд гамшгаас хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл авч байна.

Хүснэгт 18. Иргэдтэй явуулсан гамшгаас хамгаалах сургалт

Төрөл, үзүүлэлт		2017	2018	Өөрчлөлт	Дундаж
Иргэний сургалт	Сургалтын тоо	328	281	-14%	304
	Хамрагдсан хүний тоо	16784	36338	+116%	26561
Иргэд, сайн дурын бүлгийн сургалт	Сургалтын тоо		59		
	Хамрагдсан хүний тоо		3133		
Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургалт	Сургалтын тоо		14		
	Хамрагдсан хүний тоо	765	17135		
“Бэлэн бай” сургалт	Хамрагдсан хүний тоо		179		

Иргэдийн сургалт бодит байдалд яаж явагдаж байгааг авч үзэх зорилгоор Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, аргазүйн төв болон Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулсан сургалтанд дараах үзүүлэлтээр ажиглалт хийсэн.

Хүснэгт 19. Иргэдийн сургалтын үйл явцад хийсэн шинжилгээ

	Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, аргазүйн төв	Чингэлтэй дүүргийн Гамшгаас сайн дурын хэсэг /7 дугаар хорооны Иргэний танхим/
Сургалтын сэдэв:	Газар хөдлөлтийн аюул, гал түймрийн аюул, утаат орчин, эмнэлгийн анхны тусламж	Гал түймрийн аюул
Товч агуулга	Газар хөдлөлт болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах, утаат орчноос аюулгүй гарах, бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх анхан шатны мэдлэг ойлголттой болох	Гал түймэр юугаас болж гарах, гал түймэр гарсан үед ямар хохирол гарах, гал түймрээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар
Оролцогчийн тоо:	35	18
Сургалтын үргэлжлэх нийт цаг: Үүнээс багшийн цаг, эзлэх % оролцогчийн цаг, эзлэх %	1 цаг 15 мин Багш - 60% Оролцогч - 40%	2 цаг 30 мин Багш-70% Оролцогч -30%

Сургалт явагдсан хэлбэр:	лекц, тайлбар яриа дадлага, дасгал ажил	лекц, тайлбар яриа дадлага, дасгал ажил багаар ажиллах
Иргэдийн идэвх, оролцоо	Идэвхи сайн	Идэвхи дунд зэрэг
Сургалтын материал, хэрэглэгдэхүүн	Тараах материал, видео, муляж	Гал унтраах автомашин, гал унтраагуул, утаа гаргагч

Иргэдийн гамшгийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэх арга хэмжээний нэг чухал зүйл нь байнгын **дадлага, сургуулилт** хийх юм.

Манай улсад гамшгаас хамгаалах сургууль, дадлагыг иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүний гэж ангилж явуулдаг ба иж бүрэн сургуульд иргэд оролцдог.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2017 онд Сүхбаатар, Чингэлтэй, Налайх дүүргүүдэд 3 удаа, 2018 онд Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт 3 удаа тус тус зохион байгуулсан байна.

Хүснэгт 20. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд иргэдийн оролцсон байдал

	2017	2018	Дундаж
Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургуульд хамрагдсан иргэний тоо	15176	13019	14097.5

Нийслэлийн хэмжээнд жилд дунджаар иргэдэд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлэн байдлаа хангах арга замыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтанд 47000 гаруй иргэн, сургууль дадлагад ойролцоогоор 15000 иргэн хамрагддаг гэсэн дүр зургийг дээр авч үзсэн тоон мэдээллээс авч болохоор байна.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах иргэдийн сургалт, дадлагын өнөөгийн байдлыг түгээмэл хэрэглэгдэх ном, гарын авлагад тусгагдсан агуулгын хүрээнд явагдсан сургалт, сурталчилгаа болон сургууль дадлагын авч үзэхэд иргэдэд газар хөдлөлтийн өмнө хэрхэн эрсдэлээ бууруулах, аюулгүй орчин бүрдүүлж, бэлэн байдлаа хангах, газар хөдлөлтийн үед амь насаа хэрхэн хамгаалах, газар хөдлөлтийн дараа нэн тэргүүнд авах арга хэмжээний талаарх мэдлэгийг өгөхөд түлхүү чиглэгдсэн байгаа нь харагдлаа.

2.3.3. Улаанбаатар хотын иргэдийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж буй байдал

Гамшгаас хамгаалах мэдлэгийг иргэдэд олгохын эцсийн зорилго бол иргэдийг зарлан мэдээлэх дохиогоор ажиллахад сургах явдал юм. Гамшгийг зарлан мэдээлэх нь түүнийг хүлээн авч буй иргэдэд эрсдэлийн нөхцөл байдал өөрчлөгдсөнийг ойлгуулах, тохиромжтой арга хэмжээ авах талаар албан ёсны зааварчилгаагаар хангахад хэрэглэгдэнэ.

Зарлан мэдээлэх систем ба мэдээлэл нь түүнийг хүлээн авах хүний хаана, ямар нөхцөлд байгаагаас үл хамаарч мэдээлэл хүрч байхаар зохион байгуулагдах ёстой. Хувийн болон ашгийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж хүн амыг бүхэлд нь хамрахуйц олон төрлийн зарлан мэдээлэх системийг бүрдүүлнэ.

А. Зарлан мэдээллийн системийн өнөөгийн байдал

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв нь Одон орон, геофизикийн хүрээлэнгээс газар хөдлөлтийн, Цаг уур, орчны шинжилгээний газраас цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн мэдээг шилэн кабелин сүлжээгээр дамжуулан хүлээн авч, Улаанбаатар хотод суурилуулсан 60 цамхаг, 3 телевиз, 10 FM радиогоор дамжуулан зарлан мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

Газар хөдлөлтийн идэвхтэй бүсүүдэд суурилуулсан газар хөдлөлтийг мэдрэх 12 төхөөрөмжөөс хүлээн авсан мэдээг Одон орон, геофизикийн хүрээлэнд боловсруулан Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвд дамжуулах ба хүчтэй газар хөдлөлт болох үед зарлан мэдээлэх систем бүхэлдээ хүний оролцоогүйгээр автоматаар ажиллаж олон нийтэд зарлан мэдээллийг богино хугацаанд хүргэхээр зохион байгуулагдсан.


Одон орон, геофизикийн судалгааны төвтэй нийт газар хөдлөлтийг мэдрэх 12 багц төхөөрөмж нь BGAN, сансрын холбоогоор холбогдоно.

Газар хөдлөлтийн идэвхтэй бүсүүд болох (Булган аймгийн Могод сумын нутагт 3 цэгт, Дашинчилэн сумын нутагт 1 цэгт, бүгд 4 цэгт, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутагт 2 цэгт, Дэрэн сумын нутагт 1 цэгт, бүгд 3 цэгт, Төв аймгийн Баянцагаан сумын нутагт 1 цэгт, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын нутагт 3 цэгт, Хушаат сумын нутагт 1 цэгт, бүгд 4 цэгт) нийт 4 аймгийн 7 сумын нутагт 12 цэгт газар хөдлөлтийг мэдрэх төхөөрөмжийг суурилуулсан.

Удирдлагын төв нь системийн гол цөм хэсэг бөгөөд системийг нэгдсэн удирдлагаар хангах, системийн хэвийн үйл ажиллагаанд мэдээлэл холбооны дэд бүтцээр дамжуулан төхөөрөмжүүдийн хоорондын холболт, мэдээллийн урсгалыг хянах боломжтой.

Систем бүхэлдээ орчны хяналт буюу температурын дохиолол, чийгшлийн дохиолол, утааны дохиолол, галын дохиолол, гадны халдлагаас сэргийлсэн дохиоллын дэд системүүдээр тоноглогдсон.

Суурин удирдлагын төвд томоохон хэмжээний гэмтэл саатал гарч цаашид үйл ажиллагааг удирдах боломжгүй болсон тохиолдолд түүнийг бүрэн орлон ажиллах хөдөлгөөнт удирдлагын төвийг “Хьюндэй HD120” загварын тээврийн хэрэгсэл дээр тоноглон төхөөрөмжилсөн.



Зураг 34. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн ерөнхий бүдүүвч

Зарлан мэдээлэх дуут дохиоллын цамхаг нь удирдлагын төв болон хөдөлгөөнт удирдлагын төвөөс илгээсэн анхааруулах дохио, мэдээллийн дагуу идэвхжиж гамшгийн аюулын тухай мэдээллийг текст, шууд яриа болон дуут дохиоллын хэлбэрээр олон нийтэд хүргэх зориулалттай.

Удирдлагын төвөөс зарлан мэдээллийг сансрын холбоо, хэт богино долгионы радио холбооны хэрэгслээр дамжуулан өргөн нэвтрүүлгийн төхөөрөмжийг тохируулан дуун нэвтрүүлгийг радиогоор, текст болон дүрст мэдээллийг телевизээр автомат болон гар ажиллагаатайгаар дамжуулах боломжтой.

Телевиз (MYONPT, UBS, Монгол HD), 10 FM радиогийн (Улаанбаатар FM 102.5, Авто радио 96.3, Гэр бүлийн радио 104.5, Лавайн эгшиг 97.5, Монголын үндэсний радио 106, Шинэ долгион радио 107.5, Бэстрададио 98.5, Хамаг Монгол радио 95.1, Таны радио 103.6, MGL радио 102.1) газруудад өргөн нэвтрүүлгийн EBS (emergency broadcasting system) тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна.

Уг системд үүрэн холбооны 2 дахь үеийн стандартын сүлжээг ашигласан ба Удирдлагын төвөөс гамшгийн аюулын тухай сэрэмжлүүлэг мэдээллийг 160 тэмдэгтэд багтаан “Мобиком”, “Юнител”-ийн нийт хэрэглэгчдэд нэгэн зэрэг илгээхээр төхөөрөмжилсэн.

CBS (Cell Broadcast Service) гэдэг нь тухайн бүс нутгийн хэмжээнд нэг ижил мессежийг нэгэн зэрэг, хугацааны хоцрогдолгүй дамжуулах боломжтой бөгөөд бааз станцуудаас нийт сүлжээний хэрэглэгчдэд түгээх юм.

Япон болон Монгол Улсын гамшгийн аюулыг зарлан мэдээлэх техник хэрэгслийн харьцуулсан байдлыг 21-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 21. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх техник хэрэгслийн харьцуулалт

д/д	Улс, хот	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх техник хэрэгсэл					
		Телевиз	Радио	Гар утас	Электрон самбар	Гадна цамхаг	Дотоод зарлан мэдээллийн төхөөрөмж
1	Япон	√	√	√	√	√	√
2	Улаанбаатар	√	√	√	√	√	х

Улаанбаатар хотын хэмжээнд байгуулсан гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн бүрдэл хэсгүүд нь технологийн өндөр хөгжилтэй улс орнуудад ашиглагдаж байгаатай ижил төстэй боловч дотоод зарлан мэдээллийн төхөөрөмжийн хэсгийг нэмж бүрдүүлсэн тохиолдолд олон улсын жишигт нийцсэн цогц систем бүрдэхээр байна.

Жайка олон улсын байгууллагаас Япон улсын болон Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах системд хийсэн зарим харьцуулсан үнэлгээг хүснэгтэд харуулав.

Хүснэгт 22. Япон улсын болон Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах системд хийсэн зарим харьцуулсан үнэлгээ

	Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем	Японы улсын газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем
Системийг байгуулсан	Korean Telecom Corporation	Ус цаг уурын гамшгаас хамгаалах технологийн судалгааны төв, Төмөр замын институт
Үндсэн зарчим	Эхний чичиргээний мэдээллийг (Р долгион) бодит цагаар боловсруулан тухайн нутаг дэвсгэр дэх аюулын (чичиргээ) хэмжээг яаралтай мэдээлэх	
Гол алгоритм	PRESTo (Итали, Наполи их сургууль)	UrEDAS Япон (Төмөр замын институт), Гамшгаас хамгаалах технологийн судалгааны төв
Станцын тоо	Зарлан мэдээллийн системтэй холбогдсон 12 станц	Улсын хэмжээнд 4300 орчим станц
Станц бүр дээр боловсруулалт хийж голомтыг тогтоох	Боломжгүй	Дангаараа голомт, магнитутыг тогтоох боломжтой
Хэд хэдэн станцын мэдээлэл боловсруулалт	Газар хөдлөлтийн долгион ирэх цаг болон хамгийн их чичиргээний далайцаас голомтын байршил болон магнитудыг тооцож, тооцсон голомт, магнитудаас баллыг тооцоолж гаргана.	
Дохиоллын агуулга	Дохиоллын түвшин (3 түвшинтэй: их, дунд, бага)	Таамаглаж буй чичирхийллийн хүч, нөөц цаг, голомтын байршил, магнитуд
Дохиолол өөрчлөх функц	Байхгүй	Мэдээлэл шинэчлэгдэхэд шинэчлэгдэнэ

Станцад чичирхийллийг мэдэрснээс хойш дохиолол илгээх системд мэдээлэл хүрэх хүртэлх хугацаа	15 секундийн дотор	4 секундийн дотор
Станцад чичирхийллийг мэдэрснээс хойш дохиолол цацах хүртэлх нийт хугацаа	20 секундийн дотор	5-10 секундийн
Мэдээлэл хүргэх арга	Гар утасны мессеж, дуут дохиолол, радио телевиз	Телевиз, радио, areamail, J-Alert, тусгай терминал, интернет
Серверийн байрлал	Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн байранд 1	Токио (үндсэн), Осака (туслах) хотод тус бүрт 1

“Эх сурвалж: Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх” төслийн тайлан, УБ., 2013

Жайка олон улсын байгууллагаас Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлж, газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах системийн дараах дутагдалтай талуудыг онцолсон байна⁶. Үүнд:

- Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд холбогдох байгууллага хоорондын мэдээлэл солилцох, хамтран эзэмших тогтолцоо байхгүй байна.

- Гамшгийн үеийн мэдээлэл ашиглалттай холбоотой эрх зүйн тогтолцоо, хэрэгжүүлэх этгээд, зарлан мэдээллийн системд үзлэг шалгалтын тогтолцоо бүрдээгүй байна.

- Яаралтай үеийн мэдээлэл дамжуулах хурд удаан байгаа нь мэдээллийн үнэ цэнийг бууруулж байна.

- Монгол Улсын хүн амын талаас илүү хувь нь амьдарч байгаа Улаанбаатар хотод суурилуулсан дуут дохиоллын цамхгийн тоо цөөн, хамрах хүрээ бага байна.

- Зарлан мэдээллийн системийн харилцаа холбооны үндсэн сүлжээ нь тасарсан тохиолдолд орлуулах сүлжээг тооцоогүй, газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх нь тодорхойгүй байна.

- Ус, халаалт тасалдахад нөөцийг тооцоогүй байна.

- Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн барилга газар хөдлөлтийн үед дифромацадороход өрөөнүүдийн хаалга онгойхгүй болох магадлалтай байна.

- Серверийн өрөө нь хэт халалтаас сэргийлэх арга хэмжээ болон тавиуруудын бэхэлгээ хийгдээгүй байна.

- Зарлан мэдээлэх хөдөлгөөнт удирдлагын төвийг аюулгүй газарт байрлуулаагүй байна.

- Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг зарлан мэдээлэх шалгуур үзүүлэлт байхгүй.

Б. Иргэдийн зарлан мэдээллийн дохиогоор ажилласан байдалд хийсэн шинжилгээ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх, хүн, хүч дайчлан гаргах журам”-уудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль

⁶Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн тайлан, УБ., 2013, х.7-9

явагддаг бөгөөд энэ зарлан мэдээллийн дохио нь хэрхэн хүрч байгааг тодруулах асуулт бүхий анкетаар иргэдийн хандлагыг тодорхойлсон судалгааны үр дүнгээс танилцуулъя:

2017, 2018 онуудад авсан санал асуулгад Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдийн нийт 28 цэгээс 1200 гаруй иргэн хамрагдсан.

Хүснэгт 23. Санал асуулга авсан байршлууд

№	Байршил	Дүүрэг
2017 онд		
1	“Баянмонгол”хороолол орчим /БЗД 26-р хороо/	Баянзүрх дүүрэг
2	Цайз зах орчим	
3	Офицеруудын ордон орчим	
4	Гандан орчим	
5	25-р эмийн сан орчим	Баянгол дүүрэг
6	Урт цагаан, Бөмбөгөр худалдааны төв орчим	Чингэлтэй дүүрэг
7	21-р хороолол орчим	Сонгинохайрхан дүүрэг
8	Баянхошуу орчим	
9	Москва хороолол орчим	
10	Их дэлгүүр орчим	Сүхбаатар дүүрэг
11	Сөүлийн гудамж орчим	
12	19-р хороолол орчим	Хан-Уул дүүрэг
2018 онд		
№	Дүүрэг	Байршил
1	“Гэгээнтэн”, “Хурд”, “Хүннү”, “Энканто”, “Буянт-Ухаа” хорооллууд, “Чингис хаан” ОУНБ-ын орчмоос	Хан-Уул
2	“Олимп”, “Кристалтаун”, “Баянмонгол”, “Их Монгол” хорооллууд, “Сандэй”, “Нарантуул”, “Дүнжингарав” худалдааны төвүүд	Баянзүрх
3	“Дэнжийн мянга”, “Хүчит шонхор” худалдааны төвүүд орчмоос	Чингэлтэй
4	“Хархорин” худалдааны төв орчмоос	Сонгинохайрхан
5	“Барс” худалдааны төв, “Улаанбаатар” төмөр замын өртөө, “Өргөө” кино театр, 3,4-р хороолол орчмоос	Баянгол

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл:




Зураг 34. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар

2017 оны санал асуулгад ажилгүй иргэд болон хувийн хэвшлийн байгууллагуудын “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургууль”-д оролцох оролцоо идэвх, гамшгийн талаарх мэдээллийг


илүү судлах зорилготой байсан учраас нийт асуулгад оролцогчдын 73% нь хувийн байгууллагад ажилладаг болон ажилгүй иргэд оролцсон нь асуулгын дүнг судалгааны зорилгыг хангана гэж үзсэн.

Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгосон талаар мэдэх үү? гэсэн асуултанд 2017 онд оролцсон иргэдийн 60.4% буюу 363 иргэн “тийм”, 39,5% буюу 237 иргэн үгүй гэж хариулсан бол 2018 онд иргэдийн мэдлэг нэмэгдсэн дүн гарсан байна.



Зураг 35. Иргэдийн ГХАУСТӨ-ийн талаарх мэдлэг⁷

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг ямар хэлбэрээр хүлээж авсан бэ? гэсэн асуултанд:




Зураг 36. Зарлан мэдээллийн дохиог хүлээн авсан байдал

2017 оны асуулгын үр дүнтэй 2018 оныг харьцуулахад дуут дохио сонсоогүй ямар ч мэдээлэлгүй байсан хүмүүсийн эзлэх хувь 2.3%-иар өссөн, гамшгийн аюулын

⁷ Д.Нарантуяа (2018)

тухай зарлан мэдээллийг “дуут дохио” хэлбэрээр авсан иргэдийн тоо 15.9% буурсан байна. Санал асуулга авсан байршлууд өөрчлөгдөж хотын шинэ орон сууцны хорооллуудыг хамруулсан нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиог сонссон уу? гэсэн асуултанд: 2017 онд оролцсон иргэдийн 68.2% буюу 409 нь “тийм”, 31.8% буюу 191 иргэн үгүй гэж хариулсан байна.




Зураг 37. Зарлан мэдээллийн дуут дохио олон нийтэд хүрсэн байдал

Өмнөх оны асуулгын үр дүнтэй харьцуулахад 5.1%-иар буурсан байна.

- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг ямар хэлбэрээр хүлээж авсан бэ? гэсэн асуултанд санал асуулгад 2017 онд хамрагдсан иргэдийн 41.3% буюу 248 нь “дуут дохиогоор”, 24% буюу 144 иргэн “телевизээр”, 3.2% буюу 19 нь “радио, FM-ээр”, 27.3% буюу 164 нь “мессежээр” хүлээж авсан гэж хариулсан бол 4.3% буюу 25 нь энэ асуултанд хариулаагүй буюу энэ талаар ямар ч мэдээлэлгүй байсан.


2018 оны асуулгын үр дүнгээс харахад дуут дохио сонсоогүй ямар ч мэдээлэлгүй байсан хүмүүсийн эзлэх хувь 2.3%-иар өссөн, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг “дуут дохио” хэлбэрээр авсан иргэдийн тоо 15.9% буурсан байна. Санал асуулга авсан байршлууд өөрчлөгдөж хотын шинэ орон сууцны хорооллуудыг хамруулсан нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохио дуугарах үед та хаана байсан бэ? гэсэн асуултанд санал асуулгад:



Зураг 38. Зарлан мэдээллийн дуут дохио дуугарах үе дэх иргэдийн байршил


Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохио танд тодорхой, тод сонсогдсон уу? гэсэн асуултанд:



Зураг 39. Зарлан мэдээллийн дуут дохио сонсогдсон байдал


2017 оны дүнтэй 2018 оныг харьцуулбал “тод” сонссон иргэд 8.4%-иар буурч, “сул” сонссон иргэдийн тоо 3.1%-иар өсч, сонсоогүй болон хариулаагүй иргэдийн тоо 4.6%-иар өссөн байна.

- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохио дуугарсан даруйд та дараах үйлдлүүдийн алийг нь сонгох вэ? гэсэн асуултанд санал асуулгад оролцсон иргэдийн 35.8% буюу 215 нь “шууд гадагш гарна”, 24.7% буюу 148 нь “ширээн доогуур орно”, 18.2% буюу 109 нь “ширээн доогуур орох болон даацын хана налж зогсоно” гэсэн хариулт, 12.2% буюу 73 нь “даацын хана налж зогсоно” гэсэн хариулт, 5.2% буюу 31 нь “цонхны дэргэд зогсох болон шууд гадагш гарна” гэсэн хариулт, 2.5% буюу 15 нь “цонхны дэргэд зогсоно” гэсэн хариултыг зөв гэж үзсэн байна. Энэ асуултанд 1.5% буюу 9 нь хариулаагүй байна. Энэ асуултыг дүнг өмнөх онтой харьцуулахад зөв хариулт сонгосон иргэдийн нийт тоо 4.4% буюу 27 иргэнээр нэмэгдсэн байна.




Зураг 40. Гамшгийн үед иргэдийн авах арга хэмжээ

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохио дуугарах үед цугларах аюулгүй байр, талбайг мэдэх үү? гэсэн асуултанд 2017 онд 69.2% буюу 422 нь “үгүй”, 30.8% буюу 188 нь “тийм” гэж хариулсан бол 2018 онд 63.4% буюу 380 нь “үгүй”, 36.7% буюу 220 нь “тийм” гэж хариулсан байна. Өмнөх оны үр дүнтэй харьцуулахад гамшгийн аюулын үед цугларах байр талбайг мэддэг иргэдийн тоо 5.8%- иар өссөн байна.



Зураг 41. Иргэдийн гамшгийн үед цугларах аюулгүй талбайн талаарх мэдлэг

Та гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуульд оролцсон уу? гэсэн асуултанд санал асуулгад оролцсон иргэдийн 69.4% буюу 423 нь “үгүй” гэж, 30.7% буюу 187 нь “тийм” гэж хариулсан.




Зураг 42. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийн иргэдийн оролцоо

Хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой эд зүйлсийн жагсаалтыг та мэдэх үү, танд бэлэн байдаг уу? Гэсэн асуултанд 2017 онд санал асуулгад оролцсон иргэдийн 60.9% буюу 371 нь “мэдэхгүй, байхгүй” гэсэн хариулт, 27.5% буу 168 нь “мэднэ байхгүй” гэсэн хариулт, 11.6% буюу 71 иргэн “мэднэ, байдаг” гэсэн хариулт тус тус өгсөн бол 2018 онд 57.5% буюу 345 нь “мэдэхгүй, байхгүй” гэсэн хариулт, 31% буу 186 нь “мэднэ байхгүй” гэсэн хариулт, 11.5% буюу 69 иргэн “мэднэ, байдаг” гэсэн хариулт тус тус өгсөн байна.

Уг үзүүлэлтээс харахад санал асуулгад оролцсон иргэдийн 88.5 хувьд хүн нэг бүрийн үүргэвч байдаггүй бөгөөд хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой эд зүйлсийн жагсаалтыг 61% нь огт мэдэхгүй байна гэдэг нь маш хангалтгүй дүн юм.


Өмнөх оны үр дүнтэй харьцуулбал хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой зүйлийг мэддэг боловч байдаггүй иргэдийн тоо 3.5%-иар өссөн байна.

Уг үзүүлэлтээс харахад санал асуулгад оролцсон иргэдийн 90% орчимд нь хүн нэг бүрийн үүргэвч байдаггүй бөгөөд хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой эд зүйлсийн жагсаалтыг 61% нь огт мэдэхгүй байна гэдэг нь маш хангалтгүй дүн юм.



Зураг 43. Хүн нэг бүрийн үүргэвчний судалгаа

2018 онд “Таны гэр, ажлын байрны ойролцоо гамшгийн үед давхар эрсдэл учруулж болохуйц хүчин зүйлс /объект/ байрладаг уу?” гэсэн асуултанд нийт оролцогчдын 32% буюу 195 нь “өндөр барилга”, 22.3% буюу 24.8% буюу 151 нь “байхгүй” гэсэн хариулт, 17.2% буюу 105 нь “өндөр хүчдэл” гэсэн хариулт, 13.6% буюу 83 нь “ШТС” гэсэн хариулт, 12.5% буюу 76 нь “үерийн далан” гэсэн хариулт тус тус өгсөн байна.



Зураг 44. Гамшгийн эрсдэл учруулж болохуйц хүчин зүйлсийн талаар

Уг асуултын хүрээнд газар хөдлөлтийн гамшгийн үед хамгийн өндөр эрсдэл дагуулж болохуйц хүчин зүйл бол өндөр барилга гэдэг нь харагдаж байгаа бөгөөд иргэдийн зүгээс хуучин барилга, байгууламж, цэвэрлэх байгууламж зэргийг эрсдэлтэй гэж саналаа илэрхийлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд 2018 онд зохион байгуулагдсан дадлага сургуульд санал асуулгад оролцсон иргэдийн 71.2 % нь хүлээн авч сонссон нь өмнөх оны дүнтэй харьцуулбал 1.8%-иар буурсан байна. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуульд нийт санал асуулгад хамрагдсан иргэдийн 68.7% буюу өмнөх оны дүнтэй харьцуулбал 0.7%-иар буурсан нь ажиглагдсан. Шинээр үүсч буй орон сууцны хорооллын бүсүүд “Олимп”, “Кристалтаун”, “Баянмонгол”, “Их Монгол”, “Буянт-Ухаа” хорооллуудад зарлан мэдээллийн дуут дохионы хүртээмж дутмаг байгаа нь санал асуулгын дүнгээс ажиглагдсан. Үүнээс дүгнэхэд олон нийтийн идэвхи маш сул, оролцоо хангалтгүй байна. Мөн дадлага сургуульд оролцсон иргэдийн хандлагыг ажиглахад үл тоомсорлосон, хайхрамжгүй зэрэг байдал анзаарагдсан. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохионы цамхагуудын тоог нэмж, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль явагддаг ч иргэдийн мэдээлэл хүлээж авах байдал харилцан адилгүй,

хувийн хэвшлийн байгууллага, засаг захиргааны бага нэгжийн /баг, хороо/-ны зохион байгуулалт, идэвхи, оролцоо сул байна гэж үзэж байна.

- Иймээс иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн бэлэн байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хувийн хэвшлийн байгууллагуудын идэвхи, оролцоог нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна.

- Мөн иргэдийн зүгээс дадлага сургуулийг гэнэтийн байдлаар зохион байгуулах нь илүү зохимжтой гэсэн санал ирүүлсэн.

- Гамшгийн бэлэн байдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажлыг иргэдэд сонирхолтой, хүртээмжтэй байлгах

- Болзошгүй гамшгийн үед иргэд өөрсдийн амь, бие, эд хөрөнгөө хамгаалах үзүүлэх сургалтыг зохион байгуулах /хэвлэл мэдээллийн хэрэгслээр баримтат кино гаргах/

ГУРАВДУГААР БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

3.1. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээний чиглэл

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй газар хөдлөлтийн аюулын давтамж нэмэгдэж байгаа нь тус хотын хувьд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлаа дээшлүүлэхэд онцгой анхаарал хандуулах цаг ирснийг илтгэнэ.

Бэлэн байдлыг хангах арга хэмжээний мөн чанар нь гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, цаашлаад гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах бэлтгэлийг хангасан байхад оршдог.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах асуудлыг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тулгуур баримт бичиг болох Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн " *Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд "Сайжруулан барих" үйл ажиллагааг хэрэгжүүлэх* " гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд тусгаж өгсөн. Энэ тэргүүлэх чиглэлд авч үзсэн асуудлаас газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахтай холбоотой арга хэмжээг тоймлон авч үзье:

а) ...гамшгийн бэлэн байдлын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, нягтлах, тогтмол шинэчлэх

б) ...эрт зарлан мэдээлэх систем, онцгой байдлын үеийн харилцаа холбооны механизм, олон нийтийн мэдээллийн технологи, аюулыг хянах харилцаа холбооны системд хөрөнгө оруулах, хөгжүүлэх, ажиллуулах, бэхжүүлэх

в) Гамшгийн үед болон гамшгийн дараа ард иргэдийн амь насыг аврах, амин чухал бусад үйлчилгээг үзүүлэх, аюулгүй байх, үр дүнтэй ажиллах баталгааг хангахын тулд нэн чухал дэд бүтцийн гамшгийг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх...

г) Олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, аврах, яаралтай тусламжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай материалуудыг нөөцлөх төвүүдийг байгуулах

д) Яаралтай тусламжийн зохицуулалт, санхүүжилтийн механизм, журмыг бий болгох, сайжруулах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх ажиллагааг төлөвлөх, бэлтгэх төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төрийн бодлого, үйл ажиллагааг батлах

е) Онцгой байдлын үед хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ажиллах хүч, сайн дурын ажилтнуудаа сургах, техник ложистикийн чадавхыг нь бэхжүүлэх

ё) Гамшгийн дараах үе шатанд нийгэм, эдийн засгийг сэргээн босгох, суурь үйлчилгээгээр хангах асуудлыг тусгасан төлөвлөлт хийж, хэрэгжих нөхцлийг хангах

ж) Нүүлгэн шилжүүлэх дасгал сургууль зэрэг гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааны дадлагыг тогтмол зохион байгуулах... түр хоргодох аюулгүй байр, нэн шаардлагатай хүнс, яаралтай тусламжийн зүйлсийг бүрдүүлэх, түгээх тогтолцоо бий болгох

и) Гамшгийн дараах сэргээн босгох үйл ажиллагааг орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үйл явцтай уялдуулах

й) Газар ашиглалтыг төлөвлөх, барилга байгууламжийн стандартыг сайжруулахад чиглэсэн зааварчилгаа боловсруулах

к) Гамшигт өртөмтгий газарт байрлаж буй нэн чухал дэд бүтэц, хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх орон нутгийн засаг захиргааны чадавхыг бэхжүүлэх

л) Олон улсын гамшгийн яаралтай болон эрт үеийн сэргээн босгох тусламжийн ажиллагааг дотооддоо зохицуулах хууль, дүрэм, журмыг нягтлах, сайжруулах

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах онол, аргазүйд болон Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд авч үзсэн асуудлууд түүнчлэн Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдалд хийсэн судалгааны үр дүндээ тулгуурлан цаашид Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний саналыг дараах байдлаар тодорхойлов.

Гамшигт тэсвэртэй хот хөдөлгөөний 10 үндсэн чиглэлийн хүрээнд хийх ажилтай судалгааны үр дүнгээс дэвшүүлж буй арга хэмжээний саналын уялдах байдлыг тодорхойлж өгсөн болно.

Хүснэгт 24. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээ, дэвшүүлж буй саналын матриц

Арга хэмжээний чиглэл	Дэвшүүлж буй санал		
	Богино хугацаанд 1-2 жилд	Дунд хугацаанд 3-5 жилд	Урт хугацаанд 5-аас дээш жилд
Газар хөдлөлтийн гамшгаас	Шинэ хагарлын шинж чанар, үүссэн нөхцөл болон түүн дээр болох боломжит хүчтэй газар хөдлөлтийн давтагдлыг	Улаанбаатар хотод учирч болзошгүй газар хөдлөлтийн эрсдэлийг дахин үнэлэх ²	Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох ажиллагааны

<p>хамгаалах төлөвлөлтийг сайжруулах</p>	<p>судлах²</p> <p>Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүнийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулах аргачлал, зааврыг боловсруулах⁶</p> <p>Барилга, байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэршилтийг тогтоох инженер техникийн ажилтнуудыг сургаж бэлтгэх⁶;</p> <p>Нийслэлийн бүх түвшний удирдах ажилтнуудын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх⁶</p>	<p>Бүх түвшний газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээ, хохирлын төсөөлөлд үндэслэж боловсруулах⁹</p> <p>Гамшгаас хамгаалах төлөвлөгөө (Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө, Сэргээн босгох төлөвлөгөөг багтаасан) боловсруулах гарын авлага, сургалтын модулийг бий болгох⁹</p> <p>Онцгой байдлын байгууллагын холбогдох алба хаагчдын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахтай холбоотой мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх⁶</p>	<p>төлөвлөгөөг "илүү сайнаар барьж байгуулах" үзэл баримтлалд тулгуурлан боловсруулах¹⁰</p>
<p>Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бүх нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах</p>	<p>Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт, арга хэмжээний агуулга, чанарт хяналт тавих механизм бий болгох²</p> <p>Сайн дурынхан, сургагч багш нарын нэгдсэн судалгааг гаргах, тэднийг сургаж бэлтгэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах⁷</p> <p>Иргэдэд мэдлэг олгож буй өөрийн нөхцөлд нутагшсан сайн туршлага, оновчтой санал, санаачлагыг тодруулж түгээн дэлгэрүүлэхэд чиглэлд уралдаан, хөтөлбөрийг зохион байгуулах, сайн туршлагыг түгээх, санаачлагчийг алдаршуулах⁷</p>	<p>ЕБС-д аюулгүй амьдрах ухааны хичээлийн албан хөтөлбөрийг Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагааг дэмжиж сурагчдад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах цогц мэдлэг, чадвар олгох⁷</p> <p>Хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой эд зүйлсийн жагсаалтын дагуу бэлтгэх⁷</p> <p>Гамшгаас хамгаалах сургалт аргазүйн төвд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэгийг нийслэлийн иргэдэд хүргэх ажлыг шат дараатай зохион байгуулах⁴</p>	<p>Хотын хүрээлэн буй орчныг сайжруулах болон хөгжлийн урт хугацааны төлөвлөлттэй уялдуулсан газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх болон шинээр барьж байгуулах стратегийг бий болгох¹⁰</p>
<p>Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх</p>	<p>Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын хүрээнд Зарлан мэдээллийн дуут</p>	<p>Шинээр төлөвлөж буй орон сууцны хороолол болон барилгад дотоод</p>	<p>Орон сууцны хорооллын бүсүүдэд зарлан мэдээллийн</p>

<p>системийг боловсронгуй болгох</p>	<p>дохиогоор ажиллах дадлага, сургуулилтын үед явагдаж буй сургалтыг сайн дурынхан, сургагч багш нарыг татан оролцуулж хийх⁷</p> <p>Дадлага сургуулийг гэнэтийн байдлаар зохион байгуулж иргэдийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах мэдлэг, хандлагыг тандах⁷</p>	<p>зарлан мэдээллийг зайлшгүй төлөвлөх эрхзүйн зохицуулалтыг бий болгох⁹</p> <p>Зарлан мэдээллийн системийн харилцаа холбооны үндсэн сүлжээ нь тасарсан тохиолдолд орлуулах нөөц сүлжээг тооцож газар хөдлөлтөд тэсвэртэйгээр төлөвлөх⁹</p>	<p>дуут дохионы хүртээмжийг нэмэгдүүлэх⁹</p> <p>Газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээлэх системийг Р алерт системийг суурилуулан шинэчлэх⁹</p>
---	---	---	---

Тайлбар: Дэвшүүлж буй арга зам бүрийн ард байгаа 2-10 хүртэлх тоогоор уг арга хэмжээ Гамшиг тэсвэртэй хот хөдөлгөөний 10 үндсэн чиглэлийн аль хэсэгтэй уялдаж буйг харуулав.

Судалгааны ажлаас дэвшүүлсэн дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд харгалзаж үзвэл зохих онол, аргазүйн асуудлыг дараах хэсэгт дэлгэрүүлэн авч үзсэн.

3.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах арга зам

Газар хөдлөлт нь урьдчилан таамаглах боломжгүй гэнэт тохиолддог хамгийн их сүйтгэл учруулдаг хор уршиг, хөнөөл ихтэй байгалийн гамшиг юм. Газар хөдлөлтийн энэ шинж чанар нь бүх түвшинд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж бэлэн байдлаа хангах зайлшгүй шаардлагатай болохыг сануулж байдаг.

3.2.1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах

Удирдахуйн ухаанд төлөвлөлтийн үйл ажиллагаа нь нэгд, урьдчилан төсөөлөх, хоёрт, боловсруулах, гуравт, загварчлах гэсэн үндсэн үе шатыг дамжин хэрэгждэг⁸ гэж үздэг. Энэхүү үндсэн үе шатын хүрээнд төлөвлөлтийн үйл ажиллагааны 6 үе шат⁹ байдаг байна. Үүнд:

1. Нөхцөл байдлыг шинжлэх
2. Зорилго ба түүний хувилбаруудыг боловсруулах
3. Зорилго ба хувилбарыг үнэлэх
4. Зорилго ба хувилбарыг сонгох
5. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх
6. Төлөвлөгөөг хянах ба үнэлэх

Төлөвлөлтийн үйл явцын үр дүнд төлөвлөгөө гарна. Төлөвлөгөө бол биелэгдэхүйц үйл ажиллагааг тусгасан баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны чиглүүлэгч нь юм¹⁰. Төлөвлөгөөг стратегийн, тактикийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө гэж ангилдаг¹¹ бөгөөд эдгээр нь өөр хоорондоо бүгд уялдаа холбоотой,

⁸ Цэрэндорж Д, Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан, УБ 2013, х.173

⁹ Норжинванчиг, Б. Мөнх, П нар. Менежмент. 1997. Х. 69

¹⁰ Эрдэнэсүрэн, Б. Батхүрэл, Г нар. Менежмент. УБ., 2000. Х. 102

¹¹ Цэрэндорж Д, Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан, УБ 2013, х.179

өөр өөрийн зорилго, чиглэлтэй байдаг. Аль ч төлөвлөгөөг боловсруулсан төлөвлөлтийн дээрх 6 үе шатыг дамжина.

Газар хөдлөлтийн чиглэлээр өнөөдөр батлагдсан төлөвлөгөөний өнөөгийн байдлаас авч үзвэл газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах талаар урт болон дунд хугацаанд хийх ажлыг тусгасан стратегийн төлөвлөгөө (Засгийн Газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (2016-2020)), түүнийг хэрэгжүүлэх тактикийн төлөвлөгөө (Бүх шатны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө) боловсруулж байгаа нь харагдаж байна. Харин одоогоор ажиллагааны түвшний буюу шуурхай төлөвлөгөө байхгүй байна. Эдгээр төлөвлөгөө хоорондын уялдаа холбоог хангах, түүнчлэн төлөвлөгөө тус бүрийн онцлог хийгээд мөн чанарыг ойлгож үнэн бодит, хэрэгжихүйц төлөвлөгөө боловсруулах нь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангахад ихээхэн чухал ач холбогдолтой байх болно.

Стратегийн төлөвлөгөө бол зорилгоос үр дүнд хүрэх ажиллагааны арга зам, хэрэгсэл, хүч, энергийн цогц нэгдлээр илэрхийлэгдэх онцлог шинжийг өөртөө агуулж байдаг.

Стратеги хэмээх ойлголт нь дайныг явуулах, удирдах урлаг (Ш.Паламдорж, 2017) гэсэн утгатай цэрэг, армиас үүссэн нэр томъёо юм. Үүнтэй уялдуулаад авч үзвэл дайныг удирдахын гол зорилго нь ялалт байгуулах явдал бөгөөд ингэхийн тулд дайснаа судалж, өөрийн хүч нөөцөө үнэлж энэ үндсэн дээр ялалт байгуулах арга зам буюу төлөвлөгөөгөө боловсруулна.

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн стратегийн төлөвлөгөөг боловсруулахдаа Улаанбаатар хотын хувьд хамгийн том дайсан байж болох газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлж, хотын өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломжоо мөн шинжилж үзсэний үндсэн дээр уг дайсныг дарах арга зам буюу төлөвлөгөөгөө боловсруулна. Стратегийн төлөвлөгөө нь өргөн хүрээний асуудлыг урт хугацаанд буюу ихэвчлэн 2-5 жилийг хамруулан, нэн их нөөцтэй холбон авч үздэг. Стратегийн төлөвлөгөөнөөс тактикийн төлөвлөгөө урган гарч ирнэ.

Тактикийн төлөвлөгөө нь стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэмэр болж, стратегийн төлөвлөгөөний хүрээнд үндсэн нэгж хэсэг, салбарууд юу хийх шаардлагатайг тодорхойлдог. Түүнээс гадна тактикийн төлөвлөгөө нь нөөц болон цаг хугацааны хувьд илүү тодорхой байх тул олон талуудын хамтын ажиллагаа шаардсан эсвэл цаг хугацаа шаардсан ажлуудыг тактикийн төлөвлөгөөнд тусгадаг байна.

Тактикийн төлөвлөгөө нь нөөц болон цаг хугацааны хувьд илүү тодорхой, нөөцийг үр дүнтэй ашиглахыг шаарддаг зэрэг онцлог шинжүүдийг агуулдаг¹² байна. Үүнтэй холбоотойгоор бүх шатны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тактикийн төлөвлөгөөнд хамааруулж авч үзэж болно.

¹² Б.Мөнхжаргал нар., Менежмент

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь газар хөдлөлтийн аюулаас хүн ам, үнэт зүйлс, эд хөрөнгө, мал амьтан байгаль орчныг урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах ажлыг хэн, хэзээ, хэрхэн гүйцэтгэхийг дэс дараатайгаар төлөвлөсөн удирдлагын баримт бичиг юм.


Тактикийн төлөвлөгөөний эцсийн амжилт нь түүний боловсруулалтаас илүүтэйгээр хэрэгжүүлэлтийн арга замаас шалтгаалдаг. Амжилттай хэрэгжүүлэлт нь нөөцийн оновчтой ашиглалт, үр нөлөөтэй шийдвэр гаргалт болон зөв зүйлийг зөв цагт нь зөв арга замаар хийхээс хамаарч байдаг¹³. Эдгээр онцлог асуудлуудыг газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгаж өгөх нь түүнийг үр дүнтэй хэрэгжихэд нь чухал нөлөөтэй гэдгийг ойлгох нь чухал юм.

Энэхүү үе шатын хүрээнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн үйл явцыг (1) Холбогдох хууль тогтоомж, оролцогчийн хүрээг тогтоох, (2) Үүсч болох газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдлыг урьдчилан төсөөлөх, (3) Үүссэн нөхцөл байдлын үеийн нөөц, боломжоо оновчтой тодорхойлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл ямар байх хугацаа, дарааллыг тогтоох, (4) Арга хэмжээг ач холбогдлоор нь ангилж нэн яаралтай авах арга хэмжээг тогтоох (5) Төлөвлөгөөнд тусгах ажлуудыг хэрэгжүүлэх арга замыг боловсруулах, батлуулах (6) Хэрэгжүүлэх ба хянах гэсэн зургаан алхамаар хийгдэх эдгээр тус бүрдээ орц, явц, гарц ба үр дүн бүхий систем гэж үзэж болохоор байна.

Ингээд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн үйл явцыг (зураг 45) үзүүлсэн зураглалаар илэрхийлсэн болно.

¹³ П.Цэдэв., Гамшгаас хамгаалах төлөвлөлт, 2018 х.66

Зураг 45. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн үйл явц



Одоогоор Улаанбаатар хотын хэмжээнд төдийгүй нийт улс орны хэмжээнд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн хүрээнд маш хангалтгүй хийгдэж байгаа арга хэмжээ бол гамшгийн үеийн ажиллагааг тусгасан шуурхай төлөвлөгөө болон гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөнүүд юм.

3.2.2. Газар хөдлөлтийн гамшгийн үед ашиглах Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө бий болгох

Газар хөдлөлтийн гамшгийн үеийн ажиллагааг тусгасан шуурхай төлөвлөгөө төлөвлөгөө нь тактикийн түвшний төлөвлөгөө болох бэлэн байдлын төлөвлөгөөнөөс урган гарч үйл ажиллагааг нарийвчлан задалж хэн, юуг хэзээ, яаж хийх, түүнд ямар хэмжээний нөөц хэрэгтэй, түүнийг хэрхэн хангах арга хэмжээг нэг бүрчлэн заана. Энэ төлөвлөгөөг байгууллагын доод түвшинд буюу ажиллагааг гардан хэрэгжүүлдэг ажилтнууд боловсруулдаг.

Аливаа байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах асуудлыг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө одоогоор байхгүй байна гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, зөвхөн газар хөдлөлтийн гамшгийн үед талууд хэрхэн ажиллах тактикийг л тодорхойлсон төлөвлөгөөг одоогоор бүх түвшинд боловсруулж байна. Угтаа бол төлөвлөгөө нь ажлыг хэн, хэдийд, хэрхэн гүйцэтгэхийг зааварчилсан байх баримт бичиг байдаг. Одоогоор манай улсад газар хөдлөлтийн гамшиг болсон үед үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд хэн, ямар хугацаанд ямар ажлуудыг яаж хийхийг нарийвчлан төлөвлөөгүй байна.

Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө нь хэрвээ ямар нэг гамшиг тохиолдоход байгууллагын үндсэн үйл ажиллагааг тасалдахад хүргэж болзошгүй нөлөөллийг болон хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг үр дүнтэй явуулах арга замыг тодорхойлдог.

Тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нь гамшгийн өмнө гамшиг тохиолдсон үед ажилчид, эд хөрөнгө, мэдээллийн технологийн систем, мэдээллийн аюулгүй байдлаа хангах нэр хүндээ хамгаалахын тулд бэлэн байдлаа хангаж юу хийх ёстойг тогтооход тусална.

ТАТ нь газар хөдлөлтийн гамшиг тохиолдож бүх төрлийн нөөц (хүн хүч, техник хэрэгсэл, санхүү) хязгаарлагдмал болсон үед заавал авч хэрэгжүүлэх нэн чухал арга хэмжээг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх бүтэц, орчинг бүрдүүлэх зорилготой хийгдэнэ. Энэ утгаараа тус төлөвлөгөө нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй байх төлөвлөгөөнд тооцогддог байна.

Тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг дараах бүтэцтэйгээр боловсруулна. Үүнд:

- Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө
 - Онцгой байдлын үед ажиллах тогтолцоо бүрдүүлэх:
Онцгой байдлын үед үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг 2 хувилбараар томилгоожуулах
 - Онцгой байдлын үед авах хор уршгийг арилгах, сэргээх ажиллагаа:
Удирдлагын баг, тэдгээрийн цугларах болон үүрэг чиглэл өгөх дараалал
Нөөцүүд, барилга байгууламж, ажилтнуудын бүрэн бүтэн байдлыг шалгах
Харилцагч, ажилтнууд болон бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах

Хоёрдогч аюулаас сэргийлэх

Байгууллагад үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг дамжуулах

- Ажилтан бүр аюулгүй байдлаа хангах, удирдлага, гэр бүлдээ эсэн мэнд гэдгээ мэдэгдэх Б

- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө:

- удирдлагын байр болон нэмэлт байрны барилга
- байгууламж, эд зүйлийн аюулгүй нөхцлийг хангах
- амин чухал үйлчилгээ цахилгаан, ус зэргийн нөөц хувилбар гаргах
- мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах
- чухал мэдээлэл, баримт бичгийн аюулгүй байдлыг хангах
- харилцагчид, нийлүүлэгчээ олон болгох
- нөөц бүрдүүлэх

- Сургалт, дадлагын төлөвлөгөө

- Хянах, сайжруулах төлөвлөгөө

Тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлд анхаарах шаардлагатай.

1. Нэн чухал хийгдэх ажил, түүнийг хэрхэн хийх зааврыг гаргах

Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээнээс амин чухал арга хэмжээг тодорхойлох (дулааны болон хүйтний улирлаар ялгаатай байх), эдгээрийг хамгийн боломжит бага нөөц (цаг, хүн хүч, мэдээлэл)-ийг ашиглан тодорхой хугацаанд удирдан зохион байгуулах зааврыг гаргахад л тогтвортой ажиллагааны төлөвлөгөөний мөн чанар орших юм. Товчхондоо энэ төлөвлөгөөнд байгууллагын бүхий л үйл ажиллагааг бус зөвхөн хамгийн амин чухал үйл ажиллагааг хэрхэн хийхийг төлөвлөнө.

Түүнээс гадна тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад хамгийн чухал асуудал бол эдгээр тодорхойлсон нэн чухал ажлуудыг хийх хугацаа тодорхой байх ёстой. Ямар хугацаанд тогтвортой ажиллагааг хангахад энэ төлөвлөгөөг ашиглах нь тодорхой харагдаж байна гэсэн үг юм. ТАТ-нд нэн чухал арга хэмжээг хариуцах эзнийг томилж, үүнд шаардлагатай нөөцийг бэлтгэх асуудал мөн хамаардаг. Иймд ТАТ-нд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг томилгоожуулахдаа ажлын болон ажлын бус цагаар ялгаатай тогтоож өгөх нь зүйтэй. Ингэхдээ ажлын бус цагаар хамгийн бага хугацаанд тухайн байранд ирж үүрэг гүйцэтгэх боломжтой алба хаагчийг эхний ээлжинд ирж ажиллахаар, үүний дараагийн алба хаагчийг амьдарч буй байршлыг нь харгалзан үзэж томилгоожуулах нь оновчтой байж болох юм. Япон улсын хувьд газар хөдлөлтийн гамшгийн үеийн ТАТ-нд үүрэг гүйцэтгэхээр томилгоожсон эхний ээлжинд ирэх алба хаагчдыг тухайн байрнаас хамгийн боломжит бага хугацаанд хүрэлцэн ирэхүйц байршилд орших албаны байраар хангах арга хэмжээг зохион байгуулдаг байна.

Ерөнхийдөө ТАТ нь дараах агуулгын хүрээнд бичигдэнэ. Үүнд:

1. Онцгой байдлын үед ажиллах удирдлагын тогтолцоо бүрдүүлэх

- Онцгой байдлын үед үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг 2 хувилбараар томилгоожуулах

- Сэлгэн байрлах нэмэлт газар бий болгох, үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлэх
2. Онцгой байдлын үед авах хор уршгийг арилгах, сэргээх ажиллагаа:
- Удирдлагын баг, тэдгээрийн цугларах болон үүрэг чиглэл өгөх дараалал
 - Нөөцүүд, барилга байгууламж, ажилтнуудын бүрэн бүтэн байдлыг шалгах
 - Харилцагч, ажилтнууд болон бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах
 - Хоёрдогч аюулаас сэргийлэх
 - Байгууллагад үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг дамжуулах
 - Ажилтан бүр аюулгүй байдлаа хангах, удирдлага, гэр бүлдээ эсэн мэнд гэдгээ мэдэгдэх

Япон улсын туршлагаас харахад ТАТ дэх томилгоот бүрэлдэхүүн болон эдгээрийн хариуцаж хийх дээрх ажлуудын хамрах хүрээ, дарааллыг тогтоосон алхамчилсан зааврыг боловсруулж түүнийг удирдлагын байранд байршуулах нь ихээхэн үр дүнтэй гэдэг нь харагдаж байсан.

Эндээс тухайн байгууллага бүр өөрсдийн үйл ажиллагааны онцлогтоо тохируулан газар хөдлөлтийн гамшгийн үед авах нэн чухал арга хэмжээ, эдгээрийг хийх зорилтот хугацааг болон хэрэгжүүлэх алхамчилсан зааврыг өөрсдөө боловсруулах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

2. Маш товч ойлгомжтой, ашиглахад хялбар бичих

Аливаа төлөвлөгөө бол заавал тодорхой хугацаанд зохих хэмжээний хүч хөдөлмөр, нөөцийг зарсаны үр дүнд гарах бодит үр дүнг багтаасан цогц баримт бичиг байдаг. Өөрөөр хэлбэл, хэрэгжих эсэх нь тодорхой биш, хэдэн арван хуудас арга хэмжээ, мэдээллийг төлөвлөгөө гэж үзэхгүй юм. Харин ч энэ нь төлөвлөгөө боловсруулж байгаа хүмүүст цаг хугацаа, хөдөлмөрийг үнэгүй зарж, ажил хийж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж ингэснээр огт төлөвлөгөө гэж юм байхгүй байхаасаа ч илүү хор нөлөөтэй байх талтай¹⁴ байдаг тул цаашид газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон газар хөдлөлтийн гамшгийн үед ашиглах ТАТ-г боловсруулахдаа төлөвлөгөөг ашиглах уншихад аль болох ойлгомжтой, хялбар байхаар бодож боловсруулах шаардлагатай юм.

3.2.3. Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах

Улаанбаатар хотын одоогийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд орхигдоод байгаа нэг асуудал бол сэргээн босгох ажиллагааны төлөвлөгөө юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн үндсэн чиглэлд аливаа гамшгийн дараа өмнөх байдлаас "илүү сайнаар барьж байгуулах" асуудлыг тодорхойлж өгсөнтэй холбоотойгоор газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд сэргээн босгох ажиллагааг сайтар төлөвлөхөд анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна.

¹⁴ Цэрэндорж Д, Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан, УБ 2013, х.186

Өнөөдөр дэлхий дахинд гамшгийн нөхцөл байдал үүсээгүй тайван цагт сэргээн босгох арга хэмжээний үйл явцыг нарийн тодорхой төлөвлөсөн байх нь онцгой ач холбогдолтой гэж үзэх болжээ.

Доктор Накабаяши Ицүки (2017)-ын тодорхойлсноор сэргээн босгох төлөвлөлтийн үйл явцыг сэргээн босгох үндсэн бодлого, үзэл баримтлал, сэргээн босгох ажлыг хариуцах төв байгууллага, илүү сайнаар барьж байгуулах үзэл санааг тусгасан сэргээн босгох төлөвлөгөө, салбар тус бүрийн сэргээн босгох үйл явц, хэрэгжилт гэсэн байдлаар тодорхойлсон байна.

Урьдчилан бэлтгэсэн сэргээн босгох төлөвлөгөөг боловсруулах үйл явцыг дараах байдлаар тоймлон харуулав. Үүнд:

1. Сэргээн босгох зорилго, зорилтоо тодорхойлно.

Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох загвар буюу сэргээн босголтын төсөөллийг бий болгоно. Ингэхдээ аль болох засгийн газрын түвшинд авч үзэж олон улсын болон дотоодын холбогдох талуудын хооронд уг асуудлаар нэгдсэн ойлголцол, зөвшилцөлд хүрсэн байх нь чухал юм.

2. Сэргээн босгох төлөвлөгөөг боловсруулна.

Урьдчилсан загвартаа нийцүүлэн авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг "Илүү сайнаар барьж байгуулах" үзэл баримтлалд тулгуурлан тогтооно. Энэ үеийг хөгжлийн боломж гэж харж төлөвлөх нь зүйтэй. Ингэхдээ засгийн газрын урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой сэргээн босгох загварыг өргөн хүрээтэй уялдуулж энэ нь улс орны хөгжлийг хангах, ядуурлыг бууруулах асуудлыг хамаарсан байхад анхаарна.

3. Сэргээн босгох ажиллагааг хэрхэн явуулахыг тодорхойлно.

Сэргээн босгох ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудыг тодорхойлно. Салбар тус бүрийг сэргээн босгох арга замыг тогтооно. Ингэхдээ салбар тус бүрийг илүү гамшигт тэсвэртэй байдлаар сэргээн босгоход чиглэж ажиллагааг төлөвлөнө. Гамшигт тэсвэртэй сэргээн босгох ажиллагаа гэдгийн хүрээнд илүү сайнаар барьж байгуулах, хүйсийн асуудал, эрх тэгш байдал, эмзэг байдлыг бууруулах, байгалийн нөөц хадгалалт, хүрээлэн буй орчны хамгаалалт болон уур амьсгалын өөрчлөлт гэсэн 7 асуудалд анхаарал хандуулах ёстой¹⁵.

4. Сэргээн босгох ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Сэргээн босгох ажиллагаанд оролцогч талуудын сургалт, шаардагдах нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг тогтооно. Ингэхдээ төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарна. Сэргээн босгох ажиллагааг төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор бүх талуудын эрх тэгш байдлыг хангаж хэрэгжихээр зохион байгуулах нь үр дүн сайтай байна.

Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох төлөвлөгөө нь дараах агуулгатай байж болно. Үүнд:

- Сэргээн босгох арга хэмжээний үндсэн үзэл баримтлал
- Сэргээн босгох арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт (удирдлагын байр, хохирлын нөхцөл байдал, ажил гүйцэтгэх нөхцөл байдал, төсөв, хүний нөөц, газар чөлөөлөлт, нуранги цэвэрлэгээ, олон нийттэй харилцах, хорогдох байр, сайн дурынханы зохицуулалт, үнэ ханшны зохицуулалт)

¹⁵ GFDRR, WB8 EU and UNDP., Guide to developing disaster recovery framework, 2015, p.12

- Сэргээн босголтын ерөнхий зураг (хохирлын тойм, зорилтот газар, түр болон байнгын барилгын цар хүрээ)

- Иргэдийн амьжиргааг сэргээн босгох төлөвлөгөө (амины орон сууцыг сэргээн босгох, боловсрол, эрүүл мэнд, сэтгэлзүйн тусламж үйлчилгээ, нийтийн орон сууцны хангамж, эрүүл аюулгүй орчин, халамжийн үйлчилгээ)

- Салбаруудын сэргээн босгох төлөвлөгөө (барилга, дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, нийгэм хамгаалал гэх мэт)

Газар хөдлөлтийн дараах сэргээн босгох төлөвлөгөөг урьдчилан боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээний хохирлын төсөөлөлд үндэслэнэ. Сэргээн босгох төлөвлөгөөг амжилттай хэрэгжихэд уг төлөвлөгөөний дагуу орон нутгийн засаг захиргаа, бүх талуудыг татан оролцуулсан дадлага явуулж байх нь ихээхэн чухал байдаг байна.

3.3. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бүх нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах арга зам

Иргэд газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангана гэдэг нь тухайн аюул, эрсдэлийн талаарх хүн амын мэдлэг, хандлага, аюулгүй амьдрах дадал хэвшил, зан төлөв болон зарлан мэдээллийг хүлээн авч, түүгээр ажиллах чадвараар тодорхойлогдоно.

Олон улсад газар хөдлөлтийн гамшигийг даван туулах чадвартай иргэнд дараах 4 үндсэн шинж чанар агуулагдана гэж үздэг. Үүнд:

- Болзошгүй газар хөдлөлтийн аюулын талаар ойлголттой
- Газар хөдлөлтийн аюул тохиолдвол өөрт учирч болох эрсдэлийг мэддэг
- Эрсдэлтэй хүн бүр өөрийн гэр, амьдарч буй газар дахь аюулгүй байдлаа хангасан
- Газар хөдлөлтийн дараа амьдрал, амьжиргаандаа учирсан хохирлыг арилгах туршлага, чадавхтай.

Эдгээр үндсэн шинж чанарыг бүрдүүлэх чиглэлд төр засаг, тодруулбал Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Бүх нийтэд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох хүрээнд эхний ээлжинд хийх зүйл бол сургалт, дадлагаар дамжуулж иргэдийн бэлэн байдлын талаарх болон гамшигийн талаарх буруу ойлголт, хандлагыг өөрчлөх явдал юм. Учир нь иргэд гамшиг, эрсдэлтэй холбоотой буруу ойлголттой байх нь түгээмэл байдаг. Иймд иргэдийн аюул, эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь иргэдийн бэлэн байдлыг хангах үндэс суурь болно.

3.3.1. Иргэдийн түвшинд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах сургалт, дадлагыг сайжруулах асуудал

Улаанбаатар хотын хэмжээнд хотын иргэдтэй явуулж буй сургалтын өнөөгийн байдал, газар хөдлөлтийн гамшигт иргэд хэрхэн хандаж байгаа байдлыг болон тэд гамшгаас хамгаалах бэлэн байдлаа яаж хангаж байгааг авч үзсэн судалгааны үр дүнд тулгуурлан иргэдийн бэлэн байдлыг нэмэгдүүлэхийн тулд сургалт, дадлагыг үр дүнтэй явуулах шаардлагатай байна.

Иргэдийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд аюул, эрсдэлийн талаарх иргэдийн мэдлэг, ойлголт нэн чухал. Өнөөгийн байдлын судалгаагаар иргэдийн тэн хагас нь

амьдарч байгаа газартаа хүчтэй газар хөдлөлт тохиолдох магадлалтай гэж, мөн тэн хагас газар хөдлөлтийн чичирхийллийн үед амь насаа хамгаалах зөв арга хэмжээг сонгосон нь газар хөдлөлтийн аюул, эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголт иргэдийн тал хувьд нь бүрдсэн байна. Иймд цаашид мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг эрчимжүүлж, иргэдэд эрсдэлийн шалтгаан нь юу вэ гэдгийг хэлж өгөх төдийгүй, энэ эрсдэл өөрсдөд нь хэрхэн нөлөөлөх, яагаад тэд эрсдэлтэй байгаа, хэзээ, хаана аюул тохиолдож болох талаар тодорхой мэдлэгийг олгох шаардлагатай байна.

Иргэдийн мэдлэг, ойлголт нэмэгдсэнээр тэдний гамшгаас хамгаалахтай холбоотой аливаа ажиллагаанд хандах хандлага, зан төлөв нь өөрчлөгдөнө. Энэ нь гамшгийн өмнө эрсдэлээ бууруулах, бэлэн байдлаа хангах, гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, гамшгийн дараа богино хугацаанд сэргэж хэвийн амьдралдаа орох зан үйлээр илэрнэ.

Манай улсад иргэдтэй явуулж байгаа сургалт, дадлага нь гол төлөв багш төвтэй хэв маягтай байгаа тул цаашид сургалт, дадлагыг явуулахдаа сургалтын ихэнх үйл ажиллагаа оролцогч төвтэй явагддаг болгоход чиглүүлэх хэрэгтэй байна. Өнөөдөр сургалт, дадлага иргэдэд газар хөдлөлтийн өмнө, үед болон дараа хэрхэн ажиллах, ямар арга хэмжээ авах талаарх мэдээлэл, мэдлэгийг нь өгч байна. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалтыг иргэдэд мэдлэг, мэдээлэл олгохоос илүүтэй тэдгээрт газар хөдлөлтийн өмнө, үед болон дараа хэрхэн аюулгүй байдлаа хангах арга ухааныг зааж сургах замаар тэдэнд чадвар, дадлага олгоход анхаарах хэрэгтэй байна.

Гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах зан төлөвийг олгохдоо тухайн эрсдэл, эмзэг байдлыг бууруулахад нь туслах тодорхой арга замуудын талаар зааж сургах хэрэгтэй. Тухайлбал, газар хөдлөлтийн эрсдэлтэй газарт тавилга, эд хогшлоо хэрхэн аюулгүй болгох аргыг зааж болно. Мөн гамшиг болохоос өмнө тэд юу хийж чадах талаар мэдээлэл өгнө. Энэ хүрээнд тодорхой нөөцтэй болох, айл өрхийн болон олон нийтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх, уулзах аюулгүй газар товлох гэх мэт арга хэмжээ хамаарна.

Гамшгийн дараах хор уршгийг арилгах зан төлөв эзэмшүүлэхдээ аюул тохиолдсон даруйд хэрхэн ажиллах, аюулгүй байдлаа хангах талаарх мэдлэг олгох хэрэгтэй. Тухайлбал, зарлан мэдээллийн дохиогоор хэрхэн ажиллах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд хэрхэн оролцох зэрэг нь хамаарах ба энэ төрлийн сургалт гэр бүл, найз нөхөд, хөршдөө болон өөртөө хэрхэн анхны тусламжаар хангах, гамшгийн үед онцгой байдлын байгууллагын чадавх, нөөц хүрэлцэхгүй үед хэрхэн бие дааж арга хэмжээ авах чадавх эзэмшүүлэхэд чиглэнэ.

Гамшгийн дараах сэргээн босгох зан төлөв нь гамшгийн дараа иргэд хэрхэн амьжиргаагаа сэргээхийг чадварыг олгоход чиглэнэ.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах иргэдийн бэлэн байдлыг дээшлүүлэхийн тулд сургалтыг дадлагад суурилж явуулах шаардлагатай байна. Одоогоор манай улсад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын үйл явцад хийсэн шинжилгээ, сургалтанд нийтлэг ашиглагдаж байгаа ном, гарын авлагын агуулгыг Япон улсынхтай харьцуулахад дараах нийтлэг дүр төрх харагдаж байна.

Хүснэгт 25. Япон улсын болон Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлагад хийсэн харьцуулалт

Үзүүлэлт	Япон улс	Монгол Улс
Оролцоо	Суралцагч төвтэй	Багш төвтэй
Агуулга	Энгийн, нэг зүйлд төвлөрсөн	Нийлмэл, олон талын мэдлэг олгох
Хэрэглэгдэхүүн	Олон төрөл	Цөөн буюу байхгүй
Арга	Биеэр үйлдэх	Мэдээлэл өгөх

Хятадын сэтгэгч Күнзийн хэлсэн “Сонсвол мартана, харвал санана, оролцвол ойлгоно” гэсэн үг байдгыг санаж, иргэд болон сурагчдад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалтыг явуулахдаа ямар нэг зүйлийг биеэр үйлдэж мэдэж авах, хийж сурах, хэвшиж дадах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Түүнээс гадна хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, бичиг үсэг тайлагдаагүй хүмүүс гэх мэт эмзэг бүлгийн тусгай хэрэгцээ шаардлагатай хүн амд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах боловсролыг тэдгээрийн онцлогт тохирсон арга хэлбэрээр хүргэх шаардлагатай.

Одоогоор иргэдийн сургалтанд түгээмэл хэрэглэгдэж байгаа ном, гарын авлагад энэ чиглэлийн дадлага хийх арга хэлбэрийг тусгаагүй байгаа тул цаашид иргэдтэй хийх дадлага ажлын сэдэв, агуулга, түүнийг явуулах алхамчилсан заавар бүхий гарын авлага бэлтгэх нь зүйтэй.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах иргэдийн бэлэн байдлыг дээшлүүлэхийн тулд иргэдийн Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Гамшгаас хамгаалах иргэдийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хамгийн чухал зүйл бол иргэдийг зарлан мэдээллийн дохиогоор ажиллах чадварт сургах явдал юм. Иймд зарлан мэдээлэх системийг түүнийг хүлээн авах хүний хаана, ямар нөхцөлд байгаагаас үл хамаарч мэдээлэл хүрч байхаар зохион байгуулах ёстой.

Манай улсад гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд оролцох иргэдийн оролцоо жил бүр нэмэгдэж байгаа нь сайшаалтай хэдий ч судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь зарлан мэдээллийн дуут дохио "сул буюу сонсогдоогүй" гэж хариулсан байна. Энэ нь цаашид дотоод зарлан мэдээллийн төхөөрөмжийг нэмж бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Үүний зэрэгцээ иргэд зөвхөн болзошгүй аюулын талаар мэдээллийг буюу тухайн аюулаас өмнө, үед болон дараа юу хийх зааврыг хүлээн аваад зогсохгүй энэ дагуу арга хэмжээ авах мэдлэг, зөв оновчтой үйлдэх чадвартай байх хэрэгтэй.

3.3.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга зам

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах иргэдийн бэлэн байдлыг дээшлүүлэхийн тулд энэ төрлийн сургалт, дадлагад оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, энэ талаарх иргэдийн оролцооны сайн туршлагыг түгээх шаардлагатай байна.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн олон тооны санал, санаачлага, үр дүнтэй шийдлүүд хэрэгжиж, эдгээрээс нилээдгүй нь манай орны онцлогт тохирч, үр дүнгээ өгч тогтвортой явагдаж байгааг

харгалзаж улс орны хэмжээнд энэ талын сайн туршлагыг тодорхойлж, түүнийг түгээн дэлгэрүүлэх замаар үндэсний онцлогт тохирсон иргэдийн сургалт, дадлагын аргазүйтэй болох нь зүйтэй юм.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт дадлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд олон нийтийн бүлгийг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд урамшуулал олгох замаар сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Газар хөдлөлтийн гамшиг тохиолдох үед төр дангаараа арга хэмжээ авах хүч хүрэхгүй нөхцөл үүснэ. Тиймээс орон нутгийн засаг захиргааны зүгээс олон нийтийн байгууллага, сайн дурынханыг дэмжих, хөгжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

Олон нийтийн байгууллага, сайн дурынхан нь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараах байдлаар оролцож болно. Үүнд:

1. Гамшгийн өмнөх үед:

- Иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох дадлага сургууль зохион байгуулахад нь зөвлөгөө өгч, удирдан чиглүүлж, гамшгаас хамгаалах хэрэгсэл тоног төхөөрөмжийн хэрхэн ашиглах талаар зааж сургадаг.
- Олон нийтийн дадлага сургуульд тогтмол хамрагдаж чаддаггүй эмзэг бүлгийн иргэдийг онцгой байдлын дадлага сургуульд хамруулдаг. Үүгээр дамжуулан олон нийтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сонирхлыг төрүүлдэг.

2. Гамшиг тохиолдсон үед:

- Иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хоргодох байрыг нээн ажиллуулах
- Гамшигт өртсөн хүмүүсийг аврах, гал унтраах анхан шатны арга хэмжээг авах шаардлагатай мэдээлэл цуглуулах

Олон нийтийн байгууллага, сайн дурынханыг үйл ажиллагаа чанартай явуулахад нь дэмжлэг үзүүлж тодорхой хэмжээний зардал, дэмжлэгийг орон нутгийн засаг захиргаанаас олгох шаардлагатай. Уг дэмжлэгийг

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал

2. Гамшгаас хамгаалах дадлага, сургууль хийхэд олгох дэмжлэг гэсэн хоёр чиглэлээр олгож болно.

Олон нийтийн байгууллага, сайн дурынханы явуулж байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардлыг тэдгээрийн үйл ажиллагааны хүрээнд хамаарах өрхийн тоонд үндэслэн, тухайн онд олгох зардлын хувь хэмжээг тооцож олгож болох юм.

3.4. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгох арга зам

Зарлан мэдээлэх системийг үр дүнтэй байлгахад дараах 4 хүчин зүйл чухал нөлөөтэй. Үүнд:

- Хүн амд нүүрлэж буй эрсдэлийг урьдчилж мэдэх, илрүүлэх
- Эдгээр эрсдэлийг техник, технологи ашиглан хянах ба зарлан мэдээллэх арга замыг бий болгох
- Эрсдэлүүдэд тохирсон ойлгомжтой хэлбэрээр зарлан мэдээллийг хүргэх
- Хүмүүст энэ дагуу хариу арга хэмжээ авах мэдлэг, чадвар олгох

Өнөөдөр Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн зарлан мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэхийн тулд техникийн болон зохион байгуулалтын цогц арга хэмжээг иж бүрнээр нь авч хэрэгжүүлэх цаг болжээ.

3.4.1. Газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам

Зарлан мэдээлэх систем ба түүгээр дамжуулах мэдээлэл нь түүнийг хүлээн авах хүний хаана, ямар нөхцөлд байгаагаас үл хамаарч мэдээлэл хүрч байхаар зохион байгуулагдах ёстой. Хувийн болон ашгийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж хүн амыг бүхэлд нь хамрахуйц олон төрлийн зарлан мэдээлэх системийг бүрдүүлэх шаардлагатай. Зарлан мэдээлэх асуудлыг төлөвлөлтөнд тусгахдаа дараах олон төрлийн бүлгүүд дэх хүмүүст хүргэхээр зохион байгуулдаг байна. Үүнд:

- Гэрт
- Сургууль дээр
- Ажил дээр
- Нийтийн эзэмшлийн газарт
- Машинд
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд
- Бичиг үсэг тайлагдаагүй эсвэл боловсролгүй хүнд
- Ядуус, нийгмийн эмзэг бүлэгт

Улаанбаатар хотын хэмжээнд байгуулсан гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн бүрдэл хэсгүүд нь дээрх олон төрлийн бүлэг хүмүүст хүрэхээр оновчтой зохион байгуулагдаагүй байна. Учир нь өнөөгийн байдлын судалгаанаас харахад оролцогчдын 50 гаруй хувь нь барилга байгууламж дотор байгаа тохиолдолд дуут дохио огт сонсогдохгүй байна гэж хариулсан нь дотоод зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийг байрлуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд одоогийн Улаанбаатар хотод суурилуулагдсан гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгохын тулд цаашид дараах зүйлсийг хийх шаардлагатайг санал болгож байна. Үүнд:

1. Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийн тоог нэмэгдүүлэх
2. Дотоод зарлан мэдээллийн дэд системийг нэвтрүүлэх.

Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгох эхний арга зам нь дотоод зарлан мэдээллийн дэд системийг шинээр байгуулах явдал юм.

Дотоод зарлан мэдээллийн дэд системийг харилцаа холбооны бүх сувгаар хүргэхээр байгуулснаар хүртээмж, хамрах хүрээ нэмэгдэж гамшгаас учрах хохирлын хэмжээ эрс буурах боломж бүрдэнэ.

Дотоод зарлан мэдээллийн дэд системд дараах үндсэн шаардлага тавигдана. Үүнд:

- Бүхэлдээ автоматчилагдсан байх;
- Шуурхай, найдвартай байх;
- Овор бага, үнэ хямд байх;
- Бие даасан байх;

- Сүлжээний холболт хялбар байх;
- Нарийвчлал сайтай байх;
- Нөөц цахилгаан үүсгүүртэй байх.

Дотоод зарлан мэдээллийн дэд системийг байгуулснаар дараах давуу талууд бий болно.

1. Дотор орон зайд нэвтрэх чадвартай
2. Хүмүүсийн байгаа орчинд хүрэлцэхүйц хангалттай тархдаг
3. Аль ч цагт мэдээлэл дамжуулах боломжтой байх
4. Цахилгаан эрчим хүчний хараат бус байх
5. Дуу шуугианы нөлөөлөлд автахгүй байх.

Дотоод зарлан мэдээллийн дэд систем нь Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвтэй сансрын холбоо, хэт богино долгионы радио холбоогоор холбогдон зарлан мэдээллийг хүлээн авахаар зохион байгуулагдах ёстой.

Уг төхөөрөмж нь суурин болон хөдөлгөөнт удирдлагын төвөөс радио, сансрын холбоогоор дамжуулсан анхааруулах дохио, болзошгүй гамшгийн аюулын сэрэмжлүүлэх мэдээллийг текст, шууд яриа болон дуут дохиоллын хэлбэрээр хүргэнэ.

3.4.2. Газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах системийг шинэчлэх асуудал

Газар хөдлөлтийн аюулын эрт зарлан мэдээллийн хяналтын систем болон анхааруулах төхөөрөмжийн технологи нь хүмүүст газар хөдлөлтөөс үүдсэн чичирхийллийн долгион тэдгээрийн амьдарч буй газарт ирэхийг таамаглах боломжийг олгодог. Урьдчилан анхааруулсан минут, секунд хүмүүс болон тогтолцоог чичирхийллээс амь нас, эд хөрөнгөө хамгаалах арга хэмжээ авах боломж олгодог.

Манай улсад одоогоор суурилуулагдсан газар хөдлөлтийн эрт зарлан мэдээлэх систем болох амжиж анхааруулах системийн хувьд хотоос 200 км түүнээс дээш зайд байгаа идэвхтэй хагарал дээрх чичирхийллийг мэдэрч 20 секундний дотор анхааруулах шийдэлтэй юм. Гэтэл Одон орон геофизикийн хүрээлэнгээс Улаанбаатар хот орчмын ойрын зайд тохиолдох газар хөдлөлтийн идэвхжилтийн бүсэд 7 идэвхтэй хагарлын байршлыг тогтоогоод байна. Үүнд:

- **Эмээлтийн хагарал:** Улаанбаатар хотын баруун талд хил залгаа орших Эмээлт өртөөнөөс баруун хойш 13 км орчим зайд зүүн урагшаа 150°N азимутын чиглэлд Өлзийт хорооллыг дайрсан 35км урт хагарал оршиж байгааг тогтоосон. Эмээлтийн хагарал дээр магнитуд нь 6.5-7.1-тэй газар хөдлөлт болох боломжтой болохыг тодорхойлсон.
- **Хустайн хагарал:** Улаанбаатар хотоос баруун урагш 35 км зайд Хустайн нурууны урд бэлээр сунаж тогтсон 4 салбар хагарлуудаас бүрдэж байна. Үүнээс Хустайн гол хагарал нь 65°N чиглэлд 80 км урт үргэлжилнэ. Хагарлын бусад салбарууд болох Өмнөд Хустайн хагарал нь 20°N градусын чиглэлд 31 км урт, Лүнгийн хагарал нь эгц баруун тийш 58 км, Долоотойн хагарал нь 135°N градусын азимутаар 43 км урт тус тус үргэлжилсэн. Хустайн хагарал дээр магнитуд нь 7.8-тай газар хөдлөлт болох магадлалтай гэж тогтоосон.
- **Гүнжийн хагарал:** Улаанбаатар хотын зүүн хойд хэсэгт Гүнжийн аманд зүүн хойшоо чиглэлтэй 20 км урт үргэлжилсэн баруун гарын шилжилттэй огшоолтын

төрлийн хагарал байгааг тогтоосон. Гүнжийн хагарал дээр магнитуд нь 6.7 хүчтэй газар хөдлөлт болох магадлалтай.


- **Авдар уулын хагарал:** Улаанбаатар хотоос урагш 40-70км зайд 50км урт үргэлжилсэн зүүн гарын хэвтээ шилжилтийн хагарал болно. Тус хагарал дээр магнитуд нь 7.2 хүчтэй газар хөдлөлт болох боломжтой.
- **Шархайн хагарал:** Улаанбаатар хотоос баруун урагш 40-70 км зайд 45°N азимутаар 50 км урт сунаж тогтсон зүүн гарын хэвтээ шилжилттэй гэж тогтоосон. Хагарал дээр болох хүчтэй газар хөдлөлтийн магнитудыг 7.2 гэж тодорхойлов.
- **Мөнгөнморьтын хагарал:** Улаанбаатар хотоос зүүн тийш 100-150 км зайд Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт зүүн урдаас баруун хойш чиглэлтэй 100км сунаж тогтсон, баруун хойшоо уналтай тохирол хэлбэрийн хагарал гэж тогтоосон. Хагарал дээр болох боломжит хүчтэй газар хөдлөлтийн хүчийг магнитуд нь 7.5 хүчтэй гэж тооцоолсон.
- **Улаанбаатар хагарал:** Улаанбаатар хотын баруун хойд захаас зүүн урагшаа чиглэлтэй нийт 50 орчим км үргэлжилсэн 7.1 магнитудын хүчтэй газар хөдлөлтөөр үүссэн хагарал

Хот суурин газраас 50 км доторх хагарлаас бий болсон газар хөдлөлтөд одоо манайд суурилуулагдсан шиг бүсийн зарлан мэдээллийн систем анхааруулах боломжгүй тул энэ хэсгийг сохор бүс гэж нэрлэдэг¹⁶. P алерт систем (чичирхийллийн P долгионыг мэдрэх зориулалт бүхий систем) нь тухайн голомт дахь болон бүсийн анхааруулах мэдээг аль алиныг дамжуулах боломжтой. Тийм учраас энэ төрлийн сохор бүсэд P алерт-ыг суурилуулснаар асуудлыг шийдэх боломжтой юм байна. Тус сохор бүсэд суурилуулсан P алерт төхөөрөмж бүр газар хөдлөлтийн оргил хурдатгал PGA буюу P_d нь харгалзан 0.08g буюу 0.35 см байх үед бие даасан газар хөдлөлтийн зарлан мэдээлэх систем байдлаар ажиллаж анхааруулах мэдээллийг өгдөг (Wu and Kanamori, 2005; Wu et al., 2011) ажээ.

P алерт төхөөрөмжийн ажиллах зарчмыг дараах зургаар дүрслэн харуулав. Газар хөдлөлт болоход эпицентрээс шулуун долгион (P) болон хөндлөн долгион (S) тархдаг. P долгион газрын гадаргууд асар хурдтай тархаж суурилуулагдсан мэдрэгчүүдээр дамжин хүмүүст газар хөдлөлтийн талаарх урьдчилсан мэдээллийг сүйтгэх хүчтэй долгион ирэхээс урьтаж дамжуулах боломжийг олгоно. Үүнээс хойш аюул дагуулах шинж чанартай S долгионы тархалт ирэх тул энэ багахан хугацаанд хүмүүс амь насаа хамгаалах зохих үйлдлүүдийг хийж амжих юм.

1. Газар хөдлөлтийн хагарал янз бүрийн хэлбэрийн долгионыг ялгаруулдаг. Хурдтай тархах P долгион газар оронд эхний ээлжинд мэдэгдэх хэдий ч түүнээс арай бага хурдаар тархах S долгион газрын гадаргуугаар дамжин ирж хохирол, сүйтгэлийг учруулдаг.	2. Мэдрэгч P долгионыг илрүүлж, газар хөдлөлтийн зарлах төвд мэдээллийг нэн даруй дамжуулснаар уг төвд энэ мэдээлэлд үндэслэн чичирхийллийн хэмжээ, байрлал тодорхойлогдоно.	3. Зарлан мэдээллийн дохио дамжуулах төв хүмүүсийн утас, компьютерт мэдээллийг нэн даруй дамжуулна.
--	--	---


¹⁶ Yih-Min Wu, Himanshu Mittal, Ting-Chung Huang, Benjamin M. Yang, Jyh-Cherng Jan, and Sean Kuanhsiang Chen (2018) Performance of a Low-Cost Earthquake Early Warning System (P-Alert) and Shake Map Production during the 2018 Mw 6.4 Hualien, Taiwan, Earthquake., http://seismology.gi.ntu.edu.tw/papers/175_2019_Wu_et_al_SRL.pdf



Зураг 46. P алерт төхөөрөмжийн ажиллах зарчим

Энэ төрлийн зарлан мэдээллийн системийг дэлхийн хэд хэдэн оронд тухайлбал, АНУ, Япон, Тайван, Мексик, Индонези зэрэг улс орнууд нэвтрүүлээд байна.

Эдгээр улс орнуудаас бодит газар хөдлөлтийн чичирхийлэлээр туршиж, ихээхэн амжилттай зарлан мэдээллийг дамжуулсанд тооцогдож буй нь Тайвань улс юм. Тус улсын зүүн хэсгийн Hualien хотын ойролцоо 2018 оны 2 сарын 6-нд болсон 6.4 М-ийн хүчтэй 10.4 км-ийн гүнд болсон газар хөдлөлтийн үед P алерт систем нь газар хөдлөлтийн эпицентрийн эргэн тойрон дахь сохор бүсэд анхааруулах мэдээг 2-8 секундэд багтаан хүргэсэн байна¹⁷.



Зураг 47. Тайвань улсын P алерт зарлан мэдээллийн систем

АНУ-ын хувьд USGS-аас боловсруулсан ShakeAlert™-ын хэрэглэгч өөрийн компьютер болон гар утасны дэлгэц дээр P алертын мэдээллийг хүлээн авдаг. Энэхүү мэдээлэл нь тухайн голомт дахь чичирхийллийн таамаглаж буй хүч болон чичирхийллийн долгион тэдгээрийн оршин байгаа байрлалд ирэх хүртэл хэдэн

¹⁷ Yih-Min Wu, Himanshu Mittal, Ting-Chung Huang, Benjamin M. Yang, Jyh-Cherng Jan, and Sean Kuanhsiang Chen (2018) Performance of a Low-Cost Earthquake Early Warning System (P-Alert) and Shake Map Production during the 2018 Mw 6.4 Hualien, Taiwan, Earthquake

секунд байгааг хэрэглэгчид анхааруулдаг. Тухайн чичирхийллийн хүчийг Меркаллын шаталбараар хэмжих ба VI баллын хүчтэй тохиолдолд бүх хүн мэдэх ба хүмүүс зогсоход хүндрэлтэй, барилга, байгууламжид бага зэрэг эвдрэл гарна. Энэ анхааруулах мэдээлэл дээр газар хөдлөлтийн магнитуд, эпицентрийн байршил болон P болон S долгионы одоогийн байрлалыг газрын зургаар харуулдаг.

ShakeAlert™ -тай адилхан газар хөдлөлтийн эрт зарлан мэдээлэх систем нь секундэд (секундэд 0.8-4.8 км) нэг ба түүнээс дээш км-ийн хурдтайгаар газрын гадаргын өнгөн давхаргаар дамжин тархсан газар хөдлөлтийн чичирхийллийн долгионтой бараг зэрэгцэн анхааруулах мэдээллийг дамжуулах байдлаар ажилдаг.

Хэрэглэгчийн дэлгэцэд дараах төрлийн мэдээлэл ирдэг. Үүнд:

Дэлгэцэнд ирэх мэдээлэл:

Зураг 48. ShakeAlert™ системийн ажиллах зарчим, мэдээлэл



1. Эпицентрээс чичирхийллийн долгион тархах бодит цагийн замын чиглэл
2. Хагарлаас долгион тархах бодит цагийн замын чиглэл
3. GPS-ээр тогтоосон таны байрлал
4. чичирхийллийн долгион таны байгаа газар хүрэхээс өмнөх секунд
5. Таны одоо байгаа газрын таамаглаж буй эрчим
6. Тооцоолсон чичирхийллийн магнитуд
7. Хүчний шаталбар

Улаанбаатар хот орчимд газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд байгаатай холбоотойгоор газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхийн тулд зарлан мэдээлэл дамжуулах системийг газар хөдлөлтийн эпицентрээс ирэх шулуун долгион (P)-ыг мэдрэх P алерт төхөөрөмжөөр өргөтгөн шинэчлэх ажлыг нэн яаралтай эхлүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Дүгнэлт

1. Улаанбаатар хот орчмын газар нутагт тохиолдох газар хөдлөлтийн давтамж нэмэгдсэн, хотын нутаг дэвсгэр дээр шинэ идэвхтэй хагарал илрээд байгаатай холбоотойгоор газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхэд онцгой анхаарал хандуулах шаардлага нэгэнт бий болжээ.

2. Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь 1) гамшгаас хамгаалах төлөвлөлт 2) гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт 3) гамшгаас хамгаалах сургалт 4) гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл 5) гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрхзүйн орчин гэсэн төрийн бэлэн байдлыг хангах хүрээнд хамаарах 5 арга хэмжээ болон 1) гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох; 2) зан үйлийг хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх; 3) зарлан мэдээлэх дохиогоор ажиллахад сургах гэсэн хүн амын бэлэн байдлыг хангах 3 арга хэмжээнээс тогтсон цогц ойлголт байна. Энэ судалгааны ажилд төрийн бэлэн байдалд хамаарах гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрхзүйн орчны асуудлыг авч үзээгүй.

3. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр Улаанбаатар хотын хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний өнөөгийн байдлын шинжилгээг төр захиргааны байгууллагын, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын болон иргэд, олон нийтийн түвшинд авч үзэж шинжиллээ.

4. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төрийн бэлэн байдлыг хангахад төлөвлөгөө онцгой чухал юм. Энэ утгаараа Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд шинжилгээ хийхэд газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээ 75 орчим хувийг эзэлж байгаагийн 40 орчим хувь нь төлөвлөлт, 27 хувь нь сургалт, дадлага сургууль, 18 хувь нь техник хэрэгсэл, үлдсэн 12,5 хувь нь эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ эзэлж байна.

Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шинжилгээ хийхэд гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд Улаанбаатар хотын төлөвлөгөө гамшгийн үеийн удирдлага, бүрэлдэхүүн болоод газар хөдлөлтийн үед авах цөөн тооны арга хэмжээг хэт ерөнхий тодорхойлсон, зохицуулалтын шинж чанаргүй, тооцоо судалгаа голлосон байдалтай байна, түүнчлэн уг төлөвлөгөөнд гамшгийн дараах сэргээн босгох ажиллагааны зохицуулалт бараг тусгагдаагүй байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын болон Засаг даргын тамгийн газрын ажилтнуудын Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний талаарх мэдлэг, хандлага "дунд" гэсэн түвшинд үнэлэгдэж байна. Эдгээр ажилтнуудын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх мэдлэг туйлын хангалтгүй байсан.

Улаанбаатар хотын хэмжээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой сургалт, дадлага, сургууль тогтмол явагдаж хэвшсэн бөгөөд ерөнхийдөө оролцогчдын тоо буюу хамрах хүрээгээ тэлж байна.

5. Аж ахуйн нэгж, байгууллагын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдалд хийсэн шинжилгээнээс харахад газар хөдлөлтийн гамшгаас

хамгаалах төлөвлөгөөний хувьд компанийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, гамшгийн нөхцөл үүссэн үед хэрхэн ажиллах удирдлагын тогтолцоо, нэн тэргүүнд хэрэгжүүлэх ажил зэргийг тодорхойлоогүй хэт ерөнхий шинжтэй байлаа. Түүнээс гадна аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын байгууллагынхаа гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаар мэдлэг, хандлага сул байгаа нь уг төлөвлөгөөг цөөн хэдэн хүмүүсийн хүрээнд боловсруулдаг, түүнд ач холбогдол өгөхгүй байгаатэй холбоотой гэж үзлээ.

Улаанбаатар хотод аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтад жилд дунджаар 70000 ажилтан алба хаагч, харин энэ чиглэлийн дадлага, сургуульд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын нийлсэн бараг 500000 ажилтан, алба хаагчид хамрагджээ. Гэхдээ цаашид сургалт, дадлагын байгууллагын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн агуулга, чанарыг сайжруулах түүнчлэн сургалтын нэгдсэн статистик мэдээ гаргах аргачлал бий болгох шаардлага байна.

6. Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлын талаарх иргэдийн мэдлэг хандлагыг тандахад иргэдийн ихэнх нь газар хөдлөлт бидний амьдарч буй газарт тохиолдох магадлалтай гэж үзсэн ч тэдний тал хувь нь хэрхэн бэлэн байдлаа хангах талаар юу ч хийж эхлээгүй байна. Улаанбаатар хотын хэмжээнд судалгаанд оролцсон иргэдийн 60 орчим хувь нь газар хөдлөлт тохиолдсон үед өөрийгөө хамгаалах талаар ямар нэг арга хэмжээ авч чадахгүй, энэ талаар мэдэхгүй гэж бас мөн л 60 гаруй хувь нь 1-3 хоногийн гамшгийн нөөц байхгүй гэсэн хариултыг өгсөнөөс харахад цаашид газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангадаг хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх нэн шаардлагатайг илтгэнэ.

7. “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургууль”-ийг авч үзэхэд хотын хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохионы цамхагуудын тоо хэт цөөн, дээр нь иргэдийн идэвхи маш сул, оролцоо хангалтгүй байгаа нь харагдлаа. Иймд газар хөдлөлтийн гамшгийн аюулыг зарлан мэдээллийн системийг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх, гамшгийн бэлэн байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хувийн хэвшлийн байгууллагуудын идэвхи, оролцоог нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна.

8. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах онол, аргазүйд болон Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд авч үзсэн асуудлууд түүнчлэн Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдалд хийсэн судалгааны үр дүндээ тулгуурлан цаашид Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх талаар авах 22 арга хэмжээний саналыг дэвшүүллээ. Үүнд:

Нэг. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр:

- Шинэ хагарлын шинж чанар, үүссэн нөхцөл болон түүн дээр болох боломжит хүчтэй газар хөдлөлтийн давтагдлыг судлах
- Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүнийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулах аргачлал, зааврыг боловсруулах

- Барилга, байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэршилтийг тогтоох инженер техникийн ажилтнуудыг сургаж бэлтгэх;
- Нийслэлийн бүх түвшний удирдах ажилтнуудын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх
- Улаанбаатар хотод учирч болзошгүй газар хөдлөлтийн эрсдэлийг дахин үнэлэх
- Бүх түвшний газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээ, хохирлын төсөөлөлд үндэслэж боловсруулах
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө (Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө, Сэргээн босгосх төлөвлөгөөг багтаасан) боловсруулах гарын авлага, сургалтын модулийг бий болгох
- Онцгой байдлын байгууллагын холбогдох алба хаагчдын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахтай холбоотой мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх
- Газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох ажиллагааны төлөвлөгөөг "илүү сайнаар барьж байгуулах" үзэл баримтлалд тулгуурлан боловсруулах

Хоёр: Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах бүх нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах

- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт, арга хэмжээний агуулга, чанарт хяналт тавих механизм бий болгох
- Сайн дурынхан, сургагч багш нарын нэгдсэн судалгааг гаргах, тэднийг сургаж бэлтгэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах
- Иргэдэд мэдлэг олгож буй өөрийн нөхцөлд нутагшсан сайн туршлага, оновчтой санал, санаачлагыг тодруулж түгээн дэлгэрүүлэхэд чиглэлд уралдаан, хөтөлбөрийг зохион байгуулах, сайн туршлагыг түгээх, санаачлагчийг алдаршуулах
- ЕБС-д аюулгүй амьдрах ухааны хичээлийн албан хөтөлбөрийг Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаар дэмжиж сурагчдад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах цогц мэдлэг, чадвар олгох
- Хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой эд зүйлсийн жагсаалтын дагуу бэлтгэх
- Гамшгаас хамгаалах сургалт аргазүйн төвд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэгийг нийслэлийн иргэдэд хүргэх ажлыг шат дараатай зохион байгуулах
- ЕБС-д аюулгүй амьдрах ухааны хичээлийн албан хөтөлбөрийг Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаар дэмжиж сурагчдад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах цогц мэдлэг, чадвар олгох
- Хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой эд зүйлсийн жагсаалтын дагуу бэлтгэх
- Гамшгаас хамгаалах сургалт аргазүйн төвд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэгийг нийслэлийн иргэдэд хүргэх ажлыг шат дараатай зохион байгуулах

- Хотын хүрээлэн буй орчныг сайжруулах болон хөгжлийн урт хугацааны төлөвлөлттэй уялдуулсан газар хөдлөлтийн гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх болон шинээр барьж байгуулах стратегийг бий болгох

Гурав: Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгох

- Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын хүрээнд Зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага, сургуулилтын үед явагдаж буй сургалтыг сайн дурынхан, сургагч багш нарыг татан оролцуулж хийх
- Дадлага сургуулийг гэнэтийн байдлаар зохион байгуулж иргэдийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах мэдлэг, хандлагыг тандах
- Шинээр төлөвлөж буй орон сууцны хороолол болон барилгад дотоод зарлан мэдээллийг зайлшгүй төлөвлөх эрхзүйн зохицуулалтыг бий болгох
- Зарлан мэдээллийн системийн харилцаа холбооны үндсэн сүлжээ нь тасарсан тохиолдолд орлуулах нөөц сүлжээг тооцож газар хөдлөлтөд тэсвэртэйгээр төлөвлөх
- Орон сууцны хорооллын бүсүүдэд зарлан мэдээллийн дуут дохионы хүртээмжийг нэмэгдүүлэх
- Газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээлэх системийг Р алерт системийг суурилуулан шинэчлэх

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
- “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны улсын төлөвлөгөө, Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол
- Засгийн газрын 2014 оны 118 **дугаар тогтоол**, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” (2014-2016)
- Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоол, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (2016-2020)
- Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
- Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
- Нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, 2016
- Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага зохион байгуулах заавар”, 2013
- ҮСХ, ААНБ-ын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ, 2017
- Ч.Лхамжав. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгох нь” гамшиг судлалын магистрын зэрэг горилсон бүтээл, 2017
- Д.Сэржмядаг, П.Амарзаяа, Б.Батбаяр “Газар хөдлөлтийн үед хотын иргэдийн гамшгийг даван туулах чадварболон бэлэн байдлын төвшинг тодорхойлох судалгаа” 2016-2017
- П.Цэдэв., Гамшгаас хамгаалах төлөвлөлт, 2018
- “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн тайлан, 2013
- Нийслэлийн онцгой байдлын газрын гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн 2017, 2018 оны тайлан

- Гамшгаас хамгаалах үндэс /Иргэдэд зориулав/ 2017
- Гамшгаас хамгаалах үндэс /Их дээд сургууль, коллежийн оюутнуудад зориулав/ 2017
- Гамшгаас хамгаалах үндэс /Сайн дурынханд зориулав/ 2017
- Аврагч мазаалайн зөвлөмж өрхийн гарын авлага, 2014
- “Аюулгүй өрх” зөвлөмж /орон сууц/, 2016
- Өсвөрийн аврагч” бүлгийн сурагчийн гарын авлага, 2015
- “Гамшгаас хамгаалах төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлэх” сэдэвт Япон дахь сургалтын материал
- Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага зохион байгуулах заавар” ОБЕГ
- Implementation Handbook for Disaster Resilience Education at the Regional Level, 2015/March, Cabinet office (Disaster Management Office) Executive Committee for Disaster Management Education Challenge Plan “Bokomi” Guidebook
- Research Paper Earthquake Early Warning Systems, visiting researcher 2013A in term of August 13-November 22, 2013, Asian disaster reduction center, Kobe, Japan
- White paper Disaster Management in Japan
- <http://rallen.berkeley.edu/research/WarningsInJapan/>
- Д.Сэржмядаг., Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, (2017).
- Цэрэндорж Д, Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан, УБ 2013,
- Норжинванчиг, Б. Мөнх, П нар. Менежмент, 1997.
- Эрдэнэсүрэн Б, Батхүрэл Г нар., (2000.Менежмент. УБ.,.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага (2018) "Бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөө" боловсруулах аргачлал, зөвлөмж,
- Газар хөдлөлтийн гамшгийн үеийн нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд болон иргэдийн бэлэн байдалд хийсэн судалгаа, Нийслэлийн эрүүл мэндийн газар, 2014
- Т.Пүрэвдорж, Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох арга зам сэдэвт магистрын судалгааны ажил, 2018
- ОБЕГ, Дэлхийн Зөн Монгол ОУБ ба бусад., Аврагч мазаалайн зөвлөмж өрхийн гарын авлага, 2014
- ОБЕГ, Дэлхийн Зөн Монгол ОУБ ба бусад., Аюулгүй өрх, 2015
- О.Үржин, П.Цэдэв нар., Гамшгаас хамгаалах үндэс /иргэдэд зориулсан сурах бичиг/ 2016
- ОБЕГ, Дэлхийн Зөн Монгол ОУБ ба бусад., Бэлэн бай сургалтын багц, 2018
- Damon P.Coppola (2011), Introduction to International Disaster Management,
- Накабаяши Ицүки, 2017. Японы гамшгийн менежмент сэдэвт лекц
- Cabinet Office (2015) White paper on Disaster management
- Cabinet office (2015), Business continuity guidelines,
- Cabinet Office (2016) Survey the current status of the formulation of Business Continuity Plans,
- FY2015 Fact finding Survey on Company Business Continuity and Disaster Preparedness Initiatives
- Hiroaki Maruya (2015) Public Forum Progress and Future of Business Continuity Management in Japan.
- GFDRR, WB () Knowledge note 2-4 Cluster 2: Nonstructural Measures, Business Continuity Plans
- GFDRR, WB8 EU and UNDP., Guide to developing disaster recovery framework, 2015,
- ISO22301 Business Continuity Management System-Requirements, 2012

- BENIYA Shohei (2016), The Challenges of Local Governments and Assistance from Onsite Organizations of the National Government in Responding to the 2011 Tohoku Earthquake Disaster, Journal of International Cooperation Studies, Vol.23, No.2
- <http://www.bousai.metro.tokyo.jp/foreign/english/taisaku/2000022/2000105.html>
- Jeggle, T. (2013, May 20). Strategy Report on Disaster Risk Management, Reduction and Response in Mongolia. Retrieved from UNESCAP: <http://www.unescap.org/sites/default/files/Terry%27s%20report%20pdf.pdf>
- Yih-Min Wu, Himanshu Mittal, Ting-Chung Huang, Benjamin M. Yang, Jyh-Cherng Jan, and Sean Kuanhsiang Chen (2018) Performance of a Low-Cost Earthquake Early Warning System (P-Alert) and Shake Map Production during the 2018 Mw 6.4 Hualien, Taiwan, Earthquake., http://seismology.gi.ntu.edu.tw/papers/175_2019_Wu_et_al_SRL.pdf

ГАМШГИЙН ҮЕД ИРГЭДИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРАНД ТАВИХ ҮНДСЭН ШААРДЛАГА ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

П.Чимэдцэрэн¹, Д.Нарантуяа², С.Солонго³

¹ГСХ-ийн Инновацийн төвийн дарга, доктор (Ph.D), ахмад

²ГСХ-ийн ГЭҮСекторын эрхлэгч, докторант, дэслэгч

³ГСХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, ахмад

Оршил

Судалгааны ажлын үндэслэл: Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдсээр байгаа гамшиг ослын тохиолдлууд, хот суурин газрын хүн амын төвлөрөл, өндөр барилга байшин олноор баригдаж байгаа зэрэг нь гамшигийн улмаас учрах хохирлыг нэмэгдүүлэх, улмаар хүн амын аюулгүй байдалд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн нэг болоод байна. Тухайлбал геофизикийн судалгаагаар Монгол Улсын хүн амын 40 гаруй хувь нь төвлөрсөн нийслэл хот болон хот орчимд газар хөдлөлтийн 6 хагарал (Хустайн хагарал: Улаанбаатар хотоос баруун урд зүгт 30 км, Эмээлтийн хагарал: баруун урд зүгт 15 км, Гүнжийн хагарал: зүүн хойд зүгт 5 км, мөн түүнчлэн Улаанбаатар хотод газар хөдлөлтийн шинэ хагарал илэрлээ гэсэн мэдээ 2018 онд цацагдаад байна. Энэ хагарлыг одоогийн байдлаар Улаанчулуутын хогийн цэгээс Богд уулын хойд хормой буюу Скай резорт цанын баазын ойролцоо гэж таамаглаад байгаа бөгөөд энэ нь нийслэл хотын төв дундуур дайран өнгөрч байгаа гэсэн үг юм.) байгааг тогтоосон ба Улаанбаатар хотод ч газар хөдлөлт (биед мэдрэгдэх болон мэдрэгдэхгүй) бүртгэгдэж байгаа нь болзошгүй эрсдэлийг нэмэгдүүлж байгаа юм.

Нийслэл Улаанбаатар хотод нийт 92360 барилга байгууламж байгаагийн 2248 нь нийтийн орон сууц байна. Судалгаагаар газар хөдлөлтөд тэсвэргүй 1961 оноос өмнө баригдсан 152 барилга, 1961-1973 онд баригдсан 111 барилга, газар хөдлөлтөд аюултай 1961-1973 онд баригдсан 15 барилга, 1973-1987 онд баригдсан 89 барилга байдаг гэсэн тооцоо гарсан нь газар хөдлөлтийн хүчийг тэсвэрлэх боломж муутай байна. Манай орны хувьд үер, зуд, хүчтэй салхи шуурга, ахуйн хийн дэлбэрэлт, хүний буруутай үйлдлээс байшин барилга нурах аюулд орох, химийн бодисын алдагдал, хордлого зэрэг аюулын үед урьд өмнө нүүлгэн шилжүүлэлт хийгдэж байсан ба газар хөдлөлт, цацраг идэвхит үүсгүүр алдагдах, гал түймэр зэрэг гамшигийн үед нүүлгэн шилжүүлэлт хийх магадлалтай тул засгийн газар, гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага, улсын албад, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага, бусад холбогдох талууд, иргэд бэлэн байх шаардлагатай.

Байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл, осол тохиолдоход тухайн аюулт үзэгдэл, ослын цар хүрээ, үзүүлэх нөлөө, далайц, өртөх байдлаас хамааран хүн амыг аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх, амьдрах орчин нөхцөлийг хангах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарна. Гамшигт нэрвэгдэгсэд орон байраар хангагдах нь хүний үндсэн эрхийн нэг юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.8-д гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг

төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах, Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Мэргэжлийн ангийн дүрмийн Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн чиг үүрэгт “Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах”, “Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах” гэж тус тус заажээ. Эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан хүн амыг түр байрлуулах хоргодох байр нь ямар норм, стандартыг хангасан байх шаардлагатай зэрэг нь одоогоор тодорхойгүй олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас гаргасан ерөнхий стандартаар хязгаарлагдаж байна. Энэ стандарт нь нийтлэг байдлаар боловсруулагдсан байдаг тул Монгол орны онцлог нөхцөл байдалд зарим талаараа тохирохгүй, уур амьсгалын эрс тэс уур амьсгалд нийцэхгүй олон асуудлууд байгаа учраас өөрийн орны нөхцөлд тохирсон стандарт, норм дүрэмтэй байх шаардлага тулгарч байна.

Иймд, энэхүү судалгааны ажлаар газар хөдлөлт, аливаа гамшиг тохиолдоход иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр нь өнөөдөр ямар түвшинд байгаа, олон улсын стандарт шаардлагын түвшин зэрэглэл, нийтлэг байдал зэргийг судалж, харьцуулалт хийн, өөрийн орны онцлогт тохирсон стандарт, норм, дүрэм боловсруулахад тавигдах үндсэн шаардлагуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримт нотолгоон дээр суурилсан боловсруулахыг зорьлоо.

Судалгааны ажлын хүрээнд эх сурвалжийг цуглуулах, судлах, ГСХ-ийн эрдмийн зөвлөлөөр сэдвийн томъёолол, бүтцийн төлөвлөгөө, удирдагч батлуулах, судалгааны онол, арга зүйг томъёолох, тоон болон чанарын мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, хээрийн судалгаа хийх, үр дүнг тайлбарлах, нэгтгэх, сэдвийн хүрээнд асуудлыг томъёолж, шийдэл дэвшүүлэх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мөн Төв аймгийн команд штабын сургууль, Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үеэр явагдсан 2 удаагийн хээрийн дадлагад оролцон ажиглалт хийж, судалгааны ажлын үр дүнгээр “Хүйтний улиралд иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр зохион байгуулахад анхаарах зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж ОБЕГ-ын Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөс эрхлэн гаргадаг Гамшиг судлал, инноваци сэтгүүлийн 2019 оны эхний дугаарт хэвлүүлсэн.

Энэ судалгааны ажилд гамшиг ослын дараах нүүлгэн шилжүүлэлт, түр байрны талаар бодит мэдээлэл ирүүлсэн Баян-Өлгий, Дархан-Уул, Архангай аймгийн Онцгой байдлын газар, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан ГСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүд, ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяр, Гамшиг судлалын хүрээлэнгийн Нөөц судлалын төвийн судлаач Х.Батаахүү, Гамшиг судлалын төвийн ЭША, хошууч Ч.Мэндэлмаа, ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын сургалт сурталчилгааны хэлтэс, Гамшигийн шуурхай удирдлагын газрын тасгийн дарга, хошууч Б.Хишигбаатар, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн Гамшигийн хөтөлбөрийн ахлагч

Ш.Мөнгөнтуяа, Олон улсын Улаан загалмай нийгэмлэгийн Орон байрны кластер хариуцсан зөвлөх Сесилиа Шмолзер нарт гүн талархал илэрхийлье.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны ажлын зорилго нь гамшгийн үед иргэдийн түр орогнох байранд тавих үндсэн шаардлагыг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

1. Гамшгийн үед иргэдийг байрлуулах түр байрыг зохион байгуулах аргазүйн асуудалд шинжилгээ хийх

2. Иргэдийг гамшгийн үед байрлуулах түр байрны талаарх олон улсын норм, стандартыг судалж, өөрийн орны нөхцөл дэх тухайн түр байрны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх

3. Гамшгийн үед иргэдийг байрлуулах түр байрны ерөнхий шаардлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн тодорхойлж, санал, зөвлөмж боловсруулах

Судалгааны аргазүй

Судалгааны ажилд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, ажиглалт хийх зэрэг шинжлэх ухааны ерөнхий аргыг болон агуулгын шинжилгээ, нэгтгэсэн өгөгдөл шинжлэх зэрэг нийгмийн судалгааны аргыг хэрэглэсэн.

Судалгааны ажлын хязгаарлалт

Гамшигт нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлсэн үед тэдний аюулгүй байдлыг хангах үүднээс тусгайлан бэлтгэсэн орон байрны төрөл ангилал, нэр томъёонд дүн шинжилгээ хийх, иргэдийг нүүлгэн шийлжүүлэх байрны өнөөгийн байдалд судалгаа хийж, түүнд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох асуудлыг энэ судалгаанд авч үзсэн.

Судалгааны ажлын ач холбогдол

Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавих үндсэн шаардлага тодорхойлох судалгаа нь Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн захиалгат судалгаа бөгөөд МУ-ын Шадар сайдаар ахлуулсан Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн ажлын төлөвлөгөөний 1.14-т тусгагдсан “Гамшгийн үед иргэдийн түр орогнох байр, нүүлгэн шилжүүлэх байранд тавих үндсэн шаардлагыг тодорхойлсон эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах” ажлын шинжлэх ухааны үндэслэлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаад судалгааны ажлын хэрэгцээ шаардлага, ач холбогдол оршино.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГАМШГИЙН ҮЕД ИРГЭДИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр, түүний эрх зүйн зохицуулалт

1.1.1 Нүүлгэн шилжүүлэх байр, түүнийг зохион байгуулах арга зүй

Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр, түүний ангилал, нэр томъёоны асуудал

Аюулт үзэгдэл, осол, үй олноор хөнөөх зэвсгээс үүссэн аюулын үед эсвэл үүсч болзошгүй бүсээс хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг богино хугацаанд зохион байгуулалттай нүүлгэн шилжүүлж, аюулгүй газарт байрлуулан, амьдралын наад захын нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээг авах шаардлага тулгардаг.

БНМАУ-ын Батлан хамгаалах тусгай комиссын 1935 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хурлаар баталсан дүрэмд “Бүх цэргийн жанжин нь “...Дайн байлдааны үед нүүлгэн зайлуулах явдлыг ерөнхийлөн удирдана” гэсэн заалт¹⁸ орсон нь дайн болсон нөхцөлд хот, суурингийн хүн ам, эд зүйлийг нүүлгэн шилжүүлж өөр газар байршуулах асуудал төрийн бодлогод албан ёсоор орсон гэж үзэж болно. Энэ үеэс нүүлгэн зайлуулах гэсэн нэршил хэрэглэж ирсэн бөгөөд 1960-аад оноос хойш нүүлгэн шилжүүлэх, тараан байршуулах буюу хот суурин газрын хүн амыг дайсны агаарын ба химийн зэвсгийн цохилтод өртөж нэрвэгдэхээс сэргийлэх, хордсон газар орноос эрүүл нутаг руу нүүлгэн байршуулах гэсэн утгаар нэршиж иржээ. Тодруулбал, тараан байрлуулалт гэж зэрэг тогтоосон хотод ажлаа үргэлжлүүлэх үйлдвэр байгууллагын ээлжийн ажилчин, албан хаагчдыг хотын гаднах аюулгүй бүсэд зохион байгуулалттайгаар гаргаж байрлуулахыг; Нүүлгэн шилжүүлэлт гэж бусад хүн амыг зэрэг тогтоосон хотоос бүрмөсөн аюулгүй бүс нутагт зохион байгуулалттайгаар шилжүүлэн байрлуулахыг хэлнэ¹⁹ гэж заасан байна.

Иргэний хамгаалалтын үед үй олноор хөнөөх зэвсгээс хүн амыг хамгаалах зорилгоор хоргодох байр, далдлах байрыг төхөөрөмжилж ашигладаг байв²⁰.

Хоргодох байр гэдэг нь цөмийн зэвсгийн хөнөөх хүчин зүйлүүд цохих долгион, нэвтрэх радиац, гэрлийн цацраг, цацраг идэвхит хордолт, түүнчлэн хими, бактериологийн зэвсгийн хордолт халдвараас хүн амыг хамгаалахад зориулагдсан тусгай байгууламжийг хэлнэ. Хоргодох байрны хамгаалах чадвар нь цохих долгионы илүүдэл даралтыг дааж чадах бат бэх хийцүүдээр (хана, хучилт, хамгаалалтын битүүмжлэгдсэн хаалга) баригдахаас гадна сайтар битүүмжлэгдсэн байх шаардлагатай. Тухайн үед нэгэнт баригдсан хоргодох байрыг тайван цагт хоёрдмол зориулалтаар барьж ашиглана. Тухайлбал, гарааш, агуулах, сургалтын танхим гэх мэт.

Далдлах байр нь иргэний хамгаалалтын нийтийн хамгаалах хэрэгслийн нэг бөгөөд хөдөө орон нутагт хүн амыг хамгаалах зорилгоор барьж байгуулна.

¹⁸ Дамдин.П, Монгол Улсын иргэний хамгаалалтын түүхэн замнал, УБ, 2017

¹⁹ Мөн тэнд

²⁰ Доржсүрэн.Б, Иргэний хамгаалалт, ажилчин албан хаагчид, малчид, тариаланчдыг иргэний хамгаалалтын талаар сургаж бэлтгэх программ, УБ, 1986

Далдлах байр нь сайтар битүүмжлэгдээгүй нөхцөлд хими, бактериологийн хордолт халдвараас хамгаалах шаардлагыг хангаж чадахгүй. Үүгээрээ хоргодох байрнаас ялгаатай гэж иргэдэд зориулсан иргэний хамгаалалтын сурах бичигт дурдсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын албанаас онцгой байдал үүссэн эхний үеэс эхлэн дүрвэгсдийг сайтар шилж, сонгосон газар зүй зохистой **хоргодох байранд** суурьшуулан нэгдсэн дэд бүтцээр хангаж өгөх нь зайлшгүй авах ёстой арга хэмжээний нэг бөгөөд эл бүтцийг бүрдүүлэн өгөх нь тэдний амь насыг аврахын зэрэгцээгээр аливаа хүндрэл бэрхшээлийг тодорхой хэмжээгээр хөнгөрүүлж өгнө. Онцгой байдлын үед дүрвэгсдийг тухайн орон нутгийн иргэдийн орон гэр, **нийтийн хоргодох байранд** бөөнөөр нь эсвэл зохион байгуулалт бүхий **хуарангуудад** байрлуулна²¹ гэж заажээ.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.8-д гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, **хоргодох байрыг** төхөөрөмжлөх; Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын 5.1.7-д иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээг хангах (**орон байр**,... хангах) бүх төрлийн хангалтыг зохион байгуулах; Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт **Мэргэжлийн ангийн дүрмийн** 3.3-т Тусгай зориулалтын мэргэжлийн анги нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүмүүнлэгийн тусламж, гал түймэр унтраах ажиллагаа, хэв журам, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, **түр болон хоргодох байрны** үйлчилгээ, ...-ын аюулгүй ажиллагааг хангах зэрэг чиг үүрэгтэй байна гэж; Улаанбаатар хотын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд түр хоргодох байр, нүүлгэн шилжүүлэх байршил гэсэн нэршлээр тус тус томъёолжээ.

Дээр дурьдсан иргэний хамгаалалтын үеийн гамшгийн дараах иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны нэршил, судалгаа, шинжилгээний бүтээлүүдэд ашигласан нэршил, олон улсын байгууллагын ашиглаж байгаа нэршил, хууль, дүрэм, журамд тусгасан нэршил зэрэг нь агуулгын хувьд ойролцоо хэдий ч бичиглэл болоод утгын хувьд өөр өөр, зөрүүтэй томъёолсон байна. Тухайлбал, 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн “Болзошгүй гамшгийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох тухай” тогтоолын агуулга нь гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх тухай байгаа хэдий ч үгийн утга, нэршлийг харахад болзошгүй гамшгийн үед тухайн газар орныг өөр газарт нүүлгэн шилжүүлэх гэсэн утгаар ойлгогдохоор байна.

Иймээс энэхүү судалгааны ажлаар нэн түрүүнд гамшгийн үед иргэдийг түр байрлуулахтай холбоотой нэр томъёо, ойлголт, нэршлийг нэг мөр болгох шаардлагатай гэж үзлээ.

Аливаа аюулт үзэгдэл, ослын үед иргэдийн амь насыг авран хамгаалах үйл ажиллагаанаас гадна шаардлагатай тохиолдолд түр эсвэл бүр амьдрах орон байртай болгох, амьдрах таатай орчинг бүрдүүлж өгөх шаардлагатай юм.

²¹ UNHCR, Онцгой байдлын үеийн гарын авлага., Гурав дахь хэвлэл, 2007 он.

Гамшгийн дараах иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг зохицуулсан хууль, дүрэм, журам, олон улсын конвенц зэргээс харахад нэгд, гамшгийн аюулд нэрвэгдэхээс хамгаалж тухайн нутаг дэвсгэртээ түр байрлуулах орон байр, хоёрт, гамшгийн аюулын голомтоос нүүлгэн шилжүүлж нэгдсэн дэд бүтцээр хангагдаж амьдрах орчин бүрдсэн байр зохион байгуулахаар тусгажээ.

Монгол хэлний их тайлбар толь, Википедиа, Цэргийн нэр томъёоны тайлбар толь зэрэгт түр байрлах орон байрыг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

✓ **Хоргодох байр** - хөнөөх хэрэгслээс цэргийн бие бүрэлдэхүүн, хүн амыг хамгаалахад зориулан бэлтгэсэн газар доорх тусгай байгууламж;

✓ Орогнох - Орон байраа болгох, Хэн нэгэнтэй нөхцөн гэрт нь амьдрах, Нуугдан хоргодож амь зуух;

✓ Олон нийтийн түр байр - Яаралтай тусламжийн улмаас нүүлгэн шилжүүлэгдсэн хүн амыг түр хугацаагаар байршуулах аюулгүй дэд бүтцийг;

✓ Нүүлгэн байршуулах төв - гамшигт нэрвэгдсэн хүмүүст хоргодох наад захын нөхцөлийг хангасан түр зуурын аюулгүй байдлыг хангасан түр оршин суух газар;

✓ Хуаран - Олуул нэг газар бөөгнөрөх, цугларах: хуарагнан буух (айлууд цугларан нэг дор буух)

✓ Түр хоргодох байр - гамшгийн өмнөх болон дараах үеийн эмзэг бүлгийн хүмүүст хоол хүнс, хувцас, эрүүл мэндийн үйлчилгээг түр хугацаагаар байршуулна. Энэ нь олон нийтийн эсвэл гэр бүлийн хоргодох байр байж болно.

Английн Иргэний хамгаалалтын сургуулийн судлаачдын бүтээлд иргэдийг хамгаалах байрыг таван төрөлд хувааж үзсэн байна²². Үүнд:

✓ Яаралтай тусламжийн байр – emergency shelter: Энэ төрлийн хоргодох байрыг хүний амь насыг аврах, анхны түргэн тусламж үзүүлэх зорилгоор богино хугацаанд ашигладаг. Энд иргэдийг хэдэн цагаас 1 хоног хүртэлх хугацаагаар байрлуулдаг (Quarantelli, 1991, Wu, Lindell, 2004, Johnson et al., 2006, Johnson, 2007a, Johnson, 2007b, Félix нар, 2013a) ба энд хоол хүнс бэлтгэх, удаан хугацааны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрдөггүй.

✓ Түр байр – temporary shelter: Энэ төрлийн хамгаалах байранд иргэдийг гамшгийн дараа хэдхэн долоо хоногийн туршид энгийн майханд эсвэл нийтээр байрлуулна.

✓ Түр орон сууц – temporary housing: Энэ төрлийн хамгаалах байрыг ихэвчлэн зургаан сараас гурван жил хүртэл урт хугацааны туршид ашигладаг. Гамшигт нэрвэгдсэн хүмүүсийг түр орон сууц, тухайлбал, түрээсийн байшин, нэгдсэн байр зэрэгт байрлуулах нь тэднийг өдөр тутмын хэвийн үйл амьдралдаа буцаж орох боломжийг олгодог.

✓ Нүүн шилжих байр – transitional shelter: Энэ төрлийн хоргодох байрыг ихэвчлэн гамшгийн дараа нүүлгэн шилжүүлснээр өөрсдөө барьж байгуулдаг.

²² Abdulrahman Bashawria*, Stephen Garrityaand Krisen Moodleya, AN OVERVIEW OF THE DESIGN OF DISASTER RELIEF SHELTERS, Elsevier, Procedia Economics and Finance 18 (2014) 924 – 931

(Олон улсын шилжин суурьшилтын байгууллага, 2012). Ийм байршилд иргэдийг бүр эсвэл түр суурьшуулж шинээр суурьшлын бүс төлөвлөдөг байна.

✓ Байнгын орон байр – progressive shelter: Энэ төрлийн хоргодох байр нь ирээдүйд тогтвортой, сайжруулан барьж болохуйцаар бүтээгдсэн байдаг.

Дээрх судалгаанаас гамшгийн дараах иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг иргэдийн амьдрах хугацаа, байрны хийц бүтээц, амьдрах орчин нөхцөлөөс хамааруулж ангилж, нэршлийг оноосон нь харагдаж байна.

Иймд, нэгд, иргэдийг гамшгийн аюулд нэрвэгдэхээс хамгаалж тухайн нутаг дэвсгэртээ түр байрлуулах орон байрыг **түр хоргодох байр** эсвэл **олон нийтийн түр байр**; хоёрт, гамшгийн аюулын голомтоос иргэдийг нүүлгэн шилжүүлж байршуулах зорилготой нэгдсэн дэд бүтцээр хангагдсан, амьдрах орчин бүрдсэн байрыг **иргэдийг нүүлгэн байршуулах төв** эсвэл **хуаран** гэж нэрших нь утга агуулгын хувьд үндэслэлтэй гэж үзэж уг саналыг дэвшүүлж байна. Энэхүү судалгааны ажлын дараагийн хэсэг, бүлэгт дээрх дэвшүүлсэн саналын дагуу **түр хоргодох байр, иргэдийг нүүлгэн байршуулах төв** гэсэн нэршлийг ашиглах болно.

Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны зохион байгуулалтын асуудал

Гамшгаас хамгаалах менежмент нь өөр хоорондоо уялдаа бүхий гамшгийн өмнө, гамшгийн үе болон гамшгийн дараах гэсэн 3 үе шатуудад хэрэгжих хэд хэдэн үйл ажиллагаанаас бүрддэг. Эдгээр нь аюулыг бууруулах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох гэсэн 5 үйл ажиллагаанаас тогтох бөгөөд иргэдийг нүүлгэн шилжүүлэх, хоргодох байранд байлгах, амьдралын хэвийн нөхцөлөөр хангах зэрэг нь хор уршгийг арилгах үйл ажиллагааны нэг бүрдэл хэсэг юм. Гамшгийн хор уршгийг арилгах гэж хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах, зэрэг гамшгийн хамгийн бага хохиролтойгоор гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг хэлнэ²³.

Хор уршгийг арилгах үйл ажиллагаа нь гамшгийн үед хэрэгжүүлэх үе шатад хамаарах ба энд гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийх, яаралтай тусламж хүргэх, нэн чухал дэд бүтцийг сэргээх, нэрвэгдэгсдэд сэтгэлзүйн тусламж үзүүлэх, орон байраар хангах, сайн дурынхан болон хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах зэрэг ажиллагааг зохион байгуулна.

Гамшгийн дараа аль болох богино хугацаанд хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай хэрэгцээг хангах, яаралтай тусламж хүргэх зорилгоор бодит мэдээ цуглуулах замаар хохирол, хэрэгцээний үнэлгээг хийдэг. Энэ үнэлгээнд тулгуурлан тухайн бүс нутгийн гамшигт нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх, яаралтай тусламж үзүүлэх, нөөцийн хангалт гаргах шаардлагатай эсэхийг тодорхойлж холбогдох газраас шийдвэр гарна.

²³Сэржмядаг.Д, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, 2017 он.

Нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэхдээ тогтсон цэгүүдэд байршуулж, бүртгэл хийн, нэгдсэн журмаар түр хоргодох байр эсвэл нүүлгэн байршуулах төв рүү тээвэрлэхээр гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан байдаг. Гэвч бодит байдал дээр иргэд түр цугларах талбай, түр хоргодох байр зэргээ мэдэхгүй, дадлага сургууль хийсэн ч хэнэггүй хандсанаасаа болж аюулд өртөх магадлалыг улам бүр нэмэгдүүлдэг. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг энэ онд анх удаа зохион байгуулсан. Энэ сургуулилтыг зохион байгуулахад нийт 9795 хүн, 1045 техник, 80 орчим байгууллага, нийслэлийн 950 гаруй удирдах бүрэлдэхүүн оролцож, зарлан мэдээллийн дохиогоор 402 мянган иргэн 94 аюулгүй цэг дээр цугларч, эдгээрээс 3111 иргэнийг 6 цэгт нүүлгэн шилжүүлэлт хийсэн. Дадлага, сургалтын гол зорилго нь иргэд өөрийн харьяалах бүсийн түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршлыг мэдэж авах байв. Зохион байгуулагчдын зүгээс анхны удаа гэхэд иргэд маш идэвхитэй сайн оролцсон гэж дүгнэж байгаа хэдий ч нийслэлийн иргэдийн 50 орчим хувь нь гамшиг тохиолдоход хэрхэн өөрийнхөө аюулгүй байдлыг хангах, аюулгүй талбайд хэрхэн очих, Засгийн газрын тусламж дэмжлэгийг хэрхэн хүртэх талаар мэдээлэлгүй үлдсэн нь дээрх тооноос харагдаж байна. Япон Улс газар хөдлөлт, цунами зэрэг томоохон гамшигт нэрвэгдэж, гамшгийн аюулыг биеэрээ мэдэрсэн ард түмэн юм. Иймээс жишээ болгож Японы Улсын засаг захиргааны хамгийн бага нэгж болох хороод хэрхэн иргэдээ сургаж, иргэд хэрхэн бэлтгэгддэг талаар дурдъя.

Япон Улсын хувьд байгалийн гамшиг тохиолдсон үед өөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс хоргодох байранд очихыг тухайн орон нутгийн засаг захиргаанаас зааварладаг. Хоргодох байрыг дараах байдлаар ангилдаг.

Түр хоргодох газар (Түр цуглах газар): Гамшиг тохиолдсон үед биеэ түр зуур хамгаалахын тулд хоргодох газар. Мөн өргөн хүрээг хамарсан хоргодох байранд очихоос өмнө цуглах газрыг хэлнэ. Энэ төрөлд бага, дунд сургууль болон ойр орчмын цэцэрлэгт хүрээлэн орно.

Өргөн хүрээг хамарсан хоргодох байр: *Хүчтэй газар хөдлөлт, цунами зэрэг гамшгийн улмаас гал түймэр гарсан, аюулын хүрээ тэлсэн тохиолдолд хоргодох газар. Үлэмж хэмжээний гал түймрээс биеэ хамгаалахуйц хэмжээнд хангалттай уудам газар, том цэцэрлэгт хүрээлэнг орон нутгийн засаг захиргаанаас тогтоон хаягжуулсан байдаг. Энд том цэцэрлэгт хүрээлэн, талбай хамаарна.*

Японы хоргодох газар нь ногоон өнгөтэй бөөрөнхий рүү гүйж байгаа хүний дүрс бүхий таних тэмдэг болон 避難(ひなん)場所(ばしょ) гэсэн хаяг хадсан байдаг.

Иргэд гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах үүднээс өөрийн байрлаж, **оршин сууж байгаа орон нутгийн “Гамшгаас хамгаалах газрын зураг”-ийг олж аван, оршин сууж байгаа газарт тань хамгийн ойр түр хоргодох байр, өргөн хүрээг хамарсан хоргодох байр хаана байрладаг болох, очих замын хэд хэдэн хувилбар гаргах сургалтыг** байнга зохион байгуулдаг. Энэ нь байгалийн гамшиг тохиолдсон үед аюул багатайгаар амь гарах нэгэн чухал түлхүүр юм.

Мөн гамшиг гарсан эсвэл гарах магадлал өндөр байгаа бүс нутагт тухайн орон нутгийн засаг захиргааны удирдлага “Хоргодох анхааруулга”, “Хоргодох заавар” өгдөг. Оршин сууж буй бүс нутагт “Хоргодох анхааруулга”, “Хоргодох заавар” өгөгдсөн бол зааврын дагуу хэсэг бүлгээрээ хоргодох газар луу явна. Гэвч гал, утаанд автах, орон байр усанд автах зэрэг өөрийн хүчээр даван туулах боломжгүй аюул тулгарах магадлалтай байвал хэн нэгнийг хүлээлгүй өөрөө бүхнийг шийдэн өөрийн хүчээр хоргодох газар уруу явахыг зөвлөдөг.

Хоргодох байр уруу явахад дараах зарчмыг баримтална.

1 дүгээр үе шат – Хоргодох бэлтгэл хийх тухай мэдээлэл: Уг мэдээллийг хүчтэй бороо, тайфун зэргийн үеэр ноцтой нөхцөл байдал үүссэн үед зарладаг. Энэ үе шатанд үнэ цэнэтэй болон хоол хүнсний зүйлс бэлдэхийг анхааруулахаас гадна аль болох эртхэн хоргодох байр уруу явахыг сануулдаг. Энэ үед иргэд, айл өрх, албан байгууллага өөрсдийн төлөвлөгөөний дагуу хэрхэх талаар төлөвлөн, боломжтой бол хоргодох байр уруу явна.

2 дугаар үе шат – Хоргодох анхааруулга: Уг анхааруулгыг аливаа гамшиг тохиолдох үед зарладаг. Нөхцөл байдал хурцдах магадлал бий болмогц зарлах ба аль болох хурдан хоргодох байр уруу явахыг анхааруулна. Энэ үед иргэд заагдсан хоргодох байр уруу явах ёстойгоо мэднэ.

3 дугаар үе шат – Хоргодох заавар: Уг зааврыг байдал илүү ноцтой болсон үед зарлах бөгөөд яаралтай хоргодох байр уруу явах хэрэгтэй. Хэрэв хоргодох байранд амжиж хүрэхгүй бол өөрт хамгийн ойр байгаа аюулгүй газар аюул намжтал түр хоргодно.

Хоргодох байр уруу явах арга: Авч явах зүйлээ аль болох багасгаж, явган алхаж хоргодох газар очдог. Хүүхэд, өндөр настан, өвчтэй эсвэл гэмтэж бэртсэн хүн байвал бүгдээрээ хамтдаа тусалж дэмжин хоргодох байранд очдог байна²⁴.

Дээрхээс харахад цугларах цэг, хоргодох байранд хүрэлцэн очих талаар мэдээлэл дамжуулах, иргэд тухайн цэгээ мэддэг байх, хэрхэн очих хэд хэдэн замын зургийг гаргасан байх зэрэг нь энгийн мэт боловч хамгийн чухал асуудлуудын нэг юм. Энэхүү судалгааны ажлаар гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах шаардлагыг тодорхойлох зорилго тавьсан хэдий ч гамшгийн үед сандарсан иргэдийн зохион байгуулалт, аливаа хүндэрсэн нөхцөл байдалд уужуу тайван хандах чадварыг олгох сургалт зэрэг нь тулгамдсан асуудлууд болоод байна.

1.1.2 Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны эрх зүйн зохицуулалт

Нэгдсэн Үндэстний байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын албанаас дүрвэгсэд олноороо орогнол хүсэх зорилгоор хил нэвтрэх, дотоодын зөрчил, аюулт үзэгдэл, ослын улмаас иргэд дотооддоо хүчээр нүүн шилжих шаардлагатай болсон зэрэг онцгой байдлын үед иргэдийг хамгаалах, тэдэнд тулгарч буй бэрхшээлтэй аливаа асуудлын шийдлийг олох зорилгоор дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай НҮБ-ийн конвенцийг баталсан байдаг.

²⁴<http://cms.city.miyakonojo.miyazaki.jp>

Олон улсын хүмүүнлэгийн хууль, Олон улсын хүний эрхийн тухай хууль, Дүрвэгсдийн тухай хууль, Олон улсын улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны гамшгийн үед баримтлах ёсзүйн хэм хэмжээ, гамшиг ослын үед мөрдөж ажиллах минимум стандартыг боловсруулж, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд гарын авлага болгон мөрдөж байна.

Ихэнх улс орнууд гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны асуудлыг дээрх конвенц, минимум стандартыг удирдлага болгон, өөрийн улс орны хууль эрхзүйн орчны хүрээнд зохицуулдаг байна. Тухайлбал, БНХАУ-ын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай хуулийн 41 дүгээр зүйлд “Газар хөдлөлт, түүнээс үүдэх дам осол, аюулын үед яаралтай тусламжийн байр байгуулах, яаралтай тусламжийн байрны байршлыг оновчтой тогтоох, иргэдийг нүүлгэн байршуулах байр, яаралтай тусламж үзүүлэх дэд бүтцийн ерөнхий зохион байгуулалт /харилцаа холбоо, усан хангамж, цахилгаан хангамж, бохир ус зайлуулах зэрэг/-ыг хот, хөдөөгийн төлөвлөлтөд тусгах²⁵; мөн тус улсын Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хуулийн 19 дүгээр зүйлд Хот, хөдөөгийн төлөвлөлт нь онцгой байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, зохицуулах хэрэгцээ шаардлагыг хангасан байх бөгөөд онцгой байдлын үед хариу арга хэмжээ авахад шаардлагатай тоног төхөөрөмж, дэд бүтцийн талаар ерөнхий зохицуулалт хийх, мөн онцгой байдлын үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байршлыг үндэслэлтэйгээр тогтоосон байх²⁶ гэж тус тус заасан байдаг. Герман Улсын хувьд дүрвэгсдэд зориулсан онцгой байдлын үеийн хор уршгийг арилгах удирдамжид иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг богино хугацааны, дунд хугацааны, урт хугацааны²⁷ гэж 3 ангилсан байх бөгөөд түр хоргодох байр, хуарангийн дотоод стандарт, хэм хэмжээний талаарх зохицуулалтыг тусгасан байдаг.

Манай орны хувьд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.8-д Гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах, мөн хуулийн 19.1-д Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ; Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын 5.1.7-д иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээг хангах (орон байр, ус, хоол хүнс, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах) бүх төрлийн хангалтыг зохион байгуулах; Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Мэргэжлийн ангийн дүрмийн Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн чиг үүрэгт “Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах”, “Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах” гэж тус тус заажээ.

²⁵Law of the People's Republic of China on Protecting Against and Mitigating Earthquake Disasters

²⁶Emergency Response Law of the People's Republic of China

²⁷ Sonia Molina Metsger, Guidelines on Emergency Sheltering for Refugees in Germany, 2014.

Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-д заасны дагуу гаргах бөгөөд дараах тохиолдолд иргэдийг түр хоргодох байр, нүүлгэн байршуулах төвд нэгдсэн зохион байгуулалттайгаар байрлууна. Үүнд:

- Газар хөдлөлт болж хот суурин газар нурж, хүн амьдрах нөхцөлгүй болсон
- Тухайн газар нутагт техникийн холбогдолтой осол, дэлбэрэлт, цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис алдагдсанаас хүн ам, мал амьтан амьдрах орчин үгүй болсон
- Террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, алан хядах ажиллагааны улмаас үүссэн нөхцөл байдалд зайлшгүй арга хэмжээ авах
- Ган, зуд тохиолдох, хот суурин газар, газар тариалан, мал аж ахуй усны хомсдолд орох ноцтой үр дагавар үүссэн;
- Үер буусан болон үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл байдал үүссэн;
- Хүн ам, мал, амьтны болон олон улсын хөл хориот халдварт өвчин үүссэн болон уг голомтын зэргэлдээ орших суурин газрын хүн ам, мал, амьтныг урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээг авах болсон;
- Ой, хээрийн болон объектын түймэр гарч байгаль экологи, хот, суурин газрын хүн ам, эд хөрөнгө, барилга байгууламжид бодит аюул учирсан.

Дээрх тохиолдолд иргэдийг аюулгүй байршилд нүүлгэн шилжүүлэх бөгөөд МУ-ын Шадар сайдын баталсан Мэргэжлийн ангийн дүрэмд тусгай зориулалтын мэргэжлийн ангийн чиг үүрэгт нүүлгэн шилжүүлэлт, түр хоргодох байр, иргэдийг нүүлгэн байршуулах төвийн асуудлыг хэрхэн тусгасныг 1–р хүснэгтээр харуулав.

1-р хүснэгт . Мэргэжлийн ангийн түр байр, хоргодох байрны бүлгийн чиг үүрэг

№	Мэргэжлийн ангийн зориулалт	Мэргэжлийн ангийн ангилал	Тухайн мэргэжлийн ангийн чиг үүрэг
1	Нүүлгэн шилжүүлэлт, түр байр	Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны бүлэг	Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах
2	Хоргодох байр	Хоргодох байрны бүлэг	Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах

Хүснэгтээс харахад гамшгийн дараах түр хоргодох байранд иргэдийг байрлуулах үед тэдний амьдрах нэн тэргүүний хэрэгцээг хангах шаардлагатай ба нүүлгэн байршуулах төв (дээрх журамд зааснаар хоргодох байр)-ийг гамшиг, ослын үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулахаар зохицуулалт хийжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний төлөвлөгөөг

хавсаргаж, жил бүр тодотгол хийхээр заасан байна. Энд, тухайн орон нутгийн газрын зураг, дайчлахаар заасан хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, нүүлгэн шилжүүлэх хүн ам, эд материалын болон соёл урлагийн үнэт зүйлс, тэдгээрийн тоо хэмжээ, хангалт, зохион байгуулалт, мэргэжлийн ангиудын гүйцэтгэх үүрэг, ажиллах, цугларах байр, шилжүүлэх, хүлээн авах байр, хугацааг тодорхой тусгасан байдаг.

Гэтэл эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан хүн амыг түр байрлуулах хоргодох байр, цугларах, хүлээн авах байранд ямар шалгуур, норм, стандартыг хангасан байх шаардлагатай зэрэг нь одоогоор тодорхойгүй зөвхөн байршлыг заасан, шаардлагыг хэт ерөнхий байдлаар дурьдсан төдийгөөр хязгаарлагдаж байна.

1.2. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ

1.2.1. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны зохицуулалтын өнөөгийн байдал

Сэдвийн хүрээнд өнөөгийн байдлын шинжилгээг тоон болон чанарын мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, хээрийн судалгааны аргуудыг ашиглаж гүйцэтгэлээ. Төв аймгийн команд штабын сургууль, Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох зэргээр 2 удаагийн хээрийн судалгаа хийсэн.

Манай улсын хэмжээнд Иргэний хамгаалалтын байгууллага байх үед 1990-ээд оноос өмнө түр хоргодох байрыг аймаг бүрт 1-2, нийслэлд томоохон албан газар, төрийн чухал байгууллагууд зэрэг газруудад нилээдгүй байгуулсан бөгөөд тухайн үед ард иргэдийг үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах зорилгоор байгуулж байжээ. Тухайлбал, одоогийн Сүхбаатар дүүргийн прокурор байрлаж байгаа байрны доор бүрэн тоноглогдсон удирдлагын байр байгуулж байсныг тэр үеийн Иргэний хамгаалалтын байгууллагад ажиллаж байсан ахмадууд ярилцдаг.

Мөн одоогийн Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1988 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн БНМАУ-ын Батлан хамгаалах яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны “Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай” 116/87 тоот тогтоолд Монголын Ардын Армийн 165 дугаар ангийн 249 мянган төгрөгийн үнэтэй хоргодох байрыг Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газрын дансанд балансаас балансад шилжүүлж, Октябрийн районы Иргэний хамгаалалтын удирдлагын байрны зориулалтаар ашиглуулж, байрны дулаан, цахилгаан, усан хангамж зэрэг ашиглалтын зардлыг районы жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Октябрийн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаанд даалгасан байдаг. Газар доорх энэ хоргодох байгууламж нь /12x70м/ хэмжээтэй 840м² талбайтай, жижиг, том 32 өрөөтэй байрыг зориулалтын дагуу ашиглаагүй 26 жил болсон ба дулаан, цахилгаан, усан хангамж, агааржуулалтын тоног төхөөрөмж шугам хоолойнууд тоногдож зэвэрч муудсан, баруун урд талын гарах гарцыг хучилтын хавтангаар таглаж битүүлсэн, 20-30 см гүнтэй ус тогтсон, хана тааз мөөгөнцөртөж хог ихээр хуримтлагдсан байгууламжийн доторх өрөөнүүдийг

зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон байна²⁸. Үүнийг дараах зургуудаар харуулав.



1-р зураг. Одоо орж байгаа хойд хаалга. Баруун гарцыг бетоноор тагласан



2-р зураг. Нөөц цахилгаан үүсгүүр, цахилгааны щитээр тоногдсон байдал



3-р зураг. Тоногдсон ОО-ын өрөө болон сантехникийн шугам

²⁸Б.Хишигбаатар, Газар хөдлөлтийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх байршлыг сайжруулах арга зам, магистрын дипломын ажил. 2016 он.



4-р зураг. Зэвэрч муудсан агааржуулалтын хоолой



5-р зураг. Цахилгааны утас




6-р зураг. Хоргодох байрны төв коридор болон бусад өрөөнд ус тогтсон байдал



7-р зураг. Хаалттай өрөөний зураг, гаднаас харагдах байдал

Энэ үеэс хойш 2008-2009 онд нийслэл “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд тусгаж иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршлыг судалж нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны “Эзэмшил, ашиглалтанд олгохгүй болон барилга байгууламж барихыг хориглох газрын байршил хэмжээг тогтоох тухай” 114 дүгээр тогтоолоор баталгаажуулсан байдаг.

Улмаар болзошгүй гамшгийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох тухай” НИТХ-ын 2016 оны 94 дүгээр тогтоол гарсан. Иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт болзошгүй гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх байршил, түр цугларах талбайг тогтоосон байна.



8-р зураг. Улаанбаатар хотын иргэдийг түр нүүлгэн байршуулах төвийн зураглал

Нийслэл Улаанбаатар хотын 2017 оны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний төлөвлөгөөг хавсаргаж жил бүр тодотгол хийхээр заасан байна. Төлөвлөгөөнд тухайн орон нутгийн газрын зураг, дайчлахаар заасан хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, нүүлгэн шилжүүлэх хүн ам, эд материалын болон соёл, урлагийн үнэт зүйлс, тэдгээрийн тоо хэмжээ, хангалт зохион байгуулалт, мэргэжлийн ангиудын гүйцэтгэх үүрэг, цугларах байр, хүлээн авах байр, хугацааг тодорхой тусгасан байна. Улаанбаатар хотын гамшгийн үед түр хоргодох байруудыг дүүрэг, дүүргээр харуулсан зураглалыг хавсралт 1-ээр харууллаа.

Нүүлгэн шилжүүлэлт зарласан үед дараах ажиллагааг зохион байгуулахаар заасан байна.

- Нүүлгэн шилжүүлэлт явуулах тухай гарсан шийдвэрийг тухайн орон нутгийн байгууллага, хүн амд зарлах;

- Удирдагч нарыг томилж эхний ээлжинд аюулгүй бүс рүү эмзэг бүлгийн хүмүүс /хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, түүх, соёл урлагийн үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх;

- Хүн амны тоо, бүртгэлийг явуулж орон байр, хоол, хүнсээр хангах;

- Бүх тээврийн хэрэгслийг тодорхой зааж оноосон бүртгэлийг дагуу дайчилж, материал хэрэгслээр ханган хүн ам, эд хөрөнгийг тээвэрлэх ажилд бэлэн болгох;

- Нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан иргэдийг авто тээвэр болон бусад тээврийн хэрэгслээр цуваанд эмхлэн зохион байгуулж, хэв журам сахиулах бүлгийн хяналт дор нүүлгэнэ.

Нийслэл хотын нутаг дэвсгэрт нүүлгэн шилжүүлэх байршилд барилга байгууламж барихыг хориглож хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийслэл хотын Захирагчид даалгасан байдаг. Улаанбаатар хотын гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нүүлгэн шилжүүлэх талбайг 31 байршилд судалгаа гарган талбайн хэмжээ, эзэмших, ашиглах зориулалтыг нарийвчлан тогтоосон байна. Үүнийг хавсралт 3-аар харууллаа.

Улсын хэмжээнд хөдөө орон нутагт одоогоор зориулалтын дагуу баригдсан түр хоргодох байр, талбай байхгүй ба гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд сургуулийн заалуудыг төлөвлөсөн байдаг хэдий ч ихэвчлэн хуучирч муудсан, газар хөдлөлтийн 7 баллд тэсвэргүй барилгууд гэсэн судалгаа байна.

1.2.2. Дадлага сургуулийн үеийн нүүлгэн шилжүүлэлт, түр байрны зохион байгуулалтанд хийсэн судалгаа

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 116 дугаар тогтоолын дагуу ОБЕГ-аас Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд “Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийг Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Их Хурлаас баталсан Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан.

Сургуульд нийтдээ бэлтгэл ажлыг хангахад 9795 хүн, 1045 техник хэрэгсэлтэйгээр 2 сарын хугацаанд бэлтгэн явуулсан. Нэгдсэн жагсаалын арга

хэмжээнд 116 байгууллагын 4260 ажилтан, албан хаагч, танхимын команд штабын дадлага сургуульд 80 орчим байгууллагын 950 гаруй удирдах бүрэлдэхүүн оролцсон байна.



9-р зураг. Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт

Зарлан мэдээллийн дуут дохиогоор 402 мянган иргэн 94 аюулгүйн цэг талбайд гарч, нүүлгэн шилжүүлэх ажиллагааг 3111 иргэнийг хамруулан зохион байгуулан явуулсан. Эрэн хайх дадлага сургуулийн ажиллагааг 9 дүүрэгт 6 том объект дээр зохион байгуулсан.

Энэ дадлага сургуулийн үйл ажиллагаа нь давуу болон дутагдалтай талууд нэлээдгүй байсан гэж дүгнэсэн. Тухайлбал: 111 цэгийн аюулгүй талбайн зарим нь шаардлага хангахгүй хажууд нь өндөр барилгууд барьсан, явах замд нь маш их саад тотгор болохоор барилга байгууламж ихтэй байв. Аюулгүй талбайд ирсэн иргэдийг бүртгэх зохион байгуулах арга хэмжээ эмх цэгцгүй, зохион байгуулан ажиллаж байгаа албан хаагчид хүрэлцээгүй, мөн энэ үеэр хөндөгдсөн бас нэг зүйл нь статистик тоон мэдээлэл зөрүүтэй, барилга байгууламж, хүн ам, зам гарцын мэдээлэл харилцан адилгүй байлаа.

Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны хээрийн судалгааны үр дүнгээс:

1. Түр цугларах 31 байршлаас 6 газарт нүүлгэн шилжүүлэлт хийсэн ба судалгааны баг Сүхбаатар дүүргийн 2-р сургуулийн түр цугларах байршлаас Янзага зуслан/иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр/-ийн зүг явсан нүүлгэн шилжүүлэлтэд оролцож хээрийн судалгаа хийлээ. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх төв рүү 500 иргэнийг 4 автобусаар тээвэрлэж Янзага зусланд байрлуулсан. Иргэдийг зуслангийн байр, майхан, асарт байрлуулахаар төлөвлөжээ. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх төвийн план зургийг харуулав.



10-р зураг. Сүхбаатар дүүргийн Янзага зуланд байрлах иргэдийг нүүлгэн байршуулах төв

Энэ төв нь шалган нэвтрүүлэх байр, автомашины зогсоол, ангилах байр, бүртгэлийн хэсэг, эмнэлэг, бие засах газар, удирдлагын байр, сургууль цэцэрлэг, гал тогоо, хэв журам сахиулах байр, иргэдийн амрах байр, иргэний бүртгэл, спортын талбай зэргийг төлөвлөж байгуулсан нь иргэдийн анхан шатны хэрэгцээг хангах зохион байгуулалтыг авч үзсэн нь харагдаж байна. Энд, агуулахын байр байгуулаагүй байна.

Мөн иргэдийг хүлээн авах байрны дэргэд хүнсээр хангах алба, хангалтын гэрээт байгууллагууд иргэн бүрт хүнсний зүйл /ус, печень/ тарааж байсан.

11-р зураг. Сүхбаатар дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөн дэх хүнсний хэрэгцээ



12-р зураг. Гамшгийн үед хүнсний нөөц нийлүүлэх гэрээ, хүнсээр хангах албаны ажилласан байдал

Иргэдийн байрлах орон байрыг зуслангийн модон байшин, асар, майхан, гэр барьж шийдсэн байв. Энэ нь өвлийн улиралд халаалт, дулааны асуудлыг шийдэхэд хүндрэл бэрхшээл тулгарахаар байна. Мөн 500 иргэнд эрэгтэй 8, эмэгтэй 8 жорлон төлөвлөсөн нь /дараах зураг/ 31 хүнд нэг жорлон ноогдож байна.



13-р зураг. Иргэдийг нүүлгэн байршуулах төвийн орон байр, жорлонгийн хангалт

Хээрийн судалгаагаар Сүхбаатар дүүргийн 2, 4 10-р хорооны 16 иргэн, Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгийн орон байрны кластер хариуцсан шинжээч Сиселиатай ярилцлага хийсэн. Иргэд байрны хувьд 00-ийн асуудал, хангалтгүй байна, халуун уух зүйл, халуун хоол, дулаан байр, гар угаах угаалтуур шаардлагатай байна гэсэн саналыг тавьж байлаа.

Харин шинжээч Сиселиатай дараах асуудлаар ярилцлага хийсэн. Үүнд:



- Нүүлгэн шилжүүлэх байр уруу ирэх замын зургийг харахад барилга байгууламж эвдэрснээс зам хаагдах магадлал өндөртэй, замын ойролцоо өндөр барилгууд их байна. Иймээс хотын төвд иргэд явган хүрэлцэж очих боломжтой байр төлөвлөх шаардлагатай;

- Ариун цэврийн байгууламж, жорлон, хэрэглээний ус, халаалтын асуудал аль ч улсад хүндрэлтэй байдаг ч бусад улс орнууд стандартчилж, хариуцлагын тогтолцоог бий болгож өгснөөр хэрэгжилт сайжирдаг;

- Энэ байгууламжийн орчин ой мод ойрхон, өвс ихтэй, хуурайшилттай, байшин нь модон хийцтэй зэрэг нь ой, хээрийн түймэрт өртөх магадлалтай;

- Бодит гамшиг нүүрлэсэн тохиолдолд иргэд шинэ суурьшлын бүс үүсгэж, төлөвлөлтгүй хот суурин байгуулагдах, агаар орчны бохирдол ихэсдэг зэрэг хүндрэл тулгардаг тул аль болох хотын ойрхон боломжтой зай талбайд иргэдийг байрлуулах нь эргээд хэвийн амьдралдаа шилжихэд илүү хялбар байдаг тухай;

Иргэдээс яг гамшиг тохиолдоход та яах вэ, цугларах талбай руу яаж очих вэ, замд нь өндөр барилга байна уу, хэдэн төрлийн маршрут гаргасан бэ? Гэр бүлээрээ энэ маршрутаар явж үзсэн үү? Гэр бүлийн гишүүдийнхээ цусны бүлгийг мэдэх үү?

Цусны бүлэг, овог нэр, гэрийн хаягийн мэдээллээ байнга биедээ авч явдаг уу?

Ажил дээрээ байх үед газар хөдлөхөд та хамгийн түрүүн хаашаа явах вэ? гэх зэрэг асуултуудыг асууж хариултыг нь аваарай. Энэ үед хүн их зүйлийг бодож, ойлгодог юм гэх зэргээр зөвлөмж өгсөн нь хээрийн судалгааны ажлын үнэтэй мөч байлаа.



2. ОБЕГ-ын даргын 2018 оны “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах тухай” А/322 дугаар тушаалын дагуу Төв аймгийн Зуунмод сум, Эрдэнэ сумыг нүүлгэн шилжүүлэхэд хээрийн судалгаа гүйцэтгэлээ

Зуунмод сумын 6 багийн иргэд, төсөвт байгууллага болон ААНБ-ын ажилтан, албан хаагчид хамрагдсан. Зуунмод суманд тухайн цагт оршин суугаа нийт 12743 иргэнээс хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд /хэвтэрт/, 0-2 хүртэлх насны хүүхэд, тэдгээрийг харж байгаа эцэг эх, 80-аас дээш настан зэрэг

иргэд оролцоогүй бөгөөд Зуунмод сумын нийт иргэдийн 85,5 хувь буюу 10903 иргэн “Нүүн шилжих ажиллагаа”-нд оролцсон.

Нүүн шилжих ажиллагаанд оролцсон 10903 иргэнээс ЕБС-ийн /бага анги/ 1-5-р ангийн багш сурагчид, цэцэрлэгийн багш, хүүхдүүд байгууллагын гаднах “Түр цугларах аюулгүй талбай”-д цугларч, нүүн шилжих дадлага сургуульд оролцон, хээрийн штабт ирцийн бүртгэл, орон байрны судалгаа хийлээ. Номтын аманд байрших нүүн шилжих талбайд иргэдийг урьдчилан бэлтгэсэн талбайд засаг, захиргааны анхан шатны нэгж 6 баг, төсөвт байгууллага, ААНБ гэсэн 10 хэсэгт хувааж бүртгэх ажиллагааг хийсэн. Нүүн шилжих ажиллагааг төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажилласнаар иргэдийн 80 гаруй хувийг дадлага сургуульд хамруулсан.

Эрдэнэ сумыг нүүлгэн шилжүүлэлтэд хийсэн судалгаа: Сумын төвийн ойролцоо газар хөдлөлтийн аюул тохиолдсон үед сумыг нүүлгэн шилжүүлэх, хээрийн нөхцөлд хүмүүсийг орон байр, цэвэр ус, хоол хүнсээр хангах, эмнэлэг, эрүүл мэнд, боловсрол, банк санхүү болон төрийн бүхий л үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдлаар иргэдийн нүүлгэн байршуулах төвийг төлөвлөсөн байв. Энэ сургуулилтаар сумыг бүхэлд нь нүүлгэн шилжүүлсэн ба Эрдэнэ сумын гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 66 ажилтан зохион байгуулж сумын 370 өрхийн 960 иргэнийг нүүлгэн шилжүүлсэн. Уг дадлага сургуульд 54 гэр, 2асар барьж, 60 автомашин техник оролцсон /Зургаар харуулья/.



14-р зураг. Төв аймгийн Зуун мод хотыг нүүлгэн шилжүүлэх өмнөх үеийн гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг шалгаж буй байдал

Иргэдийг өглөө 06 цагт “Яаралтай цуглар” дохиогоор төв талбай дээр цуглуулан гамшгийн үед бэлэн байх ёстой аранз болон үүргэвчинд байх зүйлсийг шалган дадлага сургуулилтыг эхлүүлсэн.



15-р зураг. Төв аймгийн Эрдэнэ сумыг нүүлгэн шилжүүлэлт

Төв аймгийн Зуунмод хотын нүүлгэн шилжүүлэлтэнд нийт 10903 хүн хамрагдсан бөгөөд бэлтгэсэн талбайд засаг, захиргааны анхан шатны нэгж 6 баг, төсөвт байгууллага, ААНБ гэсэн 10 хэсэгт хувааж бүртгэл явуулж байлаа.



16-р зураг. Төв аймгийн Эрдэнэ сумыг нүүлгэн шилжүүлэлт

Нүүлгэн байршуулах төв дээр нэг цэгийн үйлчилгээ банкны үйлчилгээ явуулан, хоол хүнсээр ханган, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж иргэдийг бүрэн хамруулан ажилласан. Зургаар харууллаа.





18-р зураг. Төв аймгийн Эрдэнэ сумын нүүлгэн шилжүүлэлт, гамшгийн үеийн бэлэн байдал

Энэ нүүлгэн байршуулах төвд автомашины зогсоол, бүртгэлийн хэсэг, эмнэлэг, бие засах газар, удирдлагын байр, сургууль цэцэрлэг, гал тогоо, хэв журам сахиулах байр, иргэдийн амрах байр, иргэний бүртгэл, нэг цэгийн үйлчилгээ, банкны салбар, спортын талбай зэргийг төлөвлөж байгуулсан нь иргэдийн анхан шатны хэрэгцээг хангах зохион байгуулалтыг авч үзсэн нь харагдаж байна. Мөн иргэдийг гэрт байрлуулан халуун аарц, хоолоор үйлчилж байсан.

Иргэдийн байрлах орон байрыг дан гэр барьж шийдсэн байв. Энэ нь өвлийн улиралд халаалт, түлээ, нүүрс гэх мэт дулааны асуудлыг шийдэхэд хүндрэл бэрхшээл тулгарахаар байна. Мөн эрэгтэй, эмэгтэй гэж ангилаагүй нийтийн дунд 2 жорлон барьсан нь хангалтгүй, иргэдийг оочер, дугаарлалтанд оруулахад хүргэж байсан.

1.2.3. Монгол Улсын хэмжээнд нүүлгэн шилжүүлэлт хийсэн байдал

Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн нүүлгэн шилжүүлэх ажил явуулсан байдал: Баянгол дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 12 давхар орон сууц цууралт өгч нурах аюул тулгарсан тул Баянгол дүүргийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах” тухай А/275 дугаар захирамж мөн өдрийн “Болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдийг орон сууцнаас нүүлгэх, шилжүүлэх” тухай А/276 дугаар захирамжуудыг тус тус гарган дараах арга хэмжээг авсан байна.

Баянгол дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 12 давхар орон сууцны 16 дугаар байранд амьдардаг 49 өрхийн 244 иргэнийг Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу хамгаалалтын бүсийг тогтоон нэгдсэн нэг удирдлага, төрөл, мэргэжлийн алба хаагч нар өөр өөрсдийн үүрэгт ажлын чиглэлээр ажилласан.

Нурах аюул үүссэн байрны 48 айл өрхийн 213 иргэнд нөхцөл байдлыг танилцуулж, яаралтай аюулгүй газар шилжих талаар анхааруулга, зөвлөмжийг өгч, байрнаас гарган “Эрхэс” зочид буудалд 54, “247” зочид буудалд 21, “Мини” зочид

буудалд 24, “Таац” зочид буудалд 31, Номуун зочид буудал 24, Стар зочид буудалд 24 нийт 178 иргэнийг том оврын 3-н автобусаар тээвэрлэж, түр байрлуулсан.

Нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд Нийслэлийн Онцгой байдлын газраас 8, дүүргийн Онцгой комиссоос 21, дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 41, Цагдаагийн 1 дүгээр хэлтсээс 50, Мэргэжлийн хяналтаас 40, ус дулаанаар хангах албанаас 4, эрчим хүчээр хангах албанаас 6, 14 дүгээр хорооноос 5, СӨХ-3, Эрүүл мэндийн нэгдэлээс 4, прокурор 2, барилгын хөгжлийн төвөөс 3 нийт 187 алба хаагчид оролцож, 178 иргэнийг том оврын 3 автобусаар тээвэрлэн 7 зочид буудалд байрлуулан, халуун хоол ундаар хангасан байна.

Байрны гадна хамгаалалтанд Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, хорооны нийт 22 алба хаагчид томилогдон ажилласан ба иргэний 1 хоногийн хоол, буудлын зардалд 7,800,000 төгрөгийн зардал гаргасан байна.

Улаанбаатар хотын хувьд нүүлгэн шилжүүлэлтийг дээрх байдлаар явуулсан бол аймаг орон нутгийн хэмжээнд буюу Дархан-Уул, Архангай, Баян-Өлгий аймгуудын Онцгой байдлын газрын Гамшиг, аюулт үзэгдлийн үеэр хийгдсэн нүүлгэн шилжүүлэлт, түр хоргодох байр, түүний зохион байгуулалтын талаар авч үзвэл:

Дархан-Уул аймаг: Үүссэн нөхцөл байдал: Дархан сумын 12-р багийн 14-р байрны 9 давхар орон сууцны 7 давхрын 26 тоотод 2012.01.21-ны өдрийн 21:25 минутанд 5 литрийн багтаамжтай шингэрүүлсэн хийн түлшний баллон задарч агаарт цацагдсан, үүний улмаас дэлбэрэлт үүсч, гал түймэр гарч 3 хүн түлэгдэж, бэртсэн, дэлбэрэлтийн нөлөөнөөс 14-р байрны 1-р орцны 6, 7, 8 давхрын барилгын хийц бүтээцэд эвдрэл гэмтэл, цууралт ан цав үүсэж, хана гадагш тэлж, дэлбэрэлтийн долгионоос тус байрны 19 айл өрхийн 91 цонх, салхивчны шил хагарч, объектын урд талд 60 метрийн зайд байрлах МЦХ-ны Шуудан холбооны барилгын 1 давхрын цонхны шилэн хийц бүтээцийн 80% хагарсан нөхцөл байдал үүссэн. Гал түймэр гарах явцад цахилгаан эрчим хүч тасарсан, хор уршгийг арилгах, сэргээн босгох, тусламж үзүүлэх, даарч бээрэхээс сэргийлэх зорилгоор 33 өрхийн 115 иргэнийг нүүлгэн шилжүүлсэн байна. Түр нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ зохион байгуулах тухай, нүүлгэн шилжүүлэх тухай ажлын тайлан, төлөвлөгөөг 4-р хавсралтаар харууллаа.



19-р зураг. 1-р орцны 32 өрхийн 113 иргэнийг нүүлгэн шилжүүлэх ажиллагаа

Дээрх мэдээллийг гамшгийн статистик мэдээ, орон нутгийн гамшгийн мэдээллийн сангаас авсан ба мэдээллүүд нь хаана нүүлгэн шилжүүлж байршуулсан, хангалтыг хэрхэн хийсэн, амьдралын хэрэгцээг юунд үндэслэн хэрхэн бүрдүүлсэн талаар мэдээлэл огт байхгүй байна.

Баян-Өлгий аймаг:

2016 оны 07 дугаар сарын 10, 2018 оны 07 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд аймгийн төвд үер буусны улмаас олон тооны айл өрхүүд үерийн гамшигт өртөж Онцгой байдлын байгууллагын алба хаагчид иргэдийг эд хөрөнгийн хамт нүүлгэн шилжүүлсэн байна.

2016 оны 07 дугаар сард Өлгий сумын 6, 9 дүгээр багуудын үерийн гамшигт өртсөн 103 өрхийн 324 хүнийг аюулгүй газарт татан гаргаж, 84 өрхийн 244 иргэнийг түр амрах байр буюу сургуулийн заал, цэцэрлэгийн анги, танхимд нүүлгэн шилжүүлсэн байна.

2018 оны 07 дугаар сарын 14, 15, 16-ны өдрүүдэд үргэлжлэн орсон аадар борооны улмаас Өлгий сумын 2, 3, 4, 9, 11, 12, 13 дугаар багуудад буусан 3 удаагийн уулын үерийн гамшигт нэрвэгдсэн 530 өрхийн 2512 иргэнийг гамшгийн голомтоос татан гаргаж 236 өрхийн 972 иргэнийг (түр амрах байр) 9 газарт байрлуулж, 345 өрхийн 1844 иргэнийг мөн сургууль, цэцэрлэгийн заал, анги, танхимд нь нүүлгэн шилжүүлсэн байна.



20-р зураг. Нүүлгэн шилжүүлэлт

Аймгийн хэмжээнд гамшиг, аюулт үзэгдэл, осолд орсон иргэдийг байршуулах зориулалтын түр хоргодох байр байгаагүй тул сургууль, цэцэрлэгийн байр, заал, танхимд иргэдийг олноор байрлуулахад эрүүл ахуйн зөрчил үүсэх, түүнээс үүдэн халдварт өвчин гарах эрсдэл өндөр байдаг нь ажиглагдсан байна.

Архангай аймаг: Архангай аймгийн Хашаат сумын Номгон багийн Сайрын ам гэдэг газар сумын төвөөс зүүн урд зүгт 30 км-т 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 16 цаг 39 минутын орчимд хүчтэй салхи, аадар бороо, мөндөр орсны улмаас байгалийн онц аюулт үзэгдэл болж урьдчилсан байдлаар 8 айлын гэр нурж бусад эд зүйл эвдэрч сүйдэн ихээхэн хэмжээний хохирол учирсан байна.

Хүчтэй салхи, аадар бороо орсны улмаас 16 айлын 17 гэр нурж эвдрэн, яс модыг дахин ашиглах боломжгүй болсон, бусад эд хогшил эвдэрч, 2 айлын өвөлжөө салхинд эвдэрч нурсан, гүний худгийн онгоц усанд урссан, Номгон багийн иргэн Н.Батсайханы хонь 94, ямаа 52, морь 1 үерийн усанд урсаж хорогдсон.

Онцгой байдлын алба хаагчид 2, дүйцүүлэх албаны цэрэг 3, мэргэжлийн ангиас 32 хүн нийт 37 хүн, 5 техник хэрэгсэлтэйгээр үерт автсан 8 айл өрхийн 19 хүн, гэр, эд хогшлыг машинд ачиж аюулгүй газарт нүүлгэн шилжүүлж, үерт урссан эд хогшлыг цуглуулах зэрэг ажлуудыг хийж, эвдэрсэн эд хогшлыг айл өрх бүрээр бичүүлж, зураг авч баримтжуулсан байна.

Үерийн улмаас сумын 21 айл өрхөд 28.833.600 /хорин найман сая найман зуун гучин гурван мянга зургаан зуу/ төгрөгийн хохирол учирсан байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг нийт 41 өрхийн 164 м² талбайд хийж, 4 тонн ус, 7 кг хлорийн шохой, 2 кг HI-COP төрлийн ариутгалын бодис зарцуулжээ.

Архангай аймгийн Цэцэрлэг хотын нүүлгэн шилжүүлэх түр хорогдох байр нь дийлэнхдээ сургуулийн спорт заал, урлагийн танхим, заал байна. Зургаар дүрслэн харууллаа.



21-р зураг. Гурван тамир дээд сургуулийн спорт заал



22-р зураг. Хүмүүн цогцолбор 1 дүгээр сургуулийн спорт заал

Хүн амыг нүүлгэн шилжүүлж байрлуулахад төлөвлөсөн байр талбайнаас гадна хүмүүсийн амьдралын нөхцөлийн наад захын шаардлагыг хангасан орон байр хамгийн гол үзүүлэлт юм. Тиймээс нийслэл, дүүрэг, амгуудын нутаг дэвсгэрт ажиллаж буй амралтын газар жуулчны бааз, гэр буудлуудыг хүн амын нүүлгэн шилжүүлэлтэнд ашиглах зайлшгүй шаардлага гарч байна. Нийслэлийн дүүргүүдийн ойр орчмын нутаг дэвсгэрт 2018 оны байдлаар жуулчны бааз 77, амралтын газар 79, гэр буудал 47 бүгд 203 байгууллага ажиллаж байна. Дүүрэг бүрээр авч үзвэл: Налайх дүүрэгт 121 буюу нийт байгууллагын 59.6 хувь нь, Баянзүрх дүүрэгт 29, Сонгинохайрхан дүүрэгт 17, Сүхбаатар дүүрэгт 10, Хан-Уул дүүрэгт 12, Чингэлтэй дүүрэгт 6, Багануур дүүрэгт 8 газар тус тус ажиллаж байна. Дээрх байгууллагын 1/3 нь жилийн 4 улиралд ажиллаж байна. Бусад байгууллагыг өвлийн улиралд аливаа нэгэн гамшиг ослын үед нээж ажиллуулах бүрэн

боломжтой юм. Эдгээр байгууллагууд нийт 10465 ортой бөгөөд 2000 гаруй ажилтан, албан хаагч 278530 хүнд үйлчилж байна. Мөн “Их тамир цогцолбор”, “Бага баян-Энхийн төлөө цогцолбор”-д жилийн аль ч улиралд нэг удаагийн ээлжинд 3000 гаруй хүн хүлээн авах боломжтой байна. Үүнээс гадна эдгээр байгууллагын спорт заал, соёлын төвд 5000 шахам иргэдийг хүлээн авах боломж байна²⁹.

Цаашид орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд түр орогнох байрны талаар болон бүх талын нөөц байгаа эсэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар хэрхэн ажиллах, байгууллага хооронд хэрхэн уялдаа холбоотой ажиллах талаар оруулан дадлага сургуулилтын үед эдгээр нь хэр бодитой хэрэгжиж байгааг хянаж байх нь практик ач холбогдолтой юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ҮЕД ИРГЭДИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

2.1. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах олон улсын шаардлагад хийсэн шинжилгээ

Ихэнх улс орнуудад иргэдийн түр хоргодох байр, нүүлгэн байршуулах төв нь гамшгийн үед болон хил дамнасан эсвэл дотоодын дүрвэгсдийг хүлээн авах, амьдрах нөхцөлөөр хангах зорилгоор төлөвлөгдсөн байдаг.

Олон улсад нэрвэгдэгсдийн орон байрыг хэрхэн барьж байгуулах, ямар тохиолдолд тусгай орон байранд нүүлгэн шилжүүлэх, ямар хэлбэрийн байранд байрлуулах, тухайн газар орны байгаль орчин, нийгэм, эдийн засаг, техникийн, нийгмийн хүчин зүйлүүдийг тусгасан хэд хэдэн гол удирдамж баримт бичгүүд батлагдсан байдаг. Жишээлбэл, Transitional Shelter Guidance-Хөдөлгөөнт хамгаалах байрны удирдамж (International Organization for Migration, 2012), Collective Centre Guidelines (Camp Coordination/Camp Management, 2010 - Кэмпийн зохицуулалт/ Кэмпийн менежмент, 2010) болон бусад олон төрлийн хамгаалах байрны шаардлагыг тодорхойлсон эрдэм шинжилгээний бүтээлүүдээс дурьдвал: "Гамшгийн дараах түр байрны стратеги төлөвлөлт" (Johnson, 2007b), "Түр орон сууцны тогтвортой байдал, соёлын интеграцийг сайжруулах удирдамж" (Félix et al., 2013a) Evacuation and Shelter Guidance - Нүүлгэн шилжүүлэлт, хоргодох байрны удирдамж (HM Government, 2014) зэрэг бусад баримт бичигт бичигдсэн байна. Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн чухал баримт бичиг бол Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний минимум стандарт (Сфер төсөл, 2011), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын албанаас боловсруулсан онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээний гарын авлага зэрэг удирдамжууд болно.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын албанаас боловсруулсан Онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээний гарын авлагад дүрвэгсдийн болон гамшгийн дараах иргэдийн түр хоргодох байранд тавигдах шалгуурын асуудлуудыг тодорхойлсон байна. Энд,

²⁹Я.Жаргалсайхан, Хүн амын нүүлгэн жилжүүлэлт түүнийг боловсронгуй болгох арга зам, докторын зэрэг горилсон диссертаци, 2018 он,

байршил сонголт, байр зүй /ойрхон байх/, талбайн хэмжээ, газар ашиглах, өмчлөх эрх, хөрсний бүтэц, усан хангамж, ус зайлуулах суваг, цаг уурын нөхцөл, нутагшмал өвчин үүсгэх шинж, аюулгүй байдал, хамгаалалт зэрэг. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг үндсэн 3 хэлбэрт хуваан үздэг байна. Үүнд:

1. Тараан суурьшуулах
2. Нийтийн хоргодох байр
3. Хуаран

Гамшигт өртөөгүй суурьшлын бүсийн айлуудад тараан байршуулдаг ба энэ нь хэрэгжүүлэхэд хурдан, нутгийн захиргааны зүгээс туслалцаа, оролцоо бага шаарддаг, өртөг бага, иргэд өөрөө өөртөө үйлчилж биеэ даадаг, тухайн орон нутгийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө бага зэрэг давуу талтай. Ийм хэлбэрийн зохицуулалт нь хүлээн авагч айлууд болон тухайн орон нутгийн иргэдэд илүү ачаалал үүсч, ядуурал нэмэгддэг, хүн амын бүртгэлийн асуудалд хүндрэл үүсдэг, хүн ам хэт төвлөрснөөс тэдний хамгаалалт, тэжээллэг хоол хүнс, эрүүл мэндийн асуудалд хүндрэл үүсдэг, тусламжийн бүхий л хэлбэрийг орон нутгийн иргэд, дүрвэгсдэд адилхан хүртээх шаардлагатай болдог зэрэг сул талуудтай.

Нийтийн хоргодох байр нь иргэдийг бэлэн байгаа ямар нэг нийтийн зориулалтын байр буюу сургууль, хуаран, зочид буудал, биеийн тамирын заал зэрэг газарт байршуулах хувилбар юм. Ийм хэлбэрийн давуу тал нь иргэд ямар нэг саадгүйгээр шууд байрлах, ус, эрүүл ахуй, ариун цэвэр бусад үйлчилгээг нэн даруй үзүүлэх боломжтой байдаг бол хэт олон хүний бөөгнөрөл үүсдэг, эрүүл ахуй бусад үйлчилгээний ачаалал ихсэх, тоног төхөөрөмж, байгууламж эвдрэх, барилга байгууламжийг анхны зориулалтаар ашиглах боломжгүй болох зэргээс нутгийн иргэдийн нийтийн үйлчилгээ тасалдах зэрэг сул талууд байна.

Хуаран нь тухайн нөхцөл байдлаас хамаарч төлөвлөсөн, төлөвлөөгүй/дамжин өнгөрүүлэх/ байж болно. Нэн яаралтай хэрэгцээг хангах үүднээс урьдчилан төлөвлөгөөгүй майхан, асар, оромж барьж иргэдийг байрлуулдаг. Энэ нь үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй, зардал мөнгө ихээр шаардагддаг. Тиймээс энэ төрлийн хуарангаас дариухан шилжин нүүлгэх арга хэмжээ авах нь зүйтэй. Төлөвлөсөн хуаран нь дүрвэгсэд болон гамшигт нэрвэгдэгсдийг байрлуулах зориулалтын байгууламж байх бөгөөд бүхий л үйлчилгээгээр хангагдсан байдаг. Ийм хэлбэрийн давуу тал нь их хэмжээний хүн амд нэгдсэн үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх, хямд төсөр, тэдэнтэй харьцаж ажиллахад илүү хялбар, дүрвэгсдийг эх оронд нь сайн дураар буцаах, гамшигт нэрвэгдэгсдийг үндсэн харьяалалд нь буцаах ажлыг зохион байгуулахад хялбар байдаг. Гэтэл хүн амын хэт их төвлөрөл нь эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлдэг, хуарангийн ойр орчмын байгаль орчин бохирдох, сүйдэх, аюулгүй байдлыг хангахад хүндрэл бэрхшээл учирдаг, хуарангууд нь дүрвэгсэд, гамшигт нэрвэгдэгсдээс гадна бусад гэмт этгээдийн нуугдах, зугтах газар болох магадлалтай зэрэг сул талууд байдаг. Үүнийг багцлан дараах хүснэгтээр харуулъя.

2-р хүснэгт. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны ангилал, сул ба давуу тал

	Зохицуулалт	Давуу тал	Сул тал
Тараан байршуулах төв	Гамшигт өртөөгүй суурьшлын бүсийн айлуудад тараан байршуулахаар төлөвлөдөг	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжүүлэхэд хурдан; - Нутгийн захиргааны зүгээс туслалцаа; оролцоо бага шаарддаг; - Өртөг бага; - Иргэд өөрөө өөртөө үйлчилж биеэ даадаг; - Тухайн орон нутгийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө бага; 	<ul style="list-style-type: none"> - Хүлээн авагч айлууд болон тухайн орон нутгийн иргэдэд илүү ачаалал үүсч, ядуурал нэмэгддэг; - Хүн амын бүртгэлийн асуудалд хүндрэл үүсдэг; - Хүн ам хэт төвлөрснөөс тэдний хамгаалалт, тэжээллэг хоол хүнс, эрүүл мэндийн асуудалд хүндрэл үүсдэг; - Тусламжийн бүхий л хэлбэрийг орон нутгийн иргэд, дүрвэгсдэд адилхан хүртээх шаардлагатай болдог зэрэг;
Нийтийн хоргодох байр	Бэлэн байгаа ямар нэг нийтийн зориулалтын байр буюу сургууль, зочид буудал, биеийн тамирын заал зэрэг газарт байршуулахаар төлөвлөдөг	<ul style="list-style-type: none"> - Иргэд ямар нэг саадгүйгээр шууд байрлах; - Ус, эрүүл ахуй, ариун цэвэр бусад үйлчилгээг нэн даруй үзүүлэх боломжтой; 	<ul style="list-style-type: none"> - Хэт олон хүний бөөгнөрөл үүсдэг; - Эрүүл ахуй бусад үйлчилгээний ачаалал ихсэх; - Тоног төхөөрөмж, байгууламж эвдрэх; - Барилга байгууламжийг анхны зориулалтаар ашиглах боломжгүй болох зэргээс нутгийн иргэдийн нийтийн үйлчилгээ тасалдах зэрэг;
Хуаран	Нэн яаралтай хэрэгцээг хангах үүднээс урьдчилан төлөвлөгөөгүй майхан, асар, оромж барьж иргэдийг байрлуулдаг	<ul style="list-style-type: none"> - Их хэмжээний хүн амд нэгдсэн үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх; - Хямд төсөр, тэдэнтэй харьцаж ажиллахад илүү хялбар; - Гамшигт нэрвэгдэгсдийг үндсэн харьяалалд нь буцаах ажлыг зохион байгуулахад хялбар; 	<ul style="list-style-type: none"> - Хүн амын хэт их төвлөрөл нь эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлдэг; - Хуарангийн ойр орчмын байгаль орчин бохирдох, сүйдэх; - Аюулгүй байдлыг хангахад хүндрэл бэрхшээл учирдаг; - Хуарангууд нь дүрвэгсэд, гамшигт нэрвэгдэгсдээс гадна бусад гэмт этгээдийн нуугдах, зугтах газар болох магадлалтай зэрэг

Олон улсын стандартад хуаран төлөвлөхөд дунджаар нэг хүнд 45 м² (гал зуух, хүнсний ногоо тариалах талбайн хамт) байх, хүнсний ногоо, тариалах талбайн хэмжээг хасаад 30м²-аас багагүй байх ёстой гэж заасан байдаг. Энэ талбайд явган зам, хичээл хийх газар, эрүүл ахуйн зурвас, галын эсрэг зурвас, захиргаа, ус нөөцлөх, хуваарилах, тусламжийн барааны агуулах гэх мэт талбайгаас гадна хоргодох байр багтана.

Хоргодох байр болон хуаран байгуулахдаа мастер төлөвлөгөөний дагуу хийнэ. Мастер төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгасан байх шаардлагатай³⁰. 3–р хүснэгтээр харуулав.

³⁰UNHCR, Онцгой байдлын үеийн гарын авлага., Гурав дахь хэвлэл, 2007 он, 290х.

3-р хүснэгт. Хоргодох байр, хуарангийн олон улсын стандарт, шалгуур

	Хоргодох байр ³¹	Хуаран
Талбайн хэмжээ	Дулаан уур амьсгалтай 3-5 м ² /гал зуух ороогүй/ Хүйтэн уур амьсгалтай 4.5-5.5м ² /усанд орох талбай, гал зуухыг хамруулаад/ Нийтийн байр эсвэл майхан бол хувь хүний тухыг бодолцон 5 хүн байхаар буюу 1 гэр бүлд. Жнь: 85м ² талбайтай майханд 14-25 хүн агуулах багтаамжтай байдаг.	45 м2
1 усны гоожуур	50 хүнд	80-100 хүнд
1 гадаа жорлон	20 хүнд	1 гэр бүлд /6-10 хүн/
1 эрүүл мэндийн төв	-	20,000 хүнд
1 төв эмнэлэг	-	200,000 хүнд
1 сургуулийн блок	-	1 секторт /5000 хүн/
1 хооллох төв	Хоол хүнс бэлдэх 500 хүнд 100м ³	20,000 хүнд
1 хог хаягдал зайлуулах сав		80-100 хүнд
Агуулах	1000 хүнд 150-200 м ²	-


Хуарангийн төлөвлөлтийг хийхдээ хүн амыг багаас их рүү өөрөөр хэлбэл, гэр бүлээс 1 хуаранг хамруулдаг байна. Загварыг дараах хүснэгтээр үзүүлэв.

4-р хүснэгт. Хүн амын загвар

Загвар	Бүрдэл	Хүний тоо /дунджаар/
Гэр бүл	1	4-6
1 хороо	16 гэр бүл	80 хүн
1 блок	16 хороо	1250 хүн
1 сектор	4 блок	5000 хүн
1 хуаран	4 сектор	20,000 хүн

Хуарангийн байр зүйн төлөвлөлтийг нэг хашаанд хашигдсан бус “Н” үсэг маягаар нээлттэй байх маягаар байгуулах нь иргэдэд эерэг, өөриймсөг сэтгэгдэл төрүүлдэг байна. Жишээ болгож НҮБ-ийн Онцгой байдлын үед авах арга хэмжээний гарын авлагад тусгагдсан хуарангийн план зургийг авч үзье.

³¹UNHCR, Онцгой байдлын үеийн гарын авлага., Гурав дахь хэвлэл, 2007 он, 298х.



23-р зураг. Хуарангийн төлөвлөлтийн бүдүүвч зураг.

Дээрх план зургийг 1 хороо буюу 16 өрх, 80 хүн /4-р хүснэгт/ байхаар төлөвлөсөн байна.

Герман Улсад дүрвэгсдэд зориулсан онцгой байдлын үеийн хор уршгийг арилгах удирдамжид түр хоргодох байрны стандарт хэм хэмжээний талаар зохицуулалтыг тусгасан байдаг. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

5-р хүснэгт. Германы иргэдийг нүүлгэн шилжүүлэх орон байрны төрөл

Агуулга	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны
Албан нэршил	Анхдагч бүртгэлийн төв	Хоёрдогч бүртгэлийн төв	Нэгдсэн төв
Ерөнхий байршил			
Амьдрах хугацаа	3 өдөр хүртэл	3 сар хүртэл	3 сараас дээш
Хэрэглээний зориулалт	Гамшигт өртөгсдийг эсвэл дүрвэгсдийг хүлээн авах, бүртгэх	Түр хугацаагаар байрлуулах, орогнуулах	Гамшигт өртөгсдийг хэвийн амьдрах нөхцөлдөө эргэн шилжих хүртэл
Үүрэг	Бүртгэл, мэдээлэл дамжуулах	Мэдээлэл, орон байр, амьжиргааны болон эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлох	Мэдээлэл, байнгын оршин суух газрын судалгаа, зөвшөөрөл
Иргэдэд чиглэсэн тусламж	Тэдний хэрэгцээнд зайлшгүй шаарлагатай хэрэгцээг бүрдүүлэх сайн дурын групп	Орон байраар хангахын зэрэгцээ үндсэн хэрэгцээг бүрдүүлэх	Байнгын оршин суух нөхцөл бүрдсэн газар, орон байраар хангах
Иргэдэд зориулсан үйлчилгээ	Унтах нөхцөл, хоол, бусад суурь хэрэгцээ, эрүүл мэндийн үзлэг	Орон байр, хоол, бусад хэрэгцээ, эрүүл мэндийн тусламж	Орон байр, хүүл, хүнс, гал тогоо, суурь хэрэгцээ
Түр оршин суугчдын харьяалал	Түр байрлах бүртгэлийн жагсаалтад бүртгэгдэх	Түр оршин суух бүртгэл	Түр оршин суух зөвшөөрөл
Удирдлага, зохион байгуулалт	Засгийн газар	Холбооны улс	Ихэвчлэн нутгийн захиргаа

Герман Улсын Бавариа муж нь иргэд түр орогнох (анхдагч бүртгэлийн төв) 10 000 хүнийг нэг дор хүлээн авах хүчин чадал бүхий 2 том байгууламжтай.



WARTERAUM FELDKIRCHEN



24-р зураг. Бавариа муж дахь иргэдийн түр орогнох байр

Герман Улсын хэмжээнд 140,000 хүн хүлээн авах хүчин чадалтай 470 дунд болон урт хугацааны амьдрах нүүлгэн байршуулах төвийг шаардлагатай дэд бүтцээр төлөвлөн, тоноглож байдаг байна.



25-р зураг. Германы иргэдийг нүүлгэн байршуулах төв

Гамшиг ослын үед дээрх зохион байгуулалтаас гадна олон улсын хүмүүнлэгийн байгууллагын холбооноос гаргасан Сфер төслийн Хүмүүнлэгийн тунхаглал ба гамшгийн хариу үйлдлийн минимум стандартыг баримталдаг.

Олон улсад хэрэглэгддэг Сфер төслийн минимум стандарт, НҮБ-ийн Хүний эрхийн дээд комиссын стандарт, Монгол Улсын стандартыг харьцуулан дараах хүснэгтэд харууллаа.

6-р хүснэгт. Стандарт, шалгуур үзүүлэлт

Шаардлагатай зай	Sphere төсөл, 2004 (шалгуур)	НҮБХЭДК, 2007 (стандарт)	MNS стандарт
Нэг хүнд оногдох газрын доод хэмжээ:	45 м ² дэд бүтцийг оролцуулан, харин ХАА зориулалттай газрыг оролцуулахгүй	45 м ²	-
Нэг хүний амьдрах зай:	3,5 м ² – 4,5 м ²	УБ хотод 3,5 м ² – 4,5 м ² дулааны улирал 4,5 м ² – 5,5 м ² хүйтний улирал	6,5 м ² – 7 м ² ³²
Хуаранд байх хүний дээд тоо:	*	20,000 хүн	
Газрын налуу:	1 % - 6 %	2% - 4%	Явган хүний хөндлөн 2% - 4%, налуу 5,0 %-иас хэтрэхгүй ³³ .
Усны түвшингээс дээш газрын төвшинд байрлах	3 м борооны улиралд	*	-

³² MNS 5095:2017 нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа

³³ MNS 5682:20096 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага

Ус хангамж	Sphere төсөл, 2004 (шалгуур)	НҮБХЭДК, 2007 (стандарт)	MNS стандарт
Хангагдах усны доод хэмжээ (өдөрт нэг хүнд нэг литр)	7,5 – 15 амны ус	7 амны ус 15-20 боломжтой бол Гал тогоо 20-30 л, эмнэлэг 40-60	2,000 ³⁴
Усан хангамжийн цэг бүрт оногдох максисум хүн:	1 түгээгүүр 250 1 гар худагт 500 1 худагт 400	200 хүнд нэг түгээгүүр, 80-100 хүнд нэг түгээгүүр байвал сайн	
Ус руу явах максимум зай:	500 м	100 м	Газраас дээш 80 см-с доошгүй өндөрт 10м-20м зайд ³⁵

Ариун цэвэр	Sphere төсөл, 2004 (шалгуур)	НҮБХЭДК, 2007 (стандарт)	MNS стандарт
Нэг жорлонд оногдох хүн максимум	20 хүн (хүйсээр ялгасан бол)	Сонголт 1: гэр бүлд нэг, Сонголт 2: 20 хүн, Сонголт 3:100 хүн	/30 эмэгтэй 1 суултуур, 45 эрэгтэй 1 суултуур, 1 шээлтүүр, 30 хүнд 1 угаалтуур/ ³⁶ (10 эмэгтэй ба 15 эрэгтэйд 1 суултуур - 7 м ^{2,37}
Жорлон явах зай:	Максимум 50 м	6 м – 50 м	ОС, НБ, ҮГ-аас 15 метр, УТБ-аас 20 метр, уурхайн болон өрөмдмөл худгаас 150 -аас 250 метр, голын эргээс 200-250 метрээс багагүй зайд) ³⁸

Нийтийн үйлчилгээ	Sphere төсөл, 2004 (шалгуур)	НҮБХЭДК, 2007 (стандарт)	MNS стандарт
Шаардлагатай үйлчилгээ:	Нэг газарт оногдох тоо:	Хүн амын тоо:	
1 эмнэлэг	10	200,000	
1 эрүүл мэндийн төв	1,5	30,000	
1 эмнэлгийн цэг	(салбар бүрээр)	Ойролцоогоор 5,000	
1 бараа олгох цэг	1	20,000	
1 худалдааны цэг	1	20,000	Хот, суурин газар албан байгууллагаас 100 метрээс хол зайд ³⁹
1 сургууль	(салбар бүрээр)	5,000	

Дээрх стандартуудын харьцуулалтаас манай улс түр хоргодох байранд дүйцүүлэх боломжтой стандарт байхгүй байгаа нь харагдаж байна.

Гамшгийн дараах иргэдийг нүүлгэн байршуулах төв, түр хоргодох байрны стандартын эдгээр үзүүлэлтээс гадна хүйтэн, сэрүүн уур амьсгал 8 сарын турш үргэлжилдэг манай орны хувьд орон байрны халаалт, агаарын чанарын асуудал

³⁴ҮХАА-н сайдын 2013 оны А/162 тоот тушаал

³⁵ MNS 5775:2014 хот, суурины ундны ус түгээх цэг(байр)-ийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага

³⁶ MNS6430:2014 интэрнэт кафе, уахим тоглоомын үйлчилгээний байранд тавих шаардлага

³⁷ MNS 5095:2017 нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа

³⁸MNS 5924 : 2015 нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага.

³⁹ MNS 5408:2004 Барилгын бараа, бүтээгдэхүүний худалдаа - үйлчилгээ ерөнхий шаардлага


урган гардаг. Энэ бэрхшээлийг бусад улс орон, олон улсын байгууллага хэрхэн авч үздэгийг судаллаа.

Олон улсын судалгаагаар амьдрах орчны дулааны нөхцөлийн үндсэн элементэд дараах асуудлыг хамруулан ойлгодог байна. Үүнд:

1. Дулаан хувцас
2. Хүний бие организмын онцлог
3. Агаарын хэм
4. Барилга, байгууламжийн хананы дулаан алдагдлын байдал
5. Агаарын урсгал
6. Агаарын чийг

Эдгээр үзүүлэлтүүд нь хүний дулааны энергийн түвшинг хэвийн байлгах гол үндэс бөгөөд энэ нь хүний эрүүл байх нөхцөлийг бүрдүүлдэг байна. Онолын судалгаагаар насанд хүрсэн хүний дулааны энергийн түвшин нь өвлийн улиралд дунджаар 250Ватт байх шаардлагатай гэж үздэг⁴⁰.

Энэ дулааныг хэвийн байлгах агаарын тохиромжтой хэм нь 15-19⁰С байна⁴¹. Мөн НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссын Онцгой байдлын үеийн гарын авлагад нүүлгэн шилжүүлэх байрны тохиромжтой хэм(15-19⁰С)-ийг барихын тулд барилга байгууламжийн дулаан тусгаарлах материал, түүний чанарын үзүүлэлт, халаагч зуухны хүчин чадал, төрлийг зааж өгсөн байдаг. Тухайлбал, гадаад орчны хэм -20⁰С байх үед ихэнх барилга, байгууламжийн дулаан тусгаарлагч хананы хөндлөн урсгалын дулаан солилцлын хазайлт нь 4⁰С/м байдаг бол босоо урсгалын дулаан солилцлын хазайлт нь 1,5⁰С/м байдаг гэж тодорхойлсон байна.




26-р зураг. Дулаан солилцлын температурын өөрчлөлтийг харуулсан байдал

⁴⁰ Vincent Virgo, Winter criteria, Shelter Research Unit an initiative of the Benlux Red Cross Societies, 2015

⁴¹ WHO-Environmental health in Emergencies and disasters: a practical guide, chap6: Shelter and emergency settlements p.87.


Агаарын урсгал нь дулаан солилцлыг нэмэгдүүлдэг хэдий ч дулааны биед мэдрэгдэх хэмийг бууруулдаг. Иймээс агаарын урсгалын зохистой хэмжээ нь хүйтний улирлын нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах бас нэг анхаарах үзүүлэлт юм.



27-р зураг. Агаарын урсгалын тохиромжтой нөхцлийн бүдүүвч

Зургаас агаарын урсгалын тохиромжтой утга 0,13-0,2м/с байгаа нь харагдаж байна.

Агаарын чийг гэдэг нь дэлхийн агаар мандал болон тасалгаан доторх хийн холимогт агуулагдах усны уурын хэсэг юм. Өрөө, тасалгаан дахь агаарын чийг 40-60% байх нь хамгийн тохиромжтой нөхцөл гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлжээ.



28-р зураг. Агаарын чийгийн нөлөө

Дээрх зургаас харахад чийгийн агууламж хэт их эсвэл хэт бага байх үед бактер, вирус, харшил, астма үүсэх магадлал өндөр, чийгийн агууламж хэт бага үед амьсгалын замын халдвар, агаар дахь азотын исэл, нүүрсхүчлийн дутуу ислийн ялгарал ихэсдэг. Харин чийгийн агууламж хэт их үед мөөгөнцөр, цагаан эрвээхэй, химийн урвал/агаарын хүчилтөрөгчийн болон бусад орчны химийн

бодисын нөлөөгөөр зэврэх, исэлдэх зэрэг урвал явагдах/ таатай нөхцөл бүрддэг байна.

Эдгээр хүчин зүйлсээс гадна хүйтний улиралд нүүлгэн шилжүүлэх байрны орчмын дуу чимээ, гэрэл, харагдах орчинд анхаарах шаардлагатай юм.

Хүйтний улиралд анхаарах бас нэг том асуудал бол агаарын чанар юм. Агаарын чанарыг нүүрсхүчлийн хий, түүний дутуу исэл, тоосонцрын хэмжээ зэргээр илэрхийлдэг. Агаар дахь нүүрсхүчлийн /CO₂-ийн хэмжээ 0,15% буюу 1500 ppm түвшинд хүрэхэд бидэнд шууд мэдрэгдэх хэмжээ юм.

7-р хүснэгт. Нүүрсхүчлийн хийн түвшин, тунгийн харьцаа

Нүүрсхүчлийн хийн мэдрэгдэх түвшин	Хэмжээ /ppm/
Хэвийн /гадна орчин/	350-450
Зөвшөөрөгдөх	<600
Бага зэрэг үнэртэх	600-1000
OSHA стандарт	1000
Хөнгөн унтаарах	1000-2500
Эрүүл мэндэд нөлөөлөх	2500-5000
8 цагийн турш хүртэх тунгийн хязгаар	5000
Аюултай түвшин	
Мансуурах, амьсгал давчдах, зүрхний цохилтын ихсэх, дотор муухайрах	30,000
Толгой өвдөх, хяналтаа алдах	50,000
Үхэлд хүрэх тун	100,000

АНУ-ын Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Мэндийн Удирдах Газар /OSHA/-аас гаргасан стандартаар 8 цагийн турш байх зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь 35 ppm байхаар тогтоосон байна. 200 ppm нүүрсхүчлийн дутуу ислээр бохирдсон агаараар 2-3 цаг амьсгалсан тохиолдолд толгой өвдөх, ядрах, дотор муухайрах, чичрэх зэрэг шинж тэмдэг үзүүлдэг байна.

Хүйтний улиралд өрөө, тасалгааг дулаацуулах зорилгоор гал түлснээр агаарын чанар муудаж, тоос, тоосонцор ихээр үүсдэг. Тоосонцрын найрлагад орчны химийн нэгдэл, эрдэс бодисын тоос, үс, ноос, тоосны хачиг, мөөгөнцөр, бактер агуулагдаж байдаг тул харшил, астма үүсэх нөхцөл бүрддэг.

Иймд, дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсний дагуу гамшгийн дараах иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд эдгээр нөхцөлүүдийг анхаарч хэвийн тохиромжтой хэмжээнд байлгах шаардлагыг стандартчилж өгөх нь чухал юм.

2.2. Монгол орны нөхцөлд нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлсон байдал

Судалгааны ажлын хүрээнд иргэдийн түр хоргодох байр, түүний арга зүйн асуудал, нэр томьёо, нүүлгэн шилжүүлэх байрны өнөөгийн байдал, олон улсад тавигдах шаардлага зэрэг асуудлуудыг авч үзэж, хээрийн 2 удаагийн судалгаа хийсний үндсэн дээр гамшгийн үед иргэдийг байрлуулах орон байранд тавигдах үндсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хэрхэн авч үзэхийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд, гамшгийн үед иргэдийн аюулгүй байдлыг

хангах зорилгоор байрлуулах орон байрны үндсэн шаардлагад 1 дүгээрт: Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны нэршил ба ангиллын асуудал; 2 дугаарт: Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах гадаад хүчин зүйл; 3 дугаарт: Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах дотоод хүчин зүйл; 4 дүгээрт: Удирдлага, зохион байгуулалтын шаардлага гэсэн 4 багц асуудлыг авч үзлээ.

1. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны ангилал ба нэршлийн асуудал:

Ихэнх улс орнуудын хувьд гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр нь тухайн гамшиг тохиолдох үед нэн яаралтай тусламж үзүүлэх, удаан хугацаанд буюу хуарангийн нөхцөлд тусламж үзүүлэх гэсэн 2 хэлбэртэй байдаг хэдий ч зарим улс орны хувьд иргэдийн байрлах хугацаанаас хамаараад харилцан адилгүй ангилалд хуваадаг тухай судалгааны ажлын 1.1 дүгээр хэсэгт дурдсан. Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан байгууллага, Хүний эрхийн комиссоос гаргасан стандарт, Англи, Герман зэрэг улс орнуудын ангиллыг харьцуулж өөрийн орны нөхцөлд тохирсон ангиллын хувилбарыг дараах хүснэгтээр харуулъя.

8-р хүснэгт. Иргэдийн нүүлгэн шилжүүлэх байрны ангилал

№	Харьцуулсан байгууллага, улс	Нэршил	Ангилал
1	Сфер төсөл	1. Хоргодох байр 2. Хуаран	1. Богино хугацааны хоргодох байр 2. Төлөвлөөгүй 3. Төлөвлөсөн
2	НҮБХЭДК	1. Тараан байршуулах 2. Нийтийн хоргодох байр 3. Хуаран	1. Богино хугацаанд тараан байршуулах 2. Нийтийн хоргодох байр 3. Хуаран
3	Герман	1. Түр хоргодох байрны анхдагч бүртгэлийн төв 2. Түр хоргодох байрны хоёрдогч бүртгэлийн төв 3. Нэгдсэн төв	1. Богино хугацааны 2. Дунд хугацааны 3. Урт хугацааны
4	Англи	1. Яаралтай тусламжийн байр 2. Түр байр 3. Түр орон сууц 4. Нүүн шилжих байр 5. Байнгын орон байр	1. 1 хоног 2. 6 сар хүртэл 3. Зургаан сараас гурван жил хүртэл
5	Япон	1. Нийтийн түр хоргодох байр, 2. Нүүлгэн байршуулах байр	1. Богино хугацааны 2. Дунд ба урт хугацааны
6	Монгол	1. Хоргодох байр 2. Нүүлгэн шилжүүлэх байршил	1. Богино хугацааны 2. Дунд ба урт хугацааны

Олон улсын байгууллагаас гаргасан стандарт, зарим улс орны гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны ангилал нэршилд судалгаа хийж үзээд нэгтгэн дүгнэхэд иргэдийг амьдрах хугацаагаар нь харилцан адилгүй ангилсан байна. Манай орны хувьд гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны нэршил нь сфер төсөл болон Япон улстай, ангилал нь Япон Улстай ижил төстэй байна. Дээрх харьцуулалт болон энэхүү судалгааны ажлын 1.1.1 дүгээр зүйл дэх судалгаанд тодорхойлсоны дагуу нээд, иргэдийг гамшгийн аюулд нэрвэгдэхээс хамгаалж тухайн нутаг дэвсгэртээ түр байрлуулах орон байрыг **түр хоргодох**

байр эсвэл **олон нийтийн түр байр**; хоёрт, гамшгийн аюулын голомтоос иргэдийг нүүлгэн шилжүүлж байршуулах зорилготой нэгдсэн дэд бүтцээр хангагдсан, амьдрах орчин бүрдсэн байрыг **иргэдийг нүүлгэн байршуулах төв** эсвэл **хуаран** гэж нэрших; ангиллыг *нэгд*, **түр хоргодох байранд** байрлах хугацааг 1-7 хоног буюу **богино хугацааны**, *хоёрт*, **иргэдийг нүүлгэн байршуулах төвд** байрлах хугацааг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан 7 хоногоос 3 сар, 3 сараас дээш буюу **дунд ба урт хугацааны** гэж ангилах нь зүйтэй гэж манай орны өнөөгийн нөхцөл байдал (1.2-р хэсэг) болон олон улсын туршлагад хийсэн судалгаа (2.1-р хэсэг)-нд үндэслэн тодорхойллоо.

Гамшигт нэрвэгдэгсдийг байрлуулах орон байрны хэлбэр нь тухайн нутаг орны онцлогоос хамаараад олон төрөл байж болно. Тухайлбал, манай орны хувьд:

- Хөрш зэргэлдээ аймаг, сум дүүрэгт байрлах ах дүү, найз нөхөд эсвэл айлд байрлуулах /богино хугацаанд/;
- Буудал, байшин түрээслэх /богино хугацаанд/;
- Агуулах, сургууль, театр, цэнгэлдэх хүрээлэн зэрэг төрийн болон хувийн эзэмшлийн том барилгад байрлуулах /богино болон дунд хугацаанд/;
- Майхан, гэр, асар зэрэг оромж барьж хуаран зохион байгуулах /дунд хугацаанд/;
- Тусгай барилга, байгууламж, дэд бүтэц бүхий хороолол шинээр барьж төхөөрөмжлөх /дунд болон урт хугацаанд/ гэх мэт.

2.Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах гадаад хүчин зүйл /шаардлага/:

Гамшгийн үед иргэдийг хамгаалах нүүлгэн шилжүүлэх байрны зорилго нь хамгаалах байрны тохиромжтой шийдлийг хангах явдал юм. Түүнчлэн хамгаалагдсан, тогтвортой, аюулгүй байдал хангагдсан, хэрэглэгчийн сэтгэл ханамж (тухтай, хэрэглээнд нийцсэн) гэх мэт ерөнхий болон дараах тусгай шалгууруудыг хангасан байх шаардлагатай гэж үзэж байна. Энд, хүрээлэн буй орчны, эдийн засгийн, техникийн, нийгмийн гэсэн 4 багц хүчин зүйлийн 23 шаардлагыг тодорхойллоо. Үүнд:

1. Хүрээлэн буй орчны хүчин зүйл
 - Байршил сонголт /газар ашиглалтын эрх, гэрчилгээ, аюулгүй байдал, гамшигт өртөх байдлыг харгалзсан байх/;
 - Уур амьсгалын өөрчлөлт;
 - Цаг уурын нөлөөлөл;
 - Нөхөн сэргээх, шинэчлэх, дүйцүүлэн хамгаалах боломж;
 - Эрүүл ахуй (хөрс, ус, агаарын бохирдолгүй байх);
 - Байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдсэн гамшгийн аюул тохиолдох магадлалыг тооцох;
2. Эдийн засгийн хүчин зүйл
 - Орон байрны хэлбэр, төрөл;
 - Амьдрах хугацаа;

- Амьжиргаа /хүн амыг ажил хийх, мал аж ахуй, газар тариалан, эрхлэх боломжийг олгох, хүмүүсийн үндсэн амьжиргааг алдагдуулахгүй байх нөхцлийг бүрдүүлэх/;

3. Техникийн хүчин зүйл

- Сайн дэд бүтэц /зам, гарц, шаардлагатай бол нисэх буудал, дулаан, цахилгаан/;

- Усан хангамж;

- Бохир ус зайлуулах дэд бүтэц;

- Түр байгуулсан байр нь эргэн задлахад хялбар байх;

- Материал сонголт нь чанар, зах зээлийн үнэ, дулаан тусгаарлах чанар, хүний эрүүл мэнд байгаль орчинд ээлтэй, хоргүй байх;

- Аюулаас бүрэн тусгаарлагдсан байх;

- Иргэдийг гамшгийн өмнө амьдарч байсан төсөөтэй орон байрны хэлбэрийг сонгох;

- Сэтгэл зүйн тайван байдал аль болох хангагдахуйц байх;

4. Нийгмийн хүчин зүйл

- Соёлын ялгаа;

- Шашин шүтлэг;

- Нэр хүнд;

- Нийгмийн үнэт зүйл;

- Аюулгүй байдал;

- Холбоо харилцаа;

Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг байгуулахад эдгээр хүчин зүйлсийг харгалзан авч үзсэнээр гадаад аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдэнэ.

Гамшигт нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэхээс өмнөх түр цугларах талбай болон түр хоргодох байр нь дараах үндсэн шаардлагыг хангасан байх шаардлагатай.

1. Аюулгүй байх;

2. Тэсэрч дэлбэрэх бодисын байгууламжгүй байх;

3. Ойрхон илүү өндөр барилга байхгүй байх;

4. Түр цугларах талбайн тэмдэг тэмдэглэгээтэй байх;

5. Тухайн орчинд амьдарч буй иргэд олон нийт мэддэг байх;

6. Тухайн засаг захиргааны анхан шатны нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодорхой тусгагдсан байх;

7. Иргэд гэрээсээ түр цугларах талбай, байршил руу алхаж очих хэд хэдэн замын маршруттай байх, түүнийгээ туршсан байх, сургалт дадлага хийсэн байх зэрэг.

3. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах дотоод хүчин зүйл /шаардлага/:

Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны дотоод хүчин зүйлсийг байрны төрөл, хэлбэр, гамшигт нэрвэгдэгсэд, дотоод орчны нөхцөл, ариун цэвэр, усан хангамж, хүнс, хоол агуулах, олон нийтийн хаягийн систем, гэрэлтүүлэг, цахилгаан, зохион

байгуулалт зэрэг 11 багц хүчин зүйлийн хүрээнд харгалзан үзэх 53 шалгуурыг авч үзэхээр тодорхойллоо. Үүнд:

1. Байр: /хувь хүний тухтай байдлыг харгалзан таван хүн байхаар эсвэл 1 гэр бүлд/, Жишээ нь 85 м² талбай бүхий майхан ойролцоогоор 14-25 хүнийг агуулах багтаамжтай байдаг.
 - Нийтийн байр /сургуулийн заал, төрийн болон хувийн байгууламж/;
 - Майхан;
 - Хуаран хэлбэрээр төлөвлөсөн сууц;
 - Барилга, байгууламжийн хийц, бүтээц;
 - Амьдрах зай багтаамж;
2. Гамшигт нэрвэгдэгсэд:
 - Нэрвэгдэгсдийн нийт тоо;
 - Гэр бүлийн тоо;
 - Хүйсийн харьцаа/тоо;
 - Хүүхэд, насанд хүрэгчид, өндөр настны харьцаа/тоо;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо;
 - Шашин шүтлэгийн ялгаа/харьцаа;
 - Хувь хүний амьдрах чадвар;
3. Дотоод орчны нөхцөл /хүйтэн цаг агаартай бол зохих дулаалгатай байх, хэт халууны улиралд өрөөний хэвийн температурыг хангахуйц сэнс, сэрүүцүүлэх төхөөрөмж ашиглах 17-20 хэмд байлгах, агаарын чийг, агаарын хийн холимогийн бүрдэл хэсгийн стандарт хэмжээ, чимээ шуугиан, гэрэлтүүлгийн эрчим/.
 - Халаалт /цахилгаан халаалт, зуух, түлш/;
 - Хөргөлт;
 - Агаарын чийг;
 - Агаарын хийн холимогийн бүрдэл, агууламж;
 - Дуу чимээ;
 - Гэрэлтүүлгийн эрчим;
4. Ариун цэвэр: 20 хүнд 1 гадаа жорлон, 50 хүнд нэг шүршүүр болон бусад шаардлагатай үйлчилгээ, хангалт.
 - Жорлон;
 - Шүршүүр;
 - Угаалтуур;
 - Цэвэрлэгээ;
 - Бусад үйлчилгээ;
5. Усан хангамж: өдөрт 1 хүнд 7 литр ус, мөн гал тогоо, цэвэрлэгээ, ариун цэврийн зориулалттай ус.
 - Ундны ус;
 - Хэрэглээний ус;
 - Нөөц ус;
 - Борооны ус хуримтлуур бэлтгэх;
 - Ус хадгалах газрын аюулгүй байдал;
6. Хүнс, хоол: Ойролцоогоор 500 хүнд 100 м³. 1 хүний хоногийн хэрэгцээгээр.
7. Агуулах: 1000 хүнд 150-200 м²

- Хүнсний агуулах;
 - Бараа материалын агуулах;
 - Эм эмнэлгийн хэрэгсдлийн агуулах;
 - Химийн бодис бүхий бүтээгдэхүүний агуулах;
 - Түлшний агуулах;
8. Ахуйн хэрэгсэл:
- Хөнжил, гудас;
 - Дулаан хувцас;
 - Хоолны хэрэгсэл /аяга, таваг, халбага, сэрээ, тогоо, шанага, г.м./;
 - Ариун цэврийн хэрэглэл /оо, сойз, алчуур, саван, 00-ийн цаас, эмэгтэйчүүдийн хэрэглэл/;
 - Дэвсгэр г.м.
9. Олон нийтийн хаягийн систем: Бүх хэрэглээний байгууламжуудад стандарт хаяг байрлуулах, зай талбайн стандарт хэмжээг байримтлах;
10. Гэрэлтүүлэг, цахилгаан: гэрэл, нөөц гэрэл, механик гэрэлтүүлэг, лаа чүдэнз
- Цахилгааны эх үүсвэр;
 - Нөөц гэрэл;
 - Механик гэрэлтүүлэг;
 - Лаа, чүдэнз;
11. Зохион байгуулалтын хүчин зүйл
- Төрийн болон нийгмийн үйлчилгээ;
 - Нэрвэгдэгсэд ирэх буцах хүлээлгийн хэсгийг тусгаарлах;
 - Хүлээлгийн хэсгийн дэргэд бүртгэл, эрүүл мэндийн үзлэг хийх хэсэг байгуулах;
 - Захиргаа, үйлчилгээ, ажилтнуудын байрыг бэлдсэн байх;
 - Эрүүл мэндийн байр болон хорио цээрийн байр нь тусдаа байх;
 - Аюулгүй байдал;
 - Хашаа, хаалт, хаалгатай байх;
 - Дотоод зохион байгуулалт нь иргэдийн хөдөлгөөнийг илүү хөнгөн, саад бартаагүй, шуурхай байлгахаар ил харагдахуйц байх;
 - Бохир ус болон хатуу хог хаягдлын зохицуулалт гэх мэт.

Дотоод хүчин зүйлсэд хамаарах ихэнх шалгуурын хэмжээг нэг хүнд ногдох тоон үзүүлэлтээр гаргах, гадаад болон бусад хүчин зүйлсийг хагас тоон эсвэл чанарын үзүүлэлтээр хэм хэмжээ тогтоож стандартчилах, үндэсний стандарт болгосноор гамшигт нэрвэгдэгсдийн амьдрах орчны, хүний эрхийн баталгаа хангагдах гол үндэс болно.

4. Удирдлага, зохион байгуулалтын шаардлага

Гамшигт нэрвэгдэгсэд нь сэтгэл зүй, эрүүл мэнд, бие бялдрын хувьд эмзэг нөхцөлд байх бөгөөд энэ нь энгийн иргэдээс илүү сайн удирдлага зохион байгуулалтыг шаарддаг. Тэднийг удирдан зохион байгуулах нь олон талтай, өргөн хүрээтэй ихээхэн хүч сорьсон ажил юм. Түр байранд байрлах хүмүүстэй маш сайн харилцаа тогтоож, тэдэнд маргаашийн амьдралд итгэх итгэлийг төрүүлэхийн тулд тэдний хэрэгцээг хангахаас хавьгүй ихийг хийх хэрэгтэй. Хүмүүсийн туршлага, мэдлэгийг үнэлэн ашиглаж, тэдэнд тэгш боломж, аюулгүй нөхцөл, хамгаалагдсан орчин бүрдүүлж өгөх үүрэгтэй. Түр байрыг удирдах байгууллага, бүх үйлчилгээ иж

бүрэн байх, нэрвэгдэгсдийн бие бялдар, сэтгэл санаа, соёл, зан заншил сэтгэл зүй зэргийг иж бүрнээр нь анхаарах ёстой. Энд түр байранд үйл ажиллагаа явуулж буй бүх хамтрагчдын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Түр хоргодох байр, хуаранг удирдан зохион байгуулах асуудал нь дээрх шалгууруудыг хэрэгжүүлэх үндэс нь байх бөгөөд удирдлагын түвшинд дараах 10 үндсэн шаардлагыг чухалд авч үзлээ. Үүнд:

1. Түр байрыг удирдах байгууллага нь тэнд байрлаж буй хүмүүсийг хамгаалах, тэдэнд тусламж үйлчилгээ хүргэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна;

2. Түр байрлуулах байр байгуулах нь зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшгийн улмаас гэр орноо орхин дайжсан хүмүүсийг хамгаалан туслах хамгийн цогц арга хэмжээг зохион байгуулах;

3. Түр байрыг удирдах байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт нь олон улсын үйлчилгээний стандартыг хангаж байх;

4. Хүн бүрт тэгш хандах, үйлчилгээг жигд хүртээх үүднээс үйл ажиллагааны зохицуулалт хийх, мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх системийг хамтрагч талуудтай хамтран боловсруулсан байх;

5. Үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, удирдлагад хүмүүсийг оролцуулах, тэдний санаа бодлыг сонсох боломжийг бүрдүүлсэн байх

6. Мэдээллийг цуглуулах, шинэчлэх түгээх, ашиглах систем хэрэгжсэн байх. Хүний хувийн нууцыг хадгалах;


7. Тусгай хэрэгцээтэй болон онцгой эрсдэлд буй хүмүүсийн хэрэгцээг харгалзсан тусгай үйлчилгээ үзүүлэх;

8. Түр байранд байрлаж буй иргэд, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, салбар болон кластерийн байгууллага, засаг захиргааны байгууллага хоорондын харилцан итгэлцсэн, ил тод, бие биенээ дэмжсэн, бүгдийг оролцуулсан харилцаа хамтын ажиллагааг бий болгох;

9. Түр байрыг удирдах байгууллагын хамгийн гол зорилго нь түр байранд байрлаж буй хүмүүсийн амьдралын стандартыг сайжруулах, хүний эрхийг хамгаалах;

10. Түр байрыг удирдах байгууллага өөрийн шийдэж чадахгүй аливаа асуудлыг салбарын эсвэл кластерийн багруу зуучлан хандуулах зэрэг үүрэг хүлээнэ.

Манай орны хувьд энэхүү судалгааны хүрээнд санал болгож буй гадаад дотоод хүчин зүйл/шаардлага/, удирдлага зохион байгуулалтын шаардлага зэргийг тусгасан стандарт, заавар, журам боловсруулж батлуулах шаардлагатай байна. Олон улсын болон НҮБ-аас гаргасан стандарт, зааврыг судлан дээрх хүчин зүйлс, шаардлагуудыг тодорхойлсон бөгөөд эдгээрт үндэслэн өөрийн орны нөхцөлд тохирсон **иргэдийг нүүлгэн байршуулах төв** эсвэл **хуарангийн стандартын хувилбарыг** боловсруулж план зургаар /29 дүгээр зураг/ үзүүлэв.



29-р зураг. Иргэдийг нүүлгэн байршуулах төв /хуаран/-ийн стандартын хувилбарыг үзүүлсэн план зураг

Мөн түүнчлэн хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал юм. Олон улсын туршлагаас харахад иргэдийг нүүлгэн байршуулах төв нь хамгаалагдсан, тогтвортой, аюулгүй байх, хэрэглэгчийн сэтгэл ханамж (тухтай, хэрэглээнд нийцсэн) гэх мэт дээрх бүх шалгууруудыг хангасан байхаар стандартчилагддаг байна. Эдгээр шалгуурыг хангасан эсэх, түүний хэрэгжилтийг сайжруулахын тулд:

- Түр хоргодох байр ба төв нь шаардлага хангасан эсэхийг үнэлэх зохих аргачлалтай байх;

- Тухайн орны нөхцөлд тохирсон онцлог шалгуур, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байх;

- Амьдралын чанарыг үнэлэх аргачлалтай байх гэсэн шаардлагуудыг тавьдаг байна.

Хүний эрхийн үндсэн шаардлага бол **Хэрэглэгч-Сэтгэл ханамжтай байх** явдал юм. Иргэд, гамшигт нэрвэгдэгсэд хамгаалах байртай байх ёстой нь тэргүүн шаардлага хэдий ч тэд зөвхөн амьд үлдэх биш амьдралын нэн тэргүүний хэрэгцээгээр хангагдах эрхтэй!

ДҮГНЭЛТ

Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавих үндсэн шаардлага тодорхойлох судалгааны ажлын хүрээнд гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байр, түүний нэршил, ангилал, эрхзүйн зохицуулалт, гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны өнөөгийн байдал, олон улсын шаардлага зэргийг судалж, Монгол орны нөхцөлд иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны нэршил, ангилал, түүнд тавигдах үндсэн шаардлагын хүрээнд 1-рт: Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны нэршил ба ангиллын асуудал; 2-рт: Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах гадаад хүчин зүйл; 3-рт: Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах дотоод хүчин зүйл; 4-рт: Удирдлага, зохион байгуулалтын шаардлага гэсэн 4 багц асуудлыг тодорхойллоо. Үүнд:

1. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны нэршил, ангилал нь хууль эрх зүйн орчин, судалгааны бүтээл, олон улсын орчуулгын стандартуудад харилцан адилгүй өөр өөрөөр бичигдсэн байгааг тогтоож, үүнийг нэг мөр болгох зорилгоор нэршил болон ангиллыг хэрхэн томъёолох талаар санал дэвшүүллээ. Үүнд: ангиллыг 1-7 хоног буюу **богино хугацааны**, 7 хоногоос 3 сар, 3 сараас дээш буюу **дунд ба урт хугацааны** гэж; нэршлийг **түр хоргодох байр** эсвэл **олон нийтийн түр байр**, **иргэдийг нүүлгэн байршуулах төв** эсвэл **хуаран** гэж 2 ангилан нэрших.

2. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах гадаад хүчин зүйлийн хүрээнд хүрээлэн буй орчны, эдийн засгийн, техникийн, нийгмийн гэсэн 4 багц 23 шалгуур;

3. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх байранд тавигдах дотоод хүчин зүйлийн хүрээнд орон байрны төрөл, хэлбэр, гамшигт нэрвэгдэгсэд, дотоод орчны нөхцөл, ариун цэвэр, усан хангамж, хүнс хоол, агуулах, олон нийтийн хаягийн систем, гэрэлтүүлэг, цахилгаан, зохион байгуулалт зэрэг 11 багц 53 шалгуур;

4. Гамшгийн үед иргэдийг байрлуулах, амьдрах орчин нөхцлийг хангах удирдлага, зохион байгуулалтын 10 үндсэн шаардлагыг тус тус тодорхойллоо.

5. Олон улсын болон НҮБ-аас гаргасан стандарт, зааврыг судлан тодорхойлсон хүчин зүйлс, шаардлагуудыг үндэслэн өөрийн орны нөхцөлд тохирсон иргэдийг нүүлгэн байршуулах төв /хуаран/-ийн стандартын хувилбарыг боловсруулж план зургаар үзүүлсэн.

ЗӨВЛӨМЖ

1. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг нэгд, иргэдийг гамшгийн аюулд нэрвэгдэхээс хамгаалж тухайн нутаг дэвсгэртээ түр байрлуулах орон байрыг **түр хоргодох байр** эсвэл **олон нийтийн түр байр**; хоёрт, гамшгийн аюулын голомтоос иргэдийг нүүлгэн шилжүүлж байршуулах зорилготой нэгдсэн дэд бүтцээр хангагдсан, амьдрах орчин бүрдсэн байрыг **иргэдийг нүүлгэн байршуулах төв** эсвэл **хуаран** гэж нэрших;

2. Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрыг нэгд, **түр хоргодох байранд** байрлах хугацааг 1-7 хоног буюу **богино хугацааны**, хоёрт, **иргэдийг нүүлгэн байршуулах төвд** байрлах хугацааг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан 7 хоногоос 3 сар, 3 сараас дээш буюу **дунд ба урт хугацааны** гэж ангилах;

3. Гамшигт нэрвэгдэгсдийг байрлуулах орон байранд тавигдах шаардлагыг удирдлага, зохион байгуулалтын, гадаад хүчин зүйлийн, дотоод хүчин зүйлийн хүрээнд хүрээлэн буй орчны, эдийн засгийн, техникийн, нийгмийн, орон байрны төрөл, хэлбэр, гамшигт нэрвэгдэгсэд, дотоод орчны нөхцөл, ариун цэвэр, усан хангамж, хүнс хоол, агуулах, олон нийтийн хаягийн систем, гэрэлтүүлэг, цахилгаан, зохион байгуулалт зэрэг 25 багц 86 шалгуурыг тусгаж Монгол орны онцлогт тохирсон стандарт, заавар, дүрэм боловсруулж батлуулах;

4. Олон улсын судалгаагаар ихэнх улс орнууд түр цугларах аюулгүйн байршлыг 1-3 хоног байлгах байраар төлөвлөсөн байдаг нь иргэдийн оршин байгаа газарт хамгийн ойр, аюул багатайгаар өөрсдөө хүрэлцэн ирэх боломжтой, засгийн газрын зүгээс зөв шийдвэр гаргах тодорхой хугацаа гаргах боломж олгодог, эдийн засгийн хувьд хямд төсөр байх зэрэг олон ач холбогдолтой гэж үздэг байна. Иймээс эхний энэ байршилд түр хоргодох байрыг байгуулах нь манай улсын хувьд тохиромжтой бөгөөд энд цөөн хүний асуудлыг хороодын төлөвлөгөөнд тусгаж шийдэх учир үр дүн сайтай, үйлчилгээ хүртээмжтэй байх боломжтой;

5. Гамшгийн мэдээллийн сангаас шүүлт хийхэд нүүлгэн шилжүүлэлт хийсэн тухай мэдээлэл байгаа боловч хохирол хэрэгцээний үнэлгээнд суурилсан түр хоргодох байр, түүний нөхцөл байдал, хангалтын талаарх мэдээлэл огт байхгүй байгаа нь мэдээллийн санд хохирол хэрэгцээний үнэлгээнд үндэслэн гаргасан шийдвэр/орон байр, хангалт/-ийг тусгасан асуулгыг оруулж өгөх;

6. Бодит гамшиг нүүрлэсэн тохиолдолд иргэд шинэ суурьшлын бүс үүсгэж, төлөвлөлтгүй хот суурин байгуулагдах, агаар орчны бохирдол ихэсдэг зэрэг хүндрэл тулгардаг тул аль болох хотын ойрхон боломжтой зай талбайд иргэдийг түр байрлуулах, аль болох түргэн хугацаанд өмнөх хэвийн амьдралдаа шилжих боломжийг бүрдүүлэх;

7. Богино хугацааны түр хоргодох байрыг хөрш зэргэлдээ аймаг, сум, дүүргийн айл өрх, хамаатан, ах дүү, найз нөхдийн гэрт байхаар зохион байгуулах, туслан дэмжиж байгаа айл өрхөд урамшууллын тогтолцоог бий болгох;


8. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны асуудлыг шаардлага тус бүрээр тодорхой тусгаж өгөх, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулалтын үеэр турших;

9. Цаашид гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх байрны удирдлага, зохион байгуулалт, харилцаа холбоо, зарлан мэдээлэл, сургалт бэлэн байдлын чиглэлээр судалгаа хийх.


АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ, МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”
- Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт **Мэргэжлийн ангийн дүрэм**
- Улаанбаатар хотын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, 2017.
- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн “Болзошгүй гамшгийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Сүхбаатар дүүргийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, 2019.
- MNS 5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа
- MNS 5682:20096 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага
- ҮХАА-н сайдын 2013 оны А/162 тоот тушаал
- Цэргийн нэр томъёоны тайлбар толь
- Монгол хэлний их тайлбар толь,
- Википедиа
- MNS 5775:2014 хот, суурины ундны ус түгээх цэг (байр)-ийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага
- MNS 6430:2014 интэрнэт кафе, цахим тоглоомын үйлчилгээний байранд тавих шаардлага
- MNS 5095:2017 нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа
- MNS 5924 : 2015 нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага.
- MNS 5408:2004 Барилгын бараа, бүтээгдэхүүний худалдаа - үйлчилгээ ерөнхий шаардлага
- Abdulrahman Bashawria*, Stephen Garrityaand Krisen Moodleya, AN OVERVIEW OF THE DESIGN OF DISASTER RELIEF SHELTERS, Elsevier, Procedia Economics and Finance 18 (2014) 924 – 931
- <http://cms.city.miyakonojo.miyazaki.jp>
- [Law of the People's Republic of China on Protecting Against and Mitigating Earthquake Disasters](#)
- [Emergency Response Law of the People's Republic of China](#)
- Sonia Molina Metsger, Guidelines on Emergency Sheltering for Refugees in Germany, 2014.
- Б.Хишигбаатар, Газар хөдлөлтийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх байршлыг сайжруулах арга зам, магистрын дипломын ажил. 2016 он.
- Vincent Virgo, Winter criteria, Shelter Research Unit an initiative of the Benlux Red Cross Societies, 2015

- WHO-Environmental health in Emergencies and disasters: a practical guide, chap6: Shelter and emergency settlements p.87.
- Дамдин.П, Монгол Улсын иргэний хамгаалалтын түүхэн замнал, УБ, 2017
- Доржсүрэн.Б, Иргэний хамгаалалт, ажилчин албан хаагчид, малчид, тариаланчдыг иргэний хамгаалалтын талаар сургаж бэлтгэх программ, УБ, 1986
- UNHCR, Онцгой байдлын үеийн гарын авлага., Гурав дахь хэвлэл, 2007 он,
- Сэржмядаг.Д, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, 2017
- Чимэдцэрэн.П, Нарантуяа.Д, Гамшиг судлал инновац, онол арга зүйн сэтгүүл, ОБЕГ-ын Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, 2019 №2
- Жаргалсайхан.Я, Хүн амын нүүлгэн жилжүүлэлт түүнийг боловсронгуй болгох арга зам., докторын зэрэг горилсон диссертац, 2018 он,
- Cecilia Shmolzer, Introduction Test Methodology of shelter, Shelter Reserch Unit, IFRC, Conference on winterization, Luxemburg, 2015.
- Pusceddu Cristina, at.all., Lightweight insulation system for Emergency Shelter, Department of architecture, built environmental and construction engineering.
- Daniel Ledesma, Practical application of the winter criteria in extreme winter conditions, IFRC-SRU Conference, Luxemburg, 2015
- Daniel Ledesma, Emergency Shelter winter conditions, IFRC-SRU Conference, Luxemburg, 2015
- IFRC, Shelter Research Unit, Lifeshelter Evaluation Study, Conference on Winterization, 2015
- Winterization of collective centers for supporting IDPs, Ukraine, 2014-2015
- Daan Van Kinderen, Ferry Klos, Sheltering New sustainable shelter solutions for disaster relief, 2015
- ISO 7730 / Ergonomics of the thermal environment – Analytical determination and interpretation of thermal comfort using calculation of the PMV and PPD indices and local thermal comfort criteria (table p.17)
- Minimum Standards in Shelter, settlement and Non Food Items, 2005
- Мигаль.Г.В., Инструкция по действиям при возникновении чрезвычайных ситуации.









НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Болзошгүй гамшгийн үед түр цугларах,
нүүлгэн шилжүүлэх газрын байршил,
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008 оны 2/14 дүгээр тогтоол, Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн 2016 оны 04 сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт болзошгүй гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх байршлыг 1 дүгээр хавсралтаар, түр цугларах талбайг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Нийслэл хотын нутаг дэвсгэрт болзошгүй гамшгийн үед цугларах, нүүлгэн шилжүүлэх байршилд барилга байгууламж барихыг хориглож, тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Б.Энхболд/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТТУЛГА



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 05 дугаар
сарын 16-ны өдрийн 94 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БОЛЗОШГҮЙ ГАМШИГ ТОХИОЛДСОН ҮЕД
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ**

Нийслэл Улаанбаатар хотын гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нүүлгэн шилжүүлэх талбайг 31 байршилд судалгаа гарган талбайн хэмжээ, эзэмших, ашиглах зориулалтыг нарийвчлан тогтоов.

Баянгол дүүрэг:

1.СХД 1-р хороо Баянголын аман дахь Гольфийн талбай 40 га /хотын төвөөс 22 км зайд орших, цахилгааны шугамтай, худаг гаргах боломжтой, Заг ХХК спорт амралтын цогцолборын зориулалтаар эзэмшдэг/

2.СХД 24-р хороо Толгойтын баруун салаанд 18 га /хотын төвөөс 14 км зайд, худаг ба цахилгааны шугам ойр, Амьд байгаль ТББ эзэмшдэг/

3.БГД 20-р хороо Хорих 461 дүгээр ангийн урд талд Мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэн 50 га /хотын төвөөс 10 км зайд орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй, Баянгол агропарк ОНӨААТҮГ эзэмшдэг/

Баянзүрх дүүрэг:

4. БЗД 20-р хороо Баяндөхөмийн аманд 40 га /хотын төвөөс 20 км зайд орших, өндөр хүчдэлийн цахилгааны шугамтай, усны эх үүсвэр байхгүй, худаг гаргах боломжтой/

5. БЗД 20-р хороо Хар усан тохойд 18 га /хотын төвөөс 16 км зайд орших, цахилгааны шугамтай, худаг гаргах боломжтой/

6. БЗД 20-р хороо Монгол шилтгээн амралтын газар 12 га /хотын төвөөс 18 км зайд орших, цахилгааны шугамтай, усны эх үүсвэртэй, амралтын газар үйл ажиллагаа явуулж буй/

7. БЗД 28-р хороо Улиастайн аманд 19 га /хотын төвөөс 14 км зайд орших, өндөр хүчдэлийн цахилгааны шугамтай, усны эх үүсвэртэй, БХЯ-ы тусгай хэрэгцээний газарт хамаарна/ газарт тус тус байршуулахаар төлөвлөсөн.

Сонгино хайрхан дүүрэг:

8. СХД 21-р хороо Төмөр замын 361-н гарамын орчим 87 га /хотын төвөөс 33 км зайд орших, цахилгааны шугамтай ойр, худаг гаргах боломжтой/

9. СХД 21-р хороо Монгол наадам цогцолборын талбай 120 га /хотын төвөөс 35 км зайд орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй, Монгол наадам цогцолбор ОНӨААТҮГ эзэмшдэг/

Сүхбаатар дүүрэг:

10. СБД 20-р хороо Бэлхэд 8 га /хотын төвөөс 12 км зайд орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй, Шаб ХХК-ийн хашаанд/

11. СБД 18-р хороо Мод үржүүлгийн талбай 54 га /хотын төвөөс 10 км зайд орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй, Байгаль ой, усны нөөцийн газар, Ой, усны хайгуул, судалгааны төвийн судалгаа шинжилгээ, туршилтын талбай/

12. СБД 19-р хороо Хандгайтын зуслан дахь Дугуйн талбай 5 га /хотын төвөөс 24 км зайд орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй/

13. СБД 19-р хороо Хандгайтын зусланд Янзага хүүхдийн зуслан 19 га /хотын төвөөс 23 км зайд орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй/

14. СБД 15-р хороо Ар хустайн зусланд Оюунтүлхүүр сан, БХХҮХолбооны хашаа, түүний орчмын талбай 8 га /хотын төвөөс 11 км зайд орших, цахилгааны шугамтай ойр, худаг гаргах боломжтой/

Хан-уул дүүрэг:

15.ХУД 13-р хороо Өлзийт хорооллын урд Гавьжийн шандын 73 га /хотын төвөөс 26 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой, худаг гаргах боломжтой/

16. ХУД 8-р хороо Нүхтийн аманд 15 га /хотын төвөөс 12 км зайд орших, цахилгааны шугамтай, худаг гаргах боломжтой

Чингэлтэй дүүрэг:

Тус дүүрэг 39785 өрхийн 159514 хүн амьдарч байгаагийн 8117 өрхийн 33367 хүн ам нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна. Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт:

17. ЧД19-р хороо Өвөр гүнтийн зусланд 15.3 га, СХД 21-р хороо Ар гүнтийн зусланд 10 га /хотын төвөөс 23 км зайд орших ба худаг гаргах боломжтой, цахилгааны шугамтай ойр/

18.ЧД 17-р хороо Тахилт-3-ын аманд 20 га /хотын төвөөс 10 км зайд, худаг ба цахилгаан ойр/

19. ЧД 19-р хороо Ойн булаг зусланд 4.5 га /хотын төвөөс 26 км зайд орших ба худаг, цахилгааны шугамтай ойр амралтын газар үйл ажиллагаа явуулдаг/

Багануур дүүрэг:

20. БНД-ийн 1-р хороо,Нарийний ам 10 га /БНД-ээс 4 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой, худаг гаргах боломжтой/

21. БНД-ийн 5-р хороо,Нарийн нуур 10 га /БНД-ээс 2.5 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой, худагтай/

22. БНД-ийн 5-р хороо,Талийн толгой 10 га /БНД-ээс 2.5 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой, худагтай/

Багахангай дүүрэг:

23. БХД-ийн 1-р хороо Алтаргана гэр хорооллын баруун “Гөлтгөнө” уулийн энгэрт 2 га /БХД-ээс 2 км зайд орших, худаг, цахилгааны шугамтай/

24. БХД-ийн 1-р хороо Хангамжийн урд уул Өндөр толгойн энгэрт 2 га /БХД-ээс 1 км зайд орших, худаг, цахилгааны шугамтай/

25. БХД-ийн 1-р хороо Аэродромын талбай 502 га /БХД-ээс 2 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой, худагтай/

26.БХД-ийн 1-р хороо Нуурын гэр хорооллийн урд талбай 2 га /БХД-ээс 2 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой, худагтай/

Налайх дүүрэг:

27. БЗД-ийн Мянганы замын баруун дэнж 11-р хороо 7 га /Налайх дүүргээс 6 км зайд орших, цахилгааны шугам татах,худаг гаргах боломжтой/. Хилийн цэсээр БЗД-т

28. НД-ийн Бүс нуур 4-р хороо 20 га /Налайх дүүргээс 7 км зайд орших, цахилгааны шугам татах,худаг гаргах боломжтой./

29. НД-ийн Өвөр шандын урд талбай 7-р хороо 20 га /Налайх дүүргээс 3 км зайд орших, цахилгааны шугам татах,худаг гаргах боломжтой./

30. НД-ийн Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нэрэмжит “Бадрал” цэцэрлэгт хүрээлэн 5-р хороо 26.3 га /Налайх дүүргээс 6 км зайд орших, цахилгааны шугам татах,худаг гаргах боломжтой./

31. НД-ийн 5-р хороо, Городок тосгоны баруун урд талд 50 га газарт байршуулахаар тус тус төлөвлөсөн.

ГАМШГИЙН ҮЕД БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙГ
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ



ГАМШГИЙН ҮЕД БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙГ
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ



ГАМШГИЙН ҮЕД НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙГ
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ



Чингэлтэй дүүрэг:

Тус дүүрэг 37914 өрхийн 153933 мянган хүн амьдарч байгаагийн 6898 өрхийн хүн ам нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна. Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт:

- Зуслангийн чиглэлд Ар гүнтийн зусланд 40 га, худаг гаргах боломжтой, цахилгааны шугамтай ойр
- Чингэлтэй дүүргийн 17-р хороо Зүрх ууланд 30 га, худаг ба цахилгаан ойр

**Таних тэмдэг**

-  Гол зам
-  Туслах зам
-  Дүүргийн хил

д/д	Байршил	Хороо	Байршуулах хүн амийн тоо	Талбайн хэмжээ /га/	Хүртэлх зай /км/
1.	Ар гүнт	19	100.000	15.3	23
2.	Ойн булаг	19	85.514	4.5	26
3.	Тахилт 3-ын ам	19	80.000	20.0	10

Ар гүнтэд байрлах нүүлгэн шилжүүлэх талбай



Зүрх ууланд байрлах нүүлгэн шилжүүлэх талбай



Сүхбаатар дүүрэг:

Тус дүүрэг 36018 өрхийн 132117 мянган хүн амьдарч байгаагийн 14508 өрхийн 59900 хүн амь нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна.

Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт:

- СБД-ийн 18-р хороо Зуслангийн чиглэлд Бэлхэд 82 га,
- 16-р хороо Дамбадаржаад байрлах Ойн газрын талбай 60 га,
- 19-р хороо Хандгайтад байрлах Хасу Холдингийн талбай 50 га,
- Хандгайтад байрлах Янзага зуслан 50 га,
- Архустайд байрлах Оюунтүлхүүр сангийн талбай 10 га-д тус тус орших, цахилгааны шугам болон усны эх үүсвэртэй




№	Байршил	Хороо	Байршуулах хүн амийн тоо	Талбайн хэмжээ /га/	Хүртэлх зай /км/
1	Бэлхэд байрлах Шаб ХХК-ны Бэлх захын урд талын талбай	18	23.428	8,0	12
2	Дамбадаржаад байрлах Ойн газрын талбай	16	16.857	54,0	10
3	Хандгайтад байрлах Хасу холдинг ХХК-ны дугуйн замын талбай	19	14.000	5,0	24
4	Хандгайтад байрлах Янзага хүүхдийн зуслан	19	20.000	12.0	23
5	Архустайд байрлах Оюунтүлхүүр сан, БХХҮХолбооны хашаа болон тэр орчим	15	28.571	8.0	11

**1. Янзага зуслан, Хасу холдинг ХХК-ний талбайд байрлах нүүлгэн
шилжүүлэх талбай**



2. Янзага зуслан, Хасу холдинг ХХК-ний талбайд байрлах нүүлгэн шилжүүлэх талбай



Баянгол дүүрэг:

Тус дүүрэг 49683 өрхийн 192615 мянган хүн амьдарч байгаагийн 27867 өрхийн 125260 хүн амь нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна.

Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт нүүлгэн шилжүүлэх газар байхгүй тул

- СХД 24-р хороо Толгойтын баруун салаа Булагтайд 90 га,
- СХД 18-р хороо Баянголын ам “Заг” ХХК-ны гольфын талбай 40 га,
- БГД 20-р хороо Мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэн 60 га, худаг ба цахилгаан ойр байршуулна.



д/д	Байршил	Хороо	Байршуулах хүн амын тоо	Талбайн хэмжээ /га/	Хүртэлх зай /км/
1.	Баянголын ам	1	11.426	40.0	22
2.	Толгойтын баруун салаа Булагтайн ам	СХД 24	85.571	18.0	14
3.	Мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэн	20	16.570	50.0	10

1. Баянголын аманд байрлах нүүлгэн шилжүүлэх талбай



2. Толгойтын баруун салаанд байрлах нүүлгэн шилжүүлэх талбай



Сонгинохайрхан дүүрэг:

Тус дүүрэг 65423 өрхийн 261917 мянган хүн амьдарч байгаагийн 14762 өрхийн 60095 хүн амь нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна.

Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт:

- СХД 22-р хороо Төмөр замын 361 гарамын орчимд 120 га,
- Монгол наадам цогцолбор 100 га д байрлалтай, /цахилгааны шугамтай болон худаг гаргах боломжтой/



д/д	Байршил	Хороо	Байршуулах хүн амийн тоо	Талбайн хэмжээ /га/	Хүртэлх зай /км/
1.	Төмөр замын 361 гарам	21	28.750	87.0	33
2.	Монгол наадам цогцолбор	21	100.000	120.0	35
3.	Ар гүнт	19	15.000	15.4	23

Хан-уул дүүрэг:

Тус дүүрэг 33982 өрхийн 127477 мянган хүн амьдарч байгаагийн 8575 өрхийн 17323 хүн амь нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна. Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт:

- ХУД 13-р хороо Гавьжийн шандын баруун аманд 70 га, хотын төвөөс 30,7 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой болон худагтай/
- ХУД 4-р хороо Нүхтийн аманд 70 га, хотын төвөөс 30,7 км зайд орших, цахилгааны шугам татах боломжтой болон худагтай



д/д	Байршил	Хороо	Байршуулах хүн амийн тоо	Талбайн хэмжээ /га/	Хүртэлх зай /км/
1.	Гавьжийн шанд	13	200.000	73.0	26
2.	Нүхтийн аманд	8	114.285	15.0	12

Баянзүрх дүүрэг:

Тус дүүрэг 76126 өрхийн 294908 мянган хүн амьдарч байгаагийн 18677 өрхийн 76054 хүн амь нь төвийн халаалт бүхий орон сууцанд амьдарч байна. Болзошгүй аюул гамшиг тохиолдсон үед иргэдийг төлөвлөлтөөр тус дүүргийн нутаг дэвсгэрт:

- БЗД 20-р хороо Баяндөхөмийн ам 40 га, хотын төвөөс 30 км, Монгол шилтгээн 15 га, хотын төвөөс 25 км,
- 28-р хороо Баянбулаг 60 га, хотын төвөөс 25 км, 20 зайд орших, өндөр хүчдэлийн цахилгааны шугамтай болон усны эх үүсвэр байхгүй, худаг гаргах боломжтой



1. **Баянбулгийн аманд байрлах нүүлгэн шилжүүлэх байршил**



2. **Баяндөхөмийн аманд байрлах нүүлгэн шилжүүлэх байршил**





ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2012 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 73

Дархан

ТҮР НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, 26.1.4, 26.1.5, 26.1.7, 26.1.9, 26.1.10, 26.1.11, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 2.2, 4.2, 4.3-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1.Тус сумын 12 дугаар багийн нутаг дэвсгэрт 14 дүгээр байрны 26 тоотод 2012 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 21:20 минутын үед хийн түлшний баллон дэлбэрсэний улмаас 1 дүгээр орцны зарим хэсгийн барилгын үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт орсон тул тухайн орцны иргэдийг "Оюуны ирээдүй цогцолбор" сургуулийн дотуур байранд түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэх ажиллагааг цаг алдалгүй зохион байгуулсугай.

2.Нүүлгэн шилжүүлэх, учирсан хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, машин механизм, багаж хэрэгслээр хангаж ажиллахыг сумын Онцгой байдлын орон тооны бус штабын дарга /Б.Азжаргал/, Хүн эмнэлгийг хариуцсан туслах /М.Эрдэнэбилэг/, Материал техник хангамж хариуцсан туслах /С.Болд/, Хэргийн газрыг хамгаалалтанд авч хэв журам сахиулах ажлыг Цагдаагийн газрын хэв журмын тасаг /н.Хурц/ нарт үүрэг болгосугай.

3.Шаардагдах зардал, хөрөнгийн тооцоог гаргаж аймгийн Онцгой комиссын дарга /Г.Эрдэнэбат/-д танилцуулж ажиллахыг сумын Хангалт хариуцсан туслах /М.Тайванбаатар/-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, сумын Онцгой байдлын орон тооны бус штабын дарга /Б.Азжаргал/-д даалгасугай.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.ЦЭНДСҮРЭН



50068374

**ДАРХАН СУМЫН 12-Р БАГИЙН 14-Р БАЙРНЫ 1 ОРЦНЫ АЙЛ ӨРХИЙГ
ТҮР НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН.**

2012.01.22

Дархан

Дархан сумын Засаг даргын 2012 оны 01 дүгээр сарын 22 өдрийн 73 захирамжын дагуу иргэдийг түр нүүлгэн шилжүүлэх Дархан сумын онцгой байдлын орон тооны бус штаб дараах ажил үүргийг гүйцэтгэлээ. Дархан сумын 18 багийн Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, олон нийтийн байцаагч нийт 67 албан хаагчыг 2012 оны 01 сарын 22-ны 19 цаг 10 минутанд цуглуулж,

1-р ажлын хэсэг: 14-р байрны иргэдийг бүртгэх, нүүлгэн шилжүүлэх ажилд

- > Ч. Цэрэннадмид – 7 багийн Засаг дарга
- > Б. Бадамханд – 2-р багийн Засаг дарга
- > Б. Нарантуяа – 12-р багийн зохион байгуулагч
- > Д. Баярхүү – 10-р багийн нийгмийн ажилтан
- > Л. Энхбаяр – 12-р багийн нийгмийн ажилтан
- > Н. Цахирмаа – 15 багийн нийгмийн ажилтан

2-р ажлын хэсэг: ОИЦогцолбор дээр иргэдийг хүлээн авч бүртгэх ажилд

- > Л. Төрмандах – 14 багийн нийгмийн ажилтан
- > О. Пүрэв – 9 багийн Засаг дарга
- > Э. Цогзолмаа – 14 багийн зохион байгуулагч
- > З. Нармандах – 9 багийн зохион байгуулагч
- > Д. Одбаяр – 10-р багийн зохион байгуулагч
- > Т. Яламсүрэн – 11 багийн Засаг дарга
- > В. Баяндорж – 11 багийн нийгмийн ажилтан тус тус ажиллаа.

Бүртгэн нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа 2012 оны 1 дүгээр сарын 22-ны 19 цаг 10 минутанд эхэлж 22 цаг 54 минутанд дууссан.

. 14 байрны өрхүүдийг бүртгэж нүүлгэн шилжүүлсэн бүртгэл

№	Давхар	Хаалганы дугаар	Өрхийн тоо	Ам бүл	Тайлбар
1	1 дүгээр давхар	1.2.3 тоот аж ахуйн нэгж 4 тоот айл	1	4	
2	2 дугаар давхар	5.6.7.8 тоот	4	17	5.6 тоот эзэнгүй байсан утсаар ярьж мэдээлэ авсан.
3	3 дугаар давхар	9.10.11.12 тоот	3	12	9.10 тоот нэг айл
4	4 дүгээр давхар	13.14.15.16 тоот	4	10	13.15 тоот айл эзэнгүй байсан утсаар ярьж мэдээлэл авсан.
5	5 дугаар давхар	17.18.19.20 тоот	4	20	
6	6 дугаар давхар	21.22.23.24	4	10	23 тоот эзэнгүй байсан утсаар ярьж мэдээлэл авсан.
7	7 дугаар давхар	25.26.27.28 тоот	4	14	25.26 тоот онц байдал тогтоож нүүлгэсэн байсан.
8	8 дугаар давхар	29.30.31.32 тоот	4	15	
9	9 дүгээр давхар	33.34.35.36 тоот	4	11	
	Дүн		32	113	

Бүгд 32 өрхийн 113 хүнийг бүртгэж нүүлгэсэн ба эзэнгүй болон онц байдал тогтоож түр нүүлгэн шилжүүлсэн өрхийн мэдээллийг утсаар авч дүнд оруулсан.

5 дугаар давхарын 17.20 тоот эд хөрөнгөө зөөвөрлөн авч явсан.

Бүртгэл хийж түр нүүлгэн шилжүүлэх хугацаанд цагдаагийн газрын 2 микро автобус үйлчилсэн. Хэлтэс агентлагын холбогдох мэргэжилтэнүүд байсан.

Энэ хугацаанд гарсан зөрчилгүй, 1 давхрын 4 тоот, 2 давхрын 7 тоот өрхүүд гарахгүй гэснийг, нөхцөл байдлыг тайлбарлаж ойлгуулсны үндсэн дээр гүүсэн болно.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ШТАБЫН ДАРГЫН ТУСЛАХ



С. СОЁЛОО

БАТЛАВ.
 ДАРХАН СУМЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН
 ТОСНЫ БУС ШТАБЫН ДАРГА Б. АЗЖАРГАЛ



ДАРХАН СУМЫН 12-Р БАГИЙН 14-Р БАЙРНЫ АЙЛ ӨРХҮҮДИЙГ
 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2012.01.22

Дархан

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Хугацаа	Ажлыг гүйцэтгэх байгууллага.
1	Нүүлгэн шилжүүлэх тээврийн хэрэгсэл	Б. Амархүү	2012.01.22	Замын 1-р анги, ШШГГ 330-р анги,
2	Нүүлгэн шилжүүлэлт хийгдэх өрх, хүн амын тоо гаргах	Ж. Отгончимэг	2012.01.22	12-р багийн удирдлага
3	Байрлал, байр бэлдэх	О. Пүрэв	2012.01.22	ОИЦогцолбор
4	Ажлын зураг	С. Соёлоо	2012.01.22	Дархан сум ЗДТГ
5	Ажиллагсч	Ч. Цэрэннадмид, Б. Бадамханд, Баярхүү	2012.01.22	Дархан сум ЗДТГ
6	Харуул хамгаалалт	Э. Золбаяа	2012.01.22	Цагдаагийн газар
7	Зарцуулах төсөө	Ч. Тайванбаатар	2012.01.22	Дархан сум ЗДТГ

Төлөвлөгөө Боловсруулсан:
 Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын туслах:



С. Соёлоо

ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНД ЗОРИУЛСАН ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭГ БИЙ БОЛГОХ НЬ

А.Ариунбилэг¹, Д.Балжинням²

¹ГСХ-ийн Секторын эрхлэгч, докторант, хошууч

²ГСХ-ийн Галын инженер-судлаач, магистрант, дэслэгч

Оршил

Монгол Улсад дэд бүтэц, барилгын салбар жил ирэх тусам хөгжин дэвжиж, барилга угсралтын ажил, ашиглалтад оруулсан барилга байгууламжийн тоо урд жилийнхээс өсөн нэмэгдэж байна. Улсын хэмжээнд 2008 онд 5416 айлын орон сууц, 246 ортой эмнэлэг, 7894 суудалтай сургууль, соёлын барилга баригдан ашиглалтад орж байсан бол 10 жилийн дараа буюу 2018 онд 12824 айлын орон сууц, 616 ортой эмнэлэг, 14160 суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад орж өссөн байна. Нийт ашиглалтад орсон барилга байгууламжийн 90 орчим хувь Улаанбаатар хотод баригдсан нь Монгол Улсын нийт хүн амын 45.3 хувь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотдоо амьдарч байгаатай холбоотой юм.

Мөн хүн амын өсөлтийг дагаад Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо эрс өссөн байна. Судалгаагаар нийслэлд бүртгэлтэй автомашин 2012 онд 228952 байсан бол 2018 онд 501925 буюу 2 дахин өсч, нийт улсын хэмжээний автомашины тооны 57,6% хувийг эзэлж байна⁴². Төвлөрлөөс үүдэлтэй агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл үүсэх, дэд бүтцийн ачаалал ихсэх, нийгмийн үйлчилгээний хүчин чадал зэрэг асуудлууд зохист хэмжээнээс 2-3 дахин хэтэрсэн байна.⁴³

Үүнээс харахад Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлын нэг нь хот төлөвлөлт юм. Сүүлийн жилүүдэд төлөвлөлтийн бодлого алдагдан төвлөрлийг саармагжуулалгүй хотын төвийн хэсэг рүү хэт их шахсанаас барилгын болон галын тухай хууль, норм дүрэм, стандартын дагуу эсэх нь эргэлзээтэй, гамшгийн үед тэр дундаа гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нэвтрэх боломжгүй, эргэлт хийх зай талбай хязгаарлагдмал, аврах ажиллагаа явуулах боломжгүй олон арван барилга байгууламж баригдсан байна. Эдгээр барилга байгууламжуудаас орон сууцны барилга нь хүн амын нягтрал их, галын бага хэмжээний эх үүсвэрээс их хэмжээний хохирол үүсэх, улмаар хорт хий, утааны ялгарлаас олон хүний амь нас осолдох эрсдэлтэй объект юм. Жишээлбэл: Орон сууцны барилгын 15-20м² талбай бүхий байранд гарсан галаас үүссэн халууны хэмжээ 5 минутын дараа сууц хоорондын гудамд 280-300С°, шатны хонгилд 120-140С°, гал гарсан давхрын дээд талын давхрын шатны хонгилд 100-150С° хүртэл халсан байна. Галын утаа гал гарснаас хойш 5-6 минутад бүх давхрын шатны хонгилоор тархаж тусгай баггүйгээр хүн амьсгалах аргагүй болно⁴⁴.

Гамшгийн эрсдэлийн менежментэд газар ашиглалт, хот төлөвлөлт, барилгын норм, дүрэм, хүрээлэн буй орчин, нөөцийн менежмент, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг ягштал баримтлах шаардлагатай байдаг. Шинэ барилга

⁴²Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://www.1212.mn>

⁴³ “Хөгжлийн алтан гурвалжин бодлого” бодлогын баримт бичиг НЗДТГ

⁴⁴Гал унтраах арга зүй. Т.Лхамжав, Улаанбаатар, 1991 он

байгууламжийн орчны газар, дэд бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ эрсдэлийг тооцох, баригдсан барилга, байгууламжийн болзошгүй аюулыг тэсвэрлэх чадавхыг үнэлэх, аюулаас сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна⁴⁵.

Иймд орон сууцны хороолол, хотхон нь гал түймэр гарсан тохиолдолд эрсдэл өндөртэй объект болоод байна.

Эдгээр асуудлуудаас харахад Улаанбаатар хотын зарим орон сууцны хороолол, хотхоны барилгууд нь барилгын норм дүрэмд заасан хэмжээний дагуу ногоон байгууламж, тоглоомын талбай, автомашины зогсоол төлөвлөгдөөгүйгээс оршин суугчдын эрүүл орчинд тав тухтай амьдрах эрх алдагдаж, ямар нэгэн осол, гал түймэр тохиолдоход аврах тусгай зориулалтын автомашин орох боломжгүй байгаа нь иргэдийн амь насанд шууд заналхийлж байна. Иймд орон сууцны хороолол, хотхоны гал түймрийг унтраах, аврах ажиллагааны шуурхай байдлыг хангахад тулгамдаж буй асуудал болох галын тусгай зориулалтын автомашиныг ажиллах зам талбай, гарцын өнөөгийн байдлыг судлан, шийдвэрлэх зарим арга замыг тодорхойлох шаардлагыг үндэслэн энэхүү судалгааг хийв.

Судалгааны ажлын зорилго

Орон сууцны хороолол, хотхонд гал түймрийг унтраах, аврах ажиллагааны шуурхай байдлыг хангахад тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг бий болгох арга замыг тодорхойлно.

Судалгааны ажлын зорилт

Судалгааны ажлын зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Барилга байгууламжийн норм, дүрэм, стандартын өнөөгийн байдлыг судлах;
2. Орон сууцны хорооллын гал түймрийг унтраах тусгай зориулалтын автомашиныг ажиллуулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах;
3. Тусгай зориулалтын автомашинд зориулсан зам, талбайн тэмдэг тэмдэглэгээний стандартын талаарх зарим улс орны туршлагыг судлах;
4. Орон сууцны хорооллын зам талбайд тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэг тэмдэглэгээг нэвтрүүлэх арга замыг тодорхойлох зэрэг болно.

Судлагдсан байдал

Монгол улсад барилга, байгууламжийн гал түймрийн хийц бүтээц болон унтраах арга зүй талаас нь судалсан ном, бүтээлүүд байдаг боловч галын зориулалтын автомашины тэмдэг тэмдэглэгээтэй талаар хийгдсэн судалгааны ажил одоогоор байхгүй байна.

Судалгаанд ашигласан арга

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх харьцуулах зэрэг шинжлэх ухааны ерөнхий аргуудыг ашиглав.

⁴⁵Хотуудын гамшиг тэсвэрлэх чадавхыг үнэлэх онооны арга. НҮБ-ын Гамшигийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн газар, 2017 он

Шинэлэг тал

Энэхүү судалгааны ажил нь гадаадын улс орнуудад гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглаж байгаа тусгай зориулалтын автомашинд зориулсан зам, талбайн тэмдэг тэмдэглэгээг Монгол Улсад бий болгох боломж үндэслэлийг тодорхойлсноороо шинэлэг болно.

Судалгааны ажлын хязгаарлалт

Судалгааны ажлаар зөвхөн орон сууцны хороолол, хотхоны гаднах талбайд гал унтраах тусгай зориулалтын автомашинд зориулсан зам, талбайн тэмдэг тэмдэглэгээг бий болгох асуудлыг авч үзнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛД ГАЛ УНТРААХ, АВРАХ АВТОМАШИН АЖИЛЛАХАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

1.1. Хот төлөвлөлт, барилга байгууламжийн норм дүрэм, стандартын өнөөгийн байдлын судалгаа

Гал унтраах тусгай автомашин, автомеханик шат, авто өргөгчинд барилгын дээвэр, дээд давхруудаас авралтын үйл ажиллагаа явуулах, агаар механикийн хөөс, усаар гал унтраах үед байрлуулах тодорхой хэмжээний зам гарц, зай талбай шаардлагатай. Түлхүүр үгс болох “зам”, “гарц”, “орон сууцны хороолол”-ыг тодорхойлбол “зам” гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан хучилттай буюу шороон зурвас газар юм. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, явган хүний зам, унадаг дугуйн зам, тусгаарлах зурвас замд хамаарна. “Гарц” гэж замын зэргэлдээх нутаг дэвсгэр рүү орох, түүнээс гарахад зориулсан зорчих хэсэг замтай нийлсэн бэлчир юм⁴⁶. “Орон сууцны хороолол” гэдэг нь хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууцны цогцолбор юм.

Судалгааны ажлын хүрээнд орон сууцны хороолол, хотхоны гал түймрийг унтраах, аврах ажиллагааг явуулах тусгай зориулалтын автомашины зам гарц, талбайн талаар хот төлөвлөлт, орон сууцны барилга байгууламжийн галын аюулгүй байдлын тухай хууль, норм дүрэм, стандартад хэрхэн заасныг судлан үзлээ.

Монгол Улсын Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т *Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна: 12.6.2-т орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэр, үйлдвэрийн туслах барилга байгууламжийн хоорондын гал тусгаарлах зайг тооцох, 12.6.3-т төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн 30-аас доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, автомашины зогсоол байна* гэж заасан байна.

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т *Барилгын зураг төсөл нь нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг орон зайг чөлөөтэй ашиглах, авто зогсоол түүний орц гарцыг хөдөлгөөнд саадгүй байхаар төлөвлөсөн байна* гэж заажээ.

Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т *Барилга байгууламж, гэр хорооллыг гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай, гал түймэр*

⁴⁶ МУ-ын Засгийн газрын 2018 оны 239 дугаар тогтоол. МУ-ын замын хөдөлгөөний дүрэм

унтраах үед ашиглах усан хангамжтай байхаар төлөвлөнө, 12.1.5-т хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн, гамшиг, аюулт үзэгдлийн үед нүүлгэн шилжүүлэх нөхцөлийг хангасан байх гэж заажээ.

Монгол Улсын барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т Барилгын үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна.

5.1.1.барилгын норм, дүрэм;

5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;

5.1.3.стандарт гэж заажээ.

Эдгээр баримт бичгүүдээс барилгын үйл ажиллагаанд энэ хуулийн 5.1.1-д заасан барилгын норм, дүрмийг заавал, 5.1.2-т заасан баримт бичгийг сонгож мөрдөнө хэмээн заажээ. Иймд хуулиас гадна эдгээр баримт бичгүүдэд хот төлөвлөлтийн барилга байгууламжийн норм дүрэм, стандартад орон сууцны хорооллын гадна зай, талбайг хэрхэн тооцдог болохыг судлан үзэх шаардлагатай юм.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.1-т Барилга байгууламж, барилга хоорондын гал эсэргүүцэх зайд тоног төхөөрөмж, чингэлэг, эд зүйл байрлуулж ашиглахыг хориглоно, 6.2-т Гал унтраах автомашин, техник хэрэгсэлд зориулагдсан талбайг тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар ашиглахыг хориглоно, 6.5-т Гэр хорооллын гудамж, айл өрх нь хороо, багийн хэмжээнд жигдэрсэн харагдахуйц хаягжилттай байх бөгөөд гудамж хооронд галын автомашин чөлөөтэй зорчих, байрлах зайтай байна, 6.6-т Мухар гудамж зайлшгүй гаргасан тохиолдолд төгсгөлдөө галын автомашин чөлөөтэй эргэх 15x15м талбай гаргана гэж заасан байна.

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм БНБД 30.01.04-ийн 2.10-т “Орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбай 6 м²-ээс багагүй байна”, “Орон сууцны хорооллын ногоон бүсэд амралтын, хүүхдийн тоглоомын, явган замын талбайг оруулан тооцох ба нийт эзлэх талбай нь ногоон бүсийн талбайн 30 хувиас ихгүй байна”, 4.2-т “...сууцны хорооллын барилгажсан нутаг дэвсгэрийн 25%-иас багагүй нь цэцэрлэгжүүлсэн нутаг дэвсгэр байна” гэж заажээ. БНБД 30.01.04-ийн Галын аюулаас хамгаалах шаардлагын 12-т “зам, гарцыг ...галын машин чөлөөтэй зорчих боломжтой төлөвлөнө. Зам гарцаас 10 хүртэл давхар барилгын хана хүртэл 5м-ээс багагүй, 10 дээш давхар барилгын хана хүртэл 8м-ээс багагүй байхаар тооцож төлөвлөнө. Барилгын орц байхгүй ханын дагуу галын машин зорчих 6м-ээс ихгүй зурвас зай гаргаж төлөвлөхийг зөвшөөрнө” гэсэн заалтаас өөр галын үндсэн болон тусгай автомашины ажиллагааг хангасан зай хэмжээг зааж өгөөгүй байна.

Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 21-01-02-д Галын техник хүрэлцэн очиж байрлуулах зориулалтын зам гарцыг барилгын үндсэн зам гарцтай нэгтгэн эсвэл тусгайлан байгуулах, үндсэн болон тусгай зориулалтын галын машины орох зам гарцыг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөнө гэж заасан байна. Холбогдох норм дүрэм гэдэг нь Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулаагүй асуудлыг олон улсын байгууллага, гадаадын барилга


байгууламжийн норм, дүрэм, стандартаар зохицуулж болно гэж заасныг үндэслэн галын үндсэн болон тусгай зориулалтын авто машины орох зам гарцыг ОХУ-ын СНиП-2.07.01, СНиП II-89, СНиП II-97 норм, дүрэмд заасан шаардлага юм. Үүнээс харахад орон сууцны хорооллын зам гарцын зай хэмжээг заасан норм дүрэм одоогоор байхгүй байна.

Харин “Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага” MNS 5611:2006 стандартад “орон сууцны барилгад БНБД 21-01-02-д заасны дагуу гал түймрээс урьдчилан сэргийлэх хэмжигдэхүүн, хүмүүсийг барилгаас цаг тухайд нь нүүлгэн шилжүүлэх, зэргэлдээ орших барилга, орон сууцны хэсэг (блок) рүү гал тархахгүй байх, мөн хүмүүсийг аврах ба галыг унтраах арга хэмжээг гүйцэтгэх галын байгууллагын бие бүрэлдэхүүн барилга руу саадгүй орох боломжийг хангасан байх ёстой” гэж заажээ.


Судалгаанаас харахад барилга байгууламж, галын аюулгүй байдлын тухай хууль, норм дүрэм, стандартуудад хот төлөвлөлтөд орон сууцны хорооллын гадна талбайд галын аюулгүй байдлын зам, гарцыг төлөвлөх талаар тодорхой зааж өгсөн байна. Харин тэдгээр галын тусгай зориулалтын автомашины зам гарцын хэмжээ болон түүнд тавих шаардлагыг зааж өгөөгүй, тодорхой бус байна. Үүнээс харахад галын тусгай зориулалтын автомашины зам, гарцыг тэр болгон тооцон орон сууцны хорооллыг барьж байгуулахгүй байна.

1.2. Орон сууцны хорооллын гал түймрийг шуурхай унтраах тусгай зориулалтын автомашиныг ажиллуулахад нөлөөлж буй хүчин зүйлс

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд тохиолдож буй нийт аюулт үзэгдэл, ослын 85.6 хувийг, Улаанбаатар хотод тохиолдож буй нийт аюулт үзэгдэл ослын 96.3 хувийг объектын гал түймэр эзэлж байна (Зураг 1). Нийслэлд 2013-2018 онд гал түймэрт өртсөн объектуудыг төрлөөр нь авч үзвэл 10 хувь нь монгол гэр, 40 хувь нь барилга байгууламж, 6 хувь нь автомашин, үлдсэн хувь нь хог, хогийн суваг, хашаа хороо, саравч зэрэг бусад объектууд байна (Зураг 2).



Зураг 1. Улаанбаатар хотын хэмжээнд тохиолдсон объектын гал түймрийн тоо



Зураг 2. Гал түймэрт өртсөн объектын төрөл

Гал түймрийн аюулын нөхцөл байдал улам бүр нэмэгдэж буй өнөө үед Улаанбаатар хотын зарим орон сууцны хороолол, хотхоны барилгууд нь барилгын норм дүрэмд заасан хэмжээний дагуу ногоон байгууламж, тоглоомын талбай, автомашины зогсоол төлөвлөгдөөгүйгээс оршин суугчдын эрүүл орчинд тав тухтай амьдрах эрх алдагдаж, ямар нэгэн осол, гал түймэр тохиолдоход аврах тусгай зориулалтын автомашин орох боломжгүй байдал үүссэн нь иргэдийн амь насанд шууд заналхийлсэн байдалтай байна.

Орон сууцны хорооллын гал түймрийг унтраах тусгай зориулалтын автомашиныг шуурхай ажиллуулахад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох хүрээнд өнөөдөр Онцгой байдлын байгууллагын аврах гал унтраах ангиудад ашиглаж буй автомашин болон автомеханикийн үндсэн үзүүлэлтүүдийг судлан үзлээ. (Зураг 3)



Зураг 3. ISUZU маркийн шатны машины техникийн үзүүлэлт

Хөдөлгүүрийн загвар:	ISUZU6SD1-NA
Галын хөөрөгний загвар:	МОРИТО ME-5
Суудлын тоо:	3
Шатны секцийн тоо:	4
Шатны суналтын даацын хэмжээ:	360кг
Шатны суналтын урт:	30 метр -17иас +75 градус
Машины урт:	10150 м
өргөн:	2495 м
өндөр:	3750 м
жин:	16000 кг
эргэлтийн радиус:	15 м

Мөн Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн орон сууцны 12 хороолол, хотхоныг сонгон авч тэдгээрийн гадна зогсоол, ногоон байгууламж, галын тусгай зориулалтын автомашин явах зам гарцыг хэрхэн төлөвлөсөн, норм дүрмийн хэрэгжилтийг судлав.

Судалгаанд Баянзүрх дүүргийн Баянмонгол хороолол, Саруул хороолол, Сонгинохайрхан дүүргийн Содон стандарт цогцолбор хороолол, 1-р хороолол, Хан-Уул дүүргийн Хурд хороолол, Вива сити хотхон, Баянгол дүүргийн Голден парк хотхон, Цоглог хотхон, Чингэлтэй дүүргийн 4, 5-р хороонд байрлах байрнууд, Сүхбаатар дүүргийн Хангай хотхон, Номуун хотхон хамрагдсан. Судалгааг ард иргэдийн хамгийн их гэр орондоо байх цаг буюу оройн цагийг сонгон зураг аван баримтжууллаа.

Судалгаанаас харахад дээрх хорооллуудаас зөвхөн Вива сити, Чингэлтэй дүүргийн 4, 5-р хорооны нөхцөл байдал хэвийн буюу тус хороололд тусгай зориулалтын автомашин нэвтрэх боломжтой байна. (Зураг 4,5) Гэхдээ иргэд машинаа зогсоолд давхардуулан байрлуулж байгаа нь тусгай зориулалтын автомашиныг эргэлт хийхэд саад учруулахаар байна.



Зураг 4. ЧД 4-р хороо



Зураг 5. ХУД Вива сити хороолол

Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороолол нь 1985 оноос баригдсан, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайг норм нормативын дагуу тооцоолсон байдаг. Гэвч иргэд хорооллын зам гарц дээр эгнээ үүсгэн, мөн нийтийн эзэмшлийн ногоон байгууламж дээр автомашинаа байрлуулж, хорооллын зам гарцыг тусгай зориулалтын автомашин орох ямар ч боломжгүй болгон хаасан байна (Зураг 6).

Нийслэлийн автомашины тоо эрс ихэссэн өнөө үед орон сууцны барилгын газар доорх авто зогсоолгүй, газар дээрх зогсоол дутмагаас 1 дүгээр хороололд ч орон сууцны хорооллуудад байгаа нийтлэг дутагдал харагдаж байна.



Зураг 6.СХД 1-р хороолол



Зураг 7. БЗД Баянмонгол хороолол

Шинээр баригдсан Баянмонгол, Содон, Хангай хороолол, хотхон нь норм ба дүрэмд заасны дагуу төлөвлөгдөн баригдсан. Гэвч эдгээр хорооллуудад зөвхөн суудлын автомашин зөрж өнгөрөх буюу ойролцоогоор 2,3 метр зай үлдээж тээврийн хэрэгслүүдийг байрлуулжээ (Зураг 7).

Баянгол дүүргийн Цоглог хотхонд бүр ямар ч зай завсаргүй машин байрлуулсан байна. Хэрэв ямар нэгэн тээврийн хэрэгсэл нэвтрэхээр бол 7-10 автомашиныг гаргах шаардлагатай байна (Зураг 8).

Онцгой байдлын байгууллагад одоо ашиглаж байгаа үндсэн болон тусгай зориулалтын автомашины дундаж өргөн 2,5м бол 2,3м-ийн зайгаар нэвтрэх боломжгүй байгаа нь орон сууцны хороололд гал түймэр гарсан тохиолдолд аврах үйл ажиллагаа явуулах, зохион байгуулах боломж хязгаарлагдаж байна. Энэ

байдал зөвхөн судалгаанд хамрагдсан хороолол, хотхонд биш Улаанбаатар хотын аль ч дүүргийн орон сууцны хорооллоос харж болно (Зураг 9).



Зураг 8. БГД Цоглог хотхон



Зураг 9. СБД Хангай хотхон

Дээрх судалгаанаас орон сууцны хорооллын гал түймрийг шуурхай унтраах, тусгай зориулалтын автомашиныг ажиллуулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

1. Хот төлөвлөлтийн бодлого алдагдсан,
2. Барилга байгууламжийн норм дүрэм, стандартын хэрэгжилт сул,
3. Улаанбаатар хотын автомашины тоо хэт ихэссэн зэрэг юм.

Хотын төвлөрлийг саармагжуулалгүй төвийн хэсэг рүү хэт их шахаж газар олгох, төлөвлөлтийн хяналтгүй байдлаас бага хэмжээний газарт олон давхар барилга байгууламжууд баригдсаар байгаа билээ. Эдгээр барилгууд нь барилгын норм дүрэм, стандартад заасан зай талбай, зам гарц, ногоон байгууламжийн хэмжээг зөрчин баригдаж, гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нэвтрэх боломжгүй, эргэлт хийх зай талбай хязгаарлагдмал болох улмаар гал түймрийн аюулд их хэмжээний хохирол учрахаар байгаа нь нуугаад байх зүйл биш юм. Иймд эдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах арга хэмжээ авах нь зүйтэй.

Мөн иргэд ямар нэгэн зөвшөөрөлгүй барилгын нэгдүгээр давхрыг өөрсдийн дураар өргөтгөх, зам гарц хааж ТҮЦ, гараж барих зэрэг үйлчилгээний чиглэлээр ашиглаж байгаа нь гал түймрийн үед болзошгүй эрсдэлийг нэмэгдүүлсээр байгаа билээ. Үүний нэг жишээ нь 2019 оны 9-р сарын 10-ны өдөр "Монполимет" группийн "МРМ" цамхагт гарсан гал түймрийг унтраахаар очсон галын тусгай зориулалтын автомашины орох гарцыг хааж объект барьснаас гал гарсан талд ойртох боломжгүй болж, тойрон явж, гарц хайх зэрэг хугацаа алдаж, гал түймрийг шуурхай унтраах ажиллагаанд шууд нөлөөлж байгаа нь харагдсан. Хэдийгээр энэ гал түймэрт хүний амь эрсдээгүй ч их хэмжээний эд хөрөнгийн хохирол учирсан.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2019 оны 10 дугаар сард орон сууцны болон үйлчилгээний зориулалттай өндөр барилга байгууламжид Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт бус шалгалтыг зохион байгуулсан байна. Шалгалтыг төвийн зургаан дүүргийн 62 орон сууцны хороолол, хотхонд зохион байгуулж, нийт 182 зөрчлийг илрүүлжээ. **Нийт зөрчлийн 10 хувь нь** барилга байгууламж, задгай агуулах, галын гадна шат, гал

унтраах автомашины усны эх үүсвэрт хүрэх зам гарц, хонгил, нүхэн гарц нь автомашин явах бүрэн бололцоотой, өвлийн цагт цас, мөснөөс цэвэрлэгдсэн байнгын бэлэн байдалд байна гэсэн заалтыг зөрчсөн, **13 хувь нь** болзошгүй гал түймрийн үед хүн, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх зам гарц дагуу аваар ослын гэрэлтүүлэг төлөвлөөгүй, **14 хувь нь** барилга, байгууламж дотор гал эсэргүүцэх усан хангамжийн систем төлөвлөсөн боловч хоолой, хошуу, крант, иж бүрдэл байхгүй, **18.2 нь** галын автомат дохиолол, гал унтраах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон боловч ашиглалтын байнгын бэлэн байдлыг хангаагүй, хамгийн их буюу **34 хувь нь** орон сууцны хороололд гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах талбай байхгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.⁴⁷ Шалгалтын дүнгээс орон сууцны хороололд гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбай нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНД ЗОРИУЛСАН ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭГ БИЙ БОЛГОХ АСУУДАЛ

2.1. Тусгай зориулалтын автомашинд зориулсан зам, талбайн тэмдэг тэмдэглэгээний стандартын талаарх зарим улс орны туршлага

Гадаадын зарим улс орнуудын барилга байгууламжийн тусгай зориулалтын автомашинд зориулсан зам гарц, тэмдэг тэмдэглэгээг судалгааны ажлын энэ хэсэгт судлан үзлээ.

ОХУ-д СП4.13130.2013 “Галын хамгаалалтын систем. Объектын гал түймрийн тархалтаас хамгаалах төлөвлөлт, зохион байгуулалтад тавигдах шаардлага” дүрэмд барилгын өндрөөс хамаарч барилгын хананы гадаад ирмэгээс авто өргөгчний ажиллах зам гарцын өргөний хэмжээг:

- ✓ 28 м хүртэл өндөртэй барилгын хувьд 3.5 м
- ✓ 28-46 м өндөр барилгад 4.2 м


46 м-ээс дээш өндөртэй барилгад 6 м өргөн зам байхаар тооцон төлөвлөнө гэж заажээ. (Зураг 11)



⁴⁷НОБГ, Орон сууцны болон үйлчилгээний зориулалттай өндөр барилга байгууламжууд, барилгын нэг болон зоорийн давхарын баар, караоке, ресторанд Гамшгаас хамгаалах, Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулсан тухай илтгэх хуудас

Зураг 11. Галын тусгай зориулалтын автомашины зам гарцын өргөний хэмжээ

Австрали улсын барилгын тухай болон бусад холбогдох хуулийн дагуу барилга төлөвлөлтөд зориулж Гал түймэр болон Онцгой байдлын албаны шаардлагыг дараах байдлаар стандартчилан өгсөн байна (Зураг 12). Барилгын хананаас хороолол дундах зам нь 2-12 метр, мод ногоон байгууламжаас 1 метр зайтай байх ба замын өргөн 6 м гэж тооцжээ. 6 м нь галын автомашины байрлуулах ажлын зай юм. Туннель, нүхэн гарц, аркны өндөр 4,5 метрээс багагүй байна гэж заадаг байна.



Зураг 12. Австрали улсын барилга төлөвлөлтийн стандартад заасан галын тусгай зориулалтын автомашины зам, гарцын хэмжээ

Судалгаанаас харахад барилга байгууламжийн хувьд галын тусгай зориулалтын автомашины ажиллах зам, гарцыг дараах байдлаар шийдэж болох юм. Үүнд:

- ✓ Орон сууцны хорооллын зам, гарцад тусгайлсан тэмдэг тэмдэглэл байрлуулах;
- ✓ Барилгын норм дүрэмд зааснаар тооцоолсон нийтийн хэрэгцээний ногоон байгууламжаар;
- ✓ Зам талбайн тусгаарлах зурвасыг галын тусгай зориулалтын автомашины зогсоолд тооцоолон шийдэх боломжтой юм.

Зам, талбайд тусгайлсан тэмдэг тэмдэглэл байрлуулах:

Дээрх хэмжээсийг хорооллын дундах зам, гарцад тооцон төлөвлөх ба норм дүрэм зөрчин барьсан барилга байгууламжийг буулгах, эсвэл гал түймэр гарсан нөхцөлд ашиглах зам, гарцыг зайлшгүй гаргах шаардлагатай юм.

Олон улсад барилга байгууламжийн гадна зам, гарцад галын автомашинд зориулан тэмдэглэсэн хэвтээ тэмдэглэлийг өргөн ашигладаг. Энэхүү тэмдэглэл нь байнгын байх ба тус барилгад гал гарсан тохиолдолд зам, гарцад галын автомашины зогсож болох байрлалд, ажиллах боломжит хэмжээгээр,

анхааруулах улаан, шар өнгийн цацруулагч тусгай будгаар будаж тэмдэглэсэн байна. Тэмдэглэлийн хүрээ хэсгээр антисептик хүртэл ашигласан байдаг. Мөн тэмдэглэлтэй хэсэгт гидрант болон ус зайлуулах системийг төлөвлөн цогцоор шийдвэрлэдэг байна (Зураг 13).



Зураг 13. Барилга байгууламжийн гаднах галын тусгай зориулалтын автомашин ажиллах зам, талбай. (а. ОХУ, б. БНСУ)

Тусгай тэмдэглэлийн захад зогсож байгаа тээврийн хэрэгсэл нь тэмдэглэсэн талбайгаас тусгай зориулалтын автомашиныг хөдлөх боломжтой байх зайг үлдээж зогсоно. Галын автомашины зогсоолын байршилд оршин суугчдын тээврийн хэрэгслийг байрлуулах, түр зогсолт хийхийг хориглосон тэмдэг тавьдаг (Зураг 14).



Зураг 14. Галын автомашин зогсох зам, талбайн тэмдэг

Улс орнуудын туршлагаас харахад хэрэв галын автомашины зогсоолын тусгай тэмдэглэл бүхий талбайд тээврийн хэрэгсэл байрлуулбал хүчээр ачиж, талбайг чөлөөлөх арга хэмжээг авдаг байна.

Барилгын норм дүрэмд зааснаар тооцоолсон нийтийн хэрэгцээний ногоон байгууламжаар:

Галын тусгай зориулалтын автомашины ажиллах зам, талбайг гаргах, төлөвлөгдсөн зайгаа ашиглах бас нэг шийдэл бол зүлэгний сараалжин систем юм.⁴⁸ Энэхүү системийг Герман, ОХУ өргөн ашиглаж байгаа ба нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн нэг хэсэг болох зүлэгжүүлсэн талбайд галын

⁴⁸<http://argeon.ru/pozharnye-proezdy>

автомашин зогсох нөөц талбайг тооцоолох юм. Зүлэгний сараалжин системийг хүнд даацын автомашин зогсоход зориулж хөрсийг нягтруулах шаардлагагүй, хэт ягаан туяанд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй материалаар хийдэг. Тусгай сараалжин хавтанд дүүргэлт хийснээр гадаргууг бэхжүүлж 800 тн/м² хүртэл ачаалал даах ба дүүргэлтээсээ хамааран 20 тн хүртэл ачааг нэмж даах боломжтой. Энэхүү систем нь борооны ус болон гал унтраахад ашиглаж байгаа усыг газарт шууд шингээх ба ус зайлуулах суваг ашиглах шаардлагагүй байдаг (Зураг 15).



Зураг 15. Зүлэгний сараалжин системийг галын автомашины гарц, талбайд ашигласан байдал

Хорооллын зам, гарцын тусгаарлах зурвасыг галын тусгай зориулалтын автомашины зогсоолд тооцоолон шийдэх:

Нийтийн ногоон байгууламжийн адил хорооллын зам гарц дах тусгаарлах зурвасыг галын автомашин зогсох нөөц талбайд тооцоолох арга юм. Тусгаарлах зурвас гэдэг нь зэрэгцээ зорчих хэсгүүдийг хооронд нь тодорхой зайтай салгаж зааглахад зориулагдаж хийгдсэн, тээврийн хэрэгслийн зогсоол болон хөдөлгөөнд зориулаагүй замын хэсэг юм. Гэвч барилга, байгууламжийн гадна зогсоолгүй эсвэл түгжрэлтэй үед галын автомашины зогсож зай талбай болгон ашиглаж болох юм.⁴⁹ Гэхдээ тусгаарлах зурвас нь хөвөөгөөр хязгаарлагдах учир хөвөө болон тусгаарлах зурвасыг гадаргуугийн төрлөөр, өнгөөр нь ялгаж аль болох зам гарцтай нэг төвшинд байхаар төлөвлөдөг байна (Зураг 16).

Тусгаарлах зурвасыг нөөц талбайд тооцоолоход оршин суугчдын тээврийн хэрэгслийг байрлуулахыг хориглох болон тусгай автомашинд нэмэлтээр зай талбайг ашиглах тэмдэг тавих шаардлагатай.

⁴⁹Planning Guidelines for Emergency Vehicle Access and Minimum Water Supplies within the Metropolitan Fire District, 2014




Зураг 16. Тусгаарлах зурвасыг галын автомашины зогсоолд төлөвлөсөн байдал.

Дээрх шийдлүүд нь барилга байгууламжийн норм, стандартыг зөрчин баригдсан байшин барилгыг буулгах боломжгүй үед хорооллын зам гарцад хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд учирч болох эрсдэлийг бууруулах нэг арга юм.

2.2.Орон сууцны хорооллын зам талбайд тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэг тэмдэглэгээг нэвтрүүлэх арга зам

Судалгаанаас харахад дээрх аргуудын алийг нь ч Улаанбаатар хотын орон сууцны хороололд ашиглах бүрэн боломжтой юм.

Шинээр баригдах гэж байгаа болон гаднах зам, авто зогсоол нь хангалттай төлөвлөгдсөн орон сууцны хорооллын гаднах талбайд тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэглэл байрлуулах нь тохиромжтой юм. Гадаад улс орнуудын туршлагаас харахад галын тусгай зориулалтын автомашин ажиллах зам, гарцын хэмжээ 15м×15м, 15м×6м хэмжээтэй байна. Онцгой байдлын албанд одоо ашиглаж байгаа галын тусгай зориулалтын ISUZU6SD1-NA маркийн автомашины уртын хэмжээ 10150 м, өргөн 2495 м, өндөр 3750 м, эргэлтийн радиус 15 м, байрлуулах өргөн 6 м байдаг тул манай улсад галын тусгай зориулалтын автомашин ажиллах зам, гарцын тэмдэг тэмдэглэгээг бий болговол 15м×6м



Зураг 17.Тусгай зориулалтын автомашинд зориулсан зогсоолын тэмдэглэл

хэмжээг төлөвлөхөд хангалттай байна (Зураг 17).

Тусгай зориулалтын автомашинд зориулсан зогсоолын тэмдэглэлийг Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм БНБД 30.01.04-д заасны дагуу орон сууцны хорооллын гаднах зам талбайд 10 хүртэл давхар барилгад барилгын хана хүртэл 5м-ээс багагүй, 10 дээш давхар барилгад хана хүртэл 8м-ээс багагүй зайд байхаар тооцож зурж тэмдэглэнэ. Энэхүү тэмдэглэгээг заавал мөрдөж хэрэгжүүлэх тул улаан өнгөтэй байх шаардлагатай ба найрлагадаа цацруулагч агуулсан будгаар будаж тэмдэглэх нь зүйтэй юм (Зураг 18).

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм БНБД 30.01.04-д заасан галын тусгай зориулалтын автомашины зам, гарцын хэмжээг ОХУ-ын СП4.13130.2013 “Галын хамгаалалтын систем. Объектын гал түймрийн тархалтаас хамгаалах төлөвлөлт, зохион байгуулалтад тавигдах шаардлага”, Австрали улсын DFES Site planning and fire appliance specifications GL-11-д заасан хэмжээтэй харьцуулан үзлээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Галын тусгай зориулалтын автомашины зам, гарцын харьцуулсан хэмжээ

БНБД 30.01.04		СП4.13130.2013		DFES Site planning and fire appliance specifications GL-11
≥9	5 м багагүй	≥9	3,5 м багагүй	2-12м
≤10	8 м багагүй	≥16	4,2 м багагүй	
		<16	6 м	



Зураг 17. Тусгай зориулалтын автомашинд зориулсан зогсоолын байршил

Улаанбаатар хотод нэгэнт баригдсан орон сууцны хороололд байгаа зай талбайгаа аль болох ашиглаж хэрэгцээ шаардлагатай үед гал түймэр унтраах автомашиныг байрлуулах талбайг гаргаж авах нь зүйтэй. Үүнд барилгын норм

дүрэмд зааснаар тооцоолсон нийтийн хэрэгцээний ногоон байгууламж болон явган хүний зам, тусгаарлах зурвас зэргийг ашиглах юм.

Дээрх судалгаанаас харахад зүлэгний сараалжин систем нь орон сууцны гаднах зам, зогсоолын зай багатай манай орны нөхцөлд барилгын ногоон байгууламжийг бүрдүүлж, эвдрэл гэмтэл багатай, байнга хоосон орон зай гаргахгүй, шаардлагатай үед л ашиглах нөөц талбай болох учир хамгийн тохиромжтой юм. Онцгой байдлын албанд одоо ашиглаж байгаа галын тусгай зориулалтын ISUZU6SD1-NA маркийн автомашины бодит жин 16 тонн байдаг ба зүлэгний сараалжин систем нь 800тн/м² даацтай байдаг.

Дээрх аргуудын алийг ч хэргэлсэн тухайн зогсоолыг тэмдэглэн тусгай зориулалтын автомашинаас бусад тээврийн хэрэгслийг зогсохыг хориглох тэмдгийг заавал хэрэглэнэ.

Хот төлөвлөлт, барилга байгууламжийн норм дүрэм, стандартад оруулах өөрчлөлт

Барилгын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулиудад орон сууцны хороололд гал түймэр гарсан тохиолдолд галын автомашиныг саадгүй нэвтрэх гэж заасан боловч ажиллах зай талбайг нарийвчилж тусгаж өгөөгүй байна. Судалгаанаас харахад хуульд ерөнхийлөн зааж өгсөн боловч түүнийг дагалдан гарах бусад баримт бичгүүдэд нарийвчлан зааж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Иймд хот төлөвлөлт болон барилгын зураг төсөл боловсруулахад заавал мөрдөх баримт бичиг болох дараах норм, дүрэм, стандартад тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэг тэмдэглэгээний стандартыг оруулах боломжтой. Үүнд:

- Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04
- Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм /БНБД 31-01-10/
- Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21.01.02/ зэрэг юм.

Мөн шинээр автомашин зориулсан тэмдэг, замын тэмдэглэгээг шинээр гаргаж байгаа учир Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014 стандартын “А” хавсралтад өөрчлөлт оруулан Хориглох тэмдэг- Зогсохыг хориглоно гэсэн тэмдэг, тэмдэглэгээг шинээр бий болгоно.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгаанаас орон сууцны хорооллын гал түймрийг унтраах шуурхай ажиллагаа явуулахад хот төлөвлөлт, барилгын норм дүрмийн хэрэгжилт, нийслэлийн автомашины ачаалал тухайн орон сууцны хорооллын гадна зам гарцанд нөлөөлдөг болох нь харагдаж байна. Монгол улсад барилга байгууламж, галын аюулгүй байдлын талаарх холбогдох хууль, норм дүрэм, стандартад барилгын зам, гарцад галын автомашины ажиллах тусгайлсан зай талбай, тэмдэглэсэн тэмдэг, тэмдэглэгээг тодорхой зааж өгөөгүй байна. Цаашид хүн ам олноор оршин суух орон сууцны хороолол, хотхоны барилгын норм дүрмэнд тусгай зориулалтын галын автомашины бүрэн ажиллах зай талбайг тооцож тусгах шаардлагатай.

Иймд гадаад улс орнуудын орон сууцны хороололд гал түймрийн үед галын автомашин орох, ажиллах зам гарцын тэмдэг, тэмдэглэлийг хэрэглэж буй стандарт, туршлагыг судлаж, Улаанбаатар хотод бий болгох боломж, арга замыг дэвшүүллээ. Энэхүү санал болгож буй орон сууцны хорооллын галын тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг холбогдох баримт бичигт тусган баталж, заавал мөрдөж хэвшүүлэх нь гал түймрийг унтраах ажиллагааг шуурхай зохион байгуулахад эерэгээр нөлөөлөх боломжтой байна. Судалгааны ажлаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэйг зөвлөмж болгож байна юм. Үүнд:

1. Хот төлөвлөлт, барилгын зураг төсөл боловсруулахад заавал мөрдөх “Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04”, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм БНБД 31-01-10”, “Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 21-01-02”, “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014” стандарт зэрэг баримт бичгүүдэд өөрчлөлт оруулан тусгай зориулалтын автомашинд зориулсан тэмдэг тэмдэглэгээний стандартыг баталгаажуулах;

2. Орон сууцны хорооллын оршин суугчид тухайн барилгын зурагт тооцоолон гаргасан автомашины зам, гарцыг хааж тээврийн хэрэгслээ байрлуулахгүй байх, харъяалах хороо болон Сууц өмчлөгчдийн холбоо хамтран галын аюулгүй байдлыг хангах үүднээс хороолол, хотхонд тусгай зориулалтын автомашины орох, гарах зам болон байрлуулах зогсоолд тэмдэг тэмдэглэлийг тавих, иргэд тэмдэг тэмдэглэлийг зөрчихгүй байхад байгууллагууд хамтран ажиллах;

3. Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих зориулалтаар газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, техникийн нөхцөл олгоход Онцгой байдлын байгууллагаас санал авч, оролцоог нэмэгдүүлэх;

4. Барилгын угсралтын ажлын явцад Онцгой байдлын байгууллагаас хяналт тавьдаг байх, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар, зай хэмжээний зургийг зөрчсөн барилга угсралтын ажлыг зогсоох, барилга байгууламж эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээг авахад Нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага болон Онцгой байдлын байгууллага уялдаатай ажилладаг байх;

5. Хүн амын нягтрал ихтэй бүс болох Улаанбаатар хотод галын болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан, багтаамжтай, олон давхар авто зогсоолыг барьж байгуулах нь авто машины зогсоолыг шийдэж, ачааллыг бууруулах нэг шийдэл болох юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Барилгын тухай хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Орон сууцны тухай хууль
- Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага. MNS 5611:2006
- Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007
- Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2013
- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04
- Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД21-01-02
- Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21-02-02
- Авто зогсоол БНБД 21-05-10
- Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10
- МУ-ын Засгийн газрын 2018 оны 239 дугаар тогтоол. МУ-ын замын хөдөлгөөний дүрэм
- Д.Баян-Эрдэнэ, С.Базаррагчаа, Д.Цэцэнбат нар., Өндөр барилгын гал түймэртэй тэмцэх нь., Улаанбаатар, 2010.
- Гал унтраах мэргэжлийн сургалтын сурах бичиг. О.Ганхуяг, Улаанбаатар, 2010.
- Монгол улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын статистикийн эмхэтгэл 2004-2016. Д.Бадамсүрэн, Улаанбаатар, 2017.
- СНиП 2.07.01-89* Градостроительство. Планировка и застройка городских и сельских поселений
- Vancouver Fire Department, Development Standards - Fire Department Emergency Access
- London Fire Brigade. Fire Safety Guidance Note. Access for Fire Appliances GN29, 2015
- Government of Western Australia. Department of Fire and Emergency Services GL-11: DFES SITE PLANNING AND FIRE APPLIANCE SPECIFICATIONS, 2017
- GL-27: Planning Guidelines for Emergency Vehicle Access and Minimum Water Supplies within the Metropolitan Fire District, 2014
- https://www.1212.mn/tables.aspx?tbl_id
- <http://arreon.ru/pozharnye-proezdy>
- <http://transportation.police.gov.mn>

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Д.Сэржмядаг¹, Ш.Мөнхбаатар², Ш.Мөнгөнтуяа³, П.Амарзаяа⁴, Ч.Нямхүү⁵

¹ГСХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа

²ГСХ-ийн Гамшиг судлалын төвийн дарга, магистрант, ахмад

³МУЗН-ийн гамшгийн менежментийн хөтөлбөрийн ахлагч

^{4,5}МУЗН-ийн гамшгийн менежментийн хөтөлбөрийн ажилтан

Оршил

Судалгааны ажлын үндэслэл: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн олон талт асуудлыг хамаарах тул түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч бүх талын оролцоо, түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчлах болсон. Энэ утгаараа өнөө үед гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой мэдлэг, чадварыг сайжруулахад чиглэсэн сургалтын ач холбогдол улам бүр нэмэгдэж байна.

Дэлхий нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлж буй Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг "бүх түвшний төрийн албан хаагчид, иргэний нийгэм, олон нийт, сайн дурынхан, хувийн хэвшлийнхний гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг боловсрол, сургалтын механизмыг ашиглан сайжруулах" (24ё) гэж тодорхойлсон.

Монгол Улсын "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"-ын баримт бичигт "...хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах...",⁵⁰ гэж, Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 13.2-д гамшгаас хамгаалах сургалтыг дараах ангиллаар явуулна гэж заасан байдаг. Үүнд:

- Удирдах албан тушаалтны;
- Онцгой байдлын байгууллагын;
- Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн;
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны;
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн;
- Иргэний гэсэн 6 ангилал хамаардаг⁵¹.

Аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан гамшгаас хамгаалах сургалт гэдэгт Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.4-д заасан "төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны" сургалтыг хамааруулж ойлгосон болно.

⁵⁰ Гамгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого

⁵¹ Гамшгаас хамгаалах тухай хууль 13 дугаар зүйл

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо өнгөрсөн 10 жилийн хугацаанд 2.2 дахин нэмэгдэж⁵² 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 93426 байгууллага үйл ажиллагаа явуулж байна⁵³. Эдгээр ААНБ-д явуулах гамшгаас хамгаалах ангиллын сургалт нь бусад ангиллын сургалтуудаас хамгийн олон удаа зохион байгуулагддаг буюу сүүлийн 5 жилийн дунджаас харахад улсын хэмжээнд зохион байгуулсан нийт сургалтын 40 хувийг дангаараа эзэлж байна (ОБЕГ, 2019).

Гамшгаас хамгаалах сургалтаар дамжуулж оролцогч талуудад мэдлэг, чадвар олгох талаар өмнө дурдсан тодорхой зорилго, зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа хэдий ч одоогоор явуулж байгаа сургалт нь тэдгээрт цэгцтэй мэдлэг, чадвар олгох, дадал төлөвшүүлэх, зөв зан үйлийг хэвшүүлэхийн оронд зөвхөн мэдээлэл өгөх, сэрэмжлүүлэхээс хэтрэхгүй байна. Энэ нь гамшгаас хамгаалах сургалт тухайн газар нутаг, хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд нийцсэн цагт сая үр дүнгээ өгдөгтэй холбоотой юм.

Судалгааны ажлын зорилго, зорилт: Аж ахуйн нэгж, байгууллагад гамшгаас хамгаалах сургалтыг явуулж буй өнөөгийн байдал, туршлага сургамжийг судлах, тэдгээрт шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг тодорхойлоход энэ судалгааны ажлын зорилго оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах сургалтыг ААНБ-д явуулах онол, аргазүйн асуудлыг судлах;
2. ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулж буй өнөөгийн байдал, туршлага, сургамжийг шинжлэх;
3. Аж ахуйн нэгж, байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг тодорхойлох.

Судалгааны арга: Судалгааны ажилд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, ажиглалт хийх зэрэг шинжлэх ухааны ерөнхий аргыг болон агуулгын шинжилгээ, нэгтгэсэн өгөгдөл шинжлэх, асуулгын зэрэг нийгмийн судалгааны тусгай аргыг хэрэглэсэн.

Асуулгын судалгааны үр дүнгийн мэдээллийн боловсруулалтанд SPSS 26 программыг ашиглан, статистик шинжилгээ харьцуулалт хийсэн.

Сэдвийн судлагдсан байдал: Монгол Улсад аливаа гамшгаас хүн ам, эд хөрөнгийг хамгаалах чиг үүрэгтэй байгууллага үүсэж хөгжсөнөөс хойш гамшгаас хамгаалах сургалтын талаар 2004 онд П.Цэдэв “Монгол Улсад гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал”-аар докторын зэрэг хамгаалж, гамшгаас хамгаалах сургалтын онол, арга зүйн үндсийг тодорхойлсон анхны бүтээлээ туурвисан байдаг. Түүнээс хойш тэрээр гамшгаас хамгаалах ангиллын сургалтын талаар олон тооны эрдэм шинжилгээний бүтээл, ном, гарын авлага гаргасан хэдий ч аж ахуйн нэгж байгууллагын ажилтны ангиллын сургалтыг тухайлан авч судлаагүй байна.

⁵² Үндэсний статистикийн хороо (2017) Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ

⁵³ http://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L26

Гамшиг судлалын магистрын сургалтыг 2013 оноос явуулж эхэлсэнтэй холбоотойгоор гамшгаас хамгаалах ангиллын сургалтын талаарх судалгаа, эрдэм шинжилгээний ажил харьцангуй өргөн хүрээнд хийгдэх болсон. Тухайлбал, 2015 онд С.Амгалан “Гамшгаас хамгаалах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох боломж” сэдэвт магистрын судалгааны ажилдаа гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг бүх шатны байгууллага, тэр дундаа боловсролын байгууллагад хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа сургалтын үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж гамшгаас хамгаалах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох арга замыг дэвшүүлсэн байна.

2016 онд Б.Батбаяр “Орон нутгийн Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог бий болгох” нь сэдэвт магистрын судалгааны ажилд иргэд, сайн дурынханд гамшгаас хамгаалах сургалтыг явуулж буй өнөөгийн байдал, сайн дурынханы сургалтыг боловсронгуй болгох асуудлыг авч үзжээ. Мөн Б.Ядамжав “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалтыг боловсронгуй болгох арга зам” сэдэвт магистрын ажилдаа мэргэжлийн ангийн сургалтыг авч үзэж, сургалтын тогтолцооны загвар гаргаж, сургалтын төлөвлөгөө, агуулга арга зүйг боловсронгуй болгох арга замыг тодорхойлсон санал, зөвлөмжийг дэвшүүлсэн байдаг.

Сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдэд ахуйн ослоос өөрийгөө хамгаалах мэдлэгийг олгох сургалтыг энэ насны хүүхдийн сурах үйл бүрээр хэрхэн сургалтыг явуулах арга зүйг тодорхойлсон судалгааг 2017 онд С.Саруул “Сургуулийн өмнөх боловсролд ахуйн ослоос өөрийгөө хамгаалах сургалтын арга зүйг нэвтрүүлэх нь” сэдэвт магистрын ажилдаа авч үзэж судалсан байна. Мөн онд М.Батмөнх “Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нь” сэдэвт магистрын ажилдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын онцлог, хөгжлийн асуудлыг авч үзсэний зэрэгцээ сургалтын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, гадаадын зарим орны туршлагыг судлан өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон бол 2018 онд Д.Бат-Эрдэнэ “Онцгой байдлын байгууллагын чадамжид үзүүлэх сургалтын нөлөө” сэдэвт магистрын ажилдаа Онцгой байдлын байгууллагын сургалтын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, ахлагч бүрэлдэхүүний давтан сургалтын хэрэгцээг судалж тодорхойлох зорилгыг дэвшүүлж Онцгой байдлын байгууллагын хөгжил чадамжид сургалтын үзүүлэх нөлөөг тооцоолох, онцгой байдлын байгууллагын Аврах анги салбарт явагдаж буй сургалт, бэлтгэл, мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх, түүний тогтолцоо, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, Онцгой байдлын байгууллагын чадамжид үзүүлэх сургалтын нөлөөг шинжлэн судалсан байна. 2019 онд Г.Наранзул “Гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг боловсронгуй болгох нь” сэдэвт судалгаандаа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг явуулж буй олон улсын туршлага, өөрийн орны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид уг сургалтыг сайжруулах арга замыг авч үзэж судалсан.

НҮБХХ-ийн хэрэгжүүлсэн “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зорицуулалтын чадавхийг сайжруулах нь” төслийн хүрээнд 2014 онд “Гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар, хандлага олгох сургалтын

хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах” үндэсний зөвлөх баг гамшгаас хамгаалах сургалтын агуулгын талаарх бусад улс орны туршлага сургамжид үндэслэн сургуулийн өмнөх насны хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их, дээд сургуулийн оюутан, ажилтан, албан хаагчид гамшгаас хамгаалах тусгай чиг үүргийн бүлгүүд, сайн дурынхан, иргэд түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэгийг нэгдсэн бодлогоор олгох хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна.

Эндээс харахад гамшгаас хамгаалах сургалтын асуудал нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанаас харьцангуй их судлагдсан боловч дээрх судлаачид гол төлөв гамшгаас хамгаалах сургалтыг салбарын мэргэжилтэн бэлтгэх сургалт, сургалтын тогтолцоо, гамшгаас хамгаалах сургалтын удирдлага, зохион байгуулалт, сургалтын аргазүй талаас нь авч үзэж судалсан байдаг. Харин гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөрийн агуулга хийгээд, хэрэгцээ шаардлагыг авч үзэж судалсан нэн ялангуяа аж ахуйн нэгж, байгууллагад болон ажилтан, албан хаагчдад зохион байгуулах гамшгаас хамгаалах сургалтын талаар тухайлан авч судалсан судалгаа хомс байна.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: Аливаа гамшгийн үед төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага нь гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааг амжилттай явуулахад чухал нөлөө үзүүлдэгийн зэрэгцээ эдгээр нь эрсдэлээ бууруулах, гамшгийн үед яаралтай тусламжийн нөөцөөр хангах болон эрсдэлийг бууруулах чиглэлд хөрөнгө гаргах үндсэн эх үүсвэр нь болдог. Түүнээс гадна аж ахуйн нэгж, байгууллага болон түүний ажилтан, албан хаагчид нь гамшгаас хамгаалах талаар сургагдсан байх нь гамшгаас учирах хохирлыг багасгахад онцгой чухал нөлөөтэй. Энэ утгаараа энэ удаагийн судалгаа нь манай орны хувьд аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгохтой холбоотой сургалтын ямар хэрэгцээ байгааг тодорхойлж буйгаараа шинэлэг бөгөөд практик ач холбогдолтой байх юм.

Судалгааны ажлын хамрах хүрээ, хязгаарлалт: Энэхүү судалгааны ажилд төрийн болон хувийн хэвшлийн, төрийн бус, олон улсын байгууллагыг хамруулсан. Нэг байгууллагаас удирдах ажилтан, энгийн ажилтан болон тухайн байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хариуцсан ажилтан гэсэн 3 хүнээс асуулгын судалгааг авсан.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫГ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУРШЛАГА СУРГАМЖ

1.1. Гамшгаас хамгаалах сургалтыг ААНБ-д явуулах онол, аргазүйн асуудал

Гамшгаас хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагын алба хаагчдыг төдийгүй бүх оролцогч талуудыг сургаж, дадлагажуулах шаардлага, хэрэгцээ их байдаг. Энэ сургалтыг гамшгийн өмнөх үе шатанд буюу гамшгаас урьдчилан сэргийлэх хүрээнд эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хийх, зарлан мэдээллээр ажиллах, зохион байгуулах, гамшгийн үед өөрсдийн аюулгүй байдлыг хангах, гамшгийн дараа хэвийн нөхцөлд хурдан хугацаанд эргэж орох зэрэг өргөн хүрээний арга хэмжээг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг олгох зорилгоор зохион байгуулдаг. Аливаа улс орон, албан байгууллага, айл өрх, иргэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайтар сургагдаж бэлтгэгдээгүй байх нь гамшгийн үед хоёрдогч аюулыг үүсгэх боломжтой төдийгүй цаашид гамшгийн нөхцөл байдлыг хүндрүүлж, улмаар шаардагдах нөөцийг хэд дахин нэмэгдүүлэхэд хүргэдэг.

“Гамшгаас хамгаалах нэр томъёо, тодорхойлолт” MNS 6010:2016 Монгол Улсын стандартын 3.3.1-д “Гамшгаас хамгаалах сургалт” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд улсын алба, засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг сургаж, дадлагажуулах үйл ажиллагааг ойлгоно гэж заасан байна.

Гамшгаас хамгаалах сургалтын туйлын зорилго бол хүмүүс ямар нэг гамшгийн өмнө болон тохиолдсон үед түүнд тохирсон арга хэмжээг цаг тухайд нь үр дүнтэй авах практик чадамжийг олгох юм⁵⁴.

“Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалтад “Гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнийг сургаж дадлагажуулахад чиглэнэ” гэж заасан.

Манай улсад одоогоор гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны; онцгой байдлын байгууллагын; оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн; төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны; иргэний гэсэн зорилтот 6 бүлэг тус бүрээр зохион байгуулж байна. Энэ судалгааны ажлын хүрээнд "төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны" гэсэн ангилалд хамаарах сургалтыг авч үзсэн. Энэ сургалтын хүрээнд гамшгаас хамгаалах сургалт болон гамшгаас хамгаалах дадлага сургуулийг нэгтгэн авч үзсэн болно.

Гамшгаас хамгаалах сургалтад тавигдах шаардлага нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг боловч дараах нөхцлүүдээс хамаарна⁵⁵. Үүнд:

- Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээ, газарзүйн байршил, онцлог
- Тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, осол, түүнтэй тэмцэх хүч хэрэгслийн үүрэг гүйцэтгэх чадвар, боломж

⁵⁴ EU, UNISDR and Kyoto University (2015) 1-2-3 of Disaster Education, p7

⁵⁵ Ник Картер Гамшгийн менежмент 2005 х.289

- Сургалтад хамрагдагсдын ерөнхий мэдлэгийн түвшин
- Багш нарын заах арга барилын түвшин
- Сургалт явуулах боломж, орчин, чадавх
- Суралцагсдын идэвхи чармайлт, сурах хүсэл тэмүүлэл зэрэг асуудлуудтай холбоотой байдаг.

Гамшгаас хамгаалах сургалтаар уг сургалтад хамрагдагсдыг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны олон чиглэлээр сургаж дадлагажуулах хэрэгцээ байдаг. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах
- Төлөвлөлт
- Зохион байгуулалт
- Аврах ажил явуулах, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, цагийн байдлыг үнэлэх, яаралтай тусламж хүргэх, холбоо мэдээллээр хангах
- Хямралтай хүнд нөхцөлд авах арга хэмжээ
- Нөөц, хангалт
- Сэргээн босгох арга хэмжээ

Гамшгаас хамгаалах сургалт нь гамшиг ба эрсдэл, тэдгээрээс хамгаалах талаарх мэдлэгийг оновчтой, үнэн зөв, үр дүнтэй хүргэхэд чиглэгдэнэ. Гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулахдаа тухайн зорилтот бүлэг буюу сургалтанд хамрагдвал зохих бүлгийн гамшгаас хамгаалах талаарх мэдлэг ур чадварыг нарийн тооцож үзэх хэрэгтэй. Ингэсэн цагт тухайн зорилтот бүлэгтээ хүргэх сургалтын шаардлага, хэрэгцээ үнэн зөв тодорхойлогдоно.

Гамшгаас хамгаалах сургалтын зорилго, тавигдаж буй шаардлагаас харахад уг сургалтын онол аргазүйн үндсийг орчин үеийн сургалтад баримталж буй боловсролын философи хандлага болох прагматизмын үүднээс авч үзэх шаардлагатай болж байна. Прагматизм нь мэдлэгийн агуулгыг түүний практик үр дагавраар тодорхойлдог онцлогтой. Энэхүү онолыг үндэслэгч Америкийн эрдэмтэн Ж.Дьюйгийн үзсэнээр “Хүний туршлагаас ангид үнэмлэхүй стандартад тохирсон тийм үнэн гэж байдаггүй. Бидэнд ямар нэгэн зүйлсийн үнэн эсэхийг нотлох ердөө ганцхан үнэлгээ бий. Энэ нь түүний амьдралд үзүүлэх үр ашиг” гэжээ.

Энэ үзэл баримтлалаар бол гамшгаас хамгаалах сургалтын үр дүн нь гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах оновчтой арга хэмжээг цаг тухайд нь үнэн зөв, шуурхай хэрэгжүүлэх чадвараар илэрхийлэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор аливаа сургалтыг суралцагчдад бодит чадвар олгох дадлагатай хослуулан явуулах зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Сургалт бол тухайн зорилгод хүрэхэд нэмэр болох ур чадварыг хүмүүст эзэмшүүлэх үйл явц бөгөөд аливаа сургалтын үйл явц нь

1. Сургалтын хэрэгцээг тодорхойлох (шаардлагатай байгаа ур чадвар, сургалтын зорилго, агуулга, хүрэх үр дүнг тогтоох)
2. Сургалтыг төлөвлөх (хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, суралцагчдын суурь мэдлэгийг үнэлэх, сургалтын аргыг сонгох)
3. Сургалтыг хэрэгжүүлэх (хичээлийн хуваарь гаргах, сургалтыг явуулах)

4. Сургалтыг дүгнэх (сургалтын үр дүнг хэмжих, зорилго ба хүрэх үр дүнтэй харьцуулах) гэсэн үе шатуудыг дамжиж хэрэгжинэ⁵⁶.

Өөрөөр хэлбэл сургалтын үйл ажиллагааг удирдах үйл явц нь түүний хэрэгцээг тодорхойлохоос эхэлдэг. Сургалтын хэрэгцээнд үндэслэн сургалтын хөтөлбөр тодорхойлогддог байна.

“Хэрэгцээ” хэмээх ойлголтыг Монгол хэлний их тайлбар толинд “Хэрэгцээ гэж амьд бие, бие хүн, нийгмийн бүлэг, бүхэл нийгмийн оршин амьдрахад зайлшгүй ямар нэгэн юмыг шаардах шаардлага юм” гэж, Бизнесийн толь бичиг /businessdictionary.com/-т, “A motivating force that compels action for its satisfaction” буюу монгол хэлэнд орчуулбал, “Сэтгэл ханамжийг бий болгохын төлөөх үйлдлийг сэдэлжүүлэх хүч” гэж, харин эдийн засгийн ухааны сурах бичигт “Хэрэгцээ гэж хүний хангагдаагүй хүсэл, шаардлагыг хэлнэ.” гэх мэтээр тодорхойлжээ.

Эндээс аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээ гэдэг нь байгууллага өөрийн нөхцөл байдалдаа тохируулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшихтэй холбоотой хүсэл, шаардлага гэж ойлгогдож байна.

Сургалтын хэрэгцээг оновчтой тодорхойлох нь ихээхэн чухал юм. Учир нь хэрэгцээ нь сургалтын үндэслэл, нөлөөлөх хүчин зүйлс, шаардлагыг тодорхойлохоос гадна ямар төрлийн сургалтыг хийх шаардлагатай болохыг тогтоож өгнө.

Сургалтын хэрэгцээг маш олон төрлийн арга, хандлагаар тогтоодог боловч аль нь ч байсан эцсийн дүндээ


1. Сургалтын агуулга нь юу вэ?
2. Сургалтанд оролцогч нь хэн бэ? гэсэн 2 зүйлийг л тодорхой болгож өгнө⁵⁷.

ААНБ-д явуулах гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг тодорхойлох аргазүйн хүрээг дараах байдлаар тодорхойллоо.

Энэ хүрээнд сургалтын агуулгатай холбоотой хэрэгцээг ААНБ-д гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой хуулиар хүлээсэн ямар шаардлага тавигдаж байгаа, түүнчлэн энэ шаардлагын дагуу ямар чиг үүргийг тухайн аж ахуйн нэгж байгууллага нь гүйцэтгэх ёстой вэ гэсэн асуудлын хүрээнд авч үзсэн бол сургалтын оролцогчтой холбоотой хэрэгцээг ажилтанд гамшгаас хамгаалахтай холбоотой болон байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой ямар мэдлэг, ур чадвар шаардагддаг болон хэнд сургалт явуулах нь зүйтэй вэ гэсэн асуудлын хүрээнд тодорхойлсон.

⁵⁶ <https://businessjargons.com/training-process.html>

⁵⁷ <https://www.atdla.org/LearningProE-Zine/702237>



Зураг 1. ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулах хэрэгцээг тодорхойлох хүрээ

ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулах хэрэгцээг тодорхойлох хүрээнд авч үзсэн эдгээр асуудлыг дараах байдлаар ойлгож болох байна.

ААНБ-д тавигдаж буй гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой шаардлага

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтныг гамшгаас хамгаалах олон талт үйл ажиллагааны чиглэлээр сургаж, дадлагажуулах шаардлага байдаг. Энэхүү шаардлагыг гамшгаас хамгаалах менежментийн үзэл баримтлалын хүрээнд болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн **34 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдийн эрх, үүргийн хүрээнд авч үзлээ.**

Хүснэгт 1. Аж ахуйн нэгж, байгууллагад гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага

Үйл ажиллагаа	Гамшгаас хамгаалах арга хэмжээ	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
1.Гамшгийн эрсдэлийг бууруулах	Эрсдэлийн үнэлгээ хийх	34.1.2.Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөгөө авах. 34.2.5.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;
	Гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн бус арга хэмжээ	
2.Бэлэн байдлыг хангах	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах	34.2.1.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх; 34.2.3.Үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах; 34.2.4.Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;
	Гамшгаас хамгаалах сургалт, дадлага, сургуулилт явуулах	
	Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл бэлтгэх	
	Гамшгаас хамгаалах талаарх эрхзүйн баримт бичиг гаргах	
	зарлан мэдээлэх дохиогоор ажиллах	
Аюулгүй амьдрах зан үйлийг хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх		
3. Эрэн хайх,	Холбоо, зарлан мэдээлэл зохион	34.1.1.Гамшгаас хамгаалах талаар авч

аврах	байгуулах Нүүлгэн шилжүүлэх Эрэн хайх, аврах ажил явуулах	хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах; 34.2.7.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшиг болон аюулын нөхцөл байдлын тухай мэдээг дээд шатны байгууллага болон онцгой байдлын байгууллагад цаг тухайд нь хүргэх, шаардлагатай бичиг баримт, бодит мэдээллээр хангах;
4. Хор уршгийг арилгах	Нөөц хангалтыг зохион байгуулах Аюулгүй байдал хангах, Үйл ажиллагааны тогтвортой байдлаа хангах	34.2.6.Гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах; 34.2.8.Гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах;
5. Сэргээн босгох	Үйл ажиллагаагаа дахин сэргээх дэд бүтэц, барилга, байгууламжийг сэргээх, шинээр барих	34.2.9.Гамшгийн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх.

Эндээс ААНБ нь гамшгийн өмнө, гамшгийн үед болон гамшгийн дараах бүхий үе шатуудад байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлээр олон тооны арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байгаа нь харагдаж байна.

ААНБ-ын хувьд гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүрэг

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-д зааснаар төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх ба энэ төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг тухайн аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд гүйцэтгэх үүрэгтэй байдаг.

Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын хүрээнд ААНБ-ын ажилтнууд гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой ямар үүрэг гүйцэтгэх ёстойг тодорхойлсон.

ААНБ-ын гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь байгууллагын ажилтан, алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг гамшгийн аюулаас авран хамгаалах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, гамшгийг хохирол багатай даван туулах, сэргээн босгох, иргэдэд үйлчилгээгээ тасралтгүй олгох зорилго бүхий удирдлагын баримт бичиг юм. Эдгээр төлөвлөгөөнд туссан ажлыг хэрэгжүүлэхийн тулд байгууллагын салбар нэгж, хувь хүн бүр ямар үүрэг оролцоотой байхыг авч үзье.

1. Байгууллагын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд ажилтны гүйцэтгэх үүрэг нь:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг авах
- Хүн нэг бүрийн үүргэвч бүрдүүлэх

- Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах
 - Аюулгүй талбайд цугларах
 - Нүүн шилжих
 - Гамшгаас хамгаалах багаж хэрэгслийг бүрдүүлэх, ажиллуулах
2. Байгууллагад ямар нэг аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед ажилтны гүйцэтгэх үүрэг нь:
- Зарлан мэдээлэл дамжуулах, зарлан мэдээллээр ажиллах
 - Аюулгүй цэгт цугларах
 - Амь нас, эрүүл мэндээ хамгаалах
 - Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх
 - Шуурхай штаб, бүлэг байгуулах, зохих шийдвэрийг шуурхай гаргах
 - Ажилтнуудыг зохион байгуулах, хуваарилах
 - Хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх
 - Мэдээ, мэдээлэл цуглуулах, дамжуулах, түгээх
 - Шаардлагатай багаж хэрэгслийг ажиллуулах
 - Шаардлагатай хүмүүсийг хүнс, ус, орон байраар хангах
3. Аливаа гамшиг, ослын дараа ажилтны гүйцэтгэх үүрэг нь:
- Түр цугларах талбайд гарах, бусдыг аюулгүйгээр гаргах
 - Шаардлагатай бол нүүлгэн шилжүүлэх
 - Шаардлагатай хангалтыг зохион байгуулах
 - Ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ хийх
4. Байгууллагын тогтвортой ажиллагааг хангах чиглэлээр ажилтны гүйцэтгэх үүрэг нь:
- Нэн чухал үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ажилтнууд бие биенээ орлон ажиллах
 - Хувилбарт байршилд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, ашиглах
 - Харилцагч талууд (түншүүд, ханган нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч, үйлчлүүлэгч)-тай холбоо тогтоох, мэдээлэл дамжуулах, харилцах

ААНБ-ын ажилтнуудад гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотойгоор эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар

ААНБ-д явуулах гамшгаас хамгаалах сургалтад тавигдах шаардлага, гүйцэтгэх үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тухайн байгууллагын ажилтнууд олон төрлийн мэдлэг, дадлага, чадварыг эзэмшүүлсэн байх ёстой. Энэхүү мэдлэг, дадлага, чадварыг ажилтанд гамшгаас хамгаалах сургалтын олон төрөл хэлбэрийг ашиглан олгож болно.

Гамшгаас хамгаалах сургалтын дараах төрлүүд байж болно. Тухайлбал, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үндсэн чиглэлээр нь:

- Удирдлага, зохион байгуулалтын сургалт
- Дадлагажуулах буюу дадлага эзэмшүүлэх сургалт
- Харилцан ажиллагааг хангах, зохицуулах сургалт
- Мэргэшүүлэх сургалт гэж ангилж явуулж болно.

Удирдлага, зохион байгуулалтын сургалт нь төрийн болон төрийн бус байгууллагын удирдах бүрэлдэхүүн, ажилтнуудыг гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, гамшгийн үед удирдлагын зөв шийдвэр

гаргах тусгай ажил үүргийг гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх зорилгоор явагдана.

Дадлагажуулах буюу дадлага эзэмшүүлэх сургалтыг гамшгийн үед шуурхай удирдлагаар хангах, аврах ажил, эмнэлгийн тусламж болон бусад яаралтай тусламж үзүүлэх, холбоо зохион байгуулах, гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх ажил үүргийг гүйцэтгэх төрийн болон төрийн бус байгууллагын удирдах бүрэлдэхүүн, ажилтнуудад явуулдаг.

Харилцан ажиллагааг хангах, зохицуулах ажилд дадлагажуулах сургалтыг байгууллагууд өөрсдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны харилцан ажиллагааг хангах, уялдуулан зохицуулах, гамшгийн үе дэх харилцан ажиллагааг хангах зорилгоор хийнэ.


Мэргэшүүлэх сургалт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаагаар зохих мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилготой.

Эдгээр төрлүүдийг тухайн сургалтанд хамрагдах бүрэлдэхүүний сургалт явуулах шаардлага, хэрэгцээнд үндэслэн дангаар болон хослуулах байдлаар зохион байгуулж болно.

Гамшгаас хамгаалах сургалтыг танхимын сургалт болон дадлагын дараах хэлбэрээр буюу аргазүйгээр явуулж болно. Үүнд:

- Богино хугацааны сургалт - семинар
- Урт хугацааны сургалт -воркшоп
- Ширээний дасгал
- Сургалтын тоглолт
- Дадлага сургуулилт
- Чиг үүргийн дадлага
- Иж бүрэн сургуулилт

Сургалтын эдгээр хэлбэрүүдээр олгох мэдлэг, чадварын хүрээ, шаардагдах нөөцийн логик уялдаа холбоог дараах бүдүүвчээр харуулав.



Зураг 2. Гамшгаас хамгаалах сургалтын төрөл

Хэлэлцүүлэгт суурилсан сургалтын төрөл

1.Семинар

Семинар буюу богино хугацааны сургалт нь гол төлөв 90 минутаас 3 цаг үргэлжилдэг ба сургалтын арга зүйн хувьд лекц хэлбэр давамгайлдаг, оролцогчид асуулт асуух төдийхнөөр сургалтад оролцох оролцоо нь хязгаарлагдана.

2. Воркшоп буюу урт хугацааны сургалт

Воркшоп буюу урт хугацааны сургалт нь ихэвчлэн 1 -ээс 2 өдөр үргэлжилнэ. Энэ сургалтанд лекц болон багаар ажиллах сургалтын арга зүйг хослуулан хэрэглэнэ.

Ажиллагаанд суурилсан сургалт төрөл

3.Ширээний дасгал

Ширээний дасгал ажлаар оролцогчид гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой ямар асуудал, сул талууд учирч болохыг нэг бүрчлэн хэлэлцэж дүгнэлт гаргадаг. Энэ дасгал ажлыг зохицуулагч чиглүүлж хийнэ. Ширээний дасгал ажлын туршид чиглүүлэгч гамшгаас хамгаалах үйл ажиллагааны аль нэгэн нөхцөл байдал, үзэгдлийг тодорхойлж өгч, оролцогчдоос ийм нөхцөл үүсэх үед хэрхэн шийдвэрлэх тухай асуултыг асууж чиглүүлж ажиллана. Ингэснээр оролцогчид өөрсдийн чиг үүргээ мэдэж авдаг. Ширээний дасгалын үед оролцогчид цагийн хязгаартай, бодит байдалтай харьцуулахад дарамтгүй нөхцөлд ажилладаг.

4. Чиг баримжаа олгох дасгал/хэлэлцүүлэг

Чиг баримжаа олгох дасгал нь гол төлөв албан бус хэлэлцүүлэг хэлбэрээр явагдах ба оролцогчдод төлөвлөгөө, чиг үүрэг болон шуурхай ажиллагааны дүрмийг танилцуулахад чиглэгддэг. Энэ дасгал ажил нь хэлэлцүүлгээр сайжруулах шаардлагатай асуудлыг олж тогтоох зорилготой. Чиг баримжаа олгох дасгалыг үүссэн нөхцөл байдал болон тухайлсан судалгаа /кейс судалгаа/-нд төвлөрч хэлэлцүүлэг хэлбэрээр явуулна.

5.Дадлага сургуулилт

Тодорхой хяналт, удирдлагын дор тухайлсан нэг гамшгаас хамгаалах үйл ажиллагаа эсвэл чиг үүргээр дадлага хийх ба шалгах арга. Оролцогчдод бодит байдлыг дуурайлган үзүүлсэн нөхцөлд дадлагыг явуулбал их үр дүнтэй. Дадлагын бэлтгэл ажлыг төлөвлөх болон дадлагыг гүйцэтгэх хугацаа нь шалгаж байгаа арга хэмжээ болон чиг үүрэг, оролцогчид, явуулах байрлалаас хамаарна.

6.Чиг үүргийн дадлага, сургуулилт

Энэ сургууль нь хор уршгийг арилгах арга хэмжээ авах шаардлагатай цагийн байдлыг өгч гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй алба хаагчдын ур чадварыг шалгах ба дадлагажуулах арга хэмжээ юм. Аль нэг чиг үүрэг ба үйл ажиллагааг шалгадаг дадлагаас ялгаатай нь энэ сургуулилтаар тухайн нөхцөл байдалд хор уршгийг арилгах хүрээнд үүрэг хүлээсэн ажилтнууд хамтдаа хийх бүхий л арга хэмжээг бодит байдалд ойртуулсан нөхцөлд хэрэгжүүлж шалгадаг. Үүнийг команд штабын сургууль гэж бас нэрлэдэг.

7.Иж бүрэн сургуулилт

Иж бүрэн сургуулилт нь бодит гамшгийн нөхцөл байдалтай ойртуулсан хэлбэрээр явагдах цагийн байдалд суурилсан арга хэмжээ юм. Энэ үед Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан бүх талууд оролцож гамшгийн нөхцөл байдал

үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах тоног төхөөрөмжийг бүрэн ажиллуулж явагдана. Энэ сургуулиар хор уршгийг арилгах ажиллагааны чадавхыг бүрэн хэмжээгээр шалгана.

ААНБ-ын хэмжээнд гамшгаас хамгаалах сургалтанд хамрагдвал зохих бүрэлдэхүүн

Сургалт явуулах хэрэгцээг үнэлэх хүрээнд авч үзвэл зохих чухал асуудал бол сургалтанд оролцох бүрэлдэхүүнийг тодорхойлох юм.

Гамшгаас хамгаалах сургалтыг оролцох бүрэлдэхүүнээр нь:

- Хүн нэг бүрийн сургалт
- Бие бүрэлдэхүүний сургалт гэж ангилна.

ААНБ-д тавигдаж буй гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой шаардлага, ажилтнуудын гүйцэтгэх үүрэг, ур чадвар олгох сургалтын төрлөөс харахад байгууллагын хувьд ажилтнуудаа олон чиглэлээр сургаж дадлагажуулах хэрэгцээ байгаа нь тодорхой байна.

Ийм учраас сургалтанд хамрагдвал зохих бүрэлдэхүүнийг тодорхойлох, тэдгээртэй сургалт явуулах шаардлага, хэрэгцээг тогтоохын тулд хамгийн түрүүнд тухайн байгууллага, тэдгээрийн бие бүрэлдэхүүний үндсэн мэдлэг, ур чадварыг урьдчилан тооцох хэрэгтэй. Үүний үр дүнд сургалтанд хамрагдвал зохих бүрэлдэхүүн тодорхойлогдоно.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд салбар нэгж, хувь хүн ямар үүрэг оролцоотой байх, эдгээр төлөвлөсөн ажлуудыг хэн, хэрхэн гүйцэтгэхийг урьдчилан тогтоосон байх шаардлага гардаг.

1.2. ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулж буй өнөөгийн байдал, туршлага, сургамжид хийсэн шинжилгээ

1.2.1. Гамшгаас хамгаалах сургалтыг ААНБ-д явуулж ирсэн туршлага, сургамж

Гамшгаас хамгаалах сургалтын түүхэн хөгжил, туршлага, сургамжийг сургалтын зорилго, агуулгын хувьд ард иргэдийг аливаа аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд сургах, олон нийтийг идэвхитэй оролцуулж эхэлсэн, Монгол улсад Иргэний хамгаалалтын байгууллага үүсэх урьтач нөхцлийг бүрдүүлж өгсөн 1930-аад оноос эхлэн судаллаа.

БНМАУ-ын Засгийн газрын 1930 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 40 дүгээр хурлын тогтоолоор Улсын батлан хамгаалах зөвлөлийн харьяанд Монгол Улсыг хамгаалах явдалд туслах эвлэлийг байгуулж, эвлэлийн дүрмийг хэлэлцэн Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраар батлуулсан байна.

Дүрмийн 3.6-д “Агаарын ба хорт зайн хүчнээс улсыг хэрхэн хамгаалах явдалд эвлэлийн гишүүдийг боловсруулах сургалтыг нэвтрүүлэхээр...” гэж заасан нь Монгол Улсын Иргэний хамгаалалтын сургалтын эхлэл тавигдах үндэслэл болсон юм.

1940-өөд оноос Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын Төв хорооны Тэргүүлэгчид, 1950-иад оноос Төв хорооны Улс төрийн товчоо, Сайд нарын Зөвлөл, Цэргийн яам, Батлан хамгаалах хөдөлмөр нийгэмлэгийн Төв Зөвлөл эх оронд учирч болзошгүй аюул, ялангуяа үйл олноор хөнөөх зэвсгийн хор хөнөөлөөс хамгаалахад **албан байгууллага**, ард иргэдээ сурган бэлтгэлтэй байлгахад

анхаарч, шат дараатай арга хэмжээнүүдийг авч байсан байна. Үүний нэг жишээ нь 1959 оноос эхлэн ЗХУ-аас бэлгийн журмаар үй олноор хөнөөх зэвсгийн хөнөөл, түүнээс хамгаалах аргын тухай сургалтын кино авч хот, хөдөөд хөдөлмөрчдөд үзүүлж байсан байна.

МАХН-н Төв хорооны тогтоолоор 1957 онд Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг гэдэг олон нийтийн байгууллагыг байгуулснаар нийт хөдөлмөрчдийг цэргийн ерөнхий мэдэгдэхүүнтэй болгох, болзошгүй атом, химийн дайны үед хамгаалах арга хэмжээнд сургах, цэрэгжүүлсэн техник-спортыг хөгжүүлэх, түүнд олон нийтийг өргөн хамруулж байхаар тогтоолд заасан ба эдгээр арга хэмжээ нь бүх нийтийн хэрэг болсон иргэний хамгаалалтын бөгөөд одоогийн гамшгаас хамгаалах сургалтын эх суурь болсон гэж үзэж болно.

Тухайн үеийн Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1958 оны 93 дугаар тогтоолд атом, устөрөгчийн зэвсэг, түүний хор хөнөөлөөс **албан газар**, хүн амыг хамгаалах тухай болон сургуулиудад программт хичээлээс гадуур мэдлэг олгох арга хэмжээ авахыг зааж байсан бол 1961 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 289 дүгээр тогтоолд **“Ажилчин, албан хаагчид, нийт хөдөлмөрчдийг** агаарын довтолгооноос хамгаалах зорилгоор ард иргэдийг атом, химийн ба бактериологийн зэвсгийн хор хөнөөлийг устгах, тэдгээрийн дайралтад орсон газар зэргийг ариутган цэвэрлэх, нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн туслалцаа үзүүлэх мэдэгдэхүүнтэй болгох талаар хүчтэй ажил зохиох” гэж тусгажээ.

Иргэний хамгаалалтын алба үүссэн 1964 оноос эхлэн сургалт, ухуулга сурталчилгааны ажил нь хүмүүсийг аль болох өргөнөөр оролцуулах, тэдэнд орчин үеийн хөнөөлт зэвсэг, түүнээс хамгаалах аргыг тодорхой ойлгуулах зорилгоор **үйлдвэр, албан газар**, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, сургууль, соёлын бүх байгууллага, тасаг, цех, бригадуудад иргэний хамгаалалтын булан, танхим байгуулж байсан байна. Мөн “Улс орныг батлан хамгаалах ба ардын армийн дайчин замналыг сурталчлах” сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 1970, 1980-аад онд “Батлан хамгаалах зорилтыг сурталчлах сарын ажил” болон өргөжиж, дээрх ажилд иргэний хамгаалалтын ухуулга сурталчилгааны ажил давхар явагдаж байлаа. 1970 он гэхэд сурталчлах сарын ажлын хугацаанд **64 байгууллагын 25800 гаруй хүнийг** хамруулан иргэний хамгаалалтын сэдвээр лекц уншсан байна.

Батлан хамгаалах яамны орлогч сайд, Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 1984 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 130 дугаар хамтарсан тушаалаар **“Ажилчин, албан хаагчид, малчид, тариаланчдыг иргэний хамгаалалтын талаар заавар, программ, норматив”**-ыг батлуулж, 3 жилийн хугацаатай 20 цагийн шаталсан сургалтыг дараах байдлаар явуулдаг байсан байна. Үүнд:

Эхний жилд цөм, хими, биологийн зэвсгээс хамгаалах үндэс, напалм /шатаагч бодис-П.Д/, вакумын болон бутрагч бөмбөг зэрэг шинэ төрлийн зэвсгийн аюулаас хамгаалах тухай, шархдах, түлэгдэх, гэмтэж бэртэх үед өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх;

Хоёр дах жилд улс ардын аж ахуйн тогтвортой ажиллагааг дээшлүүлэхэд ажилчин, албан хаагчдын үүрэг, хүнсний зүйл, тэжээл, ус хамгаалах аргууд, орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний байруудад гэрэл өнгөлөн далдлах болон хүүхэд хамгаалах зэрэг сэдвүүд үзэх;

Гурав дах жилд хүчтэй үйлчилгээтэй хорт бодисоос хамгаалах арга /зөвхөн хотын хүн амд/, байгалийн гэнэтийн аюулын үед ажиллах журам, улс ардын аж ахуйн объектод гарсан үйлдвэрлэлийн ослын үед ажиллах журам, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай зэрэг сэдвүүдийг судлах.

Сургалтын зохион байгуулалтын хувьд объектын ажилчин, албан хаагчид 30-40 хүнтэй бүлгээр ажлын бус цагаар хичээллэдэг байсан юм.

Батлан хамгаалах яамны орлогч сайд, Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 1988 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 98 дугаар хамтарсан тушаалаар **“Ажилчин, албан хаагчдыг иргэний хамгаалалтад сургах заавар”**-ыг шинэчлэн баталсан бөгөөд 4 жилийн өмнөх заавартай харьцуулахад хөтөлбөрийн багтаамж 10 цаг болж багасч, агуулга нь бүхэлдээ үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах зорилготой биш, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос хамгаалах арга эзэмшихэд чиглэгдсэн онцлогтой болсон байна.

Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 1992 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 120 тоот тушаалаар **“Иргэний хамгаалалтын сургалтыг зохион байгуулах чиг баримтлал”**-ыг батлан, сургалтын хөтөлбөрийн шинэчилсэн бөгөөд уг баримт бичигт Монгол Улсын Иргэний хамгаалалтын сургалтад хамрагдах бүрэлдэхүүнийг дараах байдлаар ангилан авч үзсэн байна. Үүнд:

- Удирдах бүрэлдэхүүний
- Мэргэжлийн ангийн
- **Ажилчин, албан хаагчдын**
- Оюутан, сурагчдын
- Ард иргэдийн
- Малчид, тариаланчдын
- Гэрийн ажилтай хүмүүсийн.

Дээрх бүрэлдэхүүнээс ажилчин, албан хаагчдын сургалтыг дараах агуулгаар явуулж байсан байна. Үүнд:

- Үүргээ судлах
- Мэргэжлийн ангийн бүлэгт орох бэлтгэл хийх
- Нүүлгэн шилжүүлэх, тараан байрлуулахад гүйцэтгэх үүргэд суралцах
- Хордсон газар орныг туулах, ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжилт, идэвхжил сулруулалтын дадлага сургууль хийх
- Өөртөө болон нөхөртөө эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхэд суралцах
- Команд штабын сургууль, үзүүлэх болон иж бүрэн сургуульд оролцох
- Зарлан мэдээлэл дамжуулах.

1.2.2. Гамшгаас хамгаалах сургалтыг ААНБ-д явуулж буй өнөөгийн байдал

Манай улсад одоогоор гамшгаас хамгаалах сургалтыг

1. Удирдах албан тушаалтны;
2. Онцгой байдлын байгууллагын;
3. Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн;
4. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны;
5. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн;

6. Иргэний гэсэн зорилтот 6 бүлэг тус бүрээр зохион байгуулж байна.

Эдгээр зорилтот бүлэг тус бүрээр гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулах сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөг ОБЕГ-ын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалаар баталж гаргасан. Уг хөтөлбөрийн 3 дугаар хавсралтад "Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө"-г тусгасан. Уг төлөвлөгөөнд ажилтан албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын зорилгыг "Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах, гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зохион байгуулах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд оршино⁵⁸" гэж тодорхойлж, энэхүү зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх
2. Болзошгүй гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийг бууруулах ойлголт, мэдлэг, чадвар олгох, гамшгийн үед өөртөө болон бусдад тусламж үзүүлэх дадлыг эзэмшүүлэх
3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах мэдлэг олгох, төлөвлөгөөний дагуу үүрэг гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэх

Сургалтын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх агуулгын хүрээг дараах цаг сэдвийн төлөвлөгөө болон сэдэвчилсэн төлөвлөгөөнд үзүүлсэн байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 2. Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын цаг, сэдвийн төлөвлөгөө

д/д	Хичээлийн нэр	Сургалт зохион байгуулах хэлбэр /цаг/		Нийт цаг
		Лекц	Дадлага	
1	Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тухай	2		2
2	Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам	2	2	4
3	Амилуулах суурь тусламж		4	4
4	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, байгууллагын гамшгаас хамгаалах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг	4	6	10
Нийт цаг		8	12	20

⁵⁸ Хөтөлбөр батлах тухай., ОБЕГ-ын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалын III хавсралт

Хүснэгт 3. Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө


Сэдэв	Дэд сэдэв	Нэгж цаг		Нийт цаг
		Лекц	Дадлага	
Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тухай	Гамшиг, Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол гэж юу вэ? Аюулт үзэгдэл, ослын төрлүүд, гамшгийн ангилал	1		2
	<i>Дэлхийд болон Монгол Улсад тохиолддог гамшиг, Гамшгаас хамгаалах болон Галын аюулаас хамгаалах тухай хууль, Гамшгийн эрсдэлийн тухай ерөнхий ойлголт</i>	1		
Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам	<i>Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын суурь шалтгаанууд, нөлөөлөх хүчин зүйлс</i>	2		4
	<i>Цаг агаарын гаралтай гамшгийн эрсдэл, түүнийг бууруулах арга зам</i>		1	
	<i>Цасан болон шороон шуурга, зуд, түүнээс өөрийгөө болон өмч хөрөнгөө хамгаалах талаар</i>			
	<i>Үерийн аюул, түүнээс урьдчилан сэргийлэх арга</i>			
	Ган, цөлжилтэй тэмцэх талаар		1	
	Аянганы аюулаас сэргийлэх талаар			
	Геологийн гаралтай гамшиг, газар хөдлөлт хөрсний гулсалт			
	Биологийн гаралтай гамшиг хүний болон мал, амьтны гаралтай халдварт өвчний талаар		1	
	Халдварт өвчний голомтонд ариутгал, халдваргүйтгэл хийх хөл хорио тогтоосон захирамжийг баримтлах тухай			
Амилуулах суурь тусламж	Цус алдалт, цусыг түр тогтоох арга		2	4
	Яс хугарах, үе мултарсан үед тусламж үзүүлэх		1	
	Түлэгдэлтийн 4 зэргийн тухай болон анхны тусламжийг хэрхэн үзүүлэх талаар		1	
	Хөлдөлт, осголтын үед үзүүлэх анхны тусламж			
	Усанд живсэн хүнд анхны тусламж үзүүлэх			
Гамшгаас хамгаалах төлөвлөлт, байгууллагын гамшгаас хамгаалах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, төлөвлөгөөний бүтэц	1		10
	Үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол			
	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөлтөд анхаарах зүйлс	1	1	
	Зарлан мэдээлэл, дуут дохиогоор цугларах		1	
	Нүүлгэн шилжүүлэх журам	1		
	Эрэн хайх аврах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо		4	
Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг турших, төлөвлөгөөнд тодотгол хийх, нэмэлт өөрчөлт оруулах	1			
Нийт цаг		8	12	20

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан агуулгад шинжилгээ хийж үзвэл ерөнхий багц сэдэв нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны орчин үеийн үзэл баримтлалд нийцэж байгаа хэдий ч дэд сэдвийн хүрээнд авч үзсэн агуулга нь сэдвийн гүнзгийрэлт байхгүй, манай оронд хамгийн түгээмэл гардаг гал түймрийн эрсдэлийг бууруулах асуудлыг орхигдуулсан зэрэг дутагдалтай талууд харагдаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хууль⁵⁹-д зааснаар энэхүү цаг сэдвийн хүрээнд хийгдэх хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн дарга, захирал хариуцан, жил бүр зохион байгуулж явуулна.

ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Сургалтын хэлтсийн мэдээгээр гамшгаас хамгаалах ААНБ-ын ажилтны сургалтыг сүүлийн 5 жилд аймгуудын хэмжээнд жилд дунджаар 55 удаагийн сургалтад 2500 гаруй хүнийг хамруулж, улсын хэмжээнд жилд дунджаар 78 удаа явуулж, 4000 орчим ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан байна (Хүснэгт 4).

Сүүлийн 5 жилийн сургалтын мэдээллийн дунджаас харахад ААНБ-ын ажилтан, албан хаагчдын гамшгаас хамгаалах сургалтыг аймаг, нийслэлд харилцан адилгүй явуулж байгаа ба (Зураг 3) Орхон, Дархан-Уул, Хэнтий, Өвөрхангай, Булган аймгууд улсын дундаж (55 удаа)-аас олон удаа уг сургалтыг зохион байгуулсан байна.




Зураг 3. ААНБ-д явуулсан гамшгаас хамгаалах сургалтын тоо, аймгаар (5 жилийн дундаж)

⁵⁹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.7 дахь заалт

Хүснэгт 4. ААНБ-д явуулсан гамшигаас хамгаалах сургалтын мэдээ (Эх үүсвэр: ОБЕГ-ын Гамшигаас урьдчилан сэргийлэх газар)

№	Он	2015			2016			2017			2018			2019.09 сар			нийт			дунджаар	
		Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүний тоо	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүний тоо	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүний тоо	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүний тоо	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүний тоо	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүний тоо	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо
1	Архангай	58	119	2895	58	119	2895	51	128	2968	44	117	2140	36	69	703	247	552	11601	52	2442
2	Баянхонгор	48	100	6576	48	100	6576	19	27	4900	38	100	1065	15	16	164	168	343	19281	35	4059
3	Баян-Өлгий	40	82	980	40	82	980	33	92	844	30	97	803	19	60	943	162	413	4550	34	958
4	Булган	54	89	1386	54	89	1386	61	86	1074	114	114	1607	24	31	521	307	409	5974	65	1258
5	Говь-Алтай	28	26	873	28	26	873	49	98	1385	52	104	2826	40	82	2506	197	336	8463	41	1782
6	Говь-Сүмбэр	61	85	1165	61	85	1165	46	74	1087	57	99	1443	21	43	451	246	386	5311	61	1118
7	Дархан-Уул	81	96	2443	81	96	2443	96	12	2459	159	226	4781	117	133	2492	534	563	14618	112	3077
8	Дорноговь	80	23	1464	80	126	1464	25	25	475	73	146	1910	35	39	731	293	359	6044	62	1272
9	Дорнод	54	108	4263	54	108	4263	14	20	845	68	-	1959	43	77	1097	233	313	12427	49	2616
10	Дундговь	32	86	2927	61	116	2927	43	50	800	27	54	574	16	25	346	179	331	7574	38	1594
11	Завхан	22	43	1566	22	43	911	64	24	1498	110	366	5607	67	368	5016	285	844	14598	60	3073
12	Орхон	52	106	1285	52	106	1285	447	690	7749	32	22	2880	68	128	1853	651	1052	15052	137	3169
13	Өмнөговь	16	48	1780	16	48	780	22	38	565	31	72	683	18	26	335	103	232	4143	22	872
14	Өвөрхангай	66	132	6583	166	332	6583	128	512	4040	88	258	4868	44	83	914	492	1317	22988	103	4839
15	Сүхбаатар	32	46	1293	32	46	1293	96	138	1180	54	108	1379	26	43	753	240	381	5898	50	1242
16	Сэлэнгэ	10	28	8572	10	28	8572	17	34	507	37	74	978	30	62	853	104	226	19482	22	4101
17	Төв	23	39	2536	23	39	2536	20	20	392	24	116	1400	96	89	12295	186	303	19159	39	4033
18	Увс	5	28	1308	5	28	308	16	32	160	61	184	1510	16	39	391	103	311	3677	22	774
19	Ховд	7	28	201	7	28	201	3	12	80	37	111	1102	28	73	907	82	252	2491	17	524
20	Хөвсгөл	52	10	1661	52	10	1211	49	98	3400	-	110	4887	19	38	427	172	266	11586	36	2439
21	Хэнтий	96	25	1341	96	25	1341	96	144	2208	155	308	29523	61	61	2291	504	563	36704	106	7727
22	Улаанбаатар	310	493	23577	310	560	23577	568	568	20356	904	1207	63582	585	877	43517	2677	3705	174609	563	36760
Нийт		1227	1840	76675	1356	2240	73570	1963	2922	58972	2195	3993	137507	1424	2462	79506	8165	13457	426230	1726	89729
Аймгийн дундаж		44	64	2528	50	80	2381	66	112	1839	65	139	3520	40	75	1714	261	464	11982	55	2522
Улсын дундаж		56	84	3485	62	102	3344	89	133	2681	105	190	6250	65	112	3614	371	612	19374	78	4079

ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Сургалтын хэлтсээс авсан Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын ААНБ-ын ажилтны сургалтын мэдээлэлд шинжилгээ хийж үзэхэд сүүлийн 5 жилд энэ ангиллын сургалтын тоо, сургалтыг явуулсан цаг тогтмол нэмэгдэж байгаа (Зураг 4) боловч сургалтанд хамрагдсан хүний тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт байхгүй байна.



Зураг 4. ААНБ-ын ажилтны ангиллаар гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулсан тоо, сургалтын цагийн мэдээ, улсын дүнгээр

Аймгуудаас ирүүлсэн мэдээллээс нэг удаагийн сургалт нь дунджаар 2 цаг үргэлжилж, 40-100 хүнийг хамруулдаг гэсэн дүр зургийг харж болохоор байна.

Хүснэгт 5. Нэг удаагийн сургалтанд ноогдох цаг, хамрагдсан хүний тоо

№	Аймаг	2015		2016		2017		2018		2019.09	
		цаг	хүний тоо	цаг	хүний тоо	цаг	хүний тоо	цаг	хүний тоо	цаг	хүний тоо
Нэг удаагийн сургалтанд ноогдох цаг, хамрагдсан хүний тоо											
1	Архангай	2	50	2	50	2.5	58	2.6	49	1.9	19
2	Баянхонгор	2	137	2	137	1.4	258	2.6	28	1	11
3	Баян-Өлгий	2	24	2	24	2.8	25	3.2	27	3.1	50
4	Булган	1.6	26	1.6	26	1.4	18	1	14	1.3	22
5	Говь-Алтай	0.9	31	0.9	31	2	28	2	54	2	63
6	Говь-Сүмбэр	1.4	19	1.4	19	1.6	24	1.7	25	2	21
7	Дархан-Уул	1.2	30	1.2	30	0.1	26	1.4	30	1.1	21
8	Дорноговь	0.3	18	1.6	18	1	19	2	26	1.1	21
9	Дорнод	2	79	2	79	1.4	60	-	29	1.8	25
10	Дундговь	2.7	91	1.9	48	1.2	19	2	21	1.6	22
11	Завхан	1.9	71	1.9	41	0.4	23	3.3	51	5.5	75
12	Орхон	2	25	2	25	1.5	17	0.7	90	1.9	27
13	Өмнөговь	3	111	3	49	1.7	26	2.3	22	1.4	19
14	Өвөрхангай	2	100	2	40	4	31	2.9	55	1.9	21
15	Сүхбаатар	1.4	40	1.4	40	1.4	12	2	25	1.6	29
16	Сэлэнгэ	2.8	857	2.8	857	2	30	2	26	2	28
17	Төв	1.7	110	1.7	110	1	20	4.8	58	0.9	128
18	Увс	5.6	262	5.6	62	2	10	3	25	2.4	24
19	Ховд	4	29	4	29	4	27	3	30	2.6	32
20	Хөвсгөл	0.2	32	0.2	23	2	69	-	-	2	22
21	Хэнтий	0.3	14	0.3	14	1.5	23	2	190	1	37
22	Улаанбаатар	1.6	76	1.8	76	1	36	1.3	70	1.5	74
Улсын дундаж		1.9	101.5	2.0	83.1	1.7	39.0	2.3	45.0	1.9	36.0

ААНБ-д явагдаж байгаа гамшгаас хамгаалах сургалтын нэгдсэн дүн мэдээнд сургалт явуулсан байгууллагын тоог авч үзэхгүй байгаа нь шинжилгээг нарийвчилж хийх боломжийг хязгаарлахад хүргэж байна.

Монгол Улсад гамшгаас хамгаалах сургалтыг ААНБ-д явуулж ирсэн түүхэн хөгжил, үе шатуудын үзэл баримтлалыг нэгтгэн авч үзвэл энэ ангиллын сургалтын үндэс суурь ард иргэд, улс ардын аж ахуйг аливаа болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилго бүхий Иргэний хамгаалалтын байгууллага үүсэх урьтач нөхцөл бүрдсэн 1930-аад оноос эхлэн тавигдсан байна. Иргэний хамгаалалтын үед буюу 1950-аад оноос энэ ангиллын сургалтын агуулга нь бүхэлдээ үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах зорилгод чиглэгдэж улмаар 1990-ээд оноос байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос хамгаалах арга эзэмшүүлэхэд чиглэгдсэн байна.

Хүснэгт 6. Гамшгаас хамгаалах сургалтыг ААНБ-д явуулж ирсэн түүхэн хөгжлийн онцлог

Үе шат	Байгууллага	Баримт бичиг	Агуулга
Эхлэл тавигдсан үе 1930-1963	Монгол Улсыг хамгаалах явдалд туслах эвлэл	БНМАУ-ын Засгийн газрын 1930 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 40 дүгээр хурлын тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг хамгаалах явдалд туслах эвлэлийн дүрэм"-ын 3.6 дахь заалт	Агаарын ба хорт зайн хүчнээс улсыг хэрхэн хамгаалах явдалд эвлэлийн гишүүдийг боловсруулах сургалтыг нэвтрүүлэх
	Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг	Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1958 оны 93 дугаар тогтоол	Атом, устөрөгчийн зэвсэг, түүний хор хөнөөлөөс албан газар , хүн амыг хамгаалах тухай болон сургуулиудад програмт хичээлээс гадуур мэдлэг олгох
		1961 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 289 дүгээр тогтоол	"Ажилчин, албан хаагчид, нийт хөдөлмөрчдийг агаарын довтолгооноос хамгаалах зорилгоор ард иргэдийг атом, химийн ба бактериологийн зэвсгийн хор хөнөөлийг устгах, тэдгээрийн дайралтад орсон газар зэргийг ариутган цэвэрлэх, нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн туслалцаа үзүүлэх мэдэгдэхүүнтэй болгох талаар хүчтэй ажил зохиох"
1964-1990	Иргэний хамгаалалтын алба	1964 оноос эхлэн сургалт, ухуулга сурталчилгааны ажил	Орчин үеийн хөнөөлт зэвсэг, түүнээс хамгаалах аргыг тодорхой ойлгуулах зорилгоор үйлдвэр, албан газар , хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, сургууль, соёлын бүх байгууллага, тасаг, цех, бригадуудад иргэний хамгаалалтын булан, танхим байгуулах
		1970-1980-аад он "Улс орныг батлан хамгаалах ба ардын армийн дайчин замналыг сурталчлах" сарын ажлыг жил бүр зохион байгуулах	Энэ ажлын хүрээнд Иргэний хамгаалалтын сэдвээр байгууллагуудад лекц унших
		Батлан хамгаалах яамны	Эхний жилд цөм, хими, биологийн

		<p>орлогч сайд, Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 1984 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 130 дугаар хамтарсан тушаал “Ажилчин, албан хаагчид, малчид, тариаланчдыг иргэний хамгаалалтын талаар заавар, программ, норматив”-ыг баталсан.</p> <p>/Хөтөлбөрийн багтаамж 3 жилийн хугацаатай 20 цагийн шаталсан сургалт/</p>	<p>зэвсгээс хамгаалах үндэс, напалм /шатаагч бодис-П.Д/, вакумын болон бутрагч бөмбөг зэрэг шинэ төрлийн зэвсгийн аюулаас хамгаалах тухай, шархдах, түлэгдэх, гэмтэж бэртэх үед өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх; Хоёр дахь жилд улс ардын аж ахуйн тогтвортой ажиллагааг дээшлүүлэхэд ажилчин, албан хаагчдын үүрэг, хүнсний зүйл, тэжээл, ус хамгаалах аргууд, орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний байруудад гэрэл өнгөлөн далдлах болон хүүхэд хамгаалах зэрэг сэдвүүд үзэх; Гурав дахь жилд хүчтэй үйлчилгээтэй хорт бодисоос хамгаалах арга /зөвхөн хотын хүн амд/, байгалийн гэнэтийн аюулын үед ажиллах журам, улс ардын аж ахуйн объектод гарсан үйлдвэрлэлийн ослын үед ажиллах журам, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай зэрэг сэдвүүдийг судлах.</p>
		<p>Батлан хамгаалах яамны орлогч сайд, Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 1988 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 98 дугаар хамтарсан тушаалаар “Ажилчин, албан хаагчдыг иргэний хамгаалалтад сургах заавар”-ыг шинэчлэн баталсан /Хөтөлбөрийн багтаамж 10 цаг болсон/</p>	<p>Сургалтын агуулга нь бүхэлдээ үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах зорилготой биш, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос хамгаалах арга эзэмшихэд чиглэх</p>
1990-2003		<p>Улсын иргэний хамгаалалтын газрын газрын даргын 1992 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 120 тоот тушаалаар “Иргэний хамгаалалтын сургалтыг зохион байгуулах чиг баримтлал”-ыг баталсан</p>	<p>Сургалтын агуулга нь -Үүргээ судлах -Мэргэжлийн ангийн бүлэгт орох бэлтгэл хийх -Нүүлгэн шилжүүлэх, тараан байрлуулахад гүйцэтгэх үүргэд суралцах -Хордсон газар орныг туулах, ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжилт, идэвхжил сулруулалтын дадлага сургууль хийх -Өөртөө болон нөхөртөө эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхэд суралцах -Команд штабын сургууль, үзүүлэх болон иж бүрэн сургуульд оролцох</p>

			-Зарлан мэдээлэл дамжуулах
2003-2017	Онцгой байдлын ерөнхий газар	ОБЕГ-ын даргын 2007 оны 02 дугаар сарын 9-ны 81 тоот тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөр /Хөтөлбөрийн багтаамж 27 цаг/	
		ОБЕГ-ын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөр	Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тухай Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам Амилуулах суурь тусламж Гамшгаас хамгаалах төлөвлөлт, байгууллагын гамшгаас хамгаалах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг

ААНБ-д явуулж ирсэн гамшгаас хамгаалах сургалтын зорилго, агуулга нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үзэл баримтлалын шинэчлэл, цаг үеийн шаардлагад нийцэж улам бүр боловсронгуй болсоор иржээ. Тухайлбал, иргэний хамгаалалтын хөгжлийн эхэн 1930-1940-оод он болон цэцэглэн хөгжлийн үед буюу 1950-1980-аад оныг хүртэл дан ганц үйл олноор хөнөөх зэвсгийн хөнөөлөөс хамгаалахад чиглэж байгаад 1990-ээд оноос байгалийн гамшиг бусад болзошгүй ослын аюулгүй байдлыг хангахад улмаар 2003-2016 онд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх агуулгад, 2017 оноос гамшгийн эрсдэлийг бууруулах агуулгаар сургалт явагдах болсон.

Одоогийн мөрдөгдөж буй ажилтан, албан хаагчдын сургалтын төлөвлөгөөнд болзошгүй гамшгийн төрөл бүрээр эрсдэлийг бууруулах мэдлэг чадвар олгохоос гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний дагуу үүрэг гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэхийг чухалчлан үзсэн байгаа нь гамшгаас хамгаалах салбарын үзэл баримтлалын шинэчлэлтэй зохих түвшинд нийцэж байна.

ААНБ-д явуулж буй гамшгаас хамгаалах сургалтын түүхэн хөгжил, өнөөгийн байдлаас харахад бүхий л цаг үед энэ ангиллын сургалтыг хэрхэн өгөөжтэй болгох вэ, суралцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтыг хэрхэн явуулах вэ, бодит чадвар олгох нөхцөл бүхий сургалтын орчинг хэрхэн бүрдүүлэх вэ гэсэн бэрхшээлүүд тулгарч түүнийгээ тухайн цаг үедээ нийцүүлэн шийдвэрлэх оролдлогыг хийсээр иржээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫГ ЯВУУЛАХ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛ

2.1. Аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээ, сургалтад тавигдах шаардлагыг тодорхойлох шинжилгээ

Түүврийн ерөнхий мэдээлэлд хийсэн шинжилгээ


Аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг асуулгын судалгааны аргаар тодорхойллоо. Судалгаанд Улаанбаатар хотын 7 дүүргийн төрийн болон хувийн хэвшлийн, төрийн бус, олон улсын гэсэн нийт 89 байгууллагын 293 ажилтан оролцсон (Хүснэгт 4). Асуулгын судалгааг нэг байгууллагаас удирдах ажилтан, энгийн ажилтан болон тухайн байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хариуцсан ажилтан гэсэн 3 хүнээс авсан. Судалгааны асуулгын хуудас (Хавсралт 2) болон судалгаанд оролцсон байгууллагын нэр, ажилтны тоо (Хавсралт 3)-г хавсралтад дэлгэрэнгүй оруулав.

Хүснэгт 7. Судалгаанд оролцсон түүврийн мэдээлэл, дүүрэг ба байгууллагын төрлөөр

Оролцсон хүний мэдээлэл, дүүргээр			Оролцсон байгууллагын мэдээлэл		
Дүүргийн нэр	тоо	хувь	Байгууллагын төрөл	тоо	хувь
Багануур	50	17.1	Төрийн байгууллага	111	37.9
Баянгол	60	20.5	Их, дээд сургууль	10	3.4
Баянзүрх	44	15.0	Хувийн байгууллага	169	57.7
Налайх	29	9.9	ТББ	3	1
Сүхбаатар	28	9.5			
Сонгинохайрхан	49	16.7			
Хан-Уул	33	11.3			
Нийт	293	100	Нийт	293	100

"Аж ахуйн нэгж байгууллагад зориулсан гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа"-нд хамрагдсан нийт 7 дүүргийн 89 байгууллага, аж ахуйн нэгжийг байгууллагын төрлөөр нь авч үзвэл 1% нь төрийн бус байгууллагад, 37.9% нь төрийн байгууллагад, 3.4% нь их сургуульд, 57.7% нь хувийн байгууллагад ажилладаг байна. Харин судалгаанд хамрагдсан нийт 89 байгууллагыг эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл⁶⁰ээр хуваан авч үзэхэд давхардсан тоогоор хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани 0.3%, уул уурхайн чиглэлийн компани 0.9%, түүхий эд боловсруулах чиглэлийн компани 4.8%, цахилгаан, ус хангамжийн компани 18.5%, барилгын компани 0.6%, худалдаа эрхэлдэг компани 27.7%, үйлчилгээний үзүүлдэг компани 31.8%, төрийн удирдлагын байгууллага 2.7%, боловсролын байгууллага 3.9%, эрүүл мэндийн байгууллага 8.9%-ийг тус тус эзэлж байна (Зураг 5).

⁶⁰ Монгол Улсын Статистикийн хороо (2019) Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, шинэчилсэн хувилбарт үндэслэн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тогтоов.



Зураг 5. Судалгаанд хамрагдсан байгууллагын эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл

Байгууллагын үйл ажиллагаагаа явуулсан хугацааг тодруулахад нийт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьд 61.8% нь 16-аас дээш жил, 12.3% нь 11-15 жил, 14% нь 6-10 жил, 10.6% нь 1-5 жил үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд байв.


Хүснэгт 5. Байгууллагад ажилласан жил

Хариултын хувилбар	Давтамж	Хувь	
Утга	Сонгоогүй	4	1.4
	1-5 жил	31	10.6
	6-10 жил	41	14.0
	11-15 жил	36	12.3
	16-с дээш жил	181	61.8
	Нийт	293	100.0

Эндээс харахад судалгаанд хамрагдсан байгууллагуудын 88.1% нь 5-аас дээш жил үйл ажиллагаагаа явуулсан, 61.8% нь 16-аас дээш үйл ажиллагаа явуулсан нь тухайн байгууллагад гамшгаас хамгаалах сургалтын үйл ажиллагаа жигдэрсэн байх боломжтой гэдгийг харуулна.

Асуулгын судалгааг нэг байгууллагаас удирдах ажилтан, энгийн ажилтан болон тухайн байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хариуцсан ажилтан гэсэн 3 албан тушаалтнаас авахыг зорьсон боловч нийт судалгаа өгсөн 293 хүний 29.4% буюу 86 нь удирдах албан тушаалтан, 17.4% буюу 51 нь ХАБ хариуцсан ажилтан, 51.2% буюу 150 нь энгийн ажилтан байна.

Асуулгын судалгаа бөглөсөн хүний тухайн байгууллагад ажилласан жилийг тодруулахад нийт 293 хүний 187 нь энэхүү асуултад хариулсаны (106 хүн энэхүү асуултыг хоосон орхисон) хамгийн бага ажилласан хугацаа нь 1 сар, хамгийн их нь 35 жил ажилласан байсан. 1-5 жил ажилласан 93, 6-10 жил ажилласан 43, 11-15 жил ажилласан 21, 16-аас дээш жил ажилласан 30 хүн байлаа.




Зураг 6. Асуулгын судалгаанд оролцсон хүний албан тушаал
Зураг 7. Асуулгын судалгаа бөглөсөн хүний тухайн байгууллагад ажилласан жил

Байгууллагын үйл ажиллагаа явуулсан хугацаа болон судалгаанд хамрагдсан ажилтны тухайн байгууллагад ажилласан жилийн мэдээлэл нь ажилтан албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох ангиллын сургалтын өнөөгийн байдалд бодитой үнэлэлт өгөх, шаардлагатай сургалтын хэрэгцээг тогтооход үнэтэй санал өгөх бүрэн боломжтой судалгааны түүвэр байна гэж үзэж болохоор байна.

Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдлын мэдээлэлд хийсэн шинжилгээ

ААНБ-д явагдаж буй гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдлыг ажилтнуудын тухайн байгууллагад тохиолдож болох аюулын талаарх ойлголт, сургалт, дадлага явуулж буй давтамж, сургалтын агуулгын хүрээ, сайжруулах санал гэсэн асуултын хүрээнд авч үзсэн.

Судалгаанд оролцогчид байгууллагадаа тохиолдож болзошгүй аюулын төрлийг сонгохдоо үер 10%, хүчтэй салхи 9.1%, аянга 10.4%, газар хөдлөлт 18.2%, хүний гоц халдварт өвчин 7.6%, малын гоц халдварт өвчин 4.4%, гал түймэр 22.8%, химийн осол 5.4%, цацрагийн осол 2.3%, дэлбэрэлт, нуралт 7.4%-тай сонгосон бол аль нь ч тохиолдохгүй гэж 0.8%, мэдэхгүй гэж 1.5% нь хариулжээ.



Зураг 8. ААНБ-д тохиолдож болзошгүй аюулын төрөл, судалгаанд оролцогчдын сонголтын хувиар

Зургаас харахад ААНБ-д гал түймэр, газар хөдлөлт, аянга, үер, салхи шуурга болон халдварт өвчний аюулыг тохиолдох боломжтой гэж олон оролцогчид үзсэн байна.

Одоогоор ААНБ-д гамшгаас хамгаалах сургалт болон дадлага сургуулийг жилд хэдэн удаа явуулж байгааг оролцогчдоос тандахад нийт 276 (17 энэ асуултад хариулаагүй) хүн хариулсанаас, 1 удаа гэж 40.5%, 2-оос дээш удаа гэж 50.9%, хийдэггүй гэж 5.5 хувь, мэдэхгүй гэж 3.1% сонгосон байна. Эндээс харахад ААНБ-уудын 90 хувь нь жилд 1-ээс 2 удаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг хийж байна.

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг явуулах давтамж нь байгууллагын үйл ажиллагааны чиглэлтэй хамааралтай гэж үзэж шинжилгээ хийлээ (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг явуулах давтамж ба байгууллагын үйл ажиллагааны чиглэл хоорондын хамаарал

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл		Сургалт, дадлага зохион байгуулах давтамж				Нийт
		1 удаа	2-с дээш удаа	Хийдэггүй	Мэдэхгүй	
Хөдөө аж ахуй	тоо	1	-	-	-	1
	%	100%				100.0%
Уул уурхай, олборлолт	тоо	1	2	-	-	3
	%	33.3%	67.7%			100.0%
Боловсруулах үйлдвэрлэл	тоо	11	3	-	-	14
	%	78.5%	21.4%			100.0%
Цахилгаан, ус хангамж	тоо	12	48	-	2	62
	%	19.3%	77.4%		3.3%	100.0%
Барилга	тоо	1	1	-	-	2
	%	50%	50%			100.0%
Худалдаа	тоо	36	47	3	2	88
	%	40.9%	53.4%	3.4%	2.3%	100%
Үйлчилгээ	тоо	42	47	14	3	106
	%	39.6%	44.3%	13.2%	2.8%	100%
Төрийн удирдлага	тоо	5	3	1	-	9
	%	55.5%	33.39	11.1%		100%
Боловсрол	тоо	6	5	-	2	13
	%	46.1%	38.5%		15.4%	100%
Эрүүл мэнд	тоо	18	11	-	1	30
	%	60%	36.7%		3.3%	100%
Нийт	тоо	133	167	18	10	328
	%	40.5 %	50.9%	5.5%	3.1%	100%

Шинжилгээнээс уул уурхай болон цахилгаан ус хангамжийн байгууллагууд мөн барилга, худалдааны байгууллагуудын 50 ба түүнээс дээш хувь нь жилд 2-оос дээш удаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг зохион байгуулдаг, харин төрийн байгууллагыг төлөөлж буй төрийн удирдлага, боловсролын болон эрүүл мэндийн байгууллагууд ойролцоогоор тэн хагас нь жилд 1 удаа гамшгаас хамгаалах сургалт, дадлага хийж байгаа нь харагдаж байна. Түүнээс гадна үйлчилгээний байгууллагын 16 хувь, боловсролын байгууллагын 15 хувь болон төрийн удирдлагын байгууллагын 11 хувь нь гамшгаас хамгаалах сургалт дадлага хийдэггүй гэсэн хариултыг өгчээ.

Байгууллагад явагдаж байгаа сургалтын чиглэлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/130 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө"-ний агуулгын хүрээнд гаргаж судалгаанд оролцогчдоос асуусан үр дүнг дараах хүснэгтэд харууллаа.


Хүснэгт 10. ААНБ-д хийгдэж буй гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэл

Сургалтын агуулгын чиглэл		Хувь
1	Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичгийн тухай	13.8
2	Гамшиг, гамшигийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах тухай	11.0
3	Цаг агаарын гаралтай аюулын (цасан шуурга, их цас, зуд, шороон шуурга, үер, ой хээрийн түймэр, ган цөлжилт, аянга) үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах тухай	7.1
4	Гал түймрийн аюулын үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах тухай	14.6
5	Хүний болон мал амьтны халдварт өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	5.2
6	Химийн ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	4.0
7	Дэлбэрэлтийн ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	4.0
8	Эмнэлгийн яаралтай тусламж иртэл гамшигт нэрвэгдэгсдэд анхны тусламжийг үзүүлэх арга	12.2
9	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тухай	9.4
10	Зарлан мэдээлэх дуут дохиогоор цугларах	12.8
11	Нүүлгэн шилжүүлэлт	6.0
Нийт		100.0

Хүснэгтээс харахад одоогоор ААНБ-д гал түймрийн аюулаас хамгаалах чиглэлээр (14.6%), Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичгийн (13.8%) талаар, нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламжийг үзүүлэх арга (12.2%), зарлан мэдээлэх дуут дохиогоор цугларах (12.8%) болон гамшигийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах (11%) чиглэлийн сургалт, дадлагууд бусад чиглэлээс арай түлхүү хийгдэж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуульд ААНБ, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчийн сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан хариуцан зохион байгуулахаар заасан. Энэ судалгаанд оролцогчдын 54.1% байгууллага өөрөө гамшгаас хамгаалах сургалтыг явуулдаг гэсэн хариултыг өгсөн бол 38.8% нь орон нутгийн онцгой байдлын байгууллага сургалт, дадлагыг явуулж байна гэж хариулсан.

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах шаардлагатай гэж Та бодож байна уу? гэсэн асуултад нийт оролцогчдын 76.1% нь тийм гэж хариулсан, харин 9.6% нь үгүй гэж хариулсан бол 6.5% нь мэдэхгүй гэж, 7.59% нь энэхүү асуултанд хариулаагүй байна.



Зураг 9. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах шаардлагатай эсэхийг судалгаанд оролцогчид тодорхойлсон байдал


Цаашид гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаарх саналыг судалгаанд хамрагдсан ажилтнуудаас тодруулах зорилго бүхий "Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаар таны санал" гэсэн нээлттэй асуултад нийт 91 санал ирүүлсэн. Энэ асуултад судалгаанд оролцогчдын хариулсан байдлыг судалгааны ажлын 1 дүгээр бүлэгт тодорхойлсон ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулах хэрэгцээг тодорхойлох хүрээнд хамаарах байдлаар нь ангилж дараах хүснэгтэд үзүүллээ (Дэлгэрэнгүй хариултыг хавсралт 4-с харна уу)

Хүснэгт 11. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаар судалгаанд оролцогчдоос ирүүлсэн санал

	ААНБ-д гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой хуулиар хүлээсэн ямар шаардлага					ААНБ-ын гамшгаас хамгаалахтай холбоотой гүйцэтгэх чиг үүрэг				Гамшгаас хамгаалах болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой шаардлагатай мэдлэг, ур чадвар				Сургалтад хамрагдах бүрэлдэхүүн	
	Гамшгийн бууруулах	Бэлэн байдлыг хангах	Эрэн хайх, аврах	хор уршгийг арилгах	Сэргээн босгох	Гамшгийн эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх чиглэлд	Аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед	Гамшиг, ослын дараа	Тогтвортой ажиллагааг хангах чиглэл	Удирдлага, зохион байгуулалт	Дадлагуулах буюу дадлага эзэмшүүлэх	Харилцан ажиллагааг хангах, зохицуулах	Мэргэшүүлэх сургалт	Хүн нэг хамруулах	Нийт ажигчдыг хамруулах
Удирдах ажилтан	1	1				1	4			2	9	4	5	3	6
Байгууллагын гамшгаас хамгаалах ажиллагаа хариуцсан ажилтан үйл	2					2	1				10		5	2	3
Ажилтан		3				2	4				6	1	1	2	5
Нийт	3	4				5	9				25	5	11	7	14

Өмнөх хүснэгтэд авч үзсэн асуудлаас гадна ААНБ-д явуулах сургалтын давтамжийг нэмэгдүүлэх гэж 10, сургалт, дадлагын талаар хэвлэл мэдээллээр сурталчилах гэж 8, багш нарын ур чадварыг сайжруулах, сургалтыг мэргэжлийн байгууллагыг түшиглэж явуулах гэж 7, сургалтын үр дүнд хяналт үнэлгээ хийх гэж 1, бусад чиглэлээр 4 саналыг судалгаанд оролцогчид ирүүлсэн байсан.

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаар судалгаанд оролцогчдоос ирүүлсэн саналыг эрэмбэлж дараах зурагт үзүүллээ.



Зураг 10. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаар судалгаанд оролцогчдоос ирүүлсэн санал

Эндээс гамшгаас хамгаалах сургалтыг сайжруулахын тулд сургалтыг нийт ажилчдыг хамруулан, тодорхой чиглэлээр мэргэшүүлэх, дадлага эзэмшүүлэх сургалтыг явуулах шаардлага байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн сургалтын давтамжийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээний талаарх мэдээлэлд хийсэн шинжилгээ

ААНБ-ын сургалтын хэрэгцээг тандахдаа асуулгад оролцогчдоос байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сургалт, дадлагын чиглэлийг сонгох хаалттай асуултаар болон байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сургалт, дадлагын талаарх саналаа бичих нээлттэй асуултын хүрээнд авч үзсэн.

Судалгаанд оролцогчдын шаардлагатай сургалт, дадлагын чиглэлийг сонгосон байдлыг албан тушаалаар нь ангилан болон нийт сонголтоор авч үзэв (Хүснэгт 12). Удирдах ажилтан гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам, гал түймрээс урьдчилан сэргийлэх, анхны тусламжийн сургалтууд шаардлагатай хэмээн үзсэн байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хариуцсан ажилтан 1-9 хүртэлх чиглэлийн сургалтуудыг жигд шаардлагатай гэж үзсэн боловч гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам гэсэн сонголт арай илүү хандалт авсан. Энгийн ажилтан гал түймрээс урьдчилан, сэргийлэх, гал түймэр унтраах арга, анхны тусламжийн сургалтыг илүү шаардлагатай гэж үзсэн.

Харин нийт судалгаанд оролцогчид байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэлийг сонгосон байдлаас харахад

1. Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга зам
2. Анхны тусламж үзүүлэх
3. Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам
4. Гал түймэр унтраах арга
5. Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга гэсэн асуудлууд олон хандалт авсан байна.

Хүснэгт 12. ААНБ-д шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэлийг сонгосон хувь, албан тушаалаар

№	Гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэл	Удирдах ажилтан	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Ажилтан	Нийт судалгаанд оролцогч
А	Б	В	Г	Д	Е
1	Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал	43.6	47.8	39.2	42.5
2	Гамшгийн эрсдэлийг бууруулах арга замын тухай	52.6	58.7	39.2	46.9
3	Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах тухай	33.3	41.3	23.1	29.9
4	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах тухай	26.9	39.1	23.1	27.2
5	Гамшгийн үед ажиллах удирдлага /штаб/, мэргэжлийн анги, бүлгийн ажилтнуудын сургалт бэлтгэл, ур чадвар эзэмших	42.3	47.8	30.8	37.8
6	Нүүлгэн шилжүүлэх зохион байгуулалтын тухай	35.9	43.5	16.9	27.6
7	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга зам	53.8	47.8	49.2	51.2
8	Гал түймэр унтраах арга	37.2	45.7	46.2	44.1
9	Анхны тусламж үзүүлэх	53.8	47.8	47.7	50.0
10	Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө	21.8	17.4	13.8	16.9
11	Гамшгийн үеийн удирдлага /штаб/, мэргэжлийн анги, бүлгийн ажлын уялдаа	23.1	41.3	11.5	20.5
12	Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах	21.8	28.3	22.3	23.2
13	Гамшгийн үеийн холбоо, зохион байгуулалт	25.6	30.4	28.5	28.0
14	Дадлага сургууль зохион байгуулах	38.5	34.8	28.5	33.1
15	Онцгой байдал, гамшгийн үеийн удирдлага, удирдлагын байр, холбоо зохион байгуулалт	23.1	23.9	13.1	18.1
16	Гамшгийн үеийн хорогдох байр буюу нүүлгэн шилжүүлэх талбай, зохион байгуулалт	26.9	30.4	26.2	27.6
17	Гамшгийн үеийн шаардлагатай зүйлсийн хангалт, нөөц бүрдүүлэлт	34.6	32.6	28.5	31.5
Дундаж хувь		34.9	38.4	28.7	32.7

Судалгаанд оролцогчийн тоо	78	46	130	254
----------------------------	----	----	-----	-----


Судалгаанд оролцсон байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл болон шаардлагатай гэж үзсэн сургалтын чиглэлийг авч үзэж шинжилгээ хийж үр дүнг Хүснэгт 13-д харуулав.

Хүснэгт 13. ААНБ-д шаардлагатай гамшгаас хамгаалах сургалтын чиглэл, салбараар

Үйл ажиллагааны чиглэл	Гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэлийг сонгосон хувь (Сургалт, дадлагын 17 чиглэлийг Хүснэгт...-ын Б баганаас дэлгэрүүлж харна уу)																
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
Хөдөө аж ахуй			100				100					100					
Уул уурхай, олборлолт	33	66	66	66	66		66	33	33	33	33	33	33	33	33	33	33
Боловсруулах үйлдвэрлэл	42	50	42	42	50	35	64	21	35	28	50	28	50	50	28	42	50
Цахилгаан, ус хангамж	55	57	42	35	41	32	42	41	44	19	21	26	32	41	17	39	53
Барилга	100					100			100								
Худалдаа	28	30	16	18	28	20	53	45	53	9	9	14	18	21	9	16	17
Үйлчилгээ	31	34	15	13	22	13	44	49	54	10	9	10	21	25	11	11	20
Төрийн удирдлага	12	37	12	25	37		37	37	50	12	25	37	12	25	12	12	12
Боловсрол	36	18	18	18	54	9	45	27	54		9	18	9	9	9		
Эрүүл мэнд	63	73	56	40	56	56	56	46	36	40	43	43	50	46	33	50	43

Өмнөх хүснэгтээс харахад боловсруулах үйлдвэр, цахилгаан, ус хангамж, худалдаа үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарууд нь гамшгаас хамгаалах чиглэлээр өргөн хүрээнд сургалт авах хэрэгцээтэй гэж үзсэн бол төрийн удирдлага болон боловсролын салбар нь гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, гамшгийн үед ажиллах удирдлага /штаб/, мэргэжлийн анги, бүлгийн ажилтнуудын сургалт бэлтгэл, ур чадвар эзэмших, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга зам, гал түймэр унтраах арга, анхны тусламж үзүүлэх болон зарлан мэдээллийн дохиогоор ажиллах гэсэн чиглэлийн сургалтын хэрэгцээ байна гэсэн сонголтыг хийсэн байна. Хөдөө аж ахуй, барилгын салбарын судалгааны түүвэр хэт цөөн (1-2 байгууллага) байгаатай холбоотойгоор сонгогдсон сургалтын чиглэлүүдийг бусад чиглэлээс илүү хэрэгцээтэй гэж үзэх боломжгүй байна.

ААНБ-ын сургалтын хэрэгцээг тодорхойлохдоо тухайн байгууллагад шаардлагатай гэж үзэж буй гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сургалт, дадлагын талаарх саналаа бичих нээлттэй асуултад ирүүлсэн судалгааны ажлын 1 дүгээр бүлэгт тодорхойлсон ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулах хэрэгцээг тодорхойлох асуудлын хүрээнд хамаарах байдлаар нь ангилж дараах зурагт үзүүлээ (Дэлгэрэнгүй хариултыг хавсралт 5-с харна уу).



Зураг 11. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагын хэрэгцээг тодорхойлсон нээлттэй асуултад судалгаанд оролцогчдоос ирүүлсэн санал

2.2. ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулах хэрэгцээг тодорхойлсон нь

Аливаа сургалт нь түүний хэрэгцээг тодорхойлохоос эхэлдэг бөгөөд сургалтын хэрэгцээ нь сургалтын агуулга болон оролцогчтой холбоотойгоор тодорхойлогддог болохыг судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт авч үзсэн.

ААНБ-ын ажилтны сургалт нь бусад ангиллын сургалтаас ялгагдах тодорхой шинж чанарыг агуулж, зохих шаардлагыг хангасан байх ёстой.

Энэ ангиллын сургалтад

- Хэрэгцээнд тулгуурласан буюу практик амьдралтай холбоотой
- Системт мэдлэг, цогц чадвар олгох
- Логик уялдаатай
- Хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн
- Тэгш, хүртээмжтэй гэсэн шаардлагууд тавигдана.

Хэрэгцээнд тулгуурласан байх гэдэг бол байгууллага, ажилтан нь өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, байгууллагын оршин байгаа газар нутаг, байгууллагын өмнө тавигдаж буй зорилго, зорилттойгоо уялдуулан сургалтын агуулгыг сонгон ашиглах боломжтой байх явдал юм.

Системтэй мэдлэг, цогц ур чадвар олгох шаардлага нь сургалтад хамрагдагсдад бодит нөхцөл үүсэхэд ашиглах арга барил, чадвар эзэмшүүлэх сургалтаар заалгасан бүхнээ хожим хэрэглэж чадахуйц хэмжээнд бэлтгэхүйц агуулга бүхий бүхэллэг чанараар илэрхийлэгдэнэ.

Логик уялдаатай байх нь хичээлийн сэдвийн агуулгын залгамж холбоог хангаж дараагийн ойлголт ухагдахуун, өмнөх ойлголт ухагдахуунтай холбогдох байдлаар тухайн байгууллага гамшгаас хамгаалах үйл ажиллагааг өөрийн онцлогт нийцүүлэн зохион байгуулах боломжийг олгохуйцаар төлөвлөгдсөн байх ёстой.

Хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн байх нь суралцагчдад агуулгын хүрээнд өгөх мэдлэг нь ерөнхий байдлаар танилцуулах, улмаар дараа дараагийн сургалтаар гүнзгийрүүлэх буюу тухайлсан арга хэмжээнээс иж бүрэн хүртэл, олгох ур чадварын хувьд суралцагчийн ажилбар гүйцэтгэх дараалал нь энгийнээс, нарийн төвөгтэй руу шилжих гэсэн дэс дараалал баримталсан хэд хэдэн түвшингөөс бүрдэх явдал юм.

Тэгш, хүртээмжтэй гэсэн шаардлагын хүрээнд сургалт нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран явуулахуйц олон шийдлээр зохион байгуулагдсан, мөн байгууллагын ажилтан бүр гамшгаас хамгаалах сургалтанд хамрагдах нөхцөл, тэгш боломжоор хангагдсан байдал нь хамаарна.

ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулах хэрэгцээг тодорхойлохдоо тухайн ангиллын сургалтад тавигдах өмнө авч үзсэн шаардлага, өнгөрсөн хугацаанд ААНБ-д гамшгаас хамгаалах сургалтыг явуулж ирсэн түүхэн уламжлал, сургалтын өнөөгийн нөхцөл байдалд болон судалгааны түүвэрт сонгогдсон байгууллагаас ирүүлсэн саналд хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн дараах байдлаар тодорхойлон гаргалаа.

Сургалтын агуулгын хэрэгцээ

Сургалтын агуулгатай холбоотой хэрэгцээг тодорхойлохдоо одоогоор ААНБ-д явуулж буй гамшгаас хамгаалах сургалтын ерөнхий агуулга нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн үзэл баримтлалын шинэчлэлтэй нийцэж байгаа учир сургалтын ерөнхий сэдвийг

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа
2. Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам
3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ажилтны үүрэг
4. Анхны тусламж гэсэн 4 чиглэлээр хэвээр нь үлдээх нь зүйтэй гэж үзлээ.

Харин энэхүү ерөнхий сэдвийн хүрээнд дэлгэрүүлэн авч үзэх агуулгыг тодорхойлох хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/130 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө"-ний агуулга, түүний хэрэгжилт, судалгаанд оролцсон ажилтнуудын тухайн байгууллагад тохиолдож болох аюулыг тодорхойлсон байдал, оролцогчдоос ирүүлсэн цаашид сайжруулах саналд болон байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэлийг тодорхойлсон оролцогчдын саналд хийсэн шинжилгээг харьцуулалт хийж үр дүнг Хүснэгт 14-д үзүүлээ. Энэхүү харьцуулсан шинжилгээнээс ААНБ-ын ажилтан, алба хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын агуулгын хүрээг тодорхойлох үндэслэлийг гарган авлаа.

Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын агуулга нь одоогийн батлагдсан хөтөлбөрийн хүрээнд бол нийт 20 цагийн багтаамжтай байгаа боловч энэ өнөөгийн байдлын судалгаагаар ААНБ-уудын 90 хувь нь жилд 1-2 удаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг хийдэг, нэг сургалт нь дунджаар 2 цаг үргэлжилдэг болох нь харагдсан. Иймд уг төлөвлөгөөнд тусгагдсан агуулгыг байгууллагын ажилтнууд бүрэн эзэмшихийн тулд 3 түвшин бүхий шаталсан сургалттай байж болох юм гэж үзлээ.

Хүснэгт 14. Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын агуулгын хэрэгцээг тодорхойлох шинжилгээ

Сэдэв		Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө	ААНБ-д хийгдэж буй гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэл	Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаар судалгаанд оролцогчдоос ирүүлсэн санал	ААНБ-д шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэл	Гамшгаас хамгаалах сургалт, дадлагын хэрэгцээг тодорхойлсон оролцогчдоос ирүүлсэн санал
Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Гамшгийн эрсдэлийг бууруулах	<i>Гамшгийн эрсдэлийн тухай ерөнхий ойлголт</i>	Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичиг	Гамшгаас урьдчилан сэргийлэх	Гамшгийн эрсдэлийг бууруулах арга замын тухай Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах тухай	Гамшгийн эрсдэлийг бууруулах
	Бэлэн байдлыг хангах	Зарлан мэдээлэл, дуут дохиогоор цугларах Нүүлгэн шилжүүлэх журам	Зарлан мэдээлэх дуут дохиогоор цугларах	Бэлэн байдлыг хангах	Гамшгийн үед ажиллах удирдлага /штаб/, мэргэжлийн анги, бүлгийн ажилтнуудын сургалт бэлтгэл, Гамшгийн үеийн шаардлагатай зүйлсийн хангалт, нөөц бүрдүүлэлт	
	Эрэн хайх, аврах	Эрэн хайх аврах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо	Гал түймрийн аюулын үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах тухай		Гал түймрээс сэргийлэх, унтраах арга зам Анхны тусламж үзүүлэх	
	Хор уршгийг арилгах		Нүүлгэн шилжүүлэлт		Гамшгийн үеийн шаардлагатай зүйлсийн хангалт, нөөц бүрдүүлэлт Гамшгийн үеийн хорогдох байр буюу нүүлгэн шилжүүлэх талбай, зохион байгуулалт	Гамшгийн дараа авах арга хэмжээ
	Сэргээн босгох	-	-	-	-	-

Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам	Эрсдэлийн үнэлгээ,	<i>Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын суурь шалтгаанууд, нөлөөлөх хүчин зүйлс</i>	Гамшиг, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах тухай		Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал	
	Аюулт үзэгдэл	Салхи шуурга, Зуд, Ган, цөлжилт, Аянга, Газар хөдлөлт, Халдварт өвчин	Үер, хүчтэй салхи, аянга, газар хөдлөлт, хүний гоц халдварт өвчин, малын гоц халдварт өвчин,	Аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед авах арга хэмжээ		Аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед авах арга хэмжээ
	Осол	-	Гал түймэр, химийн осол, цацрагийн осол, дэлбэрэлт		Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга зам Гал түймэр унтраах арга	
Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ажилтны үүрэг	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, төлөвлөгөөний бүтэц Үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол гамшгаас хамгаалах төлөвлөгөөг турших, төлөвлөгөөнд тодотгол хийх, нэмэлт өөрчлөлт оруулах	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тухай		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах тухай Нүүлгэн шилжүүлэх зохион байгуулалтын тухай Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө Онцгой байдал, гамшгийн үеийн удирдлага, удирдлагын байр, холбоо зохион байгуулалт		Тогтвортой ажиллагааг хангах
Анхны тусламж	Цус алдалт, цусыг түр тогтоох арга Яс хугарах, үе мултарсан үед тусламж үзүүлэх Түлэгдэлтийн 4 зэргийн тухай болон анхны тусламж Хөлдөлт, осголтын үед Усанд живсэн хүнд анхны тусламж үзүүлэх	Эмнэлгийн яаралтай тусламж иртэл гамшигт нэрвэгдэгсдэд анхны тусламжийг үзүүлэх арга		Анхны тусламж үзүүлэх		

Ингээд тухайн ангиллын сургалтад тавигдах логик уялдаатай, системтэй мэдлэг, цогц чадвар олгох, хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн байх шаардлагад нийцүүлэн, өмнөх хүснэгтэд авч үзсэн шинжилгээнд тулгуурлан ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын агуулгын хэрэгцээг дараах байдлаар тодорхойлж гаргав.

Хүснэгт 15. ААНБ-ын ажилтан, алба хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын агуулгын хүрээ, залгамж холбоо

Сэдэв	Анхан шат	Дунд шат	Ахисан шат
Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа Гамшгаас хамгаалах тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль	Гамшгаас хамгаалах талаар гарсан журам, дүрэм, заавар /байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн сонгох/	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мөрдөгдөх стандарт, норм, дүрэм, аргачлал /байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн сонгох/
Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ	Гамшгийн эрсдэл (байгууллагын хувьд эрсдэл их буюу дунд гэж үнэлэгдсэн аюулт, үзэгдэл, ослын төрөл)-ийг бууруулах, амь нас, эрүүл мэндээ хамгаалах арга зам	-
Гамшгаас хамгаалах бэлэн байдал, төлөвлөгөө, чиг үүрэг	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Бэлэн байдлыг хангах талаарх ажилтны гүйцэтгэх үүрэг Нүүлгэн шилжүүлэх, зарлан мэдээллийн дохиогоор ажиллах	Аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед ажилтны гүйцэтгэх үүрэг Байгууллагын тогтвортой ажиллагааны төлөвлөгөө Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааны төлөвлөгөө, ажилтны үүрэг	Гамшгийн үед аж ахуйн нэгж, байгууллага, онцгой байдлын байгууллагын харилцан ажиллагаа Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг турших, тодотгох
Анхны тусламж	Анхны тусламжийн зарчим, ойлголт, ач холбогдол, хууль эрх зүйн асуудлууд Хүний биеийн эрхтэн тогтолцооны ерөнхий ойлголт Анхны тусламж үзүүлэх дараалал, Яаралтай нөхцөл байдлыг таних, эрэмбэлэх Зүрх, уушгины сэхээн амьдруулалт (CPR), Хажуугийн сэргээх байрлал	Цус алдалтын үед анхны тусламж үзүүлэх Хугарал мултрал, зөөлөн эдийн гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж Түлэгдэлтэд үзүүлэх анхны тусламж	Осголт, хөлдөлт, дулааны цохилтын үед үзүүлэх анхны тусламж Боолтын талаар ойлголт, чадвартай болох Өвчтнийг зөөвөрлөх, бэхэлгээ хийх

Байгууллага, аж ахуйн нэгжийн эрхлэх үйл ажиллагааны онцлог, байгууллагын хэмжээ, орон нутаг өөрийн байгаль, цаг агаар, зонхилон тохиолддог аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын төрлөөс хамаарч сэдвийн болон цагийн хуваарилалтад өөрчлөлт хийж болно.

Сургалтанд оролцогчтой холбоотой хэрэгцээ

Сургалтын хэрэгцээг тодорхойлоход зайлшгүй авч үзэх зүйл бол сургалтад оролцогчийг тодорхойлох юм. Энэ судалгаанд сургалтын оролцогчтой холбоотой хэрэгцээг ажилтанд гамшгаас хамгаалахтай холбоотой болон байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой ямар мэдлэг, ур чадвар шаардагддаг болон хэнд сургалт явуулах нь зүйтэй вэ гэсэн асуудлын хүрээнд авч үзэж шинжилгээ хийсэн.

Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ААНБ-д гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын хөтөлбөрт оролцогчтой холбоотой ямар нэг зүйл тусгагдаагүй байна.

ААНБ нь бүтцийн нэгж болон ажилтан бүрээ гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэлээр сургаж, дадлагажуулах шаардлагатай боловч гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд салбар нэгж, хувь хүн ямар үүрэг оролцоотой байх, эдгээр төлөвлөсөн ажлуудыг хэн, хэрхэн гүйцэтгэхийг урьдчилан тогтоосон байх шаардлага гардаг. Энэ шаардлага нь сургалтын төрөл, хэлбэр болон оролцох бүрэлдэхүүнийг тодорхойлох үндэслэл болдог.

Сургалтанд оролцогчтой холбоотой хэрэгцээг тодорхойлох хүрээнд судалгаанд оролцсон ажилтнуудын ирүүлсэн сургалтыг сайжруулахтай холбоотой саналд болон байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэлийг тодорхойлсон оролцогчдын саналд хийсэн шинжилгээг харьцуулалт хийж үр дүнг Хүснэгт 16-д үзүүллээ.

Хүснэгт 16. Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын оролцогчтой холбоотой хэрэгцээг тодорхойлох шинжилгээ

Сургалтанд оролцогчтой холбоотой хэрэгцээг тодорхойлох хүрээ		Гамшгаас хамгаалах сургалт, сайжруулах судалгаанд оролцогчдоос ирүүлсэн санал	хамгаалах дадлагыг талаар оролцогчдоос ирүүлсэн санал	Гамшгаас хамгаалах сургалт, дадлагын хэрэгцээг тодорхойлсон асуултад оролцогчдоос ирүүлсэн санал
Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой шаардлагатай мэдлэг, ур чадвар	Удирдлага, зохион байгуулалт			+
	Дадлагажуулах буюу дадлага эзэмшүүлэх	+		+
	Харилцан ажиллагааг хангах, зохицуулах	+		
	Мэргэшүүлэх сургалт			+
Сургалтад хамрагдах бүрэлдэхүүн	Хүн нэг бүрийг хамруулах	+		+
	Нийт ажилтныг хамруулах	+		+

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой шаардлагатай мэдлэг, ур чадвартай холбоотой ирүүлсэн саналын байдлаас харахад нийт оролцогчид дадлага эзэмшүүлэх бодит сургалт шаардлагатай гэж үзсэн байна.

Сургалтанд хамрагдах бүрэлдэхүүний хувьд судалгаанд оролцогчдыг албан тушаалаар нь ангилан ирүүлсэн саналд нь шинжилгээ хийж үзэхэд удирдах ажилтны хувьд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах асуудлыг, байгууллагын гамшгаас

хамгаалах асуудал хариуцсан ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой бүхий л арга хэмжээг, харин энгийн ажилтны хувьд гал түймрээс сэргийлэх, унтраах арга, анхны тусламж үзүүлэх арга замыг чухалчилж үзсэн байлаа (Хүснэгт 12).

Судалгаанд оролцсон салбараар сургалтын агуулгыг авч үзэх нь онц ач холбогдолгүй (Хүснэгт 13) харагдаж байгаа хэдий боловч гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой асуудлыг байгууллага өөрийн газар орон, үйл ажиллагаатайгаа уялдуулан сонгох байдлаар тавьж өгөх, харин гамшгаас хамгаалах төлөвлөгөө, зохион байгуулалттай холбоотой агуулгыг байгууллагын хэмжээ, цар хүрээнээс хамаарч сонгох боломжтойгоор сургалтын агуулгын хүрээг гаргаж өгөх нь зүйтэй байна.

ААНБ-ын ажилтны сургалтын өнөөгийн байдал, энэ ангиллын сургалтад тавигдах шаардлага, асуулгын судалгааны үр дүнд хийсэн шинжилгээнээс гарган авсан сургалтын хэрэгцээний мэдээлэлд үндэслэн ААНБ-д явуулах гамшгаас хамгаалах сургалтыг агуулгын хувьд 1) гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, 2) гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам, 3) гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ажилтны үүрэг, 4) анхны тусламж гэсэн дөрвөн ерөнхий сэдэв, эдгээрт хамаарах дэд сэдвүүд бүхий нийт 20 цагийн багтаамжтай, 3 түвшинтэй шаталсан сургалт байхаар сургалтын хэрэгцээг тодорхойлж гаргалаа (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох шаталсан сургалтын хэрэгцээг тодорхойлсон байдал

Эрэмбэ	Сэдэв	Дэд сэдэв	Оролцох бүрэлдэхүүн	Сургалтын хэлбэр	Цаг	Зохион байгуулах /дэмжиж тал
Анхан шат	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Нийт ажилтан	Лекц/ семинар	1	ААНБ
		Гамшгаас хамгаалах тухай хууль				
		Галын аюулгүй байдлын тухай хууль				
	Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Нийт ажилтан	Дадлага/ ширээний дасгал	2	ААНБ/тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд
		Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ				
	Гамшгаас хамгаалах бэлэн байдал, төлөвлөгөө, чиг үүрэг	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах тухай	Нийт ажилтан	Дадлага/ чиг баримжаа олгох дасгал	2	ААНБ/ОББ
		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд туссан ажилтны үүрэг	Хүн нэг бүр			
		Нүүлгэн шилжүүлэх, зарлан мэдээллийн дохиогоор ажиллах	Хүн нэг бүр			
	Анхны тусламж	Анхны тусламжийн зарчим, ойлголт, ач холбогдол, хууль эрх зүйн асуудлууд	Нийт ажилтан	Дадлага	2	ААНБ/МУЗН, эрүүл мэндийн байгууллага
Анхны тусламж үзүүлэх дараалал, Яаралтай нөхцөл байдлыг таних, эрэмбэлэх			Хүн нэг бүр			
Зүрх, уушгины сэхээн амьдруулалт (CPR) , Хажуугийн сэргээх байрлал						
Анхан шатны нийт цаг					7	
Дунд шат	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Гамшгаас хамгаалах талаар гарсан журам, дүрэм, заавар /байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн сонгох/	Нийт ажилтан	Лекц/ семинар	1	ААНБ/ОББ, ТББ
	Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам	Гамшгийн эрсдэл (байгууллагын хувьд эрсдэл их буюу дунд гэж үнэлэгдсэн аюулт, үзэгдэл, ослын төрөл)-ийг бууруулах, амь нас, эрүүл мэндээ	Үер, салхи шуурга, аянга, зуд, ган Газар хөдлөлт Хүн, малын халдварт өвчин Ой хээрийн түймэр Объектын гал Химийн осол,	Нийт ажилтан/ хүн нэг бүр	Дадлага/ дадлага, сургуулилт	2

		хамгаалах арга зам	дэлбэрэлт, Цацрагийн осол				
Гамшгаас хамгаалах бэлэн байдал, төлөвлөгөө, чиг үүрэг	Аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед ажилтны гүйцэтгэх үүрэг		Хүн нэг бүр	Дадлага/чиг баримжаа олгох дасгал	2	ААНБ/ОББ	
	Байгууллагын тогтвортой ажиллагааны төлөвлөгөө		Нийт ажилтан/ хүн нэг бүр				
	Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааны төлөвлөгөө, бүтцийн нэгжийн болон ажилтны үүрэг						
Анхны тусламж	Цус алдалтын үед анхны тусламж үзүүлэх		Хүн нэг бүр	Дадлага	2	ААНБ/МУЗН, эрүүл мэндийн байгууллага	
	Хугарал мултрал, зөөлөн эдийн гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж						
	Түлэгдэлтэд үзүүлэх анхны тусламж						
Дунд шатны нийт цаг					7		
Ахисан шат	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мөрдөгдөх стандарт, норм, дүрэм, аргачлал /байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн сонгох/		Нийт ажилтан	Лекц/ семинар	2	ААНБ/мэргэжлийн байгууллага
	Гамшгаас хамгаалах бэлэн байдал, төлөвлөгөө, чиг үүрэг	Гамшгийн үед аж ахуйн нэгж, байгууллага, онцгой байдлын байгууллагын харилцан ажиллагаа		Нийт ажилтан/ хүн нэг бүр	Дадлага/ чиг үүргийн дадлага ба иж бүрэн сургууль	2	ААНБ/ОББ
		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг турших, тодотгох, шинэчлэх					
	Анхны тусламж	Осголт, хөлдөлт, дулааны цохилтын үед үзүүлэх анхны тусламж		Хүн нэг бүр	Дадлага	2	ААНБ/МУЗН, эрүүл мэндийн байгууллага
		Боолтын талаар ойлголт, чадвартай болох					
		Өвчтнийг зөөвөрлөх, бэхэлгээ хийх					
Ахисан шатны нийт цаг					6		
Нийт цаг				Лекц 6 цаг Дадлага 14 цаг	20		

Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох шаталсан сургалтын шат тус бүрийн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. ААНБ, түүний ажилтанд гамшгаас хамгаалах, гал түймрийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргийг мэдэх, хэрэгжилтийг хангах, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг байгууллагын онцлогт нийцүүлэн хийх, анхны тусламж үндсийн талаар мэдлэг, чадвар эзэмшихэд анхан шатны сургалтын зорилго оршино.

2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг байгууллагын онцлогтой уялдуулан зохион байгуулахад шаардлагатай эрхзүйн зохицуулалтыг судлах, байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр их буюу дунд гэж үнэлэгдсэн аюулт үзэгдэл, ослын төрлөөр эрсдэлийг бууруулах, амь нас, эрүүл мэндээ хамгаалах аргыг эзэмших, гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөөр ажиллах мэдлэг эзэмших, нийтлэг тохиолддог бэртэл, гэмтлийн төрлөөр анхны тусламж үзүүлэх чадвартай болоход дунд шатны сургалт нь чиглэнэ.

3. Байгууллагын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гамшиг, ослын үед ажиллах мэдлэг, ур чадварыг улам бүр сайжруулах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, зөөх, тээвэрлэх чадвар, дадлыг эзэмшихэд ахисан шатны сургалтын зорилго оршино.

Дүгнэлт

Аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээ нь байгууллага өөрийн нөхцөл байдалдаа тохируулан гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшихтэй холбоотой хүсэл, шаардлагаар тодорхойлогдож байна.

Сургалт бол тухайн зорилгод хүрэхэд нэмэр болох ур чадварыг хүмүүст эзэмшүүлэх үйл явц бөгөөд аливаа сургалтын үйл явц нь хэрэгцээг тодорхойлохоос эхэлнэ. Сургалтын хэрэгцээг сургалтын агуулгатай холбоотой болон сургалтанд оролцогчтой холбоотой хэрэгцээний нийлбэрээр тодорхойлдог байна.

ААНБ-ын гамшгаас хамгаалах сургалтын агуулгатай холбоотой хэрэгцээг гамшгаас хамгаалах хуулиар хүлээсэн үүрэг, энэ үүргийн дагуу тухайн аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шаардлагын хүрээнд авч үзсэн бол сургалтын оролцогчтой холбоотой хэрэгцээг ажилтанд гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, оролцох бүрэлдэхүүний хүрээнд авч үзэж тодорхойлсон.

Монгол Улсад аж ахуйн нэгж, байгууллагад явуулах гамшгаас хамгаалах сургалтын үндэс суурь ард иргэд, улс ардын аж ахуйг аливаа болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилго бүхий Иргэний хамгаалалтын байгууллага үүсэх урьтач нөхцөл бүрдсэн 1930-аад оноос эхлэн тавигдсан байна. Иргэний хамгаалалтын үед буюу 1950-аад оноос энэ ангиллын сургалтын агуулга нь бүхэлдээ үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах зорилгод чиглэгдэж, улмаар 1990-ээд оноос

байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос хамгаалах арга эзэмшүүлэхэд чиглэгдсэн байна. Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын зорилго, агуулга нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үзэл баримтлалын шинэчлэл, цаг үеийн шаардлагад нийцэж улам бүр боловсронгуй болсоор иржээ.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ОБЕГ-ын даргын 2016 оны А/130 дугаар тушаалаар батлагдсан “Ажилтан, алба хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө”-нд шинжилгээ хийж үзвэл эрсдэлийг бууруулах мэдлэг чадвар олгохоос гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний дагуу үүрэг гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэхийг чухалчлан үзсэн байгаа нь гамшгаас хамгаалах салбарын үзэл баримтлалын шинэчлэлтэй зохих түвшинд нийцэж байна. Гэхдээ дэд сэдвийн хүрээнд авч үзсэн агуулга нь сэдвийн гүнзгийрэлт байхгүй, түүнчлэн гал түймрийн аюул, химийн осол болон дэлбэрэлт зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдсэн ослын эрсдэлийг бууруулах асуудлыг орхигдуулсан дутагдал байна.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын сүүлийн 5 жилийн мэдээнээс харахад ААНБ-ын ажилтны сургалт улсын хэмжээнд явагдаж буй нийт сургалтын 40 хувийг эзэлж байна. Энэ сургалтыг аймгуудын хэмжээнд жилд дунджаар 55 удаа зохион байгуулж, 2500 гаруй хүнийг хамруулдаг бол улсын хэмжээнд жилд дунджаар 78 удаагийн сургалтад 4000 орчим ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулжээ. Сургалтын нэгдсэн мэдээ гаргаж буй одоогийн хэлбэр нь хэт ерөнхий байгаа нь нарийвчилсан шинжилгээ хийх боломжгүй байдалд хүргэж байна. Иймд цаашид гамшгаас хамгаалах ангиллын сургалтын нэгдсэн дүн мэдээг нарийвчилж гаргах нэгдсэн арга хэлбэрийг бий болгох шаардлагатай байгаа нь харагдлаа.

Аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг тодорхойлох асуулгын судалгааг төрийн болон хувийн хэвшлийн, төрийн бус, олон улсын гэсэн нийт 89 байгууллагын 293 ажилтныг хамруулан явуулсан. Судалгаанд оролцогчид өөрийн байгууллагадаа гал түймэр, газар хөдлөлт, аянга, үер, салхи шуурга болон халдварт өвчний аюулыг тохиолдох боломжтой гэж үзсэн бөгөөд ААНБ-уудын 90 хувь нь жилд 1-ээс 2 удаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг хийж байна.

Сургалтын агуулгын хувьд ААНБ-д гал түймрийн аюулаас хамгаалах чиглэлээр (14.6%), Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичгийн талаар (13.8%), анхны тусламжийг үзүүлэх аргаар (12.2%), зарлан мэдээлэх дуут дохиогоор цугларах (12.8%) болон гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах (11%) чиглэлийн сургалт, дадлагууд бусад чиглэлээс илүү хийж байна.

Судалгаанд оролцогчдын 76.1% нь гамшгаас хамгаалах сургалтыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд ингэхдээ сургалтын давтамжийг нэмэгдүүлэх, багшийн ур чадварыг сайжруулах, сургалтыг мэргэжлийн байгууллагыг түшиглэж явуулах, сургалтын үр дүнд хяналт үнэлгээ хийх замаар сайжруулах боломжтой гэж үзсэн.

ААНБ-д шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах сургалт, дадлагын чиглэлийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах арга зам, анхны тусламж үзүүлэх, гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам гэж судалгаанд оролцогчид үзсэн байна.

ААНБ-д явуулах гамшгаас хамгаалах сургалтыг агуулгын хувьд 1) гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, 2) гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам, 3) гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ажилтны үүрэг, 4) анхны тусламж гэсэн дөрвөн ерөнхий сэдэв, эдгээрт хамаарах дэд сэдвүүд бүхий нийт 20 цагийн багтаамжтай, 3 түвшинтэй шаталсан сургалт байх нь зүйтэй гэж тодорхойлсон.

Гамшгаас хамгаалах сургалтыг бүх байгууллагад нийтлэг хэв загвараар явуулах боломжгүй, харин сургалтыг суралцагчийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан гаргасан цагт сая хүссэн үр дүндээ хүрнэ. Иймд сургалтыг байгууллага, аж ахуйн нэгжийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой онцлог, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, зонхилон тохиолддог аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын төрлөөс хамаарч сэдвийн болон цагийн хуваарилалтад өөрчлөлт хийхээр уян хатан байдлаар зохион байгуулах нь зүйтэй.

Зөвлөмж

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2.4-д төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны ангиллын сургалттай гэж, харин ОБЕГ-ын даргын 2016 оны А/130 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын нэр "Ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө" гэж зөрүүтэй томъёологдсон тул энэ ангиллын сургалтын нэршлийг нэг мөр болгох;

Байгууллагын үйл ажиллагаа, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, зонхилон тохиолддог аюулт үзэгдэл, ослын төрлөөс хамаарч сэдвийн болон цагийн хуваарилалтыг өөрчлөх боломжтой байдлаар сургалтын төлөвлөгөөг шинэчлэх;

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын нэгдсэн дүн мэдээг нарийвчилж гаргах нэгдсэн арга хэлбэрийг бий болгох;

Сургалтын чанарыг сайжруулах үүднээс ажилтан, албан хаагчдын сурч мэдсэн байх мэдлэг, чадварын хүрээг гаргаж, тэдгээрийг үнэлэх үнэлгээний арга хэлбэрийг бий болгох;

Албан тушаалтан, ажилтны ангиллын сургалтыг зохион байгуулах заавар боловсруулан гаргах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
- Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, 2011
- Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ, 2015
- Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, 2015
- Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах үндэсний зөвлөхийн ажлын тайлан
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний 4 дэх хөтөлбөр
- Үндэсний статистикийн хороо., Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ, 2017
- Хөтөлбөр батлах тухай., ОБЕГ-ын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаал
- Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах бодлого
- Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
- Гамшгаас өөрийгөө хамгаалах арга хэмжээний зааварчилгаа. 2009
- НҮБХХ, Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент зохицуулалтын чадавхыг сайжруулах нь төсөл, Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын тайлан, 2013
- Улсын иргэний хамгаалалтын төв штаб, Ажилтан, албан хаагчид, малчид, тариаланчдыг иргэний хамгаалалтын талаар сургаж бэлтгэх заавар, программ, норматив, 1985
- Онцгой байдлын ерөнхий газар, Монгол Улсын Иргэний хамгаалалтын түүхэн замнал, 2017
- Гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, 2005
- Д.Сэржмядаг., Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, 2017
- Ник Картер., Гамшгийн менежмент, (Орч. Ш.Болдбаатар) 2005
- П.Цэдэв., “Монгол Улсад Гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал” сэдэвт докторын диссертац
- С.Амгалан., “Гамшгаас хамгаалах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдэвт магистрын судалгааны ажил, 2015
- Б.Батбаяр., “Орон нутгийн Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог бий болгох нь” сэдэвт магистрын судалгааны ажил, 2016
- Б.Ядамжав., “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалтыг боловсронгуй болгох арга зам” сэдэвт магистрын судалгааны ажил, 2016
- С.Саруул., “Сургуулийн өмнөх боловсролд ахуйн ослоос өөрийгөө хамгаалах сургалтын арга зүйг нэвтрүүлэх нь” сэдэвт магистрын судалгааны ажил, 2017
- М.Батмөнх., “Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нь” сэдэвт магистрын судалгааны ажил, 2017

- Д.Бат-Эрдэнэ., “Онцгой байдлын байгууллагын чадамжид үзүүлэх сургалтын нөлөө” сэдэвт магистрын судалгааны ажил, 2018
- Г.Наранзул., "Гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг боловсронгуй болгох нь" сэдэвт магистрын судалгааны ажил, 2019
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр”
- EU, UNISDR and Kyoto University (2015) 1-2-3 of Disaster Education,
- Aleksandrina V. Mavrodieva*, Dyah S. Budiarti, Zhou Yu, Federico A. Pasha, Rajib Shaw., Governmental Incentivization for SMEs’Engagement in Disaster Resilience in Southeast Asia, 2019
- International Labour Organization., Needs assessment for the provate sector in Philippines:Disaster preparedness, response and recovery, 2015
- Программа обучения неработающего населения в области гражданской обороны и защиты от чрезвычайных ситуаций. МЧС
- http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=ISIC_4.0_2019.pdf&ln=Mn
- <https://businessjargons.com/training-process.html>
- <https://www.atdla.org/LearningProE-Zine/702237>

Ажилтан, албан хаагчдын гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг олгох сургалтын хөтөлбөр

Суралцахуйн зорилт	Хүлээгдэж буй үр дүн	Агуулга			Ашиглах материал
		Мэдлэг	Чадвар	Хандлага	
Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тухай ойлголт	-Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн бүр оролцох үүрэгтэйг ойлгуулах, -Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичгүүдийн тухай мэдэх -Гамшгаас хамгаалах мэдлэг, чадвартай болох	Гамшгаас хамгаалах тухай хууль, <i>Галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн заалтуудыг мэдэх</i>	-Гамшгаас хамгаалах анхан шатны арга эзэмших -Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичгүүдийг дурдах	-Гамшгийн үед авах анхны арга хэмжээг зөв гүйцэтгэх -Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүйн баримт бичгүүдийн тухай бусдад тайлбарлах	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003; Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 Улсын нөөцийн тухай хууль, 2007 Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, 2011 Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр. 2011
Гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам, амилуулах суурь тусламж	Гамшгийн эрсдэлийн тухай ерөнхий ойлголт Байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгаас өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах, эрсдэлийг бууруулах мэдлэг чадвартай болох	<i>Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын суурь шалтгаанууд, нөлөөлөх хүчин зүйлсийг мэдэх</i> Цаг агаарын гаралтай гамшгийн үед (цасан шуурга, их цас, зуд, шороон шуурга, үер, ой хээрийн түймэр, ган цөлжилт, аянга) өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах талаар мэдэх	-Гамшгийн эрсдэлийг тодорхойлох, бэлэн байдлаа хангах, өөртөө болон бусдад туслаж чадах -Өдөр тутмын урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлгийн үед тохирох арга хэмжээг авах -Мэргэжлийн байгууллагуудаас	Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар сурсан зүйлсээ амьдрал ахуйдаа хэрэглэх Өөртөө болон бусдад тусламж үзүүлэх	Дөрк Прайфер, Эрсдэлийн шинжилгээний ерөнхий ойлголт, эрсдэлд суурилсан шийдвэр гаргах, Лондонгийн их сургуулийн Хатан хааны мал эмнэлэгийн коллеж, “Шувууны томуугийн эрсдэлийн үнэлгээ” сургалтын материал 2010 П.Дамдин., Гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, 2005 Үржин О., Байгалийн болон технологийн үүдэлтэй аюул, ослын тухай ойлголт. Улаанбаатар. 2004; Үржин О., Гамшгийн менежмент. Дэд дэвтэр. Улаанбаатар. 2004; Ник Картер., Гамшгийн

			өгч буй мэдээг хүлээн авч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах		менежмент, 2005; Н.Баяраа, П.Дамдин нар., Монгол оронд тохиолддог аюулт үзэгдэл, гамшиг, сургамж, 2006
		Геологийн гаралтай гамшгийг ялгаж мэдэх (Газар хөдлөлт, хөрсний гулсалт) өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах талаар мэдэх	-Газар хөдлөлтийн үед гадаа болон байшин барилга, орон гэрт авах арга хэмжээ эзэмших -Геологийн гаралтай гамшгийн тухай гэр бүл, ойр тойрныхоо хүмүүст тайлбарлах		Газар хөдлөлтийн бvс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дvрэм /БНБД 22-01-01/; Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар /БД 31-102-00/; Монгол оронд тохиолддог аюулт үзэгдэл, гамшиг, сургамж, 2006; Байгалийн болон технологийн үүдэлтэй аюул, ослын тухай ойлголт, тэргүүн дэвтэр, Улаанбаатар 2004.
		Биологийн гаралтай гамшгийн үед (хүний болон мал амьтны халдварт өвчин) өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	-Хүн, мал амьтны халдварт өвчнүүдийг нэрлэх (тарваган тахал, боом, шувууны томуу, шүлхий болон шинэ болон дахин сэргэж байгаа өвчнүүд) -Халдварт өвчний үед авах арга хэмжээг дурьдах (ариутгал халдваргүйтгэл, хөл хорио тогтоох)	-Хувийн ариун цэврээ сахих, -Урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдах, -Хоол хүнсийг бүрэн болгох, -Сэжигтэй тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандах	Халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх талаар гарсан тогтоол, тушаал, заавар, журмын эмхтгэл - II, 2011; Эрсдэлийн шинжилгээ хийх чанарын арга, Лондонгийн их сургуулийн Хатан хааны мал эмнэлэгийн коллеж, “Шувууны томуугийн эрсдэлийн үнэлгээ” сургалтын материал, 2010; Өндөр хоруу чанартай вирусээр үүсгэгдсэн шувууны томуу өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний заавар Шувууны томуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны заавар

Амилуулах суурь тусламж	Эмнэлгийн яаралтай тусламж иртэл гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламжийг хэрхэн үзүүлэх	Амилуулах суурь тусламжийн тухай ойлголттой болох	Тухайн байгууллага болон ахуйн хүрээнд учирч болох гэмтлүүдийн (цус алдалт, яс хугарах, үе мултрах түлэгдэх, хөлдөх, усанд живэх) үед тусламж үзүүлэх чадвар эзэмших	-Анхны тусламж зөв үзүүлэх	Осол, гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж, ЭМЯ, МУЗН, 2005; Ник Картер., Гамшгийн менежмент, 2005; Аюулгүй амьдрах ухааны үндэс III сурах бичиг, 2011;
		Цус алдалт, цусыг түр тогтоох аргыг мэдэх	Цус алдалтыг түр зогсоож чадах	Цус алдахаас сэргийлэх	Эрүүл мэндийн тусламж үзүүлэх Монгол Улсын стандартууд
		Яс хугарах, үе мултарсан үед тусламж үзүүлэх аргыг мэдэх	Яс хугарах, үе мултарсан үед анхны тусламж үзүүлж чадах	Эмнэлгийн тусламж авах хүртэл зохих тусламжийг үзүүлэх	
		Түлэгдэлтийн 4 зэргийн тухай болон анхны тусламжийг хэрхэн үзүүлэх талаар мэдэх	Түлэгдэлтийн хүнд хөнгөнийг тодорхойлж, хүйтэн усанд дүрэх, шарх цэврүүг хагалахгүй, өвчинг намдаах арга чадварт эзэмших	Анхны тусламж үзүүлээд шаардлагатай бол эмнэлэгт хүргэх	
		Хөлдөлт, осголтын үед үзүүлэх анхны тусламжийг яаж үзүүлэхийг мэдэх	Хөлдөлтийг шинж тэмдгээр нь ялгадаг, дулаан байранд оруулан хөлдсөн үе мөчийг бүлээн усанд дүрэх, халуун зүйл уулгах	Улирлын болон цаг агаарын нөхцөлд тохируулан дулаан хувцаслах, цаг агаарын мэдээг сонсож хэвших	
		Усанд живсэн хүнд анхны тусламжийг яаж үзүүлэхийг мэдэх	Живсэн хүнийг зөв хэвтүүлэх, хиймэл амьсгаа хийх, амьсгалын замыг чөлөөлөх	Үертэй голын усанд орохгүй байх голын усанд орохдоо	

				болгоомжтой байх Хүүхдийг хараа, хяналтгүйгээр гол руу явуулахгүй	
Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заагдсан үүрэг хариуцлагын тухай ойлгох	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бүтэц, төлөвлөгөөг ямар үед хэрхэн хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын төлөвлөгөөнд өөрийн оролцоо үүрэг, Зарлан мэдээллэх дуут дохиогоор цугларах Нүүлгэн шилжүүлэлт Эрэн хайх, аврах үйл ажиллагааны зохион байгуулалт өөрийн оролцоог мэдэх	-Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд ажилтан, алба хаачид -Зарлан мэдээлэл, дуут дохиог ялгах, -Нүүлгэн шилжүүлэх журмын дагуу ажиллах,	-Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг хариуцлагаа ухамсарлах бусдад тайлбарлах -Зарлан мэдээллийн дагуу цугларах,	Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам” “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар” ОБЕГ-ын даргын 2013 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаал “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар” ОБЕГ,2013 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үлгэрчилсэн загвар, ОБЕГ,2013

Судалгааны асуулгын хуудас

Нэг. Ерөнхий мэдээлэл

<p>1. Байгууллагын төрөл</p> <p>a. ТББ b. Төрийн байгууллага c. Орон нутгийн засаг захиргааны байгууллага d. Их дээд сургууль e. Хувийн байгууллага</p>	<p>2. Үйл ажиллагааны үндсэн чиглэл</p> <p>a. Хөдөө аж ахуй b. Уул уурхай олборлолт c. Боловсруулах үйлдвэрлэл d. Цахилгаан, ус хангамж e. Барилга f. Худалдаа g. Үйлчилгээ h. Төрийн удирдлага i. Боловсрол j. Эрүүл мэнд k. Олон улсын байгууллага</p>
<p>3. Байгууллага үйл ажиллагаагаа явуулсан хугацаа</p> <p>a. 1-5 жил b. 6-10 жил c. 11-15 жил d. 16 –аас дээш жил</p>	<p>4. Асуулгын судалгаа бөглөсөн хүний албан тушаал</p> <p>a. Удирдах ажилтан b. ХАБ, сургалт, гамшгийн асуудал хариуцсан ажилтан c. ажилтан</p> <p>5. Асуулгын судалгаа бөглөсөн хүний тухайн байгууллагад ажилласан жил</p> <p>.....</p>

Хоёр. Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдлын мэдээлэл

<p>6. Танай байгууллагад дараах аюулуудаас аль нь тохиолдож болзошгүй гэж Та бодож байна вэ? Хэд хэдэн хариултыг зэрэг дугуйлж болно.</p>	
<p>a. үер b. хүчтэй салхи c. аянга d. газар хөдлөлт e. хүний гоц халдварт өвчин f. мал, амьтны халдварт өвчин g. гал, түймэр</p>	<p>h. химийн осол i. цацрагийн осол j. дэлбэрэлт, нуралт k. бусад (тодруулж бичнэ үү)..... l. эдгээрийн аль нь ч тохиолдохгүй m. мэдэхгүй</p>
<p>7. Танай байгууллагад гамшгаас хамгаалах сургалтыг жилд хэдэн удаа явуулдаг вэ?</p> <p>a. 1 удаа b. 2-оос дээш удаа c. хийдэггүй d. мэдэхгүй</p>	<p>8. Танай байгууллагад гамшгаас хамгаалах дадлагыг жилд хэдэн удаа явуулдаг вэ?</p> <p>a. 1 удаа b. 2-оос дээш удаа c. хийдэггүй d. мэдэхгүй</p>

<p>9. Танай байгууллагад доорх чиглэлээр сургалт, дадлага хийдэг үү? Хэд хэдэн хариултыг зэрэг дугуйлж болно.</p>	сургалт	дадлага
a. гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, эрх зүй баримт бичгийн тухай		
b. гамшиг, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах тухай		

c. цаг агаарын гаралтай аюулын (цасан шуурга, их цас, зуд, шороон шуурга, үер ой хээрийн түймэр, ган цөлжилт, аянга) үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах тухай	
d.	
e. гал түймрийн аюулын үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах тухай	
f. хүний болон мал амьтны халдварт өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	
g. химийн ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	
h. дэлбэрэлтийн ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдэх	
i. эмнэлгийн яаралтай тусламж иртэл гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламжийг үзүүлэх арга	
j. гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тухай	
k. зарлан мэдээллэх дуут дохиогоор цугларах	
l. нүүлгэн шилжүүлэлт	

10. Гамшгаас хамгаалах дадлага, сургуулийг ихэвчлэн зохион байгуулдаг талыг сонгоно уу?

- a. байгууллага өөрөө
- b. орон нутгийн онцгой байдлын байгууллага
- c. орон нутгийн удирдлага
- d. олон улсын байгууллага
- e. бусад
- f. мэдэхгүй

11. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах шаардлагатай гэж Та бодож байна уу?

- a. Тийм
- b. Үгүй
- c. Мэдэхгүй

12. Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаарх таны санал

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Гурав. Гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээний талаарх мэдээлэл

13. Танай байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сургалт, дадлагын чиглэлийг сонгоно уу? Хэд хэдэн хариултыг зэрэг дугуйлж болно.

- 1. гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал
- 2. гамшгийн эрсдэлийг бууруулах арга замын тухай
- 3. гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах арга
- 4. гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах арга

Судалгаанд оролцсон байгууллага, ажилтны мэдээлэл

№	Байгууллагын нэр	Хүний тоо	№	Байгууллагын нэр	Хүний тоо
1	441-р хорих анги	3	41	МУИС	3
2	62-р сургууль	3	42	Наранбилэг ХХК	3
3	Аав Мод	3	43	Наранбулаг Трейд ХХК	3
4	Айсмарк ХХК	3	44	Нарантуул Трейд ХХК	3
5	Алтан тариа	3	45	Номин Холдинг	3
6	Апекс ХХК	3	46	Об Пластик ХХК	3
7	АПУ ХХК	3	47	Ойн Бирж ХХК	1
8	АШУҮИС	3	48	Оргил Худалдааны Төв	3
9	Багануур ХХК	3	49	Өргөө амаржих газар	3
10	Байтаг Богд	2	50	Си Ю	3
11	Бат Хаан Амралт	3	51	Сиркл Ки	3
12	Баянгол Худалдааны Төв	3	52	Сод Монгол	2
13	БЗӨБЦТС ХК	32	53	Сөөхий	3
14	Би Цэ Трейд ХХК	3	54	Сүү ХХК	3
15	БНЦТСС	15	55	СХД ТЦҮ	3
16	БОАЖЯ	3	56	СХДНЭ	1
17	Булл Ресторан	3	57	Таван Богд	3
18	Бэнибана Кэмп	3	58	Талх Чихэр	3
19	Гранд Хилл Буудал Ресторан	3	59	Том эн Томс	3
20	ГХЯ	3	60	Траст Трейд	3
21	Да хүрээ трейд	3	61	Түмэн Плаза	3
22	Дашваанжил	3	62	Тэрэлж Моунтайн	3
23	Делта Холдинг	3	63	Тэрэлж Стар	3
24	Дүүхээ	3	64	Тэс Петролиум	1
25	ДЦС-3 ТӨХК	3	65	УБЦТСТӨХК	3
26	Жамо Гранд Трэвел	3	66	Улсын 2-р төв эмнэлэг	3
27	Жигүүр амралт	3	67	УНТЭ	3
28	Их Хуралдай	3	68	УСУГ	3
29	Кола энд Кебаб	3	69	УСУГ-ЦБА	3
30	Корса Паб	3	70	Хаан Хүнс ХХК	2
31	Макс Лайн ХХК	3	71	Хавдар судлалын үндэсний төв	3
32	Макс Ложинг ХХК	3	72	Ханбүргэдэй ХХК	3
33	Маргад Шилтгээн	3	73	ХКҮ ХХК	3
34	МБУС	1	74	ХНХЯ	3
35	Милко ХХК	3	75	Хорих 409-р анги	3
36	Мишээл Групп	3	76	ХӨСҮТ	3
37	Мойлтын тохой	3	77	Хүнс Комплекс	2
38	Монэнзим Мед ХХК	3	78	Цахиур ХХК	3
39	МТ ХХК	1	79	ЦДҮС ТӨХК	3

80	Цэргийн төв эмнэлэг	3	85	Эм Ойл ХХК	3
81	Шунхлай Трединг	1	86	Эм Си Эс Кока Кола	3
82	Шунхлай ХХК	7	87	ЭМТ	3
83	Эко Могоул ХХК, Амгалан зах	3	88	ЭМЯ	3
84	Эм Би Си ХХК	3	89	Этүгэн ИС	1
Нийт		89 байгууллага		293 ажилтан	

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг сайжруулах талаар таны санал

Ажлын байрны бодит сургалт

Албан ёсны сургалт жил бүр тогтмол явуулж, санамж бичиг, аюулгүй байдал тогтмол шалгах

Албан ёсны сургалт сард 1 удаа явуулж байх

Анхны тусламжийн үйлчилгээ

Асуултын 9 дэх хэсэгт заасан зүйлүүдээр байгууллага, хамт олон дунд жилд ядаж 1 удаа сургалт явуулж, ажилчдад мэдлэг олгох.

Аянга цахилгааны талаар сургалтаа сайжруулах шаардлагатай байх

Бага наснаас нь сургууль цэцэрлэг, сургуульд байх үеэс нь сургах, сургалтын хөтөлбөр оруулах. Пресентаци хэлбэрээс илүү дадлага сургууль, багаар ажиллуулах байдал илүү тус дэмтэй, хүнд үлдэцтэй.

Байгууллага дээрээ сургалт авах

Байгууллага өөрөө болон орон нутгийн онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны ажлын улирал бүр тодорхой хувиартайгаар ажилтан албан хаагч бүрт хүртээмжтэй сургаж дадлагажуулах шаардлагатай болов уу.

Байгууллага тус бүрт байдаг штабтай хамтран сургалт явуулж, харилцан мэдээлэл солилцох ОБЕГ-аас төрийн өмчит байгууллагаар сургалтыг улиралд 1 удаа явуулах

Байгууллагын онцлогт тохирсон хамтарсан сургалт зохион байгуулах.

Биет байдлаар жилд 2 удаа сургалт ормоор байна.

Бодит үзүүлж таниулах бааз дээр тулгуурласан байх, онол, дадлага хосолсон байх.

Бүх ажилтанд мэдээллийг өгч, сургалтанд бүрэн идэвхитэй хамруулдаг байх. Хурдан шуурхай хяналт тавьж ажилладаг байх.

Бүх ажилчдад сургалт зохион байгуулсан учир тогтвор суурьшилтай байх, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах

Бүх нийтийг хамарсан сургалт явуулбал дэмжиж ажиллахад бэлэн байна.

Гамшгаас хамгаалах дадлага сургуулийг иргэдийн дунд маш сайн ухуулан таниулж, албан байгууллагуудыг сайн хамруулах хариуцлага тооцдог байх, гамшгийн сургалт болох үед хорооны ажилтнуудыг сайн хамруулах (Хорооны ажилтнууд муу ажилладаг)

Гамшгаас хамгаалах дадлага сургуулийг сар бүр зохион байгуулах, нүүлгэн шилжүүлэх дадлага бодитоор хийх

Гамшгаас хамгаалах сургалт болон галын аюулгүй байдлын сургалтыг тухайн орон нутгийн ОБХ-ээс жилд 1-2 удаа явуулах төлөвлөгөө эсвэл хуваарь гаргаж тухайн байгууллагад сургалт хийх.

Гамшгаас хамгаалах сургалт дадлагыг багийн бүрэлдэхүүнд томилогдсон хэдхэн хүний хүрээнд л явагддаг. Нийт ажилтнуудын хүрээнд явагдахгүй байна.

Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааг хүн бүрт хүртээмжтэй болгох.

Гамшгаас хамгаалах сургалт тун бололцооны хэмжээнд сургалт таниулга зохион байгуулагддаг

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагад шаардагдах төсвийг жил бүр хангалттай төсөвт

суулгаж байх (Дээд байгууллага төсвийг танахгүй суулгах). Иргэн хүн бүрт мэдлэг суулгах.

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг зохион байгуулж явуулан багш, ажилчид, сурагчдын аюулгүй байдал болон гамшгийн нөхцөлд хэрхэн өөрийгөө болон бусдыг хамгаалахад суралцуулах.

Гамшгаас хамгаалах сургалтыг жилд 2-с доошгүй удаа явуулж байх, Гамшгаас хамгаалах дадлагыг сайжруулах хэрэгтэй. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар УЗН-тэй хамтран ажиллах талаар санал солилцож, байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхижүүлэх.

Гамшгаас хамгаалах сургалтын талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол гаргах

Гамшгаас хамгаалах тухай детальчилсан сургалт - жишээ нь: галын хорыг хаана яаж байрлуулах, галын хорыг яаж ашиглах гэх мэтээр.

Гамшгаас хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, хоргодох байрны талаар сургалт түлхүү оруулах, гал унтраах дадлага бодитоор хийлгэх

Гамшгийн сургалт дадлагыг авах

Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга аргачлал, эрсдэлийг бууруулах, хамгаалах төлөвлөгөө боловсруулах

Гамшиг болон давагдашгүй хүчин зүйлийн талаар сургалт, сурталчилгаа сайтар зохион байгуулах

Графикийн дагуу жил бүр явуулах

Давтамжийг нэмэгдүүлж, тухайн байгууллагад тохирсон.

Дадлага, сургалтыг тогтмол явуулж байх.

Дадлага, сургалтын чанарыг сайжруулж, давтамжыг нэмэгдүүлэх

Дадлагыг сайжруулах

Дүүрэг, Улсын онцгой байдлын газар байгуулагддаг жишиг үзүүлэх сургалт хийх эсвэл ажилчдаас ихэнхийг хамруулан танхимийн сургалт заагаад дараа нь практик дадлага явуулж байвал хүмүүст илүү хүртээмжтэй.

Жил бүр дүүргийн хэмжээнд дадлага, сургалтыг нийт иргэдийн дунд зохион байгуулж байх

Жилд 1-2 удаа хийхэд хангалттай

Жилд 2-оос доошгүй удаа дадлага хэлбэрээр зохион байгуулах

Жилдээ 1-2 удаа сургалт зохион байгуулаад тэр сургалтанд бүх ажилчдаа хамруулах.

Зөвлөмж ирүүлж байх

Илүү бодитой үр дүнтэй сургалт, дадлага хийлгэж, утга учрыг нь сайн таниулах

Иргэний боловсролыг сайжруулах

Иргэний хамгаалалтын сургалтыг 3-аас доошгүй хоногоор бодит байдалд зохион байгуулах

Компани болгонтой тулж ажиллавал зүгээр.

Манай байгууллагын үйл ажиллагаанд тохирсон сургалт явуулбал маш хэрэгтэй.

Манайх улирлын чанартай ажилладаг. Иймээс гал түймэр, үерийн талаар сургалт хийх нь зүйтэй байх

Мэргэжлийн байгууллага тодорхой зохион байгуулалттайгаар сургалт явуулж байх.

Мэргэжлийн байгууллагаас сургалт, дадлага авч байх.

Мэргэжлийн байгууллагаас танхимын болон дадлага сургуулийг тогтмол хийх.

Мэргэжлийн байгууллагаас явуулж буй сургалт, дадлагыг хувийн хэвшлийн ресторан, албан газруудад мэдээгээр хангаж, байнгын сургалт өгөх.

Мэргэжлийн хүмүүс хүрэлцэн ирж нэгдсэн сургалт явуулах.

Нарантуул ОУХТ, Онцгой байдлын байгууллагатай хамтарсан танхимын сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж хэвших.

Нийслэл болон дүүргийн ОБГ-тай хамтарч төлөвлөгөө боловсруулж, дадлага сургуулийг хамтарч хийх.

Нийслэл, дүүргийн ОБГ-аас байгууллагад сургалт явуулах эсвэл сургалтын материалаар хангах. ОБ-н сургуулилыг жилд 1 удаа биш олон давтамжтайгаар хүргэх.

Нийт ажилчдыг бүрэн хамруулах. Байнга бэлэн байх, онол дадлагыг бүрэн эзэмшүүлэх.

Нийт иргэдийг заавал хамруулах шаардлагатай, ажилгүй иргэд мөн адил

Нийтийг хамарсан гамшгийн үед ажиллах, зарлах мэдээлэх дохиогоор ажиллах

Нийтийг хамарсан сургалт зохион байгуулах. Нийтийн сүлжээг ашиглан бичлэг хүргэх.

ОБГ болон Анхны тусламжийн мэргэжлийн сургалтыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэж байх.

ОБЕГ-тай хамтран сургалт явуулах нь үр дүнтэй.

ОБХ-тэй хамтарсан, яг байгууллагад нь тохирсон дадлага сургуулилт зохион байгуулах хэрэгтэй. Албан бичгээр заавал хамрагд гэсэн захирамжтай.

Одоо үйлдвэртээ мөрдөж байгаа дадлага, сургалтыг цаашид өргөн хүрээтэй, мэдлэгийн хүрээгээ улам өргөжүүлэн, баталж, тоног төхөөрөмжийг сайн эзэмшиж сурах.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга цацах

Онолын сургалтаас гадна практик сургалтыг түлхүү орох

Онцгой байдлын албаны албан хаагчдын оролцоог багасгаж ажилтнуудыг илүү хамруулсан сургалт хийх, байгууллагын онцлогт тохирсон бодит дадлага хийх.

Орон нутгийн Онцгой байдлын алба нь байгууллагуудтайгаа хамтарч ажиллах

Орчин үед хэрэглэгдэж буй тоноглолыг нэвтрүүлж, сургалт хийх

Практик дадлага, сургалт хийх нь илүү үр дүнтэй

Сургалт, дадлага хослуулан ажиллах мөн сургалтанд хамрагдсан хүн бүрээс түүврийн бусаар эргэж шалгадаг байх

Сургалт, дадлагад сууж байгаагүй болохоор санаа бодол алга

Сургалт, дадлагыг сайн, олон хийх

Сургалт, сурталчилгаа, дадлага сургууль тухайн байгууллага дээр ирж хийх.

Сургалт, танин мэдэх зүйл сайн хийх.

Сургалтаа байгууллага дээрээ хийж, зохион байгуулах

Сургалтанд олон хүн хамруулах, дадлагыг хийж байнга тасралтгүй явуулах

Сургалтыг ажил болгон биечлэн заан, байгууллагуудын дунд үзүүлж, сургууль, тэмцээн

зэрэг хийх

Сургалтыг ажил хэрэг болгож биечлэн заах, байгууллагуудын дунд үзүүлэх сургууль, тэмцээн зэрэг байдлаар.

Сургалтыг биечлэн заах, үзүүлэх сургууль, АСТ тэмцээн зэрэг.

Сургалтыг жилд дор хаяж 2 удаа зохион байгуулдаг байх.

Сургалтыг мэргэжлийн албан байгууллага, багш нараар оруулах.

Сургалтыг цаг тухай бүрт нь авч байх саналтай байна.

Сургуулийн насны хүүхдүүдэд сургалтыг тогтмол оруулах. Биеэр мэдрэх үзүүлэн, төвүүдийг олшруулах.

Техник хэрэгсэл, түр хоргодох байр бэлтгэх.

Тодорхой төлөвлөгөө гарган олон нийтэд танилцуулах.

Тусгай зориулалтын ангид эрх нь хасагдсан хүмүүст гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх сургалтыг зохион байгуулах, аргачлалыг заах

Тухайн байгууллага, ААН-ийн үндсэн үйл ажиллагаа, онцлогт тохирсон эрсдэлийг урьдчилан тооцоолсон дадлага, сургууль зохион байгуулдаг байх.

Тухайн байгууллагын газарзүйн байршил, барилга байгууламжийн хийц зэргээс хамааран байгууллага дээр ажилчдыг хамруулсан сургалтыг 3 болон 10 саруудад хийх

Урьдчилан сэргийлэх дадлага сургуулилыг улирлын онцлогт тохируулан мэргэжлийн болон сургагч багшаар заалгах.

Үечилсэн дадлага, сургалт тогтмол хийх

Харуул хамгаалалтын албанд тусгайлсан сургалт өгөх хэрэгтэй бас дадлага хийлгэх.

Химийн ослын хор холбогдол, яаж урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийн талаар.

Хорих ангийн Онцгой нөхцөл байдалд тохирсон сургалтыг явуулах.

ХУД-ийн ОБГ, НОБГ, Нийслэлийн хэмжээнд жилд 1 удаа дадлага, сургуулилыг зохион байгуулдаг байна.

Хүн бүрт хүртээмжтэй сургалт зохион байгуулах

Хүн нэг бүрийн ерөнхий мэдлэгийг сайжруулах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, Ттоног төхөөрөмж дээр ажиллуулж сургах.

Хэт нуршуу бус

Эмнэлгийн яаралтай тусламж иртэл гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламжийг үзүүлэх арга.

Яаралтай тусламж үзүүлэх (амь тэмцсэн үед) гардан ажилбарыг дадлагажуулах

Байгууллагад шаардлагатай байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сургалт, дадлагын талаарх санал

Албадан хамруулдаг байдлыг зогсоож, ажилтан бүр хамгаалах чадварт суралцах итгэлтэй болгох сэтгэлгээг төлөвшүүлэх, танхимын сургалтыг багш орж дадлага, сургуулийг зохион байгуулах.

Анхны тусламж

Анхны тусламжийн сургалт гамшгийн үед яаж зохион байгуулалтанд богино хугацаанд орж ажиллах, хэрхэн холбоо барих, гамшгийн үеийн хангамж хэрхэн бүрдүүлэх. Ар гэрийнхнийгээ хэрхэн хамгаалах, ар гэртээ хангамж бүрдүүлэх. Болж өгвөл үр хүүхэд гэр бүлээрээ гамшгийн үед хэрхэн өөрсдийгөө хамгаалах талаар сонирхолтой байдлаар дадлага хийх.

Анхны тусламжийн үзүүлэх сургалт, мэдлэг олгох, Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах талаар мэдлэг олгох.

Байгууллага гамшгийн үеийн шаардлагатай зүйлсийн хангалт, нөөц бүрдүүлэлтийг хийх, штабын бие бүрэлдэхүүний үүргийг тодорхойлох

Байгууллагын нийт ажилтнуудыг хамарсан дадлага сургуулилт зохион байгуулах.

Байгууллагын удирдлагууд, мэргэжлийн ангийн гишүүдэд танхимын сургалт шаардлагатай. Танхимын сургалт орсон дараа дадлага сургуулилт хийх нь үр дүнтэй болно гэж үзэж байна. Мэргэжлийн ангируу чиглэсэн сургалт дутагдалтай санагддаг.

Бидний ажиллаж, амьдарч буй орчин нөхцөлд тохирсон сургалт, дадлага явуулах нь нэн шаардлагатай гэж үзээд: Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед ажиллах арга барил, гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ, анхны тусламж үзүүлэх, гамшгийн үеийн зохион байгуулалт авах арга хэмжээ, гамшгийн үеийн шаардлагатай зүйлс, нөөц бүрдүүлэлт гэх мэт. Ер нь л бол бүх сургалтууд шаардлагатай гэж бодож байна.

Бодит дадлага зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээтэй хамт дадлага зохион байгуулах.

Бодитой дадлага сургууль явуулах, яаралтай анхан шатны тусламж үзүүлж чаддаг байх.

Бүх ажилтнуудыг хамруулсан шуурхай бүлгийг ажиллуулж хүмүүсээ гаргах, объектийн аюулгүй байдлыг хангах дадлага сургуулилт

Гал түймрийн тухай сургалт мэдээ мэдээллийг хангалттай өгдөг

Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга зам, Зарлан мэдээллийн дохигоор ажиллах, Дадлага сургууль зохион байгуулах.

Гал түймэр унтраах арга, гамшгийн үеийн хоргодох байр буюу нүүлгэн шилжүүлэх талбай, зохион байгуулалт, гамшгийн үеийн шаардлагатай зүйлсийн хангалт, нөөц бүрдүүлэлт.

Гал унтраах арга заавар, аюулаас сэргийлэх аргын тухай дүрс бичлэг үзүүлэх, ОБХ-ийн байгууллагуудад зориулсан бүтэц, схемийн гарын авлага, сар бүр мэдээллээр хангаж байх. Химийн бодисын гамшгаас хамгаалах нарийвчилсан төлөвлөгөө (хүчил, шүлт, аммиак, нүүрс хүчил...) Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний талаар дүрст хичээл, мэргэжлийн сайн тоглолттой дүрс.

Галын аюулгүй байдлын сургалт

Галын болон анхны тусламж үзүүлэх сургалт, дадлагыг мэргэжлийн байгууллага, хувь хүнээс авах

Галын болон осол гэмтэл, эрсдэлийн талаар сургалт явуулах.

Галын ослын үед шаардагдах гал унтраах хэрэгсэл цаг хугацаа, он шинэ байх

Галын сургалт, онолоор, дадлагаар орох. Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлт хоргодох байрны талаар байвал зүгээр байх гэж бодож байна.

Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг мэргэжлийн хүмүүсээр заалгах.

Гамшгаас хамгаалах сургалтын хамтарсан төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах бүхий л чиглэлээр хамтран ажиллахад бэлэн байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, хамтран ажиллах байгууллагын уялдаа зэргийг бодитой хийх (Одоогоор цаасан дээр л байгаа болохоос бодитой бус байна). Нийт ажиллагсдын мэдлэг, дадлыг сайжруулах талаар сургалт оруулдаг байх. Хичээл, сурталчилгаа цахим хэлбэрээр байх нь чухал.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой практик дадлага, сургуулилт. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу ажиллах анги, бүлгийн ажилтнуудын гүйцэтгэх үүргүүдийг нарийвчлан зааварлах. Цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах тухай сургалтууд.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой сургалт, дадлагыг бүхий л чиглэлээр олон ажилтныг хамруулан байнга хийж байх нь зүйтэй. Байгууллага дотроо зохион байгуулахаас гадна мэргэжлийн байгууллагаас албан тушаалтан ирж сургалт зохион байгуулах нь илүү ач холбогдолтой байдаг.

Гамшгийн үед байгууламж дотор байгаа хүмүүсийг түргэн шуурхай гаргаж, нүүлгэн шилжүүлэх, анхны тусламж үзүүлэх.

Гамшгийн үед манай байгууллагын мэргэжлийн анги хэрхэн оролцох талаар бодит сургалт хэрэгтэй байна.

Гамшгийн үед удирдлага /штаб/, мэргэжлийн ангийн, бүлгийн ажлын уялдааны талаарх сургалт авах

Гамшгийн үеийн холбоо зохион байгуулалтын талаар дадлага.

Гамшгийн үеийн эрсдэлийг үнэлэх аргачлал. Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах. Дээрхи сэдвийн сургалтуудыг системтэй, давтамжтай явуулах. Мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, нүүлгэн шилжүүлэх, анхны тусламж үзүүлэх, мөн гамшиг ослын үед ажиллах баг бүрэлдэхүүнийг бүрэлдэхүүнийг бэлдэх.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тухай, гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлт хийх тухай

Гамшиг ослын талаар нийт ажилчдад сургалтын цаг улиралтайгаа холбоотойгоор сургаж таниулах

Дадлага сургууль зохион байгуулах.

Дадлага, сургуулийн давтамжыг нэмэгдүүлэх. Шинээр орж байгаа ажилтан бүрийг ОБЕГ-н Гамшгийн сургалт мэдээллийн төвд сургалтанд хамруулж байх. Шинэ ажилтан сургалтын хөтөлбөрт сургалтын хөтөлбөрийг хамруулж сургалтыг явуулдаг байх. Сургалтын мэдээллийг видео, шторк байдлаар олон нийтэд байнга түгээж байх.

Жил бүр 2-оос доошгүй удаа сургалт, дадлагыг Нийслэлийн онцгой байдлын газраас мэргэжлийн сургагч багшаар семинар, дадлага хийлгэх.

Жилд 1 удаа сургалт явагдаж байгаа нь сургалтын зай хэт хол, дадлагажих хугацаа урт байсан. Ажлын байрны бодит, дадлагажуулах сургалт хийх шаардлагатай байх.

Жилд 2-3 удаа сургалт явуулдаг мөн мэдээлэл сайн байдаг.

Жилд тогтмол хугацаанд, жилдээ 2-3 удаа бүх эмч ажилтанг хамруулсан сургалтыг хийж хэвших. Бүх эмч ажилтанг бүрэн хамруулсан дадлага сургалтыг давтамжтай хугацаанд хийж хэвшүүлэх шаардлагатай байна.

Жилд хийж байгаа сургалтаа тогтмолжуулж, давтамжыг нэмэх.

Иж бүрэн үүргэвч биедээ авч явах, зайлшгүй шаардлагатай зүйлстэй 50 ширхэгээс доошгүй багцыг байнга бэлэн байлгах, удирдах НТА нарыг нэг заводын хувцасаар хангах

Манай байгууллагыг хариуцсан улсын газартай хамтарч бүх ажилчиддаа гамшгийн үед хэрхэн аврах ажиллагаа явуулах, тухай сургалт дадлагыг тогтсон хоногуудад авч байх.

Манай байгууллагын хувьд сургалт, дадлагын үйл ажиллагаа хэвийн зохих түвшинд явагдаж байгаа. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн томилгоожсон, байгууллагад албаны гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх.

Манай цэвэрлэх байгууламжийн онцгой нөхцөлд тохирсон сургалт түүнтэй холбоотой дадлага хийх шаардлагатай, мөн хорт хийтэй хэрхэн харьцах, үүсч болох хор уршгаас сэргийлэх арга замуудын талаар

Мэргэжлийн байгууллагаас үечилсэн сургалтыг тогтмол хийж нийт ажилчдыг бүгдийг нь хамруулж байх, жил бүр.

Нарантуул ОУХТ-ийн удирдах бүрэлдэхүүн, албан тушаалтнуудад Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулах, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой шинэ стандарт, дүрмийн талаар сургалт зохион байгуулах (сургалт нь зөвхөн худалдаа үйлчилгээний буюу Нарантуул ОУХТ-тэй холбоотой байх шаардалагатай. Нарантуул ОУХТ-н түрээслэгч нарт чиглэсэн сургалтыг түлхүү зохион байгуулах.

Нүүлгэн шилжүүлэлт, зарлан мэдээллэх

Нүүлгэн шилжүүлэлтийн талбайтай болох тус талбайд үзүүлэх сургуулилт, бэлтгэл, сургалт орох боломжтой байх. Газар хөдлөлтийн гамшгийн сургуулилтийг Гамшиг судлалын хүрээлэнд хийх. Гамшгийн болоод эрүүл мэндийн анхан шатны тусламжийн дотоод сургагч багштай болох. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилсэн загвараар хийх, сургалтыг ШТС-ын менежерүүдэд орох. Мэргэжлийн анги бүрэлдэхүүнийг чадавхжуулах, сургалт орох тал дээр хамтран ажиллах, ажилдаа дадлага сургуулилт хийлгэх саналтай байна.

Одоо хэрэгжүүлэн ажиллаж байгаа: 1.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дахин сайжруулах. 2. Нийт ажилтнуудад Гамшгаас хамгаалах сургалт, түүний тухай ойлголтыг сайн өгөх, мэргэжлийн байгууллагатай хамтрах, 3. Хамтарсан дадлага сургуулийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах 4. Галын аюулгүй байдлын тухай сургалт, дадлагыг жилд 2 удаа зохион байгуулж байх.

Онцгой байдал, гамшгийн үеийн удирдлага, удирдлагын байр, холбоо зохион байгуулах.

Онцгой байдлын үед дуут дохиогоор цуглах цэгтээ ажилчид цугладаг. Үүнээс цааш ямар үйл ажиллагаа явагддаг вэ? Өөр үүрэг оролцоо байгаа бол түүний талаар сургалт авъя. Харуул хамгаалалтын албанд онцгой байдлын үеийн үүрэг оролцооны талаар дадлага, сургуулилт авъя.

Сургалт болоод дадлагыг улирал бүр чанартай сайн зохион байгуулах хэрэгтэй.

Сургалт хийх цагийг нэмэгдүүлэх, цагыг үр ашигтай зарцуулж сурах.

Сургалт, дадлагыг тогтмол явуулж байх. Гамшгийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах дадлага, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж байх.

Тогтвортой ажиллагааны төлөвлөгөө, дадлага сургууль зохион байгуулах, хүний болон мал, амьтны халдварт өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах, химийн болон дэлбэрэлтийн ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах.

Удирдах түвшний ажилтнуудад сургалтыг сайн зохион байгуулах.

Улирал бүр сургалт явуулж байх шаардлагатай.

Улирлын онцлогт болон байгууллагын онцлогт тохирсон сургалтыг мэргэжлийн багш сурагчаар сургалтыг зориулалтын орчинд зохион байгуулах.

Үер ус, гамшиг, ослын үед хэрхэн ажиллах, гал унтраах дасгал сургуулилтыг бодитой байлгах

Үер усны аюулаас хамгаалах арга зам, зарим хэрэгсэлийг ашиглах сургалт зохион байгуулах

Үер, уснаас хамгаалах, гал түймрээс хамгаалах, эмнэлгийн яаралтай тусламж иртэл гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламж үзүүлэх тухай сургалтын талаар орвол тун зүгээр байна

Химийн бодистой хэрхэн харьцах мөн анхны тусламж, үйлдвэрлэлийн осол, хэрхэн сэргийлэх гэх мэт сургалт.

Цахилгаан эрчим хүчний өөр эх үүсвэрээс холбох шугам, дэд станц барих

Цацраг идэвхит бодисын хордлогоос сэргийлэх, нүүлгэн шилжүүлэх холбоо зарлан мэдээлэх сургуулилт

Цацрагын аюулын үеэр авах арга хэмжээ, шинэ оношлогооны төв байгуулагдсантай холбоотойгоор шинэ эрсдэл нэмэгдсэн. Гамшгийн үед хэн, хэзээ, яаж ажиллах талаар хүмүүст хэвшүүлэх, Дадлага сургуулилтын давтамжийг нэмэгдүүлэх хувь хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх

Чанартай сургалт авах, байгууллагад тохирсон сургалт авах. ОБГ, МУЗН зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд тогтмол оролцуулах.

Шаардлага байгаа эсэхийг сайн мэдэхгүй байна.

Шатамхай шингэнтэй хэрхэн зөв харьцах, гал унтраах үзүүлэх сургалт.

Шинээр нэвтрүүлж байгаа болон манай оронд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж, шинэ содон мэдээ, мэдээллийг сургалтаар авч байх

Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх сургалт шаардлагатай

АВРАГЧ, ГАЛ СӨНӨӨГЧИЙН ХҮЙТНИЙ УЛИРАЛД ӨМСӨХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХУВЦАСНЫ ДУЛААЛГАНЫ ШИНЭ ШИЙДЛИЙН СУДАЛГАА

А.Ариунбилээ

ГСХ-ийн Секторын эрхлэгч, докторант, хошууч

Оршил

Монгол орны газар нутаг далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евроазийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай юм. Манай орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөрөгийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг. Монгол орны жилийн дундаж температур 0.2°C , өвлийн улирлын дундаж температур $-10^{\circ}\dots-30^{\circ}\text{C}$, зуны улирлынх нь $10^{\circ}\dots27^{\circ}\text{C}$ байдаг байна.

Жилийн аль ч улиралд, ямар ч цаг агаарын нөхцөл байдалд Онцгой байдлын байгууллагын аврагч, гал сөнөөгчид ард иргэдийнхээ аюулгүй байдлын төлөө гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх үүргээ биелүүлдэг. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1-д заасны дагуу аврагч, гал сөнөөгчид аврах ажиллагаанд тусгай зориулалтын, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг өмсөж оролцдог.

Онцгой байдлын байгууллагад ашиглаж байгаа тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн ихэнх хувийг гадаад улс орнуудын импортын бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд эдгээр хувцас хэрэглэл нь тухайн аврах ажиллагаанд зориулсан хамгаалах чадвартай боловч эрс тэс уур амьсгалтай Монгол орны хүйтний улиралд дулаан хадгалах чадвар хангалттай биш учир аврагчид үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй байдаг. Жишээлбэл гал сөнөөгчид өвлийн улиралд үүрэг гүйцэтгэхэд байлдааны хувцасны дулаан тусгаарлах давхаргаас өөр дулаалга байхгүй тул өвлийн хээрийн хувцасны нэхий давхаргыг байлдааны хувцасны дотуур өмсдөг байна. Энэ нь зориулалтын бус учир ажиллагааны үед тусгай хувцсыг хөшүүн, хүнд болгож, хөдөлгөөн хязгаарлах, ажиллагааны дараа норж улмаар хээрийн хувцсандаа өмсөхөд дарайн хатаж, хэв хэлбэрээ алдан зориулалтын хувцсандаа шаардлага хангахгүй болдог.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг хөнгөн, хямд, биед тааламжтай, дулаан тусгай зориулалтын хувцсаар хангах асуудал тулгарч байна. Шинэ нэр төрлийн дулаалгын материал, дулаан хувцас хийхээр судалж байгаа судлаачдын бүтээлийг харахад байгалийн гаралтай тэр дундаа амьтны гаралтай ширхэгтийг нарийн судалж түүний дутагдалтай талыг багасгах, харин онцлог давуу талыг бусад химийн гаралтай ширхэгтүүдэд олгох, ижил төстэй ширхэгт материал бий болгоход чиглэгдэж байна. Ингэхдээ уламжлагдан ирсэн технологид тулгуурлан улам

боловсронгуй болгохын зэрэгцээ шинэ нэр төрлийн дулаалгын материал, дулаан хувцсыг судалсаар, хийсээр байна.

Байгалийн болон химийн гаралтай ширхэгт ашиглан дулаан хувцас, дулаалгын давхарга үйлдвэрлэсээр ирсэн боловч сүүлийн үед байгалийн гаралтай ширхэгт тэр дундаа амьтны ноосыг дулаалгад хэрэглэхийг илүү ихээр зорих болжээ. Иймээс үйлдвэрийн хоёрдогч түүхий эд болох тэмээний сэв үсийг сул ширхэгт хэлбэрээр хэрэглэн түүнийг хувцсанд дулаалга болгон ашиглах технологийг судлан үзэх нь зүйтэй юм.

Судалгааны ажлын зорилго

Цаг уурын хүйтэн нөхцөлд тохирсон дулаан, хөнгөн, биед тааламжтай, сул ширхэгтэн дулаалгын материал болох тэмээний ноосыг Онцгой байдлын аврагч, гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцсанд нэмэлт дулаалга болгон ашиглах боломж, үндэслэлийг судлахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт

Энэ зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

- Аврагч, гал сөнөөгчийн хүйтний улирлын хувцас хэрэглэл, хөдөлмөрийн нөхцөл байдлыг судлах
- Ноосон дулаалгыг аврагч, гал сөнөөгчийн өмсөж буй хүйтний улирлын тусгай зориулалтын хувцсанд ашиглах боломжийг судлах
- Хүйтний улиралд өмсөх тусгай зориулалтын хувцасны дулаалгын материалын үр ашгийн тооцоог хийх зэрэг болно.

Судалгааны объект

Хувцасны зориулалттай хонь, тэмээний ноосон дулаалгын материал

Судалгааны арга

Судалгааны ажлын зорилгыг биелүүлэхэд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах болон туршилтын арга хэрэглэв.

Судалгааны ажлын хязгаарлалт

Гал сөнөөгчийн байлдааны хувцсанд ноосон дулаалга ашиглах боломжийг судлана.

Судлагдсан байдал

Монгол судлаачид хонь, тэмээний ноосны дулаан хадгалах чадварыг судлан, түүний шинж чанарыг ашиглан төрөл бүрийн дулаан хадгалах бүтээгдэхүүн гарган авсан байна. Үүнд доктор М.Баярын “Цаг уурын хүйтэн нөхцөлд ажилчдын хувцасны судалгаа боловсруулалт”, доктор П.Булгын “[Хувцасны зориулалттай мембран бүтэцтэй сул ширхэгтэн дулаалгын үеийн судалгаа, боловсруулалт](#)” зэрэг бүтээлүүдийг нэрлэж болно. Эдгээр судалгаа дээр үндэслэн Монгол орны эрс тэс цаг уурт тохирсон, хонь тэмээний ноосон дулаалгыг ашиглан тусгай зориулалтын хувцсанд зориулсан шинэ дулаалгыг шийдэх боломжийг судлаж үзэх юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АВРАГЧ, ГАЛ СӨНӨӨГЧИЙН ХҮЙТНИЙ УЛИРЛЫН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХУВЦАСНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Аврагч, гал сөнөөгчийн хүйтний улирлын хувцас хэрэглэл, хөдөлмөрийн нөхцөл байдалд хийсэн судалгаа

Аврагч, гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцасны дулаалгын шинэ шийдлийг олохын тулд аврагчдын одоо өмсөж, ашиглаж ажил үүргээ гүйцэтгэж буй хувцас хэрэглэл болон хөдөлмөрийн нөхцөл, байдлыг судлаж үзлээ.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ”, 3 дугаар зүйлийн 3.1.8-т “цэргийн байгууллага” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргээдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг хэлнэ” хэмээн заажээ. Иймд Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн алба хаагчдын хувцас хэрэглэлийн загварыг баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар, эдэлгээний хугацааг Засгийн газрын 2018 оны 41 дүгээр тогтоолоор тус тус баталж Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2017 оны 493 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийн дагуу өмсөж хэрэглэдэг.

Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэмд зааснаар дүрэмт хувцас гэдэг нь Цэргийн жинхэнэ алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, цэргийн албаны болон цэргийн анги, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, жигдрүүлэхийн тулд хүн нэг бүрт эдэлгээний хугацаагаар олгогдсон хувцас, хэрэглэл юм.

Цэргийн дүрэмт хувцсыг:

- Ёслолын хувцас;
- Албаны хувцас;
- Хээрийн хувцас;
- Тусгай зориулалтын хувцас, хэрэглэл гэж ангилна.

Ёслолын хувцас гэдэг нь Цэргийн алба хаагч ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ, баяр ёслолд оролцохдоо өмсөхөд зориулагдсан цэргийн дүрэмт хувцсыг хэлнэ.

Албаны хувцас гэдэг нь Цэргийн алба хаагч ёслолын болон хээрийн хувцас өмсөхөөс бусад өдөр тутмын үйл ажиллагаа, хичээл сургууль, албаны арга хэмжээнүүдэд өмсөхөд зориулагдсан цэргийн дүрэмт хувцсыг хэлнэ.

Хээрийн хувцас гэдэг нь Цэргийн алба хаагч хуульд заасан үндсэн болон тусгай үүрэг гүйцэтгэх, хээрийн сургууль дадлагад оролцох байлдааны жижүүрлэлт, харуул манаанд үүрэг гүйцэтгэх үед өмсөхөд зориулагдсан цэргийн дүрэмт хувцсыг хэлнэ.

Цэргийн алба хаагчийн хувцас хэрэглэлийг улирлаас нь хамааруулан дулааны, хүйтний гэж ангилна. Дулааны улирлыг 04 дүгээр сарын дунд үеэс эхлэн 10 дугаар сарын дунд үе хүртлэх, хүйтний улирлыг 10 дугаар сарын дунд үеэс эхлэн 04 дүгээр

сарын дунд үе хүртлэх хугацаа гэж ойлгоно. Хүйтний улиралд ёслолын болон албаны хувцсанд савхин дээл, цегейк малгай, урт ханцуйтай цагаан болон цэнхэр цамц, савхин бээлий, ноосон ороолт, өвлийн гутал, өмсдөг бол, хээрийн хувцсанд нэхий дотортой хүрэм, өмд, цегейк малгай, савхин бээлий, ноосон ороолт, ноосон цамц, хагас түрийтэй өвлийн гутал өмсдөг.

Тусгай зориулалтын хувцас хэрэглэл

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдад тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг дүрэмт хувцаснаас гадна тухайн аврах ажиллагааны үед өмсөх зориулалтаар олгодог. Тусгай зориулалтын хувцас, хэрэглэл гэдэг нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны үед үүргээ хэвийн гүйцэтгэх, дадлага сургуулилт хийхэд албан хаагчийг гадны нөлөөллөөс хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий ажлын хувцас, хамгаалах хэрэглэл юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1-т “Гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах” эрх эдэлнэ хэмээн заасан байдаг. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн нэр төрөл, эдэлгээний хугацааг Шадар сайдын 2011 оны 62 дугаар тушаалаар баталсан бөгөөд аврах ажиллагааны төрлөөс нь хамааран аврагчийн, усны, цацрагийн, химийн, инженер сапёрын, шүхэрчний, уулын аврах ажиллагааны, гал сөнөөгчийн, авто засварын гэж ангилдаг.

“Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын хувцасны ерөнхий ангилал, нэр төрөл, хэмжээ” MNS 6343:2012 стандартад Онцгой байдлын байгууллагын тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг өмсөх улирлаас хамааруулан хүйтний болон дулааны улирлын гэж ангилсан байна.(Хүснэгт.1)


Хүснэгт 1.Тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн нэр төрөл, ангилал

№	Тусгай зориулалтын хувцас, ангилал	Хувцасны нэр төрөл	
		Дулааны улирал (хавар, зун, намар)	Хүйтний улирал (намар, өвөл, хавар)
1	Аврагчийн хувцас, хэрэглэл	- Аврагчийн хувцас (зуны) - Гутал (зуны)	- Аврагчийн хувцас (өвлийн) - Гутал (өвлийн)
		- Дотуур хувцас - Дуулга - Ноосон малгай - Өвдөг тохой хамгаалах хэрэглэл - Бүс - Бээлий - Нүдний хамгаалалтын шил	
2	Гал сөнөөгчийн хувцас, хэрэглэл	- Ой хээрийн түймрээс хамгаалах хувцас (зуны) - Байгууламжийн түймрээс хамгаалах хувцас	- Ой хээрийн түймрээс хамгаалах хувцас (өвлийн) -Байгууламжийн түймрээс хамгаалах хувцас (өвлийн)
		- Тусгаарлах хувцас - Дулаан эсэргүүцэх хувцас - Дотуур хувцас	

			<ul style="list-style-type: none"> - Дуулга - Гар хамгаалах хэрэглэл - Хөл хамгаалах хэрэглэл - Аврах бүс - Хамгаалах бүтээлэг 	
3	Уснаас ажиллагааны хэрэглэл	аврах хувцас,	<ul style="list-style-type: none"> - Усны мандлаас аврах ажиллагааны хувцас, хэрэглэл - Усны гүнээс аврах ажиллагааны хувцас, хэрэглэл - Аврах хантааз 	
4	Цацраг, химийн хорт бодисноос ажиллагааны хэрэглэл	хорт аврах хувцас,	<ul style="list-style-type: none"> - Хүрэм, өмдний иж бүрдэл - Комбинезон, хагас комбинезон - Халат - Хормогч - Ханцуйвч - Цув - Хошуувч (амны хаалт) - Нүдний шил - Дуулга - Бээлий - Гутал 	
5	Инженер, хувцас, хэрэглэл	сапёрын	<ul style="list-style-type: none"> - Хамгаалах хантааз - Нүүр хамгаалах хэрэглэл - Хамгаалах дуулга - Тусгай зориулалтын хувцас - Гарын хамгаалах хэрэглэл - Тусгай зориулалтын гутал - Чих хамгаалах хэрэглэл 	
6	Шүхэрчний хэрэглэл	хувцас,	<ul style="list-style-type: none"> - Шүхэрчний хувцас, хэрэглэл (зуны) 	<ul style="list-style-type: none"> - Шүхэрчний хувцас, хэрэглэл (өвлийн)
			<ul style="list-style-type: none"> - Дотуур хувцас - Дуулга - Ноосон малгай - Бээлий - Нүдний хамгаалалтын шил - Гутал 	
7	Уулын ажиллагааны хэрэглэл	аврах хувцас,	<ul style="list-style-type: none"> - Уулын аврагчийн хувцас, хэрэглэл (зуны) 	<ul style="list-style-type: none"> - Уулын аврагчийн хувцас, хэрэглэл (өвлийн)
			<ul style="list-style-type: none"> - Дотуур хувцас - Гутал - Бээлий - Нүдний шил - Хамгаалах бүс - Мөрөвчтэй бүс - Хувцастай холбох холбогч 	
8	Авто засварын болон ажлын тусгай хэрэглэл	хувцас,	<ul style="list-style-type: none"> - Ажлын хувцас - Ажлын бээлий - Цацруулагчтай хантааз 	

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь ерөнхийд ангилвал нийт алба хаагчдын 50 орчим хувь нь гал сөнөөгч, 20 орчим хувь төрөл мэргэжлийн аврагч, 25 орчим хувь нь офицер болон бусад мэргэжлийн алба хаагчид, 8 орчим хувь нь энгийн албан хаагчид байна. (Зураг 1)

Зураг 1. Тусгай зориулалтын хувцас хэрэглэх алба хаагчид



Зураг 1-т харуулснаар нийт алба хаагчдын 50 орчим хувь нь гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг хэрэглэдэг болох нь харагдаж байна.

Өнөөдөр албан хэмжээнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын хувцаснаас зөвхөн “аврагчийн” аюулгүй ажиллагааны улбар шар өнгөтэй хүрэм, өмд хүйтний улиралд өмсөх зориулалттай синтетик дулаалгатай байна. Аврагчийн улбар шар хувцсыг Үндэсний аврах бригад, Нийслэлийн онцгой байдлын газрын аврах анги, орон нутагт аймгийн Онцгой байдлын газар хэлтсийн аврах салбар, аврах бүлгийн аврагчид л өмсөж хэрэглэдэг байна. Гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцас буюу байлдааны хувцасыг импортоор худалдан авч бэлтгэдэг тул эрс тэс уур амьсгалтай Монгол орны өвлийн улиралд өмсөхөд тийм ч зохимжтой байдаггүй. Гал сөнөөгчийн хувцас гэж гал түймрийг унтраах болон түүнээс аврах ажиллагааг гүйцэтгэхэд тухайн орчны аюултай, хөнөөлт хүчин зүйлс, цаг агаарын тааламжгүй үйлчлэлээс хамгаалах, ил дөл болон дулааны үйлчлэлээс хамгаалах зориулалттай боловч хүйтний улиралд манай орны хувьд цаг агаарын үйлчлэлээс хамгаалах чадвар бага байдаг.

Судалгаанаас харахад олон улсын стандартад хүйтний улиралд өмсөх байлдааны хувцас нэмэлт дулаалга буюу дулаан тусгаарлах давхаргатай байдаг байна. Мөн “Гал сөнөөгчийн хувцас. Ерөнхий шаардлага” MNS 6348:2012 стандартад байгууламжийн гал түймрээс хамгаалах байлдааны хувцасны иж бүрдэлд тэмээний эсвэл хонины ноосон дулаан тусгаарлах салдаг дотор эсвэл хантааз байна гэж заажээ.

Иймд Онцгой байдлын байгууллагын хэмжээнд хамгийн өргөн ашиглагддаг гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцас буюу байлдааны хувцсанд өөрийн орны хүйтэн цаг агаарт тохирсон нэмэлтээр ашиглах дулаалгыг бий болгох шаардлага тулгараад байгаа юм.

Хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгаа

Тусгай зориулалтын хувцасны дулаалгын шинэ шийдлийг гаргахын тулд тухайн хувцсыг ямар нөхцөл байдалд өмсөж хэрэглэх вэ гэдгийг судлах нь зүйтэй юм. Юуны өмнө Монгол орны уур амьсгал, цаг агаарын онцлогийг судлан үзлээ. Манай улс эрс тэс уур амьсгалтай бөгөөд жилийн дундаж температур 0.2°C (32°F), өвлийн улирлын дундаж температур -10°...-30°C (14°...22°F), зуны улирлынх нь 10°...27°C (50°...80°F) байна. Жилийн дундаж агаарын температур Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутгаар -4°C (24.8°F)-аас хүйтэн, үүний дотор уулс хоорондын хотгор, томоохон голын хөндийгөөр -6°C -аас -7.4°C (21.2...18.7°F) хүйтэн, цөлөрхөг хээрийн бүсэнд 2°C (35.6°F)-аас дулаан, өмнөд говьд 6°C (42.8°F) -аас дулаан байна. Агаарын жилийн дундаж температурын 0°C-ын шугам нь Монгол орны цөлөрхөг хээрийн, /говийн/ бүсийн хойд хилээр дунджаар хойд өргөрөгийн 46 градусын дагуу байна. Агаарын жилийн дундаж температур -2°C (28.4°F)-аас хүйтэн нутагт мөнх цэвдэгт хөрс тархсан байдаг. Өвлийн улиралд үнэмлэхүй бага температур -28°C-аас -54°C (-18.4°...-65.2°F) хүрч хүйтэрдэг бол зуны улиралд үнэмлэхүй их температур 30°C-аас 45°C (86°...113°F) хүрч халдаг.⁶¹

Манай орны ийм эрс тэс уур амьсгал, цаг агаарын нөхцөлд онцгой байдлын алба хаагчид ой хээрийн болон объектын гал түймэр, малын болон байгалийн голомтод халдварт өвчин, зуд, үер, цацраг, химийн хорт бодисын осол, тэсэрч дэлбэрэх болон техникийн гаралтай осол зэрэг маш олон төрлийн гамшиг осолд тусгай зориулалтын хувцсыг өмсөж ажил үүргээ гүйцэтгэдэг.

Хөдөлмөрийн нөхцлийг хэвийн болон хэвийн бус гэж ангилах бөгөөд хэвийн нөхцлийг тохиромжтой болон зөвшөөрөгдөх, хэвийн бус нөхцлийг хортой болон аюултай гэж ангилдаг. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй, хөдөлмөрийн стандартад нийцээгүй ажлын байрны нөхцлийг хэвийн бус нөхцөл гэнэ. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл нь эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтэрч, түүний үйлчлэл нь бие махбод болон үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа орчин юм. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлийн эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээний хэтрэлт, түүний үйлчлэлийн нөлөөллөөр ажилтны эрүүл мэндийн байдалд гарах өөрчлөлтийн байдлаас хамаарч хортой нөхцлийг 4 зэрэгт хувааж үздэг байна.⁶²

1 дүгээр зэрэг. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлийн хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтэрч, тэдгээрийн үйлчлэл нь ажилтны эрүүл мэндэд үйл ажиллагааны түр зуурын хямрал үүсгэж, хөдөлмөрийн чадвар нь буурах боловч эргэж хэвийн байдалд орж, нөхөн сэргээгдэх ажлын орчин.

2 дугаар зэрэг. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлийн хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтэрч, тэдгээрийн үйлчлэл нь ажилтны эрүүл мэндэд үйл ажиллагааны гүнзгий хямрал, эмгэг өвчин, мэргэжлийн өвчний урьдал үеийг үүсгэх боловч нөхөн сэргээгдэх боломжтой, ерөнхий болон хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөлд хүргэх ажлын орчин.

⁶¹<http://tsag-agaar.gov.mn/atmosphere>

⁶²Хөдөлмөрийн нөхцлийн ангилал, хүчин зүйл, үнэлгээ MNS 5080:2001

3 дугаар зэрэг. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлийн хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтэрч, тэдгээрийн үйлчлэлийн нөлөөгөөр ихэнх тохиолдолд ажилтны эрүүл мэндэд үйл ажиллагааны гүнзгий хямрал, зарим тохиолдолд бүтэц зүйн эмгэг өөрчлөлт, ажилтай холбоотой болон мэргэжлийн өвчний хөнгөн хэлбэрийг үүсгэх боловч нөхөн сэргээгдэх боломжтой, ерөнхий өвчлөлийн давтамж, хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөл нэмэгдэх ажлын орчин.

4 дүгээр зэрэг. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлийн хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтэрч, ажилтны эрүүл мэндэд үйл ажиллагааны болон бүтэц зүйн эмгэг, ажилтай холбоотой болон мэргэжлийн өвчний илэрхий хэлбэрийг үүсгэж, нөхөн сэргээгдэх боломжгүй, хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөл эрс нэмэгдэх ажлын орчин.

Аюултай нөхцөл нь ажлын байрны сөрөг хүчин зүйлийн үйлчлэл нь ажлын ээлжийн хугацаанд мэргэжлийн хурц, хүнд хордлого үүсгэж, ажилтны эрүүл мэнд, амь насанд аюул учруулах ажлын орчин юм.

Судалгаанаас харахад Онцгой байдлын байгууллагын аврагч, гал сөнөөгчдийн ажиллах орчин нөхцөл нь хортой болон аюултай нөхцөлдбагтаж байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Тэтгэврийг хөнгөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-д гал унтраах ажиллагаанд оролцдог жижүүрийн албаны гал сөнөөгч, жолооч, гал унтраах ажлын удирдагч, хэрэг бүртгэгч, галын хор цэнэглэгчийн ажлын байр орсон байдаг ба аврагч гэж ороогүй боловч бүх төрлийн аврах ажиллагаанд хийгддэг ажлууд мөн багтсан байна.

Аврагч, гал сөнөөгчид ус чийгтэй, тоосжилт ихтэй, химийн хорт болон цацраг идэвхит бодистой, халуун эсвэл маш хүйтэн зэрэг аюултай, хөнөөлт хүчин зүйлсээс гадна эрс тэс уур амьсгалтай манай орны цаг агаарын тааламжгүй үйлчлэлээс хамгаалах хувцас хэрэглэлийг өмсөж хэрэглэх шаардлагатай байна.

1.2. Монгол орны уур амьсгалд тохирсон хувцасны дулаалгын материалын судалгаа

Манай орны ийм эрс тэс уур амьсгал, цаг агаарын нөхцөлд онцгой байдлын алба хаагчид ялангуяа өвлийн улирлын зохимжтой дулаалга бүхий хувцсыг өмсөж ажил үүргээ гүйцэтгэх нь чухал юм.

Техник, технологи хөгжсөн өнөө үед агаарын маш бага хэмд ч өмсөж хэрэглэх өндөр шинж чанартай NOMEX, 3M, нано боловсруулалттай ширхэгтүүдийг ашиглан хувцас хэрэглэлийг үйлдвэрлэх болсон. Эдгээр технологи бүхий хувцасны дулаан хадгалах чадвар сайн ч өртөг өндөр байдаг. Одоо онцгой байдлын албанд хэрэглэгдэж байгаа нэг иж бүрэн галын хувцасны өртөг 1 сая 700 мянга орчим байгаа тул хангалттай дулаан хадгалах давхарга нэмэхэд өртөг шууд 15-20 хувиар өсөхөөр байна. Сүүлийн үед байгалийн болон химийн гаралтай ширхэгт ашиглан дулаан хувцас, дулаалгын давхарга үйлдвэрлэсээр байгаа боловч байгалийн гаралтай ширхэгт тэр дундаа амьтны ноосыг дулаалгад хэрэглэхийг илүү ихээр зорих болжээ. Манай ард түмэн эртнээс нааш таван хошуу малаа маллаж, ашиг шимийг нь амьдрал

ахуйдаа ашиглаж, ноос, ноолуур, арьс, ширээр өөрийн орны хүйтэн цаг агаарт тохирсон дулаан хувцас хийж өмсдөг уламжлалтай (Зураг 2).



Зураг 2.. Монгол хонь, тэмээний ноос

Энэ нь тухайн амьтны арьс, үс, цаг уурын халуун, хүйтэн, эрс тэс нөхцлөөс хамгаалах байгалийн зохилдолгоо, өвөрмөц бүтэцтэйгээс гадна түүхий эд хамгийн олдоц ихтэй, хангамж сайн байдагтай холбоотой юм.

Монгол орны эрс тэс уур амьсгалд дасан зохицсон монгол хонь, тэмээний ноос нь дулаан сайн хадгалдаг, бат бөх, гал тэсвэрлэх чадвар сайн, хиртэлт, элэгдэлт багатай, үс нь сэргэх чадвар сайтай зэрэг онцлог ба давуу чанартай. Иймд эрс тэс уур амьсгалтай Монгол орны цаг уурт тохирсон хонь, тэмээний ноосон дулаалгыг ашиглан Онцгой байдлын байгууллагын аврагч, гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцсанд дулаалгыг шийдэх боломжийг судлаж үзэх нь зүйтэй юм.

Ноосон ширхэгтийн шинж чанар


Амьтны арьсан дээрх үсэн бүрхүүлийг ноос гэх ба уургийн гаралтай, нөхөн төлждөг байгалийг гаралтай ширхэгт юм. Хонь, тэмээ, ямаа, лам гөрөөсний ноосыг хамгийн өргөн ашигладаг.

Ноосон ширхэгтийн дотоод бүтэц нь маш өвөрмөц зохион байгуулалттай ба хайрслаг, цайварлаг давхарга ба хөндий гуурснаас тогтдог (Зураг 3). Ноосны хамгийн гадна талын зузаан эвэрлэг үеийг хайрслаг давхарга гэдэг бөгөөд ширхэгтийг гадны механик болон химийн үйлчлэлээс хамгаалдаг. Бүтэц нь бие бие рүүгээ углагдан орсон хэлбэртэй байх ба хайрснууд нь цавуулаг шингэнээр холбогдон бэхлэгдсэн байдаг. Хайрсны хэлбэр хэмжээ, нимгэн зузаан, өндөр нь харилцан адилгүй байна. Хайрслаг давхарга нь ноосыг орчны чийгээс хамааран бүтэц шинж чанараа өөрчилдөг гигроскоп шинж чанартай болгодог.

Цайварлаг давхарга нь ортокортекс, паракортекс гэсэн 2 эсээс бүрдэх ба малын гарал үүсэл, нас хүйснээс хамаарч ширхэгтэд агуулагдах хэмжээ нь харилцан адилгүй байна. Ортокортекс нь паракортексийг ороосон хэлбэртэй байх ба ортокортекс ус чийг шингээж, паракортекс нь ширхэгтийн атираалаг байдлыг


нэмэгдүүлдэг. Энэ өвөрмөц бүтэц нь ноосны үрчийлт бага үүсдэг шинж чанарыг олгодог.

Ноосон ширхэгт голын хөндий гуурсанд агаар дүүрсэн байдаг учир дулааныг сайн хадгалдаг.



Зураг 3. Ноосон ширхэгтийн дотоод бүтэц.
1-хайрслас дагхарга, 2-цайварлаг дагхарга, 3-хөндий гуурс

Ноосон нь өөр хоорондоо нарийн бүдүүн, урт, атираа зэргээрээ эрс ялгаатай, дотоод бүтэц бүрэлдэхүүн нь харилцан адилгүй байдаг учир ноолуурлаг үс, завсрын үс, сор үс, хялгас үс гэж ангилдаг (Зураг 4).



Зураг 4. Ноосонд агуулагдах төрөл бүрийн үсний бүтэц, хэлбэр
1-ноолуурлаг үс, 2-завсрын үс, 3- сор үс, 4-хялгас үс

Ноолуурлаг үс нь ноосны хамгийн нарийн, зөөлөн, атираа ихтэй байдаг ба хайрслал, цайварлаг давхарганаас тогтдог. Монгол хонины ноолуурлаг үсний хөндлөн огтлол нь 15-30 μм байна.⁶³

Завсрын үс нь ноолуураас бүдүүн, сор үснээс нарийн дундаж шинжийг хадгалсан байна. Атираа болон ерөнхий шинж чанар нь ноолууртай төстэй. Хайрслал болон цайварлаг давхарганаас тогтохоос гадна тасархайтсан хөндий голтой байдаг.

Сор үс нь атираа багатай, гялалзсан сорлог үс байдаг. Хайрслал, цайварлаг, хөндий гуурстай байна. Сор үсний нарийн бүдүүнээс хамаарч хөндий голны хэмжээ харилцан адилгүй байна.

Хялгас үс нь атираагүй дээрх үснүүдтэй харьцуулахад хамгийн бүдүүн үс юм. Хайрслал, цайварлаг давхаргатай бөгөөд дийлэнх хувийг хөндий гуурс эзэлдэг учраас амархан хугарч, тасардаг.

Ноосон ширхэгтийн галд тэсвэрлэх чадвар нь сайн, шатах температур 560°C байдаг. Ноосон ширхэгтийн 80 хувь нь кератин, 17 хувь нь уургийн бус нэгдлүүд, 1 хувь липид, 0,5-1 хувь эрдэс минериалын давснаас тогтоно. Ноосны кератинд нүүрстөрөгч 50.65, хүчилтөрөгч 18.52, устөрөгч 7.03, азот 17.7, хүхэр 6 хувь агуулагдсан байдаг. Ямар нэг материалын галд тэсвэрлэх чадвар нь тухайн материалын үндсэн түүхий эдийн химийн бүтцээс хамаарах бөгөөд нүүрстөрөгчийн хэмжээ 30 хувиас илүү байвал галд амар шатдаггүй. Ноосыг шатаахын тулд 25.2 хувийн хүчилтөрөгч шаардагддаг бол агаарт байгаа хүчилтөрөгчийн хэмжээ 21 хувь байдгаас ноосыг шатаахад өөрөө унтардаг байна. Хамгийн гол нь ноосон ширхэгт нь шатахдаа хайлдаггүй учир хүний биед наалддаггүй давуу талтай.

Ноосон ширхэгт уян хатан, атираатай, хэмжээс нь олон янзаар хувирч байдаг тул хувцасны дулаалгад ашигласнаар хүний хөдөлгөөнд хэлбэрээ өөрчлөх, буцаж анхны хэлбэртээ орохдоо хялбар, хэлбэрээ сайн хадгалдаг. Ноосон дулаалгын материал бөх бат, хөнгөн, хорт бодис агуулдаггүй, хүний эрүүл мэндэд хоргүй. Дулаалгын материалуудын эрүүл ахуйн үзүүлэлтээс хөлс, ус чийг өөртөө шингээх нь ялангуяа хүйтний улиралд хамгийн чухал үзүүлэлт болно. Агаарын чийгшил их үед ноос нь хувийн жингийнхээ 35 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний чийгийг шингээгээд дулаан болгон гаргадаг. Нэг кг хуурай ноосноос 960 килоджоул дулаан ялгардаг болохыг судлаачид тогтоожээ (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Ноосон дулаалгыг шинж чанарын үзүүлэлтүүд

Зузаан	мм	10
Нягт	кг/м ³	30-40
Дулаан дамжуулалтын итгэлцүүр	Вт/м ⁰ С	0,035- 0,037
Ус шингээлт	%	35

Хүйтэн нөхцөлд хувцсанд хэргэлдэг олон төрлийн дулаалгын материалуудаас хамгийн өргөн хэрэглэдэг амьтны гаралтай шувууны өд сөд, хиймэл ширхэгт болох

⁶³Р.Мядагмаа., Нэхмэлийн үйлдвэрийн гүйцэтгэн боловсруулах технологи, Улаанбаатар, 2014. хуудас 40

сентипон зэрэг материалууд юм. Эдгээр материалуудын дулаан хадгалах чадвар болон эдэлгээний ерөнхий үзүүлэлтүүдийг ноосон дулаалгыг ерөнхий үзүүлэлтүүдтэй харьцуулан хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. Ноосон дулаалгыг бусад дулаалгатай харьцуулсан байдал


Үзүүлэлт	Ноос	Өд,сөд	Сентипон
Дулаан хадгалах чадвар	-60°C	-40°C	-20°C
Цэвэрлэгээний арга	Хими цэвэрлэгээ, гараар болон угаалгын машинаар угаах	Хими цэвэрлэгээ	Хими цэвэрлэгээ, гараар болон угаалгын машинаар угаах
Бүтэц хэлбэрээ хадгалах байдал	70 хүртэл жил, эргээд байгальд ээлтэй	20 жил, эргээд байгальд ээлтэй	5-10 жил, синтетик материал
Ус шингээлт, %	35	10	-
Агаар нэвтрүүлэлт	Амьсгалдаг	Амьсгалдаг	Амьсгалдаггүй

Хүснэгт 4-с харахад ноос болон өд, сөдөн дулаалга нь байгалийн гаралтай дулаалгын материалууд бөгөөд дулаан хадгалах чадвар харьцангуй өндөр, агаар нэвтрүүлэлт сайн байна. Энэ нь уг амьтаны байгалийн зохицлоготой холбоотой юм.

Судалгаанаас харахад Онцгой байдлын байгууллагын тусгай зориулалтын хувцасны дулаалганд дулаан хадгалах, ус чийг шингээх, галд тэсвэртэй байгалийн гаралтай ширхэгт тохиромжтой нь харагдаж байна. Иймээс ноосон дулаалгыг ашиглан аврагч, гал сөнөөгчдийн хөдөлмөрийн нөхцөл байдалд туршиж үзэх нь зүйтэй юм.

Ноосон дулаалгын түүхий эдийн нөөц Дэлхийн хэмжээнд Австрали, Хятад, Шинэ Зеланд, Аргентин, Энэтхэг, Англи, хойд Ирланд зэрэг орнууд ноосны чиглэлээр тэргүүлдэг бөгөөд жилд 50,000 тонноос дээш ноос бэлтгэдэг байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээгээр 2018 онд 30.5 сая хонь, 27.1 сая ямаа, 459.7 мянган тэмээ, 4.4 сая үхэр (үүнд 877.7 мянган сарлаг), 3.9 сая адуу, нийтдээ 66.2 сая мал тоологдсон ба ямаан сүргийн тоо толгой өмнөх оноос 222 мянган толгойгоор буурсан байна.(Зураг 5)



Зураг 5. 2018 онд тоологдсон таван хошуу малын тоо толгой

2019 оны байдлаар жилдээ дунджаар 9500 тонн ямааны ноолуур, 1400 тонн тэмээний ноос, 260 тонн сарлагийн хөөвөр, 33600 тонн хонины ноос бэлтгэх нөөцтэй байна ⁶⁴(Хүснэгт 2).

Хүснэгт 2. Түүхий эдийн нөөц, тн

№	Түүхий эд	2015	2016	2017	2018	2019
1	Хонины ноос	25500	27400	30600	33000	33600
2	Ямааны ноолуур	7700	8300	9000	9600	9500
3	Тэмээний ноос	1050	1100	1200	1300	1400
4	Сарлагийн хөөвөр	200	220	240	250	260

М

ОНГ
ОЛ
ТЭМ
ЭЭН

ээс жилд дунджаар 6.5 кг, хониноос 1.5 кг ноос авдаг. Монгол улсын стандартад хонины ноосыг нийтлэг төрлөөр нь нарийн, нарийвтар, бүдүүн, бүдүүвтэр гэж ангилдаг. Жилд бэлтгэж буй нийт хонины ноосны 90 орчим хувийг бүдүүн ноос эзэлж байна. Бүдүүн ноост хонины ноос нь бүдүүн ноолуур, завсрын үс, сор үс, хялгас үснээс бүрддэг. Тэмээний ноос нь ноолуур, завсрын үс, хялгаснаас бүрдэх бөгөөд ноолуурын агууламж нь хонины бүдүүн ноосныхоос их, зунгаг багатай, гол төлөв өөрийнхөө өнгөөр хэрэглэгддэг. Манай улс жилд ойролцоогоор 1300 тонн тэмээний ноос бэлтгэдэг бөгөөд тэмээний ноос нь дулаан хадгалах чадвар сайтай, ноолууртай харьцуулахад ширхэгт нь урт 45 мм-ээс дээш бөгөөд бөх бат чанараараа давуу байдаг.

Судалгаагаар нэхмэлийн үйлдвэрүүдийн хялгас ялгах цехийн ноолуурын гарц 60 орчим хувь байдаг бөгөөд дунджаар энэхүү ноосны 30 орчим хувийг сэв, үс эзэлдэг байна. Өөрөөр хэлбэл жилд 400-600 тонн сэв үс гарч байна. Сэв үсээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлгүй жинлэж зарах эсвэл гадаад экспортлодог байсан үетэй харьцуулахад 2002 оноос эхлэн “Ээрмэл” ХК, “Говь” ХК, “Нэхээсгүй эдлэл” ХК, Эвсэг ХХК сэв үсээр хөнжил, аяны хөнжил, гудас, зулхай зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа хэдий ч бүрэн хэмжээгээр ашиглаж чадахгүй байгаа билээ.


⁶⁴<http://mofa.gov.mn/exp/blog/11/175>

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АВРАГЧ, ГАЛ СӨНӨӨГЧИЙН ХҮЙТНИЙ УЛИРАЛД ӨМСӨХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХУВЦСАНД ШИНЭ ДУЛААЛГА АШИГЛАХ НЬ

2.1. Аврагч, гал сөнөөгчийн өмсөж буй хүйтний улирлын тусгай зориулалтын хувцсанд шинэ дулаалга ашиглах нь

Хөдөлмөрийн нөхцөлийг судлан үзэхэд тусгай зориулалтын хувцсыг хүйтэн сэрүүн нөхцөлөөс гадна ус чийгтэй, элдэв бохирдолтой орчинд өмсөж хэрэглэх нь харагдсан. Тиймээс хувцасны дулаалгын гадар давхаргад ус чийг нэвтрүүлдэггүй давхарга байх шаардлагатай юм. Энэ нь дулаан хадгалах давхарга болон аврагчийн дотуур хувцсанд ус, чийг нэвтрэх, норхоос хамгаалах хамгаалалтын давхарга болно. Дулаалга гадар давхарга, ноосон дулаалга, дотор давхаргуудаас бүрдэнэ (Зураг 6).

Зураг 6. Тусгай зориулалтын хувцасны дулаалгын давхаргын бүтэц
Гадар давхаргын материал сонголтонд полиэстер материалыг сонгох ба энэ нь



ус нэвтрүүлэхгүй мембран түрхлэгтэй амьсгалдаг даавуу байна. Дотор давхаргаар ноосон дулаалгыг дотогш нэвтрүүлэхгүй нягт нэхээстэй, хөлс чийгийг сайн нэвтрүүлэх, шатсан тохиолдолд хүний биед наалдахгүй хөвөн даавууг сонгоно. Ноосны хялгас үс хувцасны дотор тал руу нэвтрэхээс сэргийлж, мөн ноосыг бөөгнөрүүлэхгүй барьж байхаар тооцоолон дулаалгын давхаргыг хамгаалалтын давхаргаар бүрэх нимгэн цавагны нэхээсгүй материалыг сонгон авлаа. Энэхүү давхарга нь дулаан хадгалалт, ус чийг нэвтрүүлэлтэд нөлөөлөхгүй.

Дулаалгын шинэ шийдлийн давхаргын дулаан дамжуулалтын итгэлцүүрийг хүснэгт 5-т үзүүлэв.

Хүснэгт 5. Тусгай зориулалтын хувцасны дулаалгын давхаргуудын дулаан дамжуулалтын итгэлцүүр

№	Материалын төрөл	Эзэлхүүн жин, кг/м ³	Дулаан дамжуулалтын итгэлцүүр, Вт/м ² °С
1	Ус нэвтрүүлэхгүй буюу гадар давхарга	80-250	0.08-0.09
2	Ноосон дулаалга	70-250	0.04-0.06
3	Дотор давхарга	120-500	0.09-0.10


Дулаалгын шинэ шийдлийн техникийн тодорхойлолт



Зураг 7. Дулаалгын гадаад байдал



Онцгой байдлын байгууллагын гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцасны дулаалга нь хагас бариу селуэттэй. Сүлжмэл захтай, энгэрт ил дарж оёсон цахилгаан товчлоостой, оруулган тагтай хагалбар халаастай, хормой сүлжмэл манжеттай. Энгийн залгаа ханцуйтай, танаастай тохойн оёдолтой, ханцуйн үзүүр сүлжмэл манжеттай. Арын голын оёдолтой. Оёдлуудыг 0,1-0,6 см-ээр ил дарж оёсон байна. Энгэрт алба хаагчийн нэр, цолны хатгамалыг оёсон байна. Ноосон дулаалгыг хамгаалалтын нимгэн давхаргад жигд зулан тарааж, хавсарч 8 см-ийн зайтай хөндлөнгөөр ширж оёно. (Зураг 8).



Зураг 8. Ноосон дулаалгыг хамгаалалтын давхаргатай оёх.

Хувцасны зохион бүтээлтэд хөндлөн чиглэлийн сулын хэмжээг тооцдог тул дулаалгын хөндлөн чиглэлд суналт үүсэн оёдол тасрах дутагдал гарахгүй.

2.2. Хүйтний улиралд өмсөх тусгай зориулалтын хувцасны дулаалгын материалын үр ашгийн тооцоо

Онцгой байдлын байгууллагын гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцасны дулаалгын өртөг зардлыг тооцон үзлээ. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Тусгай зориулалтын хувцасны дулаалгын зардлын тооцоо

№	Зардлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Орц	Үнэ, төг	
				нэгж	нийт
1	Гадар материал	м	1.4	10000	14000
2	Ноосон дулаалга	м	1.2	30000	36000
3	Хамгаалалтын давхарга	м	1.2	1500	1800
4	Дотор	м	1.2	5000	6000
5	Цахилгаан	ш	1	1500	1500
6	Сүлжмэл манжет	м	0.5	3000	1500
7	Наалт	м	0.1	1800	180
8	Утас	ш	0.01	2000	20
9	Ажлын хөлс /НӨАТ тооцсон/				30000
Нийт					91000

Нэг ширхэг тусгай зориулалтын хувцасны дулаалгын өртөг 91000 төгрөг болж байна. Энэ тооцоог бууруулах боломжтой бөгөөд материалуудын орцыг ганцаарчилсан эсгүүрээр, ажлын хөлсийг захиалга хувцасны хөлсөөр тооцсон болно. Оёдлын үйлдвэрүүдэд бөөнөөр үйлдвэрлэвэл үнийн дүнг 30 хүртэл хувиар бууруулах боломжтой. Нийт гал сөнөөгчдийг дулаалгаар хангая гэвэл 80 орчим сая төгрөг зарцуулагдах тооцоо гарч байна. Тусгай зориулалтын дулаалгын эдэлгээний хугацааг

тодорхойлох шаардлагатай бөгөөд туршилтын загварыг 3 сар туршиад үр дүн харагдана. Дулаалгын шинэ шийдлийн давуу болон сул тал, боломж болон аюул заналыг свот шинжилгээгээр харууллаа (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Свот шинжилгээ

<p style="text-align: center;">Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дулаан сайн хадгална ✓ Загварлаг ✓ Хөнгөн ✓ Хөдөлгөөнд саад учруулахгүй ✓ Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ✓ Хурдан хатна ✓ Угааж цэвэрлэхэд хялбар ✓ Шатахад хүүний биед хайлж наалдахгүй ✓ Өмсөж хэргэлэхэд хялбар 	<p style="text-align: center;">Сул тал</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дулаалгын бусад давхаргуудыг импортоор авна
<p style="text-align: center;">Боломж</p> <ul style="list-style-type: none"> ✓ Алба хаагчийн хөдөлмөрийн бүтээмж дээшилнэ ✓ Алба хаагч аврах ажиллагаанд оролцоогүй байхдаа хүрэм хэлбэрээр өмсөж болно ✓ Эх орны түүхий эд учир түүхий эдээр тасрахгүй ✓ Цааш хөгжүүлэн хүйтний улирлын хувцсанд ашиглах боломжтой ✓ Өөрийн орны түүхий эд учир үнэ бууруулах боломжтой ✓ Судлаачид цаашид шинэ технологи боловсруулах 	<p style="text-align: center;">Аюул занал</p> <ul style="list-style-type: none"> ✓ Эдийн засгийн байдлаас хамааран үйлдвэрлэл тасалдаж болзошгүй ✓ Хямд үнэтэй импортын бүтээгдэхүүн нийлүүлэгдэх ✓ Боловсруулах үйлдвэр цөөн байна

Свот шинжилгээнээс харахад дулаан хадгалах, Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын 80 орчим хувь нь залуучууд байдаг тул загвар дизайнтай байх, эдэлгээний хувьд хүний биед сөрөг нөлөөгүй зэрэг давуу талууд харагдаж байна. Дулаалгыг өмсөж хэрэглэн даарахгүй, хөдөлгөөн хязгаарлахгүй учир алба хаагчийн хөдөлмөрийн бүтээмж дээшилнэ. Эх орны түүхий эд учир түүхий эдээр тасрахгүй, үнэ бууруулж, цаашид шинэ технологи боловсруулах бүрэн боломжтой. Дулаалгыг хүрэм болон дулаалга болгож 2 хэлбэрээр ашиглаж болно. Цааш хөгжүүлэн хүйтний улирлын хувцсанд ч ашиглах боломжтой.

Мөн манай орон нэхмэл даавууны үйлдвэрлэл тийм сайн хөгжөөгүй тул дулаалгын бусад давхаргуудыг импортоор авах сул талууд харагдаж байна. Мөн ноосон дулаалгыг боловсруулах үйлдвэр цөөн, эдийн засгийн байдлаас хамааран

үйлдвэрлэл тасалдах, ижил төстэй, хямд үнэтэй импортын бүтээгдэхүүн нийлүүлэгдэх аюул занал харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл өндөртэй, эрс тэс уур амьсгалтай Монгол орны аль ч улиралд, ямар ч цаг агаарын нөхцөл байдалд Онцгой байдлын байгууллагын аврагч, гал сөнөөгчид ард иргэдийнхээ аюулгүй байдлын төлөө гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх үүргээ биелүүлдэг.

Судалгааны ажлаар Онцгой байдлын байгууллагын 50 орчим хувийг эзэлдэг гал сөнөөгчийн тусгай зориулалтын хувцас буюу байлдааны хувцсанд шинээр тэмээний сэв үсийг сул ширхэгт хэлбэрээр дулаалганд ашиглах боломжийг судлан үзлээ.

Онцгой байдлын байгууллагын гал сөнөөгчдийн байлдааны хувцсыг ОХУ, БНСУ, БНХАУ улсуудаас импортоор оруулж ирэн бэлтгэдэг тул Монгол орны эрс тэс, хүйтэн өвлийн улиралд өмсөн аврах үйл ажиллагааны үед даарах, норох, норсон үедээ хөлдөх зэрэг асуудлууд тохиолддог. Энэ үед аврагч, гал сөнөөгчид зориулалтын бус дулаалга хэрэглэн хөдөлгөөн хязгаарлах, шатамхай шинж чанартай хувцас давхарлан өмсөж хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчиж өөрсдийгөө эрсдэлд оруулдаг. Байлдааны хувцсанд нэмэлт дулаалгыг давхарга нэмүүлэн худалдан авахад өртөг шууд 15-20 хувиар өсөхөөр судалгаа байна. Иймд Монгол орны эрс тэс уур амьсгалд дасан зохицсон монгол хонь, тэмээний ноосны дулаан сайн хадгалдаг, бат бөх, галд тэсвэртэй, хиртэлт, элэгдэлт багатай, үс нь сэргэх чадвар сайтай зэрэг онцлог давуу чанаруудыг ашиглан байлдааны хувцасны дулаалгыг хийх боломжийг судаллаа.

Ноос нь тухайн амьтны арьс, үс цаг уурын халуун, хүйтэн, эрс тэс нөхцөлөөс хамгаалах байгалийн зохилдолгоо, өвөрмөц бүтэцтэйгээс гадна түүхий эд хамгийн олдоц ихтэй, хангамж сайн байдагтай холбоотой юм. Ноосон ширхэгт нь хайрслал, цайварлаг давхарга болон хөндий голтой бүтэцтэй учир голын хөндий гуурсанд агаар дүүрч дулааныг сайн хадгалдаг биологийн онцлог давуу талтай юм. Агаарын чийгшил их үед ноос нь хувийн жингийнхээ 35 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний чийгийг шингээж, дулаан болгон ялгаруулдаг.

Судалгааны ажлын тооцоогоор 1 ширхэг тусгай зориулалтын хувцасны дулаалгын өртөг 91000 төгрөг байгаа нь гадаад улс орнуудаас импортлохоос даруй 3,5 дахин бага байгаа юм. Энэ тооцоог бууруулах боломжтой бөгөөд материалуудын орцыг ганцаарчилсан эсгүүрээр, ажлын хөлсийг захиалга хувцасны хөлсөөр тооцсон бөгөөд бөөнөөр үйлдвэрлэвэл үнийн дүнг 30 хүртэл хувиар бууруулах боломжтой. Нийт гал сөнөөгчдийг дулаалгаар хангая гэвэл 80 орчим сая төгрөг зарцуулагдах тооцоо гарч байна. Тусгай зориулалтын дулаалгыг 2-3 жилийн эдэлгээний хугацаатай олгох бөгөөд туршилтын загварыг 3 сар туршихад үр дүн харагдана.

Дулаалгын шинэ шийдлийн давуу болон сул тал, боломж болон аюул заналыг свот шинжилгээгээр тооцон үзсэн. Свот шинжилгээнээс харахад дулаан хадгалах болон загвар дизайн сайн, эдэлгээний хувьд хүний биед сөрөг нөлөөгүй зэрэг давуу талуудтай, дулаалгыг өмсөж хэрэглэн даарахгүй, хөдөлгөөн хязгаарлахгүй учир алба хаагчийн хөдөлмөрийн бүтээмж дээшлэх, эх орны түүхий эд учир түүхий эдээр тасрахгүй, үнэ бууруулж, цаашид шинэ технологи боловсруулах бүрэн боломжтой байна. Харин боловсруулалтын технологи хоцрогдолтой, сэв үсний хялгас хувцасны давхарга руу нэвтрэн гарах, дулаалгын бусад давхаргуудыг импортоор авах зэрэг сул талууд ажиглагдаж байна. Мөн ноосон дулаалгыг боловсруулах үйлдвэр цөөн, эдийн засгийн байдлаас хамааран үйлдвэрлэл тасалдах, ижил төстэй, хямд үнэтэй импортын бүтээгдэхүүн нийлүүлэгдэх зэрэг аюул занал харагдаж байна.

Дээрх тооцоо судалгаагаас харахад аврагч, гал сөнөөгчдийн тусгай зориулалтын хувцсанд тэмээний ноосон дулаалгыг ашиглах бүрэн боломжтой юм хэмээн дүгнэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын хувцасны ерөнхий ангилал, нэр төрөл, хэмжээ MNS 6343:2012
- Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, хүчин зүйл, үнэлгээ MNS 5080:2001.
- ЗХЖШ-ын даргын 2017 оны 493 дугаар тушаал. “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”
- Р.Мядагмаа., Нэхмэлийн үйлдвэрийн гүйцэтгэн боловсруулах технологи, Улаанбаатар, 2014
- М.Баяр., Докторын зэрэг горилсон бүтээл. Цаг уурын хүйтэн нөхцөлд ажилчдын хувцасны судалгаа боловсруулалт, 2006
- П.Булга., Докторын зэрэг горилсон бүтээл.[Хувцасны зориулалттай мембран бүтэцтэй сул ширхэгтэн дулаалгын үеийн судалгаа, боловсруулалт](#), 2007
- Н.А.Савостицкий, Э.К.Амирова. Материаловедение швейного производства, Москва, 2013
- <http://tsag-agaar.gov.mn/atmospher>